НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

15160 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Хуульчдын гудамж 13/1
Утас: 321138, Факс: (976-11) 322936
E-mail: info@nduz.gov.mn, http: nduz.gov.mn

2023.05.01 № 33

танай ______________ -ны № ______________ -т

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА П.АНУЖИН ТАНАА

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны системчилсэн үнэлгээний тайланг хүргүүлж байна.

Хавсралт 225 хуудастай.

ДАРГА Х.БУЛГАНТУЯА

1119276367
5284708 СБА1473

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2023 он

## АГУУЛГА


1. **АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТ**
2. **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТОЙМ**
3. **НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО**
4. **НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
   - 4.1 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэн эрх
   - 4.2 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн
   - 4.3 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаан
5. **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ХАМРАЛТ**
   - 5.1 Нийгмийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл
   - 5.2 Нийгмийн даатгалын сангийн орлого
   - 5.3 Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт
   - 5.4 Нийгмийн даатгалын хамралт
6. **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОЖ БУЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨР, ЗАРДАЛ**
   - 6.1 Тэтгэвэр олголт
   - 6.2 Тэтгэмж олголт
   - 6.3 ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгосон төлбөр, зардал
   - 6.4 Ажилгүйдлийн тэтгэмж олголт
7. **ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ**
   - 7.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
   - 7.2 Нийгмийн даатгалын хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт
8. **НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАХИМЖУУЛАЛТ, ЧАНАР, ХҮРТЭЭМЖ**
   - 8.1 Мэдээлэл технологийн үйл ажиллагаа
   - 8.2 Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хөгжүүлэлт, хүртээмж
9. **ЭМНЭЛЭГ, ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАЛ**
10. **ХЯНАЛТ ШАЛГАЛТ**
11. **МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА, ИЛ ТОД БАЙДАЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ**
   - 11.1 Хэрэглэгчийн үнэлгээ
   - 11.2 Сургалт сурталчилгаа, олон нийттэй харилцах
   - 11.3 Лавлах үйлчилгээ
   - 11.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
   - 11.5 Гадаад харилцаа, хамтын ажиллагаа
12. **ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА**
   - 12.1 Хүний нөөц
   - 12.2 Үйл ажиллагааны зардал
13. **ДҮГНЭЛТ**

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| Товчлол | Тайлал |
|---|---|
| ААНБ | Аж ахуйн нэгж, байгууллага |
| АХБ | Азийн хөгжлийн банк |
| БНКазУ | Бүгд Найрамдах Казахстан Улс |
| БНСУ | Бүгд Найрамдах Солонгос Улс |
| БНТУ | Бүгд Найрамдах Турк Улс |
| БНУУ | Бүгд Найрамдах Унгар Улс |
| ДТШ | Даатгуулагчийн төлөх шимтгэл |
| ЗГ | Засгийн газар |
| КЭХА | Капиталын эрх хүлээн авагч |
| МАОЭНХ | Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо |
| МАХ | Монголын Ахмадын Холбоо |
| МУ | Монгол Улс |
| МҮХАҮТ | Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим |
| МҮЭХ | Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо |
| НББСШУБХ | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| НД | Нийгмийн даатгал |
| НДБ | Нийгмийн даатгалын байгууллага |
| НДЕГ | Нийгмийн даатгалын ерөнхий газар |
| НДС | Нийгмийн даатгалын сан |
| НДҮЗ | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл |
| НДХ | Нийгмийн даатгалын хэлтэс |
| НХС | Нийгмийн халамжийн сан |
| ОХУ | Оросын Холбооны Улс |
| ОУХБ | Олон улсын хөдөлмөрийн байгууллага |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТҮЦ | Төрийн үйлчилгээний цэг |
| УИХ | Улсын Их Хурал |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| ҮЭХ | Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо |

| | |
|---|---|
| ХНХЯ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХЧТА | Хөдөлмөрийн чадвар түр алдалт |
| ЭМД | Эрүүл мэндийн даатгал |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ЭХМТК | Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах төв комисс |

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


Хүснэгт 1. НДС-ийн орлогын биелэлт

Хүснэгт 2. НДС-ийн 2022 оны орлогын гүйцэтгэл

Хүснэгт 3. НДС-ийн 2022 оны зарлагын гүйцэтгэл

Хүснэгт 4. НДС-ийн 2022 онд зарцуулсан мөнгөн дүн, үйлчлүүлсэн хүний тоо

Хүснэгт 5. Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн

Хүснэгт 6. Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн

Хүснэгт 7. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн

Хүснэгт 8. Хяналт, шалгалтад хамрагдсан НДХ, зөрчлийн дүн

Хүснэгт 9. НДБ-ын албан хаагчдын нас, хүйсийн мэдээлэл

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. НДС-ийн төсвийн гүйцэтгэл
График 2. Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо
График 3. Тэтгэвэр, тэтгэмж авагчдын бүтэц
График 4. Даатгуулагчдын тоо
График 5. НДБ-ын бүтэц
График 6. НДҮЗ-ийн бүтэц
График 7. НДС-ийн төсөв
График 8. НДС-ийн орлогын бүтэц
График 9. НД-ын хамралт
График 10. Тэтгэврийн зарлага
График 11. Тэтгэвэр авагчдын бүтэц
График 12. Тэтгэврийн доод болон дундаж хэмжээ
График 13. Тэтгэмжийн зарлага
График 14. ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага
График 15. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн
График 16. НДБ-ын албан хаагчдын албан тушаалын ангилал, тоо
График 17. НДБ-ын үйл ажиллагааны зардал

## ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Хавсралт 2. ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт НД-ын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлт

Хавсралт 3. МУ-ын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд НД-ын чиглэлээр тусгагдсан зорилт арга хэмжээний биелэлт

Хавсралт 4. НД-ын салбарын 2022 оны хөгжлийн үзүүлэлт

Хавсралт 5. Байгууллагын 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан

Хавсралт 6. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт

Хавсралт 7. Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Хавсралт 8. Нийгмийн даатгалын санхүүгийн 2022 оны аудитын тайлан

## ӨМНӨХ ҮГ

НДҮЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж байна.

НДҮЗ нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг удирдлага болгож, Нийгмийн даатгалын тухай хуульд заасан бүрэн эрх, чиг үүргийнхээ хүрээнд НД-ын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн НД-ын салбарыг нэгдсэн удирдлагаар хангаж ажилласан болно.

Тайлангийн хугацаанд НДҮЗ нь НД-ын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зохицуулалтыг хийж, холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангах, даатгуулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхэд чиглэгдсэн олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

2022 оны жилийн эцсийн байдлаар НД-ын шимтгэлийн орлого 2.4 их наяд төгрөг төвлөрүүлэхээс 2.7 их наяд төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 112.1 хувиар биелүүлж, 2.8 сая хүн /давхардсан тоогоор/-д тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 3.4 их наяд төгрөг зарцуулсан болно.

НД-ын болон тэтгэврийн дэвтрийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлсэн бөгөөд НД-ын нийт 34 үйлчилгээний 24 үйлчилгээг цахимжуулаад байна.

НДҮЗ нь 2022 онд нийт 8 удаа хуралдан 17 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 7 тогтоол баталсан.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиудаас бүрдсэн Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулан ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлээд байна.

Хуулийн төсөлд олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, ахмад настан бүрд суурь тэтгэвэр олгох, иргэн бүр сайн дурын үндсэн дээр хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд даатгуулж, нэмэгдэл тэтгэвэр авах, тэтгэврийг индексжүүлэн нэмэгдүүлэх, хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд шилжих асуудлуудыг тусгасан юм.

# НЭГ. АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТ

**АЛСЫН ХАРАА**

Нийгмийн түншлэгч талуудын тэгш оролцоог хангаж, нийгмийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлж, нийгмийн даатгалын тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог дэмжин, нийгмийн даатгалын сангуудын бие даасан байдал, удирдлага, засаглалыг сайжруулж, бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц нийгмийн даатгалын бүрэн бие даасан тогтолцоог бий болгон хөгжүүлнэ.

**ЭРХЭМ ЗОРИЛГО**

Нийгмийн даатгалын үйл ажиллагаанд оролцогч талуудын тэгш оролцоотойгоор нийгмийн даатгалын эрх зүйн орчин, тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгож, төрөөс баримталж буй бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, хүн амын насжилт, хөдөлмөр эрхлэлтийн хэв шинж, тэтгэвэр, тэтгэмж авагчдын тооны байдал зэрэг нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн хүчин зүйлтэй уялдуулан тэтгэврийн даатгалын тогтолцоог шинэчилж, олон давхаргат тогтолцоог бий болгох, хүн амыг нийгмийн даатгалд бүрэн хамруулах, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөн арвижуулах, нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, иргэдийнхээ нийгмийн баталгааг хангана.

**ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТ**

Даатгуулагч, ажил олгогч, Засгийн газрын нийгмийн даатгалын үйл ажиллагаанд тэгш оролцох боломж, нөхцөлийг хангаж, нийгмийн даатгалтай холбогдолтой хууль, тогтоомжийн биелэлт болон даатгалын сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавьж, иргэддээ хүргэх нийгмийн даатгалын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй зохион байгуулах, даатгуулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн даатгалтай холбоотой аливаа асуудлыг нийгмийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, хамтын удирдлагын хүрээнд олонхын саналаар шийдвэрлэж, гаргасан тогтоол, журам, зөвлөмж, удирдамж, шийдвэрийн хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллана.

## ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТОЙМ



НДҮЗ нь тайлант хугацаанд УИХ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”, 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, 2015 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”, ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө, Нийгмийн даатгалын үйлчилгээний маркетингийн дунд хугацааны хөтөлбөр (2019-2022 он)-ийг хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг бодлогын баримт бичиг, салбарын үндэсний хөтөлбөр, байгууллагын стратеги төлөвлөгөөний зорилтыг чиглэл болгон 67 ажил үйлчилгээ, арга хэмжээг чиг үүргийн дагуу хийж гүйцэтгэхээр боловсруулсан. Төлөвлөгөөт ажил, үйлчилгээ, арга хэмжээний биелэлт тус бүрд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэхэд нийт хэрэгжилт 94.8 хувьтай гарсан бөгөөд төлөвлөлт, түүний биелэлт, хэрэгжилтийн байдал байгууллагын төсөв, санхүү, дотоод үйл ажиллагаа “бүрэн хангалттай” үр дүнд хүрлээ.

Хэрэгжүүлсэн нийт арга хэмжээний зорилт, арга хэмжээ нь зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн 100 хувийн хэрэгжилттэй 48, зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан 90.0-99.4 хувийн хэрэгжилттэй 10, тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, гүйцэтгэл нь 70.0-74.0 хувийн хэрэгжилттэй 8 арга хэмжээ байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар НД-ын шимтгэлийн орлого 2,379.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2,668.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 112.1 хувиар биелүүлж, 2868.1 мянган хүн /давхардсан тоогоор/-д тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 3,415.7 тэрбум төгрөг зарцуулав.

График 1. НДС-ийн төсвийн гүйцэтгэл /тэрбум.төг/



ЗГ-ын 2022 оны "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 63 дугаар тогтоолын дагуу тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж, НДС-аас болон цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу олгож байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар тус тус нэмэгдүүлэн, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, нэмэгдсэн тэтгэврийг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгож эхэллээ. Уг арга хэмжээнд 469.2 мянган тэтгэвэр авагч хамрагдаж, тэтгэврийн нэмэгдэлд 637.4 тэрбум төгрөг зарцуулсны дүнд дундаж тэтгэвэр 555.6 мянган төгрөгт хүрэв.

График 2. Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо /мян.хүн/




График 3. Тэтгэвэр, тэтгэмж авагчдын бүтэц /хувиар/







НД-ын салбарын 2022 оны зорилтот түвшин хангагдаж, эдийн засгийн идэвхтэй хүн амд НД-д даатгуулагчдын эзлэх хувь хэмжээ, нийт даатгуулагчдын тоо, үүнээс: албан журмаар даатгуулагчдын тоо, НД-ын үйлчилгээ авсан хүний тоо зэрэг 2022 оны хөгжлийн үзүүлэлтүүд өссөн дүнтэй байна.



2022 оны байдлаар нийгмийн даатгалд 1.1 сая иргэн албан журмаар, 164.5 мянган иргэн сайн дураар даатгуулж хүний амьдралд учирч болох гэнэтийн болон жам ёсны эрсдэлээ НДС-тай хуваалцаж байна.

### 15 наснаас эхлэн нийгмийн даатгалд даатгуулах боломжтой:

- Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан нийгмийн даатгалд албан журмаар даатгуулна.
- Оюутан, суралцагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, ажилгүй иргэн зэрэг албан журмаар даатгуулснаас бусад иргэн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах боломжтой.



2022 онд 7.2 мянган даатгуулагч ХЧТА-ы тэтгэмжид 36.0 тэрбум төгрөг авсан байна.

Даатгуулагч нь ердийн өвчин, ахуйн осол эсвэл үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан тохиолдолд **хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж** авах эрхтэй.



Даатгуулагч эх **жирэмсний болон амаржсаны тэтгэмж** авах эрхтэй.

Даатгуулагч эх хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаандаа дахин хүүхэд төрүүлэх бүрт жирэмсний болон амаржсаны тэтгэмж авна.

2022 онд 58.5 мянган даатгуулагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмжид 121.1 тэрбум төгрөг авсан байна.



2022 онд 62.2 мянган даатгуулагч тахир дутуугийн тэтгэвэрт 316.7 тэрбум төгрөг авсан байна.

**Тахир дутуу** болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл **тэтгэвэр авах** эрхтэй.



2022 онд 30.5 мянган даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмжид 78.6 тэрбум төгрөг авсан байна.

Даатгуулагч ажилгүй болоход **ажилгүйдлийн тэтгэмж, мэргэжил олгох, давтан сургалтын зардал** авах эрхтэй.



2022 онд 0.01 мянган даатгуулагч хөдөлмөрийн чадвараа нөхөн сэргээхтэй холбоотой төлбөр, зардал, хөнгөлөлт, шимтгэлийн зардалд 10 сая төгрөг авсан байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч хиймэл эрхтэн, засал эмчилгээ /протез, ортопед/ хийлгэх, тэтгэврийн даатгалын шимтгэлээ төлүүлэх, рашаан сувилалд эмчлүүлэхэд буюу **хөдөлмөрийн чадвараа нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр** авах эрхтэй.



2022 онд 14.2 мянган даатгуулагчийн ар гэрт оршуулгын тэтгэмжийн зардалд 14.2 тэрбум төгрөг олгосон

Даатгуулагч нас барсан тохиолдолд түүний ар гэрт оршуулгын тэтгэмж олгоно.



Даатгуулагч нас барсан тохиолдолд түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүд **тэжээгчээ алдсаны тэтгэвэр** авах эрхтэй.

2022 онд 19.6 мянган даатгуулагчийн гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тэжээгчээ алдсаны тэтгэврийн зардалд 103.7 тэрбум төгрөг олгосон байна.



2022 онд 372.0 мянган даатгуулагч өндөр насны тэтгэвэртээ 2,408.0 тэрбум төгрөг авсан байна.

Даатгуулагч **өндөр насны тэтгэврийг** насан туршдаа авна.

Нийгмийн даатгалын сангаас 2022 онд нийт **772.4 мянган даатгуулагчид** нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж, тэдний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд **3,311.8** тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

НД-ын нэгдсэн мэдээллийн санд 55.4 мянган ажил олгогч, 1104.8 мянган албан журмын, 164.5 мянган сайн дураар даатгуулагч, 555.6 мянган тэтгэвэр авагчийг хамруулаад байгаа бөгөөд төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан 18 байгууллагатай холбогдох мэдээллийг тогтмол солилцож байна.

График 4. Даатгуулагчдын тоо /мян.хүн/




Тэтгэмжийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсэн болон амаржсаны, ажилгүйдлийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн үйлчилгээг цахимжуулахтай холбогдуулан төрийн мэдээлэл солилцооны ХУР системд 10 төрлийн, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia-д 5 төрлийн мэдээллийг шинээр боловсруулан оруууллаа.

НД-ын нийт 34 үйлчилгээнээс цахим НД-ын дэвтэр, тэтгэврийн дэвтэр, архив, шимтгэл төлөлт, шимтгэлийн тайлан гаргах, хүлээн авах, лавлагаа, тодорхойлолт гаргах, тэтгэвэр тэтгэмжийн тооцоолол хийх, өөрчлөлт оруулах, авах зэрэг 24 үйлчилгээг цахимжуулаад байна. Үүнд:

1. Цахим архивын үйлчилгээ;
2. НД-д сайн дураар даатгуулах гэрээ цахимаар байгуулах, сунгах;
   - Гар утасны аппликэйшн ашиглах /нийгмийн даатгал/
   - Цахим систем ашиглах /www.ndaatgal.mn/
3. НД-ын шимтгэлийг цахимаар төлөх;
   - НД-ын болон Банкны аппликэйшн ашиглах
   - Интернэт банк
   - Мобайл банк

- Qpay систем ашиглах
- Цахим систем ашиглах /www.ndaatgal.mn/

4. НД-ын шимтгэлийн тайланг цахимаар гаргах, хүлээн авах;
    - Цахим систем ашиглах /www.ndaatgal.mn/
5. НД-ын лавлагаа, мэдээлэл, тодорхойлолт цахимаар авах;
    - Цахим систем ашиглах /www.ndaatgal.mn, E-mongolia/
    - ТҮЦ машинаар
    - Гар утасны аппликейшн /нийгмийн даатгал, E-mongolia/
    - Call center төвөөс /1800-0724, 7777-1289/
6. Ажил олгогч шимтгэл төлөлтийн тодорхойлолт цахимаар авах;
7. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа;
8. Өндөр насны тэтгэврийн цахим өөрчлөлт;
9. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн цахим өөрчлөлт;
10. Тэжээгчээ алдсаны тэтгэврийн цахим өөрчлөлт;
11. Цахим нийгмийн даатгалын дэвтэр;
12. Цахим тэтгэврийн дэвтэр;
13. Өргөдөл гомдлыг цахимаар хүлээн авч шийдвэрлэх;
14. Өндөр насны тэтгэвэр олгох;
15. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр олгох;
16. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох;
17. Эмнэлгийн хөдөлмөр магадлах комиссын үйл ажиллагаа олгох, хувь хэмжээ, хугацаа сунгах;
18. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох;
19. Жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгох;
20. Ажилгүйдлийн тэтгэмж олгох;
21. Эмнэлгийн хуудас олгох;
22. Өндөр насны тэтгэвэр тогтоолтын хуудас;
23. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас;
24. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас.




НД-ын гар утасны аппликейшнийг 250.0 мянга орчим даатгуулагч идэвхтэй хэрэглэж байна. Тайлангийн хугацаанд 3555 иргэнд баталгаажуулалтын нууц дугаарыг цахим хэлбэрээр олгож, утсаар 1402 иргэнд заавар зөвлөгөө өгсөн.

“Даатгуулагчид зориулсан веб” системийг ашиглан нийтдээ 69.9 мянган даатгуулагч сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, төлбөрөө төлөх үйлчилгээнд хамрагдсан бөгөөд “Даатгуулагчид зориулсан веб” систем, “Нийгмийн даатгал” аппликейшн, “Нэгдсэн лавлагааны програм”-аас нийтдээ 2.4 сая орчим QR кодтой шимтгэл төлөлтийн лавлагаа тодорхойлолт авсан байна.

Төрийн үйлчилгээний 109 ТҮЦ машинаар үзүүлж буй үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэн даатгуулагч 2000-2005 оны НД-ын шимтгэл төлөлтийн

тодорхойлолтоо авах боломжийг нэмж бүрдүүлсэн. Тайлангийн хугацаанд 156.9 мянган иргэн ТҮЦ машинаас 4 төрлийн лавлагаа тодорхойлолтоо хэвлэн авсан байна.

НДБ-д цахимаар нийтдээ 5803, үүнээс: www.ndaatgal.mn вебсайтын “Санал хүсэлт” буланд 178 санал хүсэлт, асуулт, “Нийгмийн даатгал” аппликейшнээр 5085 санал хүсэлт, ЗГ-ын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд 540 иргэдээс асуулт, хүсэлт ирүүлснийг ажлын 5 хоногт багтаан хариуг хүргүүлж ажиллалаа.




НДҮЗ нь 2022 онд нийт 8 удаа хуралдан 17 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 7 тогтоол батлан гаргасан. Эдгээр тогтоолуудаас “Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, “Нэрийн дансны 2022 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” гэсэн нийтээр заавал дагаж мөрдүүлэх 2 тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэв.

НДҮЗ-ийн 04 дүгээр тогтоолоор нас барагчийн ар гэрт олгох тэтгэмжийн хэмжээг хоёр сая төгрөгөөр шинэчлэн, амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг гурван сая таван зуун мянган төгрөгөөр тус тус тогтоож, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр шийдвэрлэлээ. Ийнхүү 2016 оноос хойш 6 жилийн дараа оршуулгын тэтгэмжийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж, амьгүй донор болсон даатгуулагчийн ар гэрт оршуулгын тэтгэмжийг анх удаа олгох болсон нь хүндээр өвчилсөн хүний амь насыг аврах, буяны үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ын үнэ тариф нэмэгдсэн энэ үед нас барсан иргэдийн оршуулгын үйл ажиллагааг явуулахад нь чухал ач холбогдолтой шийдвэр болов.

Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл, үзэл баримтлалын шинэчлэлийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулан ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэв. УИХ-ын 2022 оны намрын чуулганаар хуулийн төслийг хэлэлцэхээр

шийдвэрлэсэн бөгөөд хуулийн төсөлд олон нийтээс санал авах, хэлэлцүүлэг хийх үйл ажиллагааг зохион байгуулж байна.

## ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО

НДБ нь НДҮЗ, Ажлын алба, НД-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүрэг, БНСУ дахь НД-ын газар, хэлтэс, тасаг, НД-ын байцаагч, ажилтнаас бүрддэг.

НДҮЗ нь УИХ-аас томилогдсон ЗГ, Даатгуулагч, Ажил олгогчийг төлөөлсөн тус бүр 3, нийт 9 гишүүнтэй.

НДҮЗ-ийн Ажлын алба нь УИХ-ын НББСШУБХ-ны 2018 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан 12 орон тоотойгоор ажиллаж байна. Ажлын алба нь Нийгмийн даатгалын хууль тогтоомжоор хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэх, НД-ын асуудлаар шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл, судалгаа, дүгнэлт гаргуулах, гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, НД-ын үйл ажиллагаанд хяналт тавих, Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад туслах чиг үүрэгтэй ажилладаг.

ЗГ-ын “Агентлаг байгуулах тухай” 2017 оны 344 дүгээр тогтоол, НДҮЗ-ийн 2018 оны 04 дүгээр тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, орон тоог батлах тухай” 2018 оны А/25 дугаар тушаалын дагуу нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага НДЕГ нь 6 газар, 5 хэлтэс, дэргэдээ 2 төвтэй, нийт 111 албан хаагчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Аймаг, нийслэл, дүүргийн 31 газар, хэлтэст НД-ын бодлогын хэрэгжилтийг хангах, НД-ын үйлчилгээг иргэд даатгуулагчдад үзүүлэх чиг үүрэг бүхий 1293, салбарын хэмжээнд нийт 1416 албан хаагч, улсын байцаагчид ажиллаж байна.

График 5. НДБ-ын бүтэц



# ДӨРӨВ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 4.1 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэн эрх

1994 онд Нийгмийн даатгалын тухай багц хуулийг шинээр баталж, ЗГ, ажил олгогч, даатгуулагч гэсэн 3 талын оролцоотой, зах зээлийн харилцааны жишигт нийцсэн, орлогоороо зарлагаа нөхөж ажиллах даатгалын санг бүрдүүлэн, НДС-ийн үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалтыг хянаж, нэгдсэн удирдлагаар хангах зорилго бүхий 3 талын төлөөллөөс бүрдсэн НДҮЗ-тэй байхаар хуульчилсан.

Энэ нь НД-ын харилцаанд оролцогч талуудын тэгш оролцоог хангаж, даатгуулагчдынхаа эрх ашгийг хамгаалсан, бие даасан, тогтвортой үйл ажиллагаатай даатгалын байгууллагыг бэхжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн оновчтой удирдлагын хэлбэр юм.

НДҮЗ-ийн гишүүдийг УИХ-аас 6 жилийн хугацаатай томилдог ба Үндэсний зөвлөл нь ЗГ-ыг төлөөлсөн 3, ажил олгогчийг төлөөлсөн 3, даатгуулагчийг төлөөлсөн 3, нийт 9 гишүүнтэй, Ажлын албатайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

НДҮЗ нь хууль эрх зүйн хүрээнд даатгуулагч иргэдийнхээ ашиг сонирхолд нийцсэн тогтоол шийдвэрүүдийг гаргаж, салбарынхаа тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, цаашид НД-ын тогтолцоог боловсронгуй болгож, даатгалын сангуудыг бие даасан тогтвортой байдлаар хөгжих боломжуудыг судлан, хэрэгжүүлэхээр ажиллаж ирлээ.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг, УИХ-ын НББСШУБХ-ны 2018 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу Үндэсний зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, НД-ын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох, тэтгэвэр нэмэгдүүлэх талаар санал боловсруулж, холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх;
- Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлт болон НДС-ийн орлого зарлагын байдалд хяналт тавих;
- НД-ын үйл ажиллагаа, боловсон хүчний хангалт, санхүүгийн асуудлаар НДБ-ын тайлан мэдээллийг сонсон хэлэлцэж, санал дүгнэлт гаргаж, энэ талаар холбогдох арга хэмжээ авах;
- НДБ-ын цахим тооцоолуурын техник, технологи, програм хангамж, үйлчилгээний байдлыг хянаж үнэлэлт, дүгнэлт өгөх;
- НД-ын төв байгууллагын бүтцийг батлах, НДС-ийн төсвийн төслийг боловсруулах, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг баталж, гүйцэтгэлд нь хяналт тавих;
- НД-ын асуудлаар журам, зөвлөмж гаргах;

- Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс болон гомдлын шаардлагын зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар түүнд хяналт тавих;
- НД, эмнэлэг хөдөлмөрийн магадалгааны асуудлаар иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг барагдуулах зэрэг хууль тогтоомжид заасан бусад тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

## 4.2 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт Үндэсний зөвлөлийн дарга, гишүүдийг талуудын санал болгосноор УИХ нэр дэвшигчийн сонсгол хийж 6 жилийн хугацаагаар томилох бөгөөд Үндэсний зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

1. Засгийн газрыг төлөөлж сангийн, хууль зүйн, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус бүр 1 хүн;
2. Даатгуулагчийг төлөөлж нийт ажилтны дийлэнх олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалсан үйлдвэрчний эвлэлийг төлөөлсөн 3 хүн;
3. Ажил олгогчийг төлөөлсөн 3 хүн.

График 6. НДҮЗ-ийн бүтэц



### 4.3 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаан

УИХ-ын НББСШУБХ-ны 2018 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батлагдсан НДҮЗ-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт "Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна" гэж заасны дагуу НДҮЗ нь 2022 онд нийт 8 удаа хуралдан 17 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 7 тогтоол батлан гаргасан. Эдгээр тогтоолуудаас "Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" болон "Нэрийн дансны 2022 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай" гэсэн нийтээр заавал дагаж мөрдүүлэх 2 тогтоолыг баталж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэв.





***Капитал банкны өр төлбөрт хөрөнгө авахаар шийдвэрлэлээ***

НДҮЗ-ийн 01 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалт, Улсын Их Хурлын 2020 оны "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай" 32 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.8 дахь хэсэг, МУ-ын ЗГ-ын 2021 оны 07 дугаар сарын 07, 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, ТӨБЗГ-ын 2021 оны 07 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн зөвшөөрлийг тус тус үндэслэн КЭХА-аас 25.9 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 86 ширхэг үл хөдлөх хөрөнгийг НДС-ийн нэхэмжилсэн өр төлбөрт суутган авахыг зөвшөөрлөө. 2022 онд хөрөнгийн нээлттэй дуудлага худалдааг нийт 8 удаа зохион байгуулж, 20 хөрөнгийг 6.2 тэрбум төгрөгөөр зарж, орлогыг НДС-д төвлөрүүлсэн байна.

***Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн хуваарьт 3 удаа өөрчлөлт оруулж, мөрдүүлэв***

НДҮЗ-ийн 02, 03, 05 дугаар тогтоолуудаар Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хууль, Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.6 дахь заалтыг үндэслэн тэтгэвэр авагчдын тэтгэврийн нэмэгдэлд

зарцуулахаар батлагдсан хөрөнгийн эх үүсвэрт шаардагдах хөрөнгийг тэтгэврийн даатгалын сангийн өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан орлогоос буюу харилцахын мөнгөн хөрөнгөөс зарцуулахыг НДЕГ-т зөвшөөрч, 2022 оны НДС-ийн болон аймаг, дүүргийн НДС-ийн төсвийн хуваарьт 3 удаа холбогдох өөрчлөлтүүдийг оруулж, тодотгосон төсвийн хуваарийг шинэчлэн батлаж, мөрдүүлэв.

***Оршуулгын тэтгэмжийн хэмжээг 6 жилийн дараа 2 дахин нэмэгдүүллээ***

НДҮЗ-ийн 04 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн $21^1$ дүгээр зүйл, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 24 дүгээр зүйл, ХНХЯ-ны саналыг тус тус үндэслэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан оршуулгын тэтгэмжийн болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмжийн хэмжээг хоёр сая төгрөгөөр шинэчлэн, амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг гурван сая таван зуун мянган төгрөгөөр тус тус тогтоож, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр шийдвэрлэлээ. Ийнхүү 2016 оноос хойш 6 жилийн дараа оршуулгын тэтгэмжийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж, амьгүй донор болсон даатгуулагчийн ар гэрт оршуулгын тэтгэмжийг анх удаа олгох болсон нь хүндээр өвчилсөн хүний амь насыг аврах, буяны үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ын үнэ тариф нэмэгдсэн энэ үед нас барсан иргэдийн оршуулгын үйл ажиллагааг явуулахад нь чухал ач холбогдолтой шийдвэр болов.

***Нэрийн дансны 2022 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг 9.8 хувиар тогтоолоо***

НДҮЗ-ийн 07 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын хууль тогтоомж болон ҮСХ-оос ирүүлсэн саналыг үндэслэн даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2022 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 9.8 хувиар тогтоон холбогдох арга хэмжээг авч ажиллахыг НДЕГ-т үүрэг болгов.

***Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн хуваарийг батлаж хүргүүлэв***

НДҮЗ-ийн 06 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.6 дахь заалтыг үндэслэн тэтгэвэрт зарцуулах хөрөнгийн эх үүсвэрт шаардагдах 214.5 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын сангийн, ажилгүйдлийн даатгалын сангаас олгох тэтгэмжид зарцуулах хөрөнгийн эх үүсвэрт шаардагдах 24.4 тэрбум төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангийн харилцахын мөнгөн хөрөнгөөс зарцуулахыг НДЕГ-т зөвшөөрч, 2023 оны НДС-ийн болон аймаг, дүүргийн НДС-ийн төсвийн хуваарийг тус тус баталж, холбогдох газруудад хүргүүлэв.

# ТАВ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ХАМРАЛТ

## 5.1 Нийгмийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд 3,301.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталсан. Үүнд:

- НД-ын шимтгэлийн орлого 2,379.9 тэрбум төгрөг;
- ЭМДС-аас санхүүжих 1.1 тэрбум төгрөг;
- Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 920.9 тэрбум төгрөгөөр баталсан болович Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” 239 дүгээр тушаалын 8 дугаар хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн сар, улирлын хуваарь”-иар улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 76.1 тэрбум төгрөгөөр бууруулж 844.7 тэрбум төгрөг болгосон.

Нийт зарлага 3,511.7 тэрбум төгрөг. Үүнд:

- Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардалд 3,403.4 тэрбум төгрөг;
- НДБ-ын үйл ажиллагааны зардалд 32.2 тэрбум төгрөг,
- УИХ-ын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хуулийн дагуу Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд даатгуулагчаас төлсөн НД-ын шимтгэлийн 50 хувийн буцаан олголтод 150.8 тэрбум төгрөгийг баталсан болович Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” 239 дүгээр тушаалаар тухайн зардлыг 76.1 тэрбум төгрөгөөр бууруулж, 74.7 тэрбум төгрөг болгосон.

График 7. НДС-ийн төсөв /тэрбум.төг/



## 5.2 Нийгмийн даатгалын сангийн орлого

НДС-д тайлангийн хугацаанд шимтгэлийн орлого 2,379.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2,668.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 112.1 хувиар биелүүлсэн. /Энэ дунд ЭМДС-аас санхүүжих 1.1 тэрбум, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 844.7 тэрбум төгрөг ороогүй/

График 8. НДС-ийн орлогын бүтэц /хувиар/




НДС-ийн нийт орлогын 55.1 хувь буюу 1,471.6 тэрбум төгрөгийг ажил олгогч, 44.3 хувь буюу 1,182.2 тэрбум төгрөгийг даатгуулагчийн төлсөн шимтгэл, 0.6 хувь буюу 14.8 тэрбум төгрөгийг ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн шимтгэлийн орлого болон бусад орлого эзэлж байна.

Хүснэгт 1. НДС-ийн орлогын биелэлт /тэрбум.төг/

| № | Орлогын төрөл | 2021 | 2022 |
|---|---|---|---|
| 1 | Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг | 593.9 | 842.8 |
| 2 | Ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагаас | 790.4 | 1,182.0 |
| 3 | Төсөвт газраас | 343.4 | 289.5 |
| 4 | Даатгуулагчаас | 854.7 | 1,068.1 |
| 5 | Сайн дурын даатгуулагчаас | 137.5 | 111.7 |
| 6 | Гадаадад ажиллаж буй иргэдийн | 2.6 | 2.5 |
| 7 | ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн | 1.7 | 1.5 |
| 8 | ЭМДС-аас санхүүжих | 1.1 | 1.1 |
| 9 | Бусад орлого | 6.7 | 13.3 |
| | **Нийт** | **2,732.0** | **3,512.5** |

Мөн орлогын 24.0 хувь буюу 842.8 тэрбум төгрөгийг тэтгэврийн болон ҮОМШӨ-ний даатгалын санд улсын төсвөөс, 0.03 хувь буюу 1.1 тэрбум төгрөгийг ЭМДС-аас шилжүүлсэн санхүүжилтийн орлого тус тус эзэлж байна.

Хүснэгт 2. НДС-ийн 2022 оны орлогын гүйцэтгэл /тэрбум.төг, хувиар/

| № | Орлого | Мөнгөн дүн /тэрбум.төг/ | Нийт орлогод эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Тэтгэврийн даатгалын сан | 3,013.2 | 85.8 |
| 2 | Тэтгэмжийн даатгалын сан | 236.9 | 6.8 |
| 3 | ҮОМШӨ-ний даатгалын сан | 208.8 | 5.9 |
| 4 | Ажилгүйдлийн даатгалын сан | 53.6 | 1.5 |
| | **Нийт** | **3,512.5** | **100** |

## Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага

**2,668.6** тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг **112.1** хувиар биелүүллээ.

**734.7** мянган хүний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт НДС-аас **3,197,2** тэрбум төгрөг олголоо.

### 5.3 Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт

НДС-ийн зардлын төсөв 3,435.6 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд 3,384.5 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт, 31.2 тэрбум төгрөгийг НДБ-ын үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулсан.

Хүснэгт 3. НДС-ийн 2022 оны зарлагын гүйцэтгэл /тэрбум.төг, хувиар/

| № | Зардал | Мөнгөн дүн /тэрбум.төг/ | Нийт зардалд эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Тэтгэврийн даатгалын сан | 3,031.3 | 88.7 |
| 2 | Тэтгэмжийн даатгалын сан | 165.9 | 4.9 |
| 3 | ҮОМШӨ-ний даатгалын сан | 35.9 | 1.1 |
| 4 | Ажилгүйдлийн даатгалын сан | 78.7 | 2.3 |
| 5 | ДТШ 50 хувийн буцаалт | 72.7 | 2.1 |
| 6 | Үйл ажиллагааны зардал | 31.2 | 0.9 |
| | **Нийт** | **3,415.7** | **100.0** |

НДС-ийн зарлага өмнөх оны мөн үеэс 850.2 тэрбум төгрөг буюу 33.1 хувиар өссөн.

Хүснэгт 4. НДС-ийн 2022 онд зарцуулсан мөнгөн дүн, үйлчлүүлсэн хүний тоо /мян.хүн, тэрбум.төг/

| № | Нийгмийн даатгалын сан | 2020 он | | 2021 он | | 2022 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Тэтгэврийн | 437.1 | 2,153.6 | 455.5 | 2,281.8 | 473.8 | 3,031.3 |
| 2 | Тэтгэмжийн | 191.2 | 145.4 | 364.5 | 169.4 | 260.9 | 165.9 |
| 3 | ҮОМШӨ-ний | 7.6 | 31.6 | 5.7 | 30.7 | 7.2 | 35.9 |
| 4 | Ажилгүйдлийн | 21.3 | 94.4 | 26.2 | 57.0 | 30.5 | 78.7 |
| 5 | ДТШ 50 хувийн буцаалт | - | - | - | - | 2087.7 | 72.7 |
| 6 | Үйл ажиллагааны зардал | | 26.8 | | 26.6 | | 31.2 |
| | **Нийт** | **657.2** | **2,451.8** | **851.9** | **2,565.5** | **2,860.1** | **3,415.7** |

НДС-аар үйлчлүүлсэн иргэдийн тоо өмнөх оныхоос 2008.2 мянга буюу 70.2 хувиар өссөн нь "Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай" хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд давхардсан тоогоор 2087.7 мянган даатгуулагчдад 72.7 тэрбум төгрөгийг олгосон, НДБ-ын үйл ажиллагааны зардал 4.6 тэрбум төгрөг буюу 17.3 хувиар тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.




### 5.4 Нийгмийн даатгалын хамралт

| 2021 он | 2022 он |
|---|---|
| **1177.8** мянган даатгуулагч | **1269.3** мянган даатгуулагч |

Нийгмийн даатгалд 2022 оны байдлаар **1269.3 мянган** даатгуулагч хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад **7.7%**-иар нэмэгдсэн байна.

НД-ын мэдээллийн санд 2022 оны жилийн эцсийн байдлаар 55.4 мянган ААНБ бүртгэгдсэн нь 2021 онтой харьцуулахад 2.7 мянган ажил олгогч буюу 5.1 хувиар нэмэгдсэн.

График 9. НД-ын хамралт /мян.хүн/




Мөн албан журмын 1104.8 мянган даатгуулагч хамрагдсан нь нийт ажиллах хүчний 90.3 хувийг эзэлж байна. /ҮСХ-ны 2022 оны 4-р улирлын мэдээгээр нийт ажиллах хүчний тоо 1222.8 мянган хүн/

## ЗУРГАА. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОЖ БУЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨР, ЗАРДАЛ

### 6.1 Тэтгэвэр олголт

2022 онд тэтгэврийн даатгалын сангаас нийт 473.8 мянган иргэнд 3,030.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон. Нийгмийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө буюу 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон 45.1 мянган тэтгэвэр авагч, 20.0 мянган цэргийн албан хаагчдын тэтгэвэрт 453.3 тэрбум төгрөг зарцуулсан.

Хүснэгт 5. Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/

| № | Тэтгэврийн төрөл | 2020 он | | 2021 он | | 2022 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Өндөр насны | 332.9 | 1,663.9 | 353.2 | 1,789.6 | 372.0 | 2,408.0 |
| 2 | Тахир дутуугийн | 65.9 | 255.8 | 63.1 | 247.7 | 62.2 | 316.7 |
| 3 | Тэжээгчээ алдсаны | 19.2 | 77.6 | 19.5 | 77.1 | 19.6 | 103.7 |
| 4 | Цэргийн | 19.1 | 153.7 | 19.7 | 162.7 | 20.0 | 201.8 |
| **Нийт** | | **437.1** | **2,151.0*** | **455.5** | **2,277.1*** | **473.8** | **3,030.2*** |

*Үйл ажиллагааны зардал, бусад зардал болон ДТШ 50 хувийн буцаалтын дүн ороогүй болно.

График 10. Тэтгэврийн зарлага /тэрбум.төг/




Тэтгэврийн даатгалын сангийн зардал өмнөх оноос 753.1 тэрбум төгрөг буюу 33.1 хувиар өссөн.

График 11. Тэтгэвэр авагчдын бүтэц /хувиар/




Нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 7.9 хувь нь хувь тэнцүүлсэн тэтгэвэр, 92.1 хувь нь бүрэн тэтгэвэр авч байна.

НДС-аас олгож буй бүрэн тэтгэврийн доод хэмжээ 500.0 мянган төгрөг байгаа нь амьжиргааны доод түвшингээс 79.9 хувиар илүү байна. /ҮСХ-ны 2022 оны мэдээллээр Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны доод түвшин сарын 277.8 мянган төгрөг/




График 12. Тэтгэврийн доод болон дундаж хэмжээ /мян.төг/




Улсын хэмжээгээр дундаж тэтгэврийн хэмжээ өмнөх оноос 30.8 хувиар өссөн.

## 6.2 Тэтгэмж олголт

Тэтгэмжийн даатгалын сангаас 260.9 мянган даатгуулагчдад 165.9 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгожээ.

Хүснэгт 6. Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/

| № | Тэтгэмжийн төрөл | 2020 он | | 2021 он | | 2022 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Хөдөлмөрийн чадвар түр алдсаны | 113.7 | 20.2 | 179.7 | 30.4 | 162.3 | 27.4 |
| 2 | Жирэмсний болон амаржсаны | 64.6 | 109.9 | 64.9 | 119.3 | 58.5 | 121.1 |
| 3 | Оршуулгын | 12.9 | 12.9 | 16.2 | 16.2 | 14.2 | 14.2 |
| 4 | Эхийн хүүхдээ асрах чөлөөтэй байсан хугацааны шимтгэл | 83.7 | 2.2 | 103.7 | 3.2 | 25.9 | 3.2 |
| | **Нийт** | **274.9** | **145.2*** | **364.5** | **169.1*** | **260.9** | **165.9*** |

*Үйл ажиллагааны зардал, бусад зардал болон ДТШ 50 хувийн буцаалтын дүн ороогүй болно.

График 13. Тэтгэмжийн зарлага /тэрбум.төг/




Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.2 тэрбум төгрөг буюу 1.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

### 6.3 ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгосон төлбөр, зардал

2022 оны жилийн эцсийн байдлаар 7.2 мянган даатгуулагчдад тахир дутуугийн, тэжээгчээ алдсан, ХЧТА, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувиллын зардалд ҮОМШӨ-ний даатгалын сангаас 36.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан.

Хүснэгт 7. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/

| № | Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл | 2020 он | | 2021 он | | 2022 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Тахир дутуугийн тэтгэвэр | 3.9 | 24.8 | 3.7 | 24.4 | 3.5 | 27.5 |
| 2 | Тэжээгчээ алдсаны тэтгэвэр | 0.5 | 2.9 | 0.5 | 2.9 | 0.5 | 3.4 |
| 3 | ХЧТА-ны тэтгэмж | 1.1 | 0.9 | 0.7 | 0.7 | 1.2 | 1.3 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр | 0.02 | 0.02 | 0.01 | 0.08 | 0.01 | 0.01 |
| 5 | Рашаан сувиллын зардал | 2.1 | 0.6 | 0.8 | 0.2 | 2.0 | 1.1 |
| 6 | Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал | - | 0.7 | - | 0.7 | - | 1.1 |
| 7 | Тахир дутуугийн тэтгэвэр авагчдын тэтгэврийн даатгалын шимтгэл | - | 1.6 | - | - | - | 1.5 |
| | **Нийт** | **7.6** | **31.5*** | **5.7** | **29.0*** | **7.2** | **36.0*** |

*Үйл ажиллагааны зардал, бусад зардал болон ДТШ 50 хувийн буцаалтын дүн ороогүй болно.

График 14. ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага /тэрбум.төг/




ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 7.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

**6.4 Ажилгүйдлийн тэтгэмж олголт**

2022 онд ажилгүйдлийн даатгалын сангаас 30.5 мянган даатгуулагч 78.6 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж авсан байна.

График 15. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн




## ДОЛОО. ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ

### 7.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

2022 оны жилийн эцсийн байдлаар МУ-ын Засгийн газрын тогтоол, МУ-ын Ерөнхий сайдын захирамж, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл, МУ-ын Ерөнхий сайдын албан даалгавар, НДҮЗ-ийн тогтоолын нийт 52 шийдвэрийн 81 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 90.2 хувьтай байна. Үүнд:

- МУ-ын ЗГ-ын тогтоолын 21 шийдвэрийн 30 заалтаас 11 шийдвэрийн 20 заалт бүрэн хэрэгжиж, 2 шийдвэрийн 2 заалт 90 хувийн биелэлттэй, НДБ-ын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх боломжгүй хасуулах саналтай 2 шийдвэрийн 2 заалт, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 6 шийдвэрийн 6 заалт;
- МУ-ын Ерөнхий сайдын 2 захирамжийн 4 заалт бүрэн хэрэгжиж 100 хувийн биелэлттэй;
- ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн 18 шийдвэрийн 26 заалтаас 13 шийдвэрийн 20 заалт бүрэн хэрэгжиж, НДБ-д хамааралгүй байгаа тул хасуулах саналтай 2 шийдвэрийн 3 заалт, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 3 шийдвэрийн 3 заалт;
- МУ-ын Ерөнхий сайдын албан даалгавар 1 шийдвэрийн 1 заалт бүрэн хэрэгжиж 100 хувийн биелэлттэй;
- НДҮЗ-ийн 7 тогтоолын 17 заалт бүрэн хэрэгжиж 100 хувийн биелэлттэй;
- Бусад хамтарсан тушаалын 3 заалт бүрэн хэрэгжиж 100 хувийн биелэлттэй байна.

### 7.2 Нийгмийн даатгалын хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

***Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж байна.***

Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл, үзэл баримтлалын шинэчлэлийн хүрээнд 2021 онд Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулан ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлээд байсан юм. Гэвч Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсний дараа УИХ-аас Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж, ЗГ-аас 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн НДС-аас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авч байгаа тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг 15-43 хувиар нэмэгдүүлсэн нь өргөн мэдүүлсэн багц хуулийн төсөлд тусгасан зарим зүйл, заалтыг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүссэн. Мөн УИХ дахь олонхын бүлгээс хуулийн төслүүдийг хуримтлалын нэгдсэн сантай уялдуулж дахин боловсруулах чиглэл өгсөн, ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон зэрэг шалтгааны улмаас Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийг буцаан татан авч, үүссэн нөхцөл байдалд нийцүүлэн дахин боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэв. УИХ-ын 2022 оны намрын чуулганаар хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэсэн бөгөөд хуулийн төсөлд олон нийтээс санал авах, хэлэлцүүлэг хийх үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд НД-ын тогтолцоо, зарчим, төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, НД-д даатгуулах, шимтгэл төлөх, НДС бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавих болон НД-ын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох харилцааг тусгана. Мөн НД-ын тогтолцооны зарчим, даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлага, мэдээллийн нэгдсэн сан, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын итгэлцүүр, шимтгэлийг нөхөн төлүүлэх, буцаан олгох, тэтгэврийн нөөц санг байгуулах, нэрийн дансны бүртгэлийг мөнгөжүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх, шимтгэлийн өр, хөөн хэлэлцэх хугацааг тогтоох, НДС-ийн хэтийн тооцоолол хийх, сангийн эрсдэлийг үнэлэх, санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий мэргэжлийн хороог ажиллуулах зэрэг шинэ зохицуулалтыг тусгалаа.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлд олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, ахмад настан бүрд суурь тэтгэвэр олгох, иргэн бүр сайн дурын үндсэн дээр хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд даатгуулж, нэмэгдэл тэтгэвэр авах, тэтгэврийг индексжүүлэн нэмэгдүүлэх, хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд шилжих асуудлуудыг тусгалаа.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөлд НДС-аас олгох тэтгэмжийн бүх харилцааг энэ хуулиар бүхэлд нь зохицуулах бөгөөд ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх, донор болсон даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсан, ихэр хүүхэд төрүүлсэн эхийн амаржсаны тэтгэмжийн хэмжээг тус тус нэмэгдүүлэх, ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг ОУХБ-ын стандартад нийцүүлэх, ажил олгогчид 3 жилд нэг удаа 15 хувиар шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхээр зохицуулсан байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төсөлд урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөрийг нэмэгдүүлэх, даатгуулагчийн протез, ортопедын үнийг 3 жил тутамд 1 удаа бүрэн чөлөөлөх, үйлдвэрлэлийн осол гаргаагүй ажил олгогчид 15 хувиар шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх, үйлчилгээг цахимжуулах асуудлууд тусгагдсан.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд МУ-д анх удаа хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, ахмад настнууд ирээдүйд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах, хангалттай орлогын эх үүсвэртэй байх боломжийг олгохоор зохицуулав.

***Тэтгэврийн хэмжээг дахин нэмэгдүүлж, дундаж тэтгэвэр 555.6 мянган төгрөгт хүрлээ.***

ЗГ-ын 2022 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 63 дугаар тогтоолын дагуу тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж, НДС-аас болон цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу олгож байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар тус тус нэмэгдүүлэн, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, нэмэгдсэн тэтгэврийг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгож эхэллээ. Уг арга хэмжээнд 469.2 мянган тэтгэвэр авагч хамрагдаж, тэтгэврийн нэмэгдэлд 637.4 тэрбум төгрөг зарцуулсны дүнд дундаж тэтгэвэр 555.6 мянган төгрөгт хүрлээ.

Энэ арга хэмжээний дүнд 2022 оны 01 дүгээр сарын байдлаар тэтгэвэр авч байсан 469.2 мянган хүний тэтгэвэр дунджаар 130.8 мянган төгрөгөөр, үүнээс бүрэн тэтгэвэр авч байсан 385.1 мянган хүний тэтгэвэр дунджаар 150.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэвэр авч байсан 84.1 мянган хүний тэтгэвэр дунджаар 100.0 мянган төгрөгөөр, дундаж тэтгэвэр 424.8 мянган төгрөгөөс 555.6 мянган төгрөгт хүрч, дунджаар 130.8 мянган төгрөгөөр буюу 30.8 хувиар тус тус нэмэгдсэн.

Нийт тэтгэвэр авагчдын 58.1 хувь нь доод хэмжээ /350 000 төг/-ний тэтгэвэр авч байсан бол тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний дараа тэтгэвэр авагчдын 76.1 хувь нь доод хэмжээ /500 000 төг/ авдаг боллоо. Тэтгэвэр нэмэгдүүлэхийн өмнө бүрэн тэтгэврийн доод хэмжээнээс дээш /350 001-435 000 төгрөг/ тэтгэвэр авч байсан 75.4 мянган хүн, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээнээс дээш /300 001-348 000 төгрөг/ тэтгэвэр авч байсан 4.4 мянган хүн, нийт 79.8 мянган хүний

тэтгэврийн хэмжээ нь тэтгэврийн доод хэмжээ /500 000 төг/-ээр өөрчлөн тогтоогдсон.




## НАЙМ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАХИМЖУУЛАЛТ, ЧАНАР, ХҮРТЭЭМЖ

### 8.1 Мэдээлэл технологийн үйл ажиллагаа

УИХ-аас 2022 онд баталсан хууль тогтоомжийн өөрчлөлт болон хэрэглэгчдийн хүсэлтээр НД-ын үйлчилгээнд шинээр 3 систем, 15 сервис үйлчилгээг нэвтрүүлж, програм хангамжуудад 110 гаруй удаагийн өөрчлөлт хийв.

НД-ын нэгдсэн мэдээллийн санд 55.4 мянган ажил олгогч, 1104.8 мянган албан журмын, 164.5 мянган сайн дураар даатгуулагч, 473.8 мянган тэтгэвэр авагчийн дэлгэрэнгүй мэдээлэл бүхий 74GB мэдээлэл агуулагдаж байгаа бөгөөд тогтмол баяжуулалт хийж, 160 загвараар 250 гаруй удаа мэдээллийн боловсруулалт, судалгаа хийж, хэрэглэгчдийг мэдээллээр хангалаа.

Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан 18 байгууллагатай холбогдох мэдээллийг тогтмол солилцож байна. Тэтгэмжийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсэн болон амаржсаны, ажилгүйдлийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн үйлчилгээг

цахимжуулахтай холбогдуулан төрийн мэдээлэл солилцооны ХУР системд 10 төрлийн, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia-д 5 төрлийн сервисийг шинээр боловсруулан хүргүүлсэн.

### 8.2 Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хөгжүүлэлт, хүртээмж

НД-ын гар утасны аппликейшнийг 250.0 мянга орчим даатгуулагч идэвхтэй хэрэглэж байна. Тайлангийн хугацаанд 3555 иргэнд баталгаажуулалтын нууц дугаарыг цахим хэлбэрээр олгож, утсаар 1402 иргэнд заавар зөвлөгөө өгсөн.

“Даатгуулагчид зориулсан веб” системийг ашиглан нийтдээ 69.9 мянган даатгуулагч сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, төлбөрөө төлөх үйлчилгээнд хамрагдсан бөгөөд “Даатгуулагчид зориулсан веб” систем, “Нийгмийн даатгал” аппликейшн, “Нэгдсэн лавлагааны програм”-аас нийтдээ 2.4 сая орчим QR кодтой шимтгэл төлөлтийн лавлагаа тодорхойлолт авсан байна.

Төрийн үйлчилгээний 109 ТҮЦ машинаар үзүүлж буй үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэн даатгуулагч 2000-2005 оны НД-ын шимтгэл төлөлтийн тодорхойлолтоо авах боломжийг нэмж бүрдүүлсэн. Тайлангийн хугацаанд 156.9 мянган иргэн ТҮЦ машинаас 4 төрлийн лавлагаа тодорхойлолтоо хэвлэн авсан байна.

НДБ-д цахимаар нийтдээ 5803, үүнээс: www.ndaatgal.mn вебсайтын “Санал хүсэлт” буланд 178 санал хүсэлт, асуулт, “Нийгмийн даатгал” аппликейшнээр 5085 санал хүсэлт, ЗГ-ын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд 540 иргэдээс асуулт, хүсэлт ирүүлснийг ажлын 5 хоногт багтаан хариуг хүргүүлж ажиллалаа.

## ЕС. ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАЛ

Улсын хэмжээнд хөдөлмөрийн чадварын алдалтын хувь, хугацаа тогтоолгосон нийт 103235 иргэн байгаагаас НДС-аас 64717 иргэн, НХС-аас 38518 иргэн байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.2 хувиар буурсан байна. Үүнээс: Нийслэлийн хэмжээнд 39586 /38.4%/ иргэн, орон нутгийн хэмжээнд 63649 /61.6%/ иргэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгожээ. Мөн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоолгосон 9778, сунгуулсан 93475, цуцлуулсан 9294, нас барсан 2461, хөдөлмөрийн нөхцөл сольсон 82, ажлын цаг хорогдуулсан 4 иргэн байна.

Тайлангийн хугацаанд нийт 5 удаагийн дахин магадлалаар Сүхбаатар дүүрэг, Говь-Сүмбэр, Дорноговь, Баянхонгор, Сүхбаатар, Баян-Өлгий аймгуудад 1406 иргэнийг дахин магадалж үүнээс: 1025 /79.2%/ иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг хэвээр магадлан, 332 /26.3%/ иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын заалт, хувь, хугацааг өөрчилж, 49 /4%/ иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцлахаар шийдвэрлэлээ. Мөн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгосон даатгуулагч /иргэн/-ийн тоогоор улсын дундаж /3.2/-аас өндөр байгаа Ховд, Архангай, Дорнод аймгуудад ЭМЯ-ны мэргэжлийн салбар зөвлөлүүдтэй хамтарсан магадлал хийж, нийт хөдөлмөрийн чадвар алдсан 2493

иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон байдалд хяналт шалгалт хийж, 1430 даатгуулагч /иргэн/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэвээр магадлан, 223 даатгуулагч /иргэн/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 773 даатгуулагч /иргэн/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, заалт, оношийг тус тус өөрчилж магадлав.

## АРАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Тайлант хугацаанд Өвөрхангай, Сүхбаатар, Төв аймаг, Баянзүрх дүүргийн НДХ-т Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг 2017-2021 онуудын сангийн болон үйл ажиллагааны санхүүгийн баримтууд, тэтгэвэр, тэтгэмжийн хувийн хэрэг болон бусад анхан шатны баримтыг хамруулан шалгалаа.

Хүснэгт 8. Хяналт, шалгалтад хамрагдсан НДХ, зөрчлийн дүн

| Тайлангийн хугацаа | № | Шалгалтад хамрагдсан аймаг, дүүргийн нэр | Илэрсэн төлбөр, зөрчлийн дүн /сая.төг/ | Шалгалтын хэлбэр |
|---|---|---|---|---|
| 2022 он | 1 | Төв аймгийн НДХ | 178.3 | Төлөвлөгөөт хяналт, шалгалт |
| | 2 | Сүхбаатар аймгийн НДХ | 24.1 | |
| | 3 | Өвөрхангай аймгийн НДХ | 0 | |
| | 4 | Баянзүрх дүүргийн НДХ | 1,727.5 | |
| | | **Нийт дүн** | **1,929.9** | |

Дээрх шалгалтаар үндэслэлгүй баримтаар шүүхийн шийдвэр гаргуулсан, хуурамч архивын лавлагаа гаргуулан хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авсан 86 хүнтэй холбоотой 1,834.0 сая төгрөг, байцаагчийн алдаанаас 103 хүнд илүү тооцож олгосон 61.9 сая төгрөг, 50 хүнд дутуу олгосон 44.8 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 44 хүнд үндэслэлгүйгээр олгосон 29.6 сая төгрөг, 1 хүнд дутуу олгосон 1.1 сая төгрөгийн тус тус төлбөр, зөрчил илрүүлэн, 698.5 сая төгрөгийн төлбөрийг нөхөн төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоож 81.9 хувийг барагдуулав.

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, салбарын хэмжээнд ААНБ, иргэнтэй холбоотой асуудлаар аймаг, орон нутагт 401, нийслэлд 503 зөрчлийн шинжтэй нийт 904 үйлдлийг шалгалаа. Шалгалтад хамрагдсан зөрчлийн 89.6 хувь буюу 810 хэргийг хялбаршуулсан журмаар, 0.3 хувь буюу 3 хэргийг зөрчлийн хэрэг нээж, 9.0 хувь буюу 81 гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 1.1 хувь буюу 10 хэргийг харьяаллын дагуу шилжүүлсэн байна. Нийт 894 ААНБ-д 1,155.8 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлэн нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсний 586.5 сая төгрөгийн төлбөр, зөрчлийг орон нутгийн НДХ-үүд, 568.2 сая төгрөгийн төлбөр, зөрчлийг дүүргийн НДХ хариуцан шийдвэрлэж, 2022 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар нийт төлбөр, зөрчлийн 79.2 хувь буюу 915.3 сая төгрөгийг барагдуулаад байна. Шалгалтад хамрагдсан 811 байгууллагад Зөрчлийн тухай хуулийн дагуу 203.0 сая

төгрөгийн торгууль оногдуулах арга хэмжээ авч, 98.4 хувь буюу 200.0 сая төгрөгийг барагдуулав. Нийт торгуулийн 64.2 сая төгрөгийг орон нутгийн НДХ-ийн, 138.8 сая төгрөгийг холбогдох дүүргийн НДХ-ийн дансанд төвлөрүүллээ.

## АРВАН НЭГ. МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА, ИЛ ТОД БАЙДАЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ

### 11.1 Хэрэглэгчийн үнэлгээ

НДБ-ын шударга байдлын үнэлгээг 2022 онд Авлигатай тэмцэх газраас "Эс Ай Си Эй" үнэлгээний байгууллагатай хамтран үнэлсэн бөгөөд тус үнэлгээгээр нийт төрийн байгууллагын хэмжээнд 83.2 оноогоор хоёрдугаар байр эзэлсэн.

НДБ-аас иргэд даатгуулагч, ажил олгогчдод үзүүлж буй үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор ХНХЯ-тай хамтран АХБ-ны "Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл"-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 21 аймаг, 8 дүүрэг /Багахангай дүүргээс бусад/-ийн НДХ-д дотоод хяналт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны системийг нэвтрүүлэн, киоск төхөөрөмж байршуулаад байна.

Энэхүү киоск төхөөрөмжийг байршуулснаар иргэн өөрт нь үйлчилгээ үзүүлсэн төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэх боломжтой болох бөгөөд ингэснээр иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлон НДБ-ын үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулах, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг дүгнэх, байцаагч, ажилтнуудын ажлын ачааллыг хэмжих, тэдний ажлын үр дүнг бодитой үнэлэх ач холбогдолтой юм.

Уг киоск төхөөрөмжөөс иргэд, даатгуулагчид дараах үйлчилгээг авах боломжтой. Үүнд:

- Үйлчилгээний дугаар авч дарааллын дагуу үйлчлүүлэх;
- Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход, шинээр ажил олгогчоор бүртгүүлэхэд шаардлагатай баримт бичгийн жагсаалтыг харах, хэвлэн авах, сайн дурын даатгалын гэрээ байгуулах, ЭМД-ын шимтгэлээ төлөхтэй холбоотой мэдээлэл авах;
- НД-ын үйлчилгээ, байцаагчийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх. /киоск дээрх болон үйлчилгээний тасалбар дээрх QR кодоор, мессежээр, веб линкээр гэх мэт/
- Лавлагаа авах зэрэг.

"Дотоод хяналт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны систем"-ийг 2022 оны 08 дугаар сараас ашиглаж эхэлсэн бөгөөд НДБ-аас үзүүлж байгаа 30 гаруй нэр төрлийн үйлчилгээнд иргэд, даатгуулагч, тэтгэвэр авагчид 1-5 оноогоор үнэлгээ өгөх боломжтой юм. Төхөөрөмжийг ашиглаж эхэлснээс хойш 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд аймаг, дүүргийн НДХ-ийн 589 байцаагч ажилтны 148402 иргэнд үзүүлсэн 170784 үйлчилгээ /давхардсан тоогоор/ бүртгэгдсэн байна. Үүнээс 16002 иргэн өөрийн авсан үйлчилгээндээ үнэлгээ өгсөн бөгөөд үнэлгээний дундаж нь 4.8 гарсан байна.

## 11.2 Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах

Тайлангийн хугацаанд албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр нийт 1046 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 21678 албан хаагчийг хамруулсан байна.

Ажил олгогч, даатгуулагчийн Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх чиглэлээр 3299 удаагийн сургалтыг явуулж, 13949 аж ахуйн нэгжийн 241533 иргэд, даатгуулагчид оролцов.

МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжинэ” гэсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХНХЯ, Европын Холбооны Европын Комиссын техникийн туслалцаатайгаар ‘’Үндэсний тэтгэврийн шинэчлэл” сэдэвт семинарыг зохион байгуулав. Тус семинарт Литва, Бельги, Польш, Словени улсын зөвлөхүүд оролцож, өөрийн орны болон Европын Холбооны бусад гишүүн орны туршлагаас хуваалцлаа.



*“Үндэсний тэтгэврийн шинэчлэл” семинар /2022.09.12/*

Нийт 892 удаагийн явуулын үйлчилгээ, 187 нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, 146383 иргэд, даатгуулагчдад НД-ын талаар мэдээлэл, зөвлөгөө, үйлчилгээ үзүүллээ.

Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээний талаар @sigomongolia сошиал хуудсаар НДБ-ын танилцуулга ном, 7 заавар, гарын авлага, 53 постер мэдээлэл, 4 шторк, 71 удаагийн цаг үеийн буюу нийт 133 удаагийн мэдээллийг бэлтгэн түгээснийг давхардсан тоогоор 2.8 сая хүн үзсэн байна.

Хэвлэл мэдээллийн 81 /давхардсан тоогоор/ байгууллагаар дамжуулан 578 удаагийн давтамжтайгаар Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд, даатгуулагчдад хүргэж, хэвлэл мэдээллийн байгууллагыг эх сурвалж, мэдээллээр хангав.

2022 онд НДБ үүсэж, хөгжсөний 80 жилийн ой тохиосон бөгөөд уг ойд зориулсан арга хэмжээний хүрээнд “НДБ-ын 80 жил-Хөгжил шинэчлэлийн алсын хараа” зөвлөгөөнийг зохион байгуулж, НДБ-ын түүхэн замнал, үйл ажиллагаа, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээний ач холбогдлыг олон нийтэд сурталчлах, үйл ажиллагаагаа НД-ын харилцаанд оролцогч талуудад тайлагнаж шинэчлэлийн асуудлыг хэлэлцлээ.



*“Нийгмийн даатгалын байгууллагын 80 жил-хөгжил, шинэчлэлийн алсын хараа” зөвлөгөөн 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулав*

Иргэд, даатгуулагчдын санал хүсэлтэд шуурхай хариулах, эргэх холбоог хангах зорилгоор @sigomongolia сошиал хуудсанд чатбот мессенжерийг ажиллуулж, нийт 75519 иргэн мэдээлэл авахаар хандсанаас 60738 иргэн автомат хариулагчаас мэдээлэл авсан бол 11125 иргэн тухайлсан зөвлөгөө мэдээлэл авахаар, 2619 иргэн бусад асуудлаар, 1037 иргэн санал, гомдлоо илэрхийлж хандсаныг тухай бүр шийдвэрлэв. Мөн 3500 орчим иргэн сэтгэгдэл, санал хүсэлтээ илэрхийлснийг тухай бүр хариулан, санал гомдлыг холбогдох газарт шилжүүлэн шийдвэрлүүллээ.

### 11.3 Лавлах үйлчилгээ

НД-ын үйлчилгээний лавлах утсаар нийт 113329 иргэн үйлчилгээний ажилтантай холбогдож шаардлагатай мэдээ, мэдээллийг авсан бол автомат хариулагчаас 67886 иргэн мэдээлэл, зөвлөгөө сонссон байна. Автомат хариулагчаас авсан мэдээллийг агуулгаар нь ангилж үзвэл тэтгэвэртэй холбоотой 7020, тэтгэмжтэй холбоотой 27106, сайн дурын даатгалтай холбоотой 6727, ЭХМТК-той холбоотой 1334, НД-ын шимтгэл төлөлттэй холбоотой 5167, ажлын бус цагаар болон бусад асуудлаар 20532 иргэн холбогдсон байна. Мөн хуульд орсон өөрчлөлтийн дагуу автомат хариулагчийн мэдээллийг шинэчлэв.

### 11.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

НДБ-ын хэмжээнд Шилэн дансны тухай хууль, ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасны дагуу шилэн дансны цахим хуудсанд НД-ын 33 байгууллага, НДС-ийн 31 салбар эрх, нийт 238 хэрэглэгчээр хандан НДС-ийн болон байгууллагын шилэн дансны мэдээллийг төсөв, гүйцэтгэлийн 9, хөрөнгө

оруулалт, тендер, худалдан авалтын 5, бусад 7, нийт 21 төрлийн мэдээллийг байршуулсан.

НД-ын төв, орон нутгийн байгууллагууд 2022 онд нийт 10069 мэдээллийг байршуулахаас 10040 мэдээллийг мэдээлж, мэдээлэл байршуулалт 99.7 хувьтай байна. Үүнээс:

- Хугацаанд нь байршуулсан мэдээлэл 9565, биелэлт 95.0%
- Хугацаа хоцроосон мэдээлэл 475, нийт байршуулбал зохих мэдээллийн 4.7%
- Мэдээлээгүй 29, нийт байршуулбал зохих мэдээллийн 0.3%-ийг тус тус эзэлж байна.

### 11.5 Гадаад харилцаа, хамтын ажиллагаа



Тайлант хугацаанд БНСУ-д хөдөлмөр эрхэлж байгаа иргэдээс НДС-д нийт 2.5 тэрбум төгрөгийн НД-ын шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, давхардсан тоогоор 13.1 мянган хүнд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын сангаас буцаан олголт авах талаар мэдээлэл, заавар зөвлөгөө өгч, сурталчиллаа. БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын сангаас 74 иргэн шимтгэлээ нэхэмжилж, 51 иргэн 179.5 сая воны шимтгэлээ буцаан авсан бөгөөд 23 иргэний нэхэмжлэх шалгагдаж байна. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэд, даатгуулагчдад 2 улсын хэлэлцээрийн дагуу МУ-ын тэтгэврийн даатгалд 1005 даатгуулагчийг хамруулснаас шинээр 374, гэрээ сунгасан 468, ажил олгогч, даатгуулагчийн хүсэлтээр дахин гэрээг шинэчилсэн 163 хүн байна. Мөн тус улсад ажиллаж амьдарч байгаа иргэдээс шинээр 215 даатгуулагчийг сайн дураар даатгалд хамруулав.



МУ-ын 34 иргэн БНУУ-аас сар бүр тэтгэвэр авч байна. Тус улсад ажилласан жилээ баталгаажуулж, өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 2 иргэний тэтгэврийг шинээр тогтоож, 26 иргэний холбогдох материалыг илгээгээд байна.



МУ, ОХУ-ын хооронд НД-ын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг шинэчлэхтэй холбоотой зохион байгуулсан 2 талын ажлын хэсгийн цахим уулзалтад оролцож, хэлэлцээрийн төсөлд оруулахаар тохирсон нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгаж, талууд өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу хэлэлцээрийн төслийг дотооддоо үргэлжлүүлэн хэлэлцэхээр тохиролцов.



МУ, БНТУ-ын ЗГ хоорондын "Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр"–ийг хэрэгжүүлэхэд ашиглах маягтын загваруудыг 2 талын ажлын хэсгийн гишүүд боловсруулж, 2022 оны 03 дугаар сарын 02-нд талууд албан ёсоор баталснаар хэрэгжилтийг зохион байгуулж эхлэв.



МУ, БНКазУ хооронд тэтгэврийн салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг хэлэлцэх шинжээчдийн ажлын хэсгийн 12 дахь удаагийн уулзалтаар хэлэлцээрийн төслийн эцсийн хувилбарыг тохиролцов.

## АРВАН ХОЁР. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 12.1 Хүний нөөц

НД-ын салбарын хэмжээнд 1416 /100%/ ажилтан, албан хаагч ажиллаж байгаагаас санхүү, эдийн засгийн мэргэжилтэй 1062 /75.0%/, эрх зүйч 44 /3.1%/, бусад мэргэжлийн албан хаагч 310 /21.9%/ байна.

График 16. НДБ-ын албан хаагчдын албан тушаалын ангилал, тоо




НД-ын салбарт ажиллагсдын 70.9 хувь нь эмэгтэйчүүд, 55.6 хувь нь 40 хүртэлх насны хүмүүс байна.

Хүснэгт 9. НДБ-ын албан хаагчдын нас, хүйсийн мэдээлэл

| № | Нас | Тоо | Хүйс | Тоо |
|---|---|---|---|---|
| 1 | 30 хүртэлх | 273 | Эрэгтэй | 412 |
| 2 | 31-40 | 504 | Эмэгтэй | 1004 |
| 3 | 41-50 | 411 | - | - |
| 4 | 51-60 | 228 | - | - |

### 12.2 Үйл ажиллагааны зардал

НДБ-ын 2022 оны үйл ажиллагааны зардалд 32.2 тэрбум төгрөг батлагдсанаас 31.2 тэрбум төгрөгийг зарцуулж, 1.0 тэрбум төгрөгийг хэмнэсэн байна. Нийт зардлын 74.0 хувь буюу 23.1 тэрбум төгрөгийг ажилтан, албан хаагчдын цалин хөлс, НД-ын шимтгэлд зарцуулжээ.

График 17. НДБ-ын үйл ажиллагааны зардал /тэрбум.төг/




## АРВАН ГУРАВ. ДҮГНЭЛТ

НДҮЗ нь тайлант хугацаанд УИХ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", 2015 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан "Тэрээс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого", ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө, Нийгмийн даатгалын үйлчилгээний маркетингийн дунд хугацааны хөтөлбөр (2019-2022 он)-ийг хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

УИХ-ын 2021 оны 56 дугаар тогтоолоор баталсан МУ-ын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд НД-ын чиглэлээр хэрэгжүүлэхээр 1 зорилт бүхий 1 арга хэмжээ тусгагдаж, хэрэгжилтийн явцыг жилийн эцсийн байдлаар дүгнэж үзэхэд 70.0 хувь буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" байна.

2022 онд 10 зорилтын 67 арга хэмжээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлж, жилийн эцсийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 94.8 хувьтай байна.

Тайлангийн хугацаанд НД-ын шимтгэлийн орлого 2,379.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2,668.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 112.1 хувиар биелүүлж, 2868.1 мянган хүн /давхардсан тоогоор/-д тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 3,415.7 тэрбум төгрөг зарцуулав.

2022 оны жилийн эцсийн байдлаар МУ-ын ЗГ-ын тогтоол, МУ-ын Ерөнхий сайдын захирамж, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл, МУ-ын Ерөнхий сайдын албан даалгавар, НДҮЗ-ийн тогтоолын нийт 52 шийдвэрийн 81 заалт хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт 90.2 хувьтай байна.

Тайлангийн хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн

хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, ажил үүргийг зохих түвшинд биелүүлжээ.

Цаашид НД-ын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, НДС-ийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зохицуулалтыг хийж, холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангах, даатгуулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний үр дүнг улам сайжруулах шаардлагатай байна.

**Аудитын дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1,8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгууд/ төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 36 төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 4 байгууллагыг түүвэрт хамруулж, 31 байгууллага “Өөрчлөлтгүй”, 1 байгууллага “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байна. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 285.0 сая төгрөгийн 22 санхүүгийн алдааг аудитын явцад залруулж, 6.6 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт, 174,033.0 сая төгрөгийн зөрчилд 33 албан шаардлага, 595.8 сая төгрөгийн зөрчилд 39 зөвлөмжүүдийг тус тус хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар үзсэн нийцлийн асуудлаар 3,998.3 сая төгрөгийн 14 албан шаардлага, 595.8 сая төгрөгийн 16 зөвлөмж хүргүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Капитал банкны эрх хүлээн авагчаас авах авлага барагдуулаагүй, Чингис хаан банкин дахь харилцах дансны үлдэгдэл санд төвлөрөөгүй, олон жилийн насжилттай авлага барагдаагүй зэрэг 172,179.9 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрч, 6 албан шаардлага өгсөн. Зөрчлийн дүн болон 172,179.9 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 29,689.0 сая төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

Албан шаардлага:

- Капитал банкнаас 73,999.9 сая төгрөгийн авлагаас тайланд онд 1,744.8 сая төгрөгийг мөнгөн хэлбэрээр, 2,905.2 сая төгрөгийн 32 нэр төрлийн үл хөдлөх хөрөнгийг хүлээн авч, данс бүртгэлд тусгаж, жилийн эцсийн санхүүгийн тайланд 69,350.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Капитал банкнаас авах авлагыг үе шаттай барагдуулах, холбогдох төрийн байгууллагуудтай хамтарч ажиллах;

- Чингис хаан банкинд байршиж буй НДС-ийн 96,105,9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг НДС-ийн төв санд төвлөрүүлээгүй, тус банктай 2021 онд байгуулсан “Төлбөр тооцооны үүрэг хэсэгчлэн гүйцэтгэх тухай” гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүй тул зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах;
- Санхүүгийн тайланд олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй иргэн, аж ахуй нэгж байгууллага, татан буугдсан банк, даатгалын компани болон Нийслэлийн өмчийн харилцааны газраас авах 6,451.2 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, хууль хяналтын байгууллагад хандан барагдуулаагүй зөрчлийг арилгах;
- Капитал банкны эрх хүлээн авагчаас шилжүүлэн авсан “Энхтайван найрамдлын ордон”-г 2021 онд “М” ХХК-тай гэрээ байгуулж түрээсэлсэн боловч, гэрээний үүргийг хангуулаагүйгээс жилийн эцсийн санхүүгийн тайланд 87.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлийг баталгаажуулаагүй тул түрээсийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж бүртгэх, зөрчлийг арилгах, алдааг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах;
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд илэрсэн алдаа, зөрчилд дүн шинжилгээ хийж, дотоод хяналтын үйл ажиллагаа, хариуцлагыг сайжруулах, аудитын зөвлөмжийн дагуу төлөвлөгөө, удирдамж гаргаж, үе шаттай хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2023 он

## АГУУЛГА


1. **СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭЛБЭР, ТӨРӨЛ**
2. **СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙХ БЭЛТГЭЛ АЖИЛ, ТӨЛӨВЛӨЛТ**
3. **СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
   - 3.1 Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт
   - 3.2 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа
     - 3.2.1 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын хэрэгжилт
     - 3.2.2 Нийгмийн даатгалын хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох, Засгийн Газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт
   - 3.3 Үндсэн үйл ажиллагаа
     - 3.3.1 Нийгмийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл
     - 3.3.2 Нийгмийн даатгалын сангийн орлого
     - 3.3.3 Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт
     - 3.3.4 Нийгмийн даатгалын хамралт
     - 3.3.5 Нийгмийн даатгалын сангаас үзүүлж буй тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардал
     - 3.3.6 Мэдээлэл технологийн үйл ажиллагаа
     - 3.3.7 Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хөгжүүлэлт, хүртээмж
     - 3.3.8 Эмнэлэг, хөдөлмөрийн магадлал
     - 3.3.9 Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах
     - 3.3.10 Хяналт шалгалт
     - 3.3.11 Лавлах үйлчилгээ
     - 3.3.12 Гадаад харилцаа, хамтын ажиллагаа
     - 3.3.13 Хүний нөөц
     - 3.3.14 Үйл ажиллагааны зардал
     - 3.3.15 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
4. **ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**
5. **ЦААШДЫН БОДЛОГО, ЧИГЛЭЛ**
6. **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН АКТЫН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТ**
7. **УИХ-ЫН БАЙНГЫН ХОРООНООС ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| **Товчлол** | **Тайлал** |
|---|---|
| ААНБ | Аж ахуйн нэгж, байгууллага |
| АХБ | Азийн хөгжлийн банк |
| БНКазУ | Бүгд Найрамдах Казахстан Улс |
| БНСУ | Бүгд Найрамдах Солонгос Улс |
| БНТУ | Бүгд Найрамдах Турк Улс |
| БНУУ | Бүгд Найрамдах Унгар Улс |
| ДТШ | Даатгуулагчийн төлөх шимтгэл |
| ЗГ | Засгийн газар |
| ЗГХЭГ | Засгийн газрын хэрэг эрхлэх газар |
| КЭХА | Капиталын эрх хүлээн авагч |
| МАОЭНХ | Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо |
| МАХ | Монголын ахмадын холбоо |
| МУ | Монгол Улс |
| МҮХАҮТ | Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим |
| МҮЭХ | Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо |
| НББСШУБХ | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| НД | Нийгмийн даатгал |
| НДБ | Нийгмийн даатгалын байгууллага |
| НДЕГ | Нийгмийн даатгалын ерөнхий газар |
| НДС | Нийгмийн даатгалын сан |
| НДҮЗ | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл |
| НДХ | Нийгмийн даатгалын хэлтэс |
| НХС | Нийгмийн халамжийн сан |
| ОХУ | Оросын Холбооны Улс |
| ОУХБ | Олон улсын хөдөлмөрийн байгууллага |
| СЯ | Сангийн яам |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТҮЦ | Төрийн үйлчилгээний цэг |
| УИХ | Улсын Их Хурал |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |

| | |
|---|---|
| УТҮГ | Улсын төсөвт үйлдвэрийн газар |
| ҮЭХ | Үйлдвэрчний эвлэлийн холбоо |
| ХАСХОМ | Хувийн ашиг сонирхлын хөрөнгө оруулгын мэдүүлэг |
| ХЗДХЯ | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| ХНХЯ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| ХНХҮТ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв |
| ХХТАО | Хөдөлмөрийн хөлс,түүнтэй адилтгах орлого |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХЧТА | Хөдөлмөрийн чадвар түр алдалт |
| ЦХХХЯ | Цахим хөгжил, харилцаа, холбооны яам |
| ЭЗХЯ | Эдийн засгийн хөгжлийн яам |
| ЭМД | Эрүүл мэндийн даатгал |
| ЭМДЕГ | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ЭХМТК | Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах төв комисс |

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


Хүснэгт 1. Системчилсэн үнэлгээний бүдүүвч

Хүснэгт 2. Системчилсэн үнэлгээ хийх төлөвлөгөө

Хүснэгт 3. НДС-ийн орлогын биелэлт

Хүснэгт 4. НДС-ийн 2022 оны орлогын гүйцэтгэл

Хүснэгт 5. НДС-ийн 2022 оны зарлагын гүйцэтгэл

Хүснэгт 6. НДС-ийн 2022 онд зарцуулсан мөнгөн дүн, үйлчлүүлсэн хүний тоо

Хүснэгт 7. Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн

Хүснэгт 8. Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн

Хүснэгт 9. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн

Хүснэгт 10. Нийгмийн даатгалын үйлчилгээний цахимжуулалт

Хүснэгт 11. Хяналт, шалгалтад хамрагдсан НДХ, зөрчлийн дүн

Хүснэгт 12. НДБ-ын албан хаагчдын нас, хүйсийн мэдээлэл

Хүснэгт 13. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

Хүснэгт 14. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ


График 1. НДБ-ын бүтэц

График 2. НДС-ийн төсөв

График 3. НДС-ийн орлогын бүтэц

График 4. НД-ын хамралт

График 5. Тэтгэврийн зарлага

График 6. Тэтгэвэр авагчдын бүтэц

График 7. Тэтгэврийн доод болон дундаж хэмжээ

График 8. Тэтгэмжийн зарлага

График 9. ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага

График 10. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн

График 11. НДБ-ын албан хаагчдын албан тушаалын ангилал, тоо

График 12. НДБ-ын үйл ажиллагааны зардал

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УИХ-ын Төрийн байгуулалтын Байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоолын дагуу НДҮЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланг Хууль зүйн яам /хуучин нэрээр/-наас боловсруулсан "Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу гаргаж, үнэлгээ хийсэн болно.

Хүснэгт 1. Системчилсэн үнэлгээний бүдүүвч




## НЭГ. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭЛБЭР, ТӨРӨЛ

*Системчилсэн үнэлгээ хийх шалтгаан:*

Тухайн байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө санхүү оновчтой болсон, зорилгодоо хүрсэн эсэхийг тогтоох шаардлага гарсан.

*Системчилсэн үнэлгээний зорилго:*

Үнэлгээний зорилго нь байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж өөрийн тавьсан зорилгодоо ямар хэмжээнд хүрсэн байдлыг бүх талаар тодорхойлоход чиглэсэн болно.

*Системчилсэн үнэлгээний зорилт:*

Үнэлгээний зорилт нь байгууллагын дэвшүүлсэн зорилго, хөгжлийн үр ашиг, үр дүнтэй байдал, үр нөлөө болон тогтвортой байдлын уялдаа холбоо, хэрэгжилтийг тодорхойлж аль болох системтэй, бодит байдалд нийцсэн байдлаар төлөвлөсөн, хэрэгжиж буй болон хэрэгжсэн үйл ажиллагааг үнэлсэн болно.

*Системчилсэн үнэлгээний хэлбэр:*

Үнэлгээний хэлбэр нь хэрэгжсэн хөтөлбөр болон арга хэмжээнд өгөх хэрэгжилтийн үнэлгээ /ретроспектив/ болно.

*Системчилсэн үнэлгээний төрөл:*

Үнэлгээ нь байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгод ямар хэмжээнд хүрснийг тодорхойлоход чиглэх бөгөөд Системчилсэн үнэлгээ хийхдээ “Дотоодын буюу өөрийн байгууллагын үнэлгээ”-ний хэлбэрийг сонгож, дараах чиглэлээр үнэлгээ хийлээ. Үүнд:

- Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт.
- НДҮЗ-ийн үйл ажиллагаа.
- Үндсэн үйл ажиллагаа.

## ХОЁР. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙХ БЭЛТГЭЛ АЖИЛ, ТӨЛӨВЛӨЛТ

Бэлтгэл, төлөвлөлтийн үе шатууд.

*Системчилсэн үнэлгээ хийх бэлэн байдлыг хангах:*

- Системчилсэн үнэлгээ хийх талаар НДЕГ-т НДҮЗ-ийн Ажлын албаны даргын албан бичгээр мэдэгдэж, бэлэн байдлыг хангуулах;
- Үнэлгээний багийг бүрдүүлэх.

*Үнэлгээнд оролцогч байгууллагуудын цар хүрээ:*

- НДҮЗ-ийн Ажлын алба;
- НДЕГ;
- ЭХМТК;
- Мэдээлэл технологийн төв;
- Нийслэлийн Нийгмийн даатгалын газар
- Дүүргийн НДХ;
- Аймгийн НДХ;
- БНСУ дахь Нийгмийн хамгааллын төвийн Нийгмийн даатгалын тасаг

*Үнэлгээ хийх хугацаа:*

- 2023 оны 02, 03, 04 дүгээр сарууд.

*Хөндлөнгийн ба өөрийн үнэлгээг сонгох:*

- Өөрийн үнэлгээ хийнэ.

*Үнэлгээний зорилго, хамрах хүрээг тодорхойлох:*

- Үнэлгээний зорилго, хамрах хүрээ нь байгууллагын бүх салбар нэгжийн хүрээнд үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгодоо ямар хэмжээнд хүрсэн байдлыг бүх талаар тодорхойлоход чиглэсэн болно.

Хүснэгт 2. Системчилсэн үнэлгээ хийх төлөвлөгөө

| Хугацаа | | 2- р сар | | | | 3-р сар | | | | 4-р сар | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хэрэгжүүлбэл зохих ажлууд | | → | | | | | | | | | | | | |
| **Төлөвлөлтийн шат** | Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлсон уулзалт хийх | ■ | | | | | | | | | | | | |
| | Үнэлгээний баг бүрдүүлэх | | ■ | | | | | | | | | | | |
| | Үнэлгээний төлөвлөгөөг боловсруулах | | | ■ | | | | | | | | | | |
| | Үнэлгээ хийх талаар НДЕГ-т албан бичиг хүргүүлэх | | | | | ■ | | | | | | | | |
| | Тайлан гаргаж өгөх, НДЕГ-ын холбогдох мэргэжилтэнтэй уулзах | | | | | | ■ | ■ | | | | | | |
| **Үнэлгээний шат** | Баримт бичигтэй танилцах | | | | | | | | ■ | ■ | | | | |
| | Тайлангийн талаар тодруулга, асуулга авах | | | | | | | | | | ■ | | | |
| | Ярилцлага хийх | | | | | | | | | | ■ | | | |
| | Дүн шинжилгээ хийх | | | | | | | | | | ■ | ■ | | |
| | Дүгнэлт гаргах | | | | | | | | | | ■ | ■ | | |
| | Тайлан гаргах | | | | | | | | | | ■ | ■ | | |
| | Зөвлөмж бичих | | | | | | | | | | | | ■ | |
| | НДҮЗ-ийн хуралдаанд танилцуулах | | | | | | | | | | | | | ■ |
| | УИХ-ын НББХ-нд хүргүүлэх | | | | | | | | | | | | | ■ |

## ГУРАВ. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

### 3.1 Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт

НДБ нь НДҮЗ, Ажлын алба, НД-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүрэг, БНСУ дахь НД-ын газар, хэлтэс, тасаг, НД-ын байцаагч, ажилтнаас бүрддэг.

НДҮЗ нь УИХ-аас томилогдсон ЗГ, Даатгуулагч, Ажил олгогчийг төлөөлсөн тус бүр 3, нийт 9 гишүүнтэй.

НДҮЗ-ийн Ажлын алба нь УИХ-ын НББСШУБХ-ны 2018 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан 12 орон тоотойгоор ажиллаж байна.

Ажлын алба нь НДҮЗ-ийн гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах, Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад туслах чиг үүрэгтэй ажиллаж байна.

ЗГ-ын “Агентлаг байгуулах тухай” 2017 оны 344 дүгээр тогтоол, НДҮЗ-ийн 2018 оны 04 дүгээр тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, орон тоог батлах тухай” 2018 оны А/25 дугаар тушаалын дагуу нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага НДЕГ нь 6 газар, 5 хэлтэс, дэргэдээ 2 төвтэй, нийт 111 албан хаагчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Аймаг, нийслэл, дүүргийн 31 газар, хэлтэст НД-ын бодлогын хэрэгжилтийг хангах, НД-ын үйлчилгээг иргэд даатгуулагчдад үзүүлэх чиг үүрэг бүхий 1293, нийт 1416 албан хаагч, улсын байцаагчид ажиллаж байна.

График 1. НДБ-ын бүтэц




### 3.2 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа

НДҮЗ нь тайлант хугацаанд төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг удирдлага болгож, Нийгмийн даатгалын тухай хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд НД-ын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллалаа.

### 3.2.1 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын хэрэгжилт

НДҮЗ нь 2022 онд нийт 8 удаа хуралдан 17 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 7 тогтоол батлан гаргасан. Эдгээр тогтоолуудаас "Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" болон "Нэрийн дансны 2022 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай" гэсэн нийтээр заавал дагаж мөрдүүлэх 2 тогтоолыг баталж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэв.

***Капитал банкны өр төлбөрт хөрөнгө авахаар шийдвэрлэлээ***

НДҮЗ-ийн 01 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалт, Улсын Их Хурлын 2020 оны "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай" 32 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.8 дахь хэсэг, МУ-ын ЗГ-ын 2021 оны 07 дугаар сарын 07, 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, ТӨБЗГ-ын 2021 оны 07 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн зөвшөөрлийг тус тус үндэслэн КЭХА-аас 25.9 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 86 ширхэг үл хөдлөх хөрөнгийг НДС-ийн нэхэмжилсэн өр төлбөрт суутган авахыг зөвшөөрлөө. 2022 онд хөрөнгийн нээлттэй дуудлага худалдааг нийт 8 удаа зохион байгуулж, 20 хөрөнгийг 6.2 тэрбум төгрөгөөр зарж, орлогыг НДС-д төвлөрүүлсэн байна.

***Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн хуваарьт 3 удаа өөрчлөлт оруулж, мөрдүүлэв***

НДҮЗ-ийн 02, 03, 05 дугаар тогтоолуудаар Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хууль, Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.6 дахь заалтыг үндэслэн тэтгэвэр авагчдын тэтгэврийн нэмэгдэлд зарцуулахаар батлагдсан хөрөнгийн эх үүсвэрт шаардагдах хөрөнгийг тэтгэврийн даатгалын сангийн өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан орлогоос буюу харилцахын мөнгөн хөрөнгөөс зарцуулахыг НДЕГ-т зөвшөөрч, 2022 оны НДС-ийн болон аймаг, дүүргийн НДС-ийн төсвийн хуваарьт 3 удаа холбогдох өөрчлөлтүүдийг оруулж, тодотгосон төсвийн хуваарийг шинэчлэн баталж, мөрдүүлэв.

***Оршуулгын тэтгэмжийн хэмжээг 6 жилийн дараа 2 дахин нэмэгдүүллээ***

НДҮЗ-ийн 04 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн $21^1$ дүгээр зүйл, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 24 дүгээр зүйл, ХНХЯ-ны саналыг тус тус үндэслэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан оршуулгын тэтгэмжийн болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нас барагчийн ар гэрт олгох

тэтгэмжийн хэмжээг хоёр сая төгрөгөөр шинэчлэн, амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг гурван сая таван зуун мянган төгрөгөөр тус тус тогтоож, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр шийдвэрлэлээ. Ийнхүү 2016 оноос хойш 6 жилийн дараа оршуулгын тэтгэмжийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж, амьгүй донор болсон даатгуулагчийн ар гэрт оршуулгын тэтгэмжийг анх удаа олгох болсон нь хүндээр өвчилсөн хүний амь насыг аврах, буяны үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ын үнэ тариф нэмэгдсэн энэ үед нас барсан иргэдийн оршуулгын үйл ажиллагааг явуулахад нь чухал ач холбогдолтой шийдвэр болов.

***Нэрийн дансны 2022 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг 9.8 хувиар тогтоолоо***

НДҮЗ-ийн 07 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын хууль тогтоомж болон ҮСХ-оос ирүүлсэн саналыг үндэслэн даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2022 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 9.8 хувиар тогтоон холбогдох арга хэмжээг авч ажиллахыг НДЕГ-т үүрэг болгов.

***Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн хуваарийг баталж хүргүүлэв***

НДҮЗ-ийн 06 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.6 дахь заалтыг үндэслэн тэтгэвэрт зарцуулах хөрөнгийн эх үүсвэрт шаардагдах 214.5 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын сангийн, ажилгүйдлийн даатгалын сангаас олгох тэтгэмжид зарцуулах хөрөнгийн эх үүсвэрт шаардагдах 24.4 тэрбум төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангийн харилцахын мөнгөн хөрөнгөөс зарцуулахыг НДЕГ-т зөвшөөрч, 2023 оны НДС-ийн болон аймаг, дүүргийн НДС-ийн төсвийн хуваарийг тус тус баталж, холбогдох газруудад хүргүүлэв.

**3.2.2 Нийгмийн даатгалын хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох, Засгийн Газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт**

***Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж байна.***

Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл, үзэл баримтлалын шинэчлэлийн хүрээнд 2021 онд Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулан ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлээд байсан юм. Гэвч Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсний дараа УИХ-аас Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж, ЗГ-аас 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн НДС-аас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авч байгаа тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг 15-43 хувиар нэмэгдүүлсэн нь өргөн мэдүүлсэн багц хуулийн төсөлд тусгасан зарим зүйл, заалтыг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүссэн. Мөн УИХ дахь олонхын бүлгээс хуулийн төслүүдийг

хуримтлалын нэгдсэн сантай уялдуулж дахин боловсруулах чиглэл өгсөн, ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон зэрэг шалтгааны улмаас Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийг буцаан татан авч, үүсэх нөхцөл байдалд нийцүүлэн дахин боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэв. УИХ-ын 2022 оны намрын чуулганаар хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэсэн бөгөөд хуулийн төсөлд олон нийтээс санал авах, хэлэлцүүлэг хийх үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд нийгмийн даатгалын тогтолцоо, зарчим, төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, нийгмийн даатгалд даатгуулах, шимтгэл төлөх, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавих болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох харилцааг тусгана. Мөн нийгмийн даатгалын тогтолцооны зарчим, даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлага, мэдээллийн нэгдсэн сан, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын итгэлцүүр, шимтгэлийг нөхөн төлүүлэх, буцаан олгох, тэтгэврийн нөөц санг байгуулах, нэрийн дансны бүртгэлийг мөнгөжүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх, шимтгэлийн өр, хөөн хэлэлцэх хугацааг тогтоох, НДС-ийн хэтийн тооцоолол хийх, сангийн эрсдэлийг үнэлэх, санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий мэргэжлийн хороог ажиллуулах зэрэг шинэ зохицуулалтыг тусгалаа.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлд олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, ахмад настан бүрд суурь тэтгэвэр олгох, иргэн бүр сайн дурын үндсэн дээр хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд даатгуулж, нэмэгдэл тэтгэвэр авах, тэтгэврийг индексжүүлэн нэмэгдүүлэх, хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд шилжих асуудлуудыг тусгалаа.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төслөөр НДС-аас олгох тэтгэмжийн бүх харилцааг энэ хуулиар бүхэлд нь зохицуулах бөгөөд ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх, донор болсон даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсан, ихэр хүүхэд төрүүлсэн эхийн амаржсаны тэтгэмжийн хэмжээг тус тус нэмэгдүүлэх, ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг ОУХБ-ын стандартад нийцүүлэх, ажил олгогчид 3 жилд нэг удаа 15 хувиар шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхээр зохицуулсан байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төсөлд урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөрийг нэмэгдүүлэх, даатгуулагчийн протез, ортопедын үнийг 3 жил тутамд 1 удаа бүрэн чөлөөлөх, үйлдвэрлэлийн осол гаргаагүй ажил олгогчид 15 хувиар шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх, үйлчилгээг цахимжуулах асуудлууд тусгагдсан.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд МУ-д анх удаа хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, ахмад настнууд ирээдүйд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах, хангалттай орлогын эх үүсвэртэй байх боломжийг олгохоор зохицуулав.

***Тэтгэврийн хэмжээг дахин нэмэгдүүлж, дундаж тэтгэвэр 555.6 мянган төгрөгт хүрлээ.***

ЗГ-ын 2022 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 63 дугаар тогтоолын дагуу тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж, НДС-аас болон цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу олгож байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар тус тус нэмэгдүүлэн, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, нэмэгдсэн тэтгэврийг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгож эхэллээ. Уг арга хэмжээнд 469.2 мянган тэтгэвэр авагч хамрагдаж, тэтгэврийн нэмэгдэлд 637.4 тэрбум төгрөг зарцуулсны дүнд дундаж тэтгэвэр 555.6 мянган төгрөгт хүрлээ.

### 3.3 Үндсэн үйл ажиллагаа

НДҮЗ нь 2022 онд Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

- НД-ын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, НД-ын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, НДС-ийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийг батлах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах;
- НДС-ийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, НДС-ийн хуримтлал бий болгох, гүйцэтгэлийг тайлагнах;
- НД-ын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;
- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон НД-ын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж, шийдвэр гаргах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах;
- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, НД-ын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах;
- НД-ын үйлчилгээг цахимжуулах, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх;
- БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа МУ-ын иргэдийг НД-ын талаарх мэдээллээр хангах, тэтгэврийн даатгалд хамруулах, төлсөн шимтгэлийг бүртгэх, тэтгэврийн даатгалын сан бүрдүүлэх, төвлөрүүлэх, шимтгэлийн буцаан олголтыг холбогдох журмын дагуу зохион байгуулах болно.

### 3.3.1 Нийгмийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд 3,301.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталсан. Үүнд:

- НД-ын шимтгэлийн орлого 2,379.9 тэрбум төгрөг;
- ЭМДС-аас санхүүжих 1.1 тэрбум төгрөг;
- Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 920.9 тэрбум төгрөгөөр баталсан боловч Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” 239 дүгээр тушаалын 8 дугаар хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн сар, улирлын хуваарь”-иар улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 76.1 тэрбум төгрөгөөр бууруулж 844.7 тэрбум төгрөг болгосон.

Нийт зарлага 3,511.7 тэрбум төгрөг. Үүнд:

- Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардалд 3,403.4 тэрбум төгрөг;
- НДБ-ын үйл ажиллагааны зардалд 32.2 тэрбум төгрөг,
- УИХ-ын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хуулийн дагуу Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд даатгуулагчаас төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийн буцаан олголтод 150.8 тэрбум төгрөгийг баталсан боловч Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” 239 дүгээр тушаалаар тухайн зардлыг 76.1 тэрбум төгрөгөөр бууруулж, 74.7 тэрбум төгрөг болгосон.

График 2. НДС-ийн төсөв /тэрбум.төг/




### 3.3.2 Нийгмийн даатгалын сангийн орлого

НДС-д тайлангийн хугацаанд шимтгэлийн орлого 2,379.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2,668.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 112.1 хувиар биелүүлсэн. /Энэ дунд ЭМДС-аас санхүүжих 1.1 тэрбум, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 844.7 тэрбум төгрөг ороогүй/

График 3. НДС-ийн орлогын бүтэц /хувиар/




НДС-ийн нийт орлогын 55.1 хувь буюу 1,471.6 тэрбум төгрөгийг ажил олгогч, 44.3 хувь буюу 1,182.2 тэрбум төгрөгийг даатгуулагчийн төлсөн шимтгэл, 0.6 хувь буюу 14.8 тэрбум төгрөгийг ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн шимтгэлийн орлого болон бусад орлого эзэлж байна.

Хүснэгт 3. НДС-ийн орлогын биелэлт /тэрбум.төг/

| № | Орлогын төрөл | 2021 | 2022 |
|---|---|---|---|
| 1 | Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг | 593.9 | 842.8 |
| 2 | Ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагаас | 790.4 | 1,182.0 |
| 3 | Төсөвт газраас | 343.4 | 289.5 |
| 4 | Даатгуулагчаас | 854.7 | 1,068.1 |
| 5 | Сайн дурын даатгуулагчаас | 137.5 | 111.7 |
| 6 | Гадаадад ажиллаж буй иргэдийн | 2.6 | 2.5 |
| 7 | ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн | 1.7 | 1.5 |
| 8 | ЭМДС-аас санхүүжих | 1.1 | 1.1 |
| 9 | Бусад орлого | 6.7 | 13.3 |
| | **Нийт** | **2,732.0** | **3,512.5** |

Мөн орлогын 24.0 хувь буюу 842.8 тэрбум төгрөгийг тэтгэврийн болон ҮОМШӨ-ний даатгалын санд улсын төсвөөс, 0.03 хувь буюу 1.1 тэрбум төгрөгийг ЭМДС-аас шилжүүлсэн санхүүжилтийн орлого тус тус эзэлж байна.

Хүснэгт 4. НДС-ийн 2022 оны орлогын гүйцэтгэл /тэрбум.төг, хувиар/

| № | Орлого | Мөнгөн дүн /тэрбум.төг/ | Нийт орлогод эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Тэтгэврийн даатгалын сан | 3,013.2 | 85.8 |
| 2 | Тэтгэмжийн даатгалын сан | 236.9 | 6.8 |
| 3 | ҮОМШӨ-ний даатгалын сан | 208.8 | 5.9 |
| 4 | Ажилгүйдлийн даатгалын сан | 53.6 | 1.5 |
| | **Нийт** | **3,512.5** | **100** |

### 3.3.3 Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт

НДС-ийн зардлын төсөв 3,435.6 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд 3,384.5 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт, 31.2 тэрбум төгрөгийг НДБ-ын үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулсан.

Хүснэгт 5. НДС-ийн 2022 оны зарлагын гүйцэтгэл /тэрбум.төг, хувиар/

| № | Зардал | Мөнгөн дүн /тэрбум.төг/ | Нийт зардалд эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Тэтгэврийн даатгалын сан | 3,031.3 | 88.7 |
| 2 | Тэтгэмжийн даатгалын сан | 165.9 | 4.9 |
| 3 | ҮОМШӨ-ний даатгалын сан | 35.9 | 1.1 |
| 4 | Ажилгүйдлийн даатгалын сан | 78.7 | 2.3 |
| 5 | ДТШ 50 хувийн буцаалт | 72.7 | 2.1 |
| 6 | Үйл ажиллагааны зардал | 31.2 | 0.9 |
| | **Нийт** | **3,415.7** | **100.0** |

НДС-ийн зарлага өмнөх оны мөн үеэс 850.2 тэрбум төгрөг буюу 33.1 хувиар өссөн.

Хүснэгт 6. НДС-ийн 2022 онд зарцуулсан мөнгөн дүн, үйлчлүүлсэн хүний тоо /мян.хүн, тэрбум.төг/

| № | Нийгмийн даатгалын сан | 2020 он | | 2021 он | | 2022 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Тэтгэврийн | 437.1 | 2,153.6 | 455.5 | 2,281.8 | 473.8 | 3,031.3 |
| 2 | Тэтгэмжийн | 191.2 | 145.4 | 364.5 | 169.4 | 260.9 | 165.9 |
| 3 | ҮОМШӨ-ний | 7.6 | 31.6 | 5.7 | 30.7 | 7.2 | 35.9 |
| 4 | Ажилгүйдлийн | 21.3 | 94.4 | 26.2 | 57.0 | 30.5 | 78.7 |
| 5 | ДТШ 50 хувийн буцаалт | - | - | - | - | 2087.7 | 72.7 |
| 6 | Үйл ажиллагааны зардал | | 26.8 | | 26.6 | | 31.2 |
| | **Нийт** | **657.2** | **2,451.8** | **851.9** | **2,565.5** | **2,860.1** | **3,415.7** |

НДС-аар үйлчлүүлсэн иргэдийн тоо өмнөх оныхоос 2008.2 мянга буюу 70.2 хувиар өссөн нь "Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай" хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд давхардсан тоогоор 2087.7 мянган даатгуулагчдад 72.7 тэрбум төгрөгийг олгосон, НДБ-ын үйл ажиллагааны зардал 4.6 тэрбум төгрөг буюу 17.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### 3.3.4 Нийгмийн даатгалын хамралт

График 4. НД-ын хамралт /мян.хүн/



НД-ын мэдээллийн санд 2022 оны жилийн эцсийн байдлаар 55.4 мянган ААНБ бүртгэгдсэн нь 2021 онтой харьцуулахад 2.7 мянган ажил олгогч буюу 5.1 хувиар нэмэгдсэн.

Мөн албан журмын 1,104.8 мянган даатгуулагч хамрагдсан нь нийт ажиллах хүчний 90.3 хувийг эзэлж байна. /ҮСХ-ны 2022 оны 4-р улирлын мэдээгээр нийт ажиллах хүчний тоо 1222.8 мянган хүн/

### 3.3.5 Нийгмийн даатгалын сангаас үзүүлж буй тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардал

***Тэтгэврийн даатгалын сан***

2022 онд тэтгэврийн даатгалын сангаас нийт 473.8 мянган иргэнд 3,030.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон. Нийгмийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө буюу 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон 45.1 мянган тэтгэвэр авагч, 20.0 мянган цэргийн албан хаагчдын тэтгэвэрт 453.3 тэрбум төгрөг зарцуулсан.

Хүснэгт 7. Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/

| № | Тэтгэврийн төрөл | 2020 он | | 2021 он | | 2022 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Өндөр насны | 332.9 | 1,663.9 | 353.2 | 1,789.6 | 372.0 | 2,408.0 |
| 2 | Тахир дутуугийн | 65.9 | 255.8 | 63.1 | 247.7 | 62.2 | 316.7 |
| 3 | Тэжээгчээ алдсаны | 19.2 | 77.6 | 19.5 | 77.1 | 19.6 | 103.7 |
| 4 | Цэргийн | 19.1 | 153.7 | 19.7 | 162.7 | 20.0 | 201.8 |
| | **Нийт** | **437.1** | **2,151.0*** | **455.5** | **2,277.1*** | **473.8** | **3,030.2*** |

*Үйл ажиллагааны зардал, бусад зардал болон ДТШ 50 хувийн буцаалтын дүн ороогүй болно.

График 5. Тэтгэврийн зарлага /тэрбум.төг/



Тэтгэврийн даатгалын сангийн зардал өмнөх оноос 753.1 тэрбум төгрөг буюу 33.1 хувиар өссөн.

График 6. Тэтгэвэр авагчдын бүтэц /хувиар/




Нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 7.9 хувь нь хувь тэнцүүлсэн тэтгэвэр, 92.1 хувь нь бүрэн тэтгэвэр авч байна.

НДС-аас олгож буй бүрэн тэтгэврийн доод хэмжээ 500.0 мянган төгрөг байгаа нь амьжиргааны доод түвшингээс 79.9 хувиар илүү байна. /ҮСХ-ны 2022 оны мэдээллээр Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны доод түвшин сарын 277.8 мянган төгрөг/

График 7. Тэтгэврийн доод болон дундаж хэмжээ /мян.төг/




Улсын хэмжээгээр дундаж тэтгэврийн хэмжээ өмнөх оноос 30.8 хувиар өссөн.

***Тэтгэмжийн даатгалын сан***

Тэтгэмжийн даатгалын сангаас 260.9 мянган даатгуулагчдад 165.9 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгожээ.

Хүснэгт 8. Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/

| № | Тэтгэмжийн төрөл | 2020 он | | 2021 он | | 2022 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Хөдөлмөрийн чадвар түр алдсаны | 113.7 | 20.2 | 179.7 | 30.4 | 162.3 | 27.4 |
| 2 | Жирэмсний болон амаржсаны | 64.6 | 109.9 | 64.9 | 119.3 | 58.5 | 121.1 |
| 3 | Оршуулгын | 12.9 | 12.9 | 16.2 | 16.2 | 14.2 | 14.2 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Эхийн хүүхдээ асрах чөлөөтэй байсан хугацааны шимтгэл | 83.7 | 2.2 | 103.7 | 3.2 | 25.9 | 3.2 |
| | **Нийт** | **274.9** | **145.2*** | **364.5** | **169.1*** | **260.9** | **165.9*** |

*Үйл ажиллагааны зардал, бусад зардал болон ДТШ 50 хувийн буцаалтын дүн ороогүй болно.

График 8. Тэтгэмжийн зарлага /тэрбум.төг/




Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.2 тэрбум төгрөг буюу 1.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

***ҮОМШӨ-ний даатгалын сан***

2022 оны жилийн эцсийн байдлаар 7.2 мянган даатгуулагчдад тахир дутуугийн, тэжээгчээ алдсан, ХЧТА, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувиллын зардалд ҮОМШӨ-ний даатгалын сангаас 36.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан.

Хүснэгт 9. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/

| № | Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл | 2020 он | | 2021 он | | 2022 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Тахир дутуугийн тэтгэвэр | 3.9 | 24.8 | 3.7 | 24.4 | 3.5 | 27.5 |
| 2 | Тэжээгчээ алдсаны тэтгэвэр | 0.5 | 2.9 | 0.5 | 2.9 | 0.5 | 3.4 |
| 3 | ХЧТА-ны тэтгэмж | 1.1 | 0.9 | 0.7 | 0.7 | 1.2 | 1.3 |
| 4 | Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр | 0.02 | 0.02 | 0.01 | 0.08 | 0.01 | 0.01 |
| 5 | Рашаан сувиллын зардал | 2.1 | 0.6 | 0.8 | 0.2 | 2.0 | 1.1 |
| 6 | Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал | - | 0.7 | - | 0.7 | - | 1.1 |
| 7 | Тахир дутуугийн тэтгэвэр авагчдын тэтгэврийн даатгалын шимтгэл | - | 1.6 | - | - | - | 1.5 |
| | **Нийт** | **7.6** | **31.5*** | **5.7** | **29.0*** | **7.2** | **36.0*** |

*Үйл ажиллагааны зардал, бусад зардал болон ДТШ 50 хувийн буцаалтын дүн ороогүй болно.

График 9. ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага /тэрбум.төг/




ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 7.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

***Ажилгүйдлийн даатгалын сан***

2022 онд ажилгүйдлийн даатгалын сангаас 30.5 мянган даатгуулагч 78.6 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж авсан байна.

График 10. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн



### 3.3.6 Мэдээлэл технологийн үйл ажиллагаа

УИХ-аас 2022 онд баталсан хууль тогтоомжийн өөрчлөлт болон хэрэглэгчдийн хүсэлтээр нийгмийн даатгалын үйлчилгээнд шинээр 3 систем, 15 сервис үйлчилгээг нэвтрүүлж, програм хангамжуудад 110 гаруй удаагийн өөрчлөлт хийв.

НД-ын нэгдсэн мэдээллийн санд 55.4 мянган ажил олгогч, 1104.8 мянган албан журмын, 164.5 мянган сайн дураар даатгуулагч, 473.8 мянган тэтгэвэр авагчийн дэлгэрэнгүй мэдээлэл бүхий 74GB мэдээлэл агуулагдаж байгаа бөгөөд тогтмол баяжуулалт хийж, 160 загвараар 250 гаруй удаа мэдээллийн боловсруулалт, судалгаа хийж, хэрэглэгчдийг мэдээллээр хангалаа.

Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан 18 байгууллагатай холбогдох мэдээллийг тогтмол солилцож байна. Тэтгэмжийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсэн болон амаржсаны, ажилгүйдлийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн үйлчилгээг цахимжуулахтай холбогдуулан төрийн мэдээлэл солилцооны ХУР системд 10 төрлийн, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia-д 5 төрлийн сервисийг шинээр боловсруулан хүргүүлсэн.

### 3.3.7 Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хөгжүүлэлт, хүртээмж

НД-ын гар утасны аппликейшнийг 250.0 мянга орчим даатгуулагч идэвхтэй хэрэглэж байна. Тайлангийн хугацаанд 3555 иргэнд баталгаажуулалтын нууц дугаарыг цахим хэлбэрээр олгож, утсаар 1402 иргэнд заавар зөвлөгөө өгсөн.

“Даатгуулагчид зориулсан веб” системийг ашиглан нийтдээ 69.9 мянган даатгуулагч сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, төлбөрөө төлөх үйлчилгээнд хамрагдсан бөгөөд “Даатгуулагчид зориулсан веб” систем, “Нийгмийн даатгал” аппликейшн, “Нэгдсэн лавлагааны програм”-аас нийтдээ 2.4 сая орчим QR кодтой шимтгэл төлөлтийн лавлагаа тодорхойлолт авсан байна.

Төрийн үйлчилгээний 109 ТҮЦ машинаар үзүүлж буй үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэн даатгуулагч 2000-2005 оны НД-ын шимтгэл төлөлтийн тодорхойлолтоо авах боломжийг нэмж бүрдүүлсэн. Тайлангийн хугацаанд 156.9 мянган иргэн ТҮЦ машинаас 4 төрлийн лавлагаа тодорхойлолтоо хэвлэн авсан байна.

НДБ-д цахимаар нийтдээ 5803, үүнээс: www.ndaatgal.mn вебсайтын “Санал хүсэлт” буланд 178 санал хүсэлт, асуулт, “Нийгмийн даатгал” аппликейшнээр 5085 санал хүсэлт, ЗГ-ын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд 540 иргэдээс асуулт, хүсэлт ирүүлснийг ажлын 5 хоногт багтаан хариуг хүргүүлж ажиллалаа.

НДБ-аас иргэд, даатгуулагч, ажил олгогчдод үзүүлж буй үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор ХНХЯ-тай хамтран АХБ-ны “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 21 аймаг, 8 дүүргийн НДХ-дэд “Дотоод хяналт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны систем”-ийг нэвтрүүлэн, киоск төхөөрөмжийг байршуулж, 28 аймаг, дүүргийн НДХ-ийн 541 албан хаагч 81762 иргэд, даатгуулагчдад үйлчилгээ үзүүлэн, 10583 иргэд, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллав.

**Нийгмийн даатгалын нийт 34 үйлчилгээний 24 үйлчилгээ цахимжлаа**

1. Цахим архивын үйлчилгээ;
2. НД-д сайн дураар даатгуулах гэрээ цахимаар байгуулах, сунгах;
   - Гар утасны аппликэйшн ашиглах /нийгмийн даатгал/
   - Цахим систем ашиглах /www.ndaatgal.mn/
3. НД-ын шимтгэлийг цахимаар төлөх;
   - НД-ын болон Банкны аппликэйшн ашиглах
   - Интернэт банк
   - Мобайл банк
   - Qpay систем ашиглах
   - Цахим систем ашиглах /www.ndaatgal.mn/
4. НД-ын шимтгэлийн тайланг цахимаар гаргах, хүлээн авах;
   - Цахим систем ашиглах /www.ndaatgal.mn/
5. НД-ын лавлагаа, мэдээлэл, тодорхойлолт цахимаар авах;
   - Цахим систем ашиглах /www.ndaatgal.mn, E-mongolia/
   - ТҮЦ машинаар
   - Гар утасны аппликейшн /нийгмийн даатгал, E-mongolia/
   - Call center төвөөс /1800-0724, 7777-1289/
6. Ажил олгогч шимтгэл төлөлтийн тодорхойлолт цахимаар авах;
7. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа;
8. Өндөр насны тэтгэврийн цахим өөрчлөлт;
9. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн цахим өөрчлөлт;
10. Тэжээгчээ алдсаны тэтгэврийн цахим өөрчлөлт;
11. Цахим нийгмийн даатгалын дэвтэр;
12. Цахим тэтгэврийн дэвтэр;
13. Өргөдөл гомдлыг цахимаар хүлээн авч шийдвэрлэх;
14. Өндөр насны тэтгэвэр олгох;
15. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр олгох;
16. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох;
17. Эмнэлгийн хөдөлмөр магадлах комиссын үйл ажиллагаа олгох, хувь хэмжээ, хугацаа сунгах;
18. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох;
19. Жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгох;
20. Ажилгүйдлийн тэтгэмж олгох;
21. Эмнэлгийн хуудас олгох;
22. Өндөр насны тэтгэвэр тогтоолтын хуудас;
23. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас;
24. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас;

Цахимжуулсан үйлчилгээнээс 16-г сонгон хэмнэлтийн судалгааг 2022 оны байдлаар хийхэд 1 жилд 12.4 тэрбум төгрөгийг даатгуулагч, иргэд, ажил олгогч хэмнэсэн байна. Эндээс үзвэл цахимжуулалт нь үйлчилгээг түргэн шуурхай, ил тод, авилга ашиг сонирхлын зөрчлөөс ангид авах боломжийг бүрдүүлж байна.

Хүснэгт 10. Нийгмийн даатгалын үйлчилгээний цахимжуулалт

**Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулснаар хэмнэсэн зардал**

12/31/2023

| Цахимжуулсан үйлчилгээ | Даатгуулагч | 1 жилд хэмнэсэн зардал /төг/ | 5 жилд хэмнэх зардал /төг/ |
|---|---|---|---|
| 1. Нийгмийн даатгалын дэвтрийг цахимжуулснаар хэмнэсэн зардал | 1,269,375 | 3,021,535,404 | 15,107,677,022 |
| 2. Тэтгэврийн дэвтрийг цахимжуулснаар хэмнэсэн зардал | 476,446 | 701,185,736 | 3,505,928,679 |
| 3. Эмнэлгийн хуудсыг цахимжуулснаар хэмнэсэн зардал | 220,809 | 593,806,076 | 2,969,030,380 |
| 4. Ажилгүйдлийн тэтгэмжийг цахимжуулснаар хэмнэсэн зардал | 30,491 | 76,227,500 | 381,137,500 |
| 5. Тэтгэвэр тогтоолтын хуудсыг цахимжуулснаар хэмнэсэн зардал | 6,627 | 6,627,000 | 33,135,000 |
| 6. НДШ төлөлтийн талаарх тодорхойлолтыг хуудсыг цахимжуулснаар хэмнэсэн зардал /e-Mongolia/ | 4,886,276 | 4,886,276,000 | 24,431,380,000 |
| 7. Иргэн (Даатгуулагч)-д нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолтыг хуудсыг цахимжуулснаар хэмнэсэн зардал | 69,667 | 69,667,000 | 348,335,000 |
| 8. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагааг цахимжуулснаар хэмнэсэн зардал | 30,530 | 30,530,000 | 152,650,000 |
| 9. Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолтыг хуудсыг цахимжуулснаар хэмнэсэн зардал | 81,145 | 81,145,000 | 405,725,000 |
| 10. НДШ-ийн 50 хувь буцаан олголт авах дансны мэдээлэл бүртгүүлэх, засах үйлчилгээг цахимжуулснаар хэмнэсэн зардал | 15,564 | 15,564,000 | 77,820,000 |
| 11. Ажил олгогчийн "Шимтгэлийн цахим систем"-ээр НДШ тайланг цахимаар илгээсэн ажил олгогчийн хэмнэсэн зардал | 526,484 | 526,484,000 | 2,632,420,000 |
| 12. ТҮЦ /Төрийн үйлчилгээний цахим машин/-аар үйлчилгээ үзүүлснээр хэмнэсэн зардал | 150,028 | 150,028,000 | 750,140,000 |
| 13. Нийгмийн даатгалын гар утасны аппликейшнаар Сайн дурын даатгалын гэрээ байгуулснаар хэмнэсэн зардал | 2,878 | 2,878,000 | 14,390,000 |
| 14. Хур систем, ТҮЦ, Төрийн 1 цэгийн үйчилгээний төв, НДХ-үүдэд лавлагаа хэвлэх, бусад хандалт | 23,025,200 | - | - |
| **Нийт дүн** | | **12,387,753,716** | **61,938,768,581** |

### 3.3.8 Эмнэлэг хөдөлмөрийн магадлал

Улсын хэмжээнд хөдөлмөрийн чадварын алдалтын хувь, хугацаа тогтоолгосон нийт 103235 иргэн байгаагаас НДС-аас 64717 иргэн, НХС-аас 38518 иргэн байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.2 хувиар буурсан байна. Үүнээс: Нийслэлийн хэмжээнд 39586 (38.4%) иргэн, орон нутгийн хэмжээнд 63649 (61.6%) иргэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгожээ. Мөн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоолгосон 9778, сунгуулсан 93475, цуцлуулсан 9294, нас барсан 2461, хөдөлмөрийн нөхцөл сольсон 82, ажлын цаг хорогдуулсан 4 иргэн байна.

Тайлангийн хугацаанд нийт 5 удаагийн дахин магадлалаар Сүхбаатар дүүрэг, Говь-Сүмбэр, Дорноговь, Баянхонгор, Сүхбаатар, Баян-Өлгий аймгуудад 1406 иргэнийг дахин магадалж үүнээс: 1025 (79.2%) иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг хэвээр магадлан, 332 (26.3%) иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын заалт, хувь, хугацааг өөрчилж, 49 (4%) иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцлахаар шийдвэрлэлээ. Мөн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгосон даатгуулагч (иргэн)-ийн тоогоор улсын дундаж (3.2)-аас өндөр байгаа Ховд, Архангай, Дорнод аймгуудад ЭМЯ-ны мэргэжлийн салбар зөвлөлүүдтэй хамтарсан магадлал хийж, нийт хөдөлмөрийн чадвар алдсан 2493 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон байдалд хяналт шалгалт хийж, 1430 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэвээр магадлан, 223 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 773 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, заалт, оношийг тус тус өөрчилж магадлав.

### 3.3.9 Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах

Тайлангийн хугацаанд албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр нийт 1046 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 21678 албан хаагчийг хамруулсан байна.

Ажил олгогч, даатгуулагчийн Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх чиглэлээр 3299 удаагийн сургалтыг явуулж, 13949 аж ахуйн нэгжийн 241533 иргэд, даатгуулагчид оролцов.

Нийт 892 удаагийн явуулын үйлчилгээ, 187 нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, 146383 иргэд, даатгуулагчдад НД-ын талаар мэдээлэл, зөвлөгөө, үйлчилгээ үзүүллээ.

Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээний талаар @sigomongolia сошиал хуудсаар НДБ-ын танилцуулга ном, 7 заавар, гарын авлага, 53 постер мэдээлэл, 4 шторк, 71 удаагийн цаг үеийн буюу нийт 133 удаагийн мэдээллийг бэлтгэн түгээснийг давхардсан тоогоор 2.8 сая хүн үзсэн байна.

Хэвлэл мэдээллийн 81 (давхардсан тоогоор) байгууллагаар дамжуулан 578 удаагийн давтамжтайгаар Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд, даатгуулагчдад хүргэж, хэвлэл мэдээллийн байгууллагыг эх сурвалж, мэдээллээр хангав.

Иргэд, даатгуулагчдын санал хүсэлтэд шуурхай хариулах, эргэх холбоог хангах зорилгоор @sigomongolia сошиал хуудсанд чатбот мессенжерийг ажиллуулж, нийт 75519 иргэн мэдээлэл авахаар хандсанаас 60738 иргэн автомат

хариулагчаас мэдээлэл авсан бол 11125 иргэн тухайлсан зөвлөгөө мэдээлэл авахаар, 2619 иргэн бусад асуудлаар, 1037 иргэн санал, гомдлоо илэрхийлж хандсаныг тухай бүр шийдвэрлэв. Мөн 3500 орчим иргэн сэтгэгдэл, санал хүсэлтээ илэрхийлснийг тухай бүр хариулан, санал гомдлыг холбогдох газарт шилжүүлэн шийдвэрлүүллээ.

### 3.3.10 Хяналт шалгалт

Тайлант хугацаанд Өвөрхангай, Сүхбаатар, Төв аймаг, Баянзүрх дүүргийн НДХ-т Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг 2017-2021 онуудын сангийн болон үйл ажиллагааны санхүүгийн баримтууд, тэтгэвэр, тэтгэмжийн хувийн хэрэг болон бусад анхан шатны баримтыг хамруулан шалгалаа.

Хүснэгт 11. Хяналт, шалгалтад хамрагдсан НДХ, зөрчлийн дүн

| Тайлангийн хугацаа | № | Шалгалтад хамрагдсан аймаг, дүүргийн нэр | Илэрсэн төлбөр, зөрчлийн дүн /сая төг/ | Шалгалтын хэлбэр |
|---|---|---|---|---|
| 2022 он | 1 | Төв аймгийн НДХ | 178.3 | Төлөвлөгөөт хяналт, шалгалт |
| | 2 | Сүхбаатар аймгийн НДХ | 24.1 | |
| | 3 | Өвөрхангай аймгийн НДХ | 0 | |
| | 4 | Баянзүрх дүүргийн НДХ | 1,727.5 | |
| | | **Нийт дүн** | **1,929.9** | |

Дээрх шалгалтаар үндэслэлгүй баримтаар шүүхийн шийдвэр гаргуулсан, хуурамч архивын лавлагаа гаргуулан хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авсан 86 хүнтэй холбоотой 1,834.0 сая төгрөг, байцаагчийн алдаанаас 103 хүнд илүү тооцож, олгосон 61.9 сая төгрөг, 50 хүнд дутуу олгосон 44.8 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 44 хүнд үндэслэлгүйгээр олгосон 29.6 сая төгрөг, 1 хүнд дутуу олгосон 1.1 сая төгрөгийн тус тус төлбөр, зөрчил илрүүлэн, 698.5 сая төгрөгийн төлбөрийг нөхөн төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоож 81.9 хувийг барагдуулав.

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, салбарын хэмжээнд ААНБ, иргэнтэй холбоотой асуудлаар аймаг, орон нутагт 401, нийслэлд 503 зөрчлийн шинжтэй нийт 904 үйлдлийг шалгалаа. Шалгалтад хамрагдсан зөрчлийн 89.6 хувь буюу 810 хэргийг хялбаршуулсан журмаар, 0.3 хувь буюу 3 хэргийг зөрчлийн хэрэг нээж, 9.0 хувь буюу 81 гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 1.1 хувь буюу 10 хэргийг харьяаллын дагуу шилжүүлсэн байна. Нийт 894 ААНБ-д 1,155.8 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлэн нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсний 586.5 сая төгрөгийн төлбөр, зөрчлийг орон нутгийн НДХ-үүд, 568.2 сая төгрөгийн төлбөр, зөрчлийг дүүргийн НДХ хариуцан шийдвэрлэж, 2022 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар нийт төлбөр, зөрчлийн 79.2 хувь буюу 915.3 сая төгрөгийг барагдуулаад байна. Шалгалтад хамрагдсан 811 байгууллагад Зөрчлийн тухай хуулийн дагуу 203.0 сая төгрөгийн торгууль оногдуулан арга хэмжээ авч, 98.4 хувь буюу 200.0 сая төгрөгийг

барагдуулав. Нийт торгуулийн 64.2 сая төгрөгийг орон нутгийн НДХ-ийн, 138.8 сая төгрөгийг холбогдох дүүргийн НДХ-ийн дансанд төвлөрүүллээ.

### 3.3.11 Лавлах үйлчилгээ

НД-ын үйлчилгээний лавлах утсаар нийт 113329 иргэн үйлчилгээний ажилтантай холбогдож шаардлагатай мэдээ, мэдээллийг авсан бол автомат хариулагчаас 67886 иргэн мэдээлэл, зөвлөгөө сонссон байна. Автомат хариулагчаас авсан мэдээллийг агуулгаар нь ангилж үзвэл тэтгэвэртэй холбоотой 7020, тэтгэмжтэй холбоотой 27106, сайн дурын даатгалтай холбоотой 6727, ЭХМТК-той холбоотой 1334, НД-ын шимтгэл төлөлттэй холбоотой 5167, ажлын бус цагаар болон бусад асуудлаар 20532 иргэн холбогдсон байна. Мөн автомат хариулагчийн мэдээллийг хуульд орсон өөрчлөлтийн дагуу шинэчлэв.

### 3.3.12 Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

Тайлант хугацаанд БНСУ-д хөдөлмөр эрхэлж байгаа иргэдээс НДС-д нийт 2.5 тэрбум төгрөгийн НД-ын шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, давхардсан тоогоор 13.1 мянган хүнд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын сангаас буцаан олголт авах талаар мэдээлэл, заавар зөвлөгөө өгч, сурталчиллаа. БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын сангаас 74 иргэн шимтгэлээ нэхэмжилж, 51 иргэн 179.5 сая воны шимтгэлээ буцаан авсан бөгөөд 23 иргэний нэхэмжлэх шалгагдаж байна. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэд, даатгуулагчдад 2 улсын хэлэлцээрийн дагуу МУ-ын тэтгэврийн даатгалд 1005 даатгуулагчийг хамруулснаас шинээр 374, гэрээ сунгасан 468, ажил олгогч, даатгуулагчийн хүсэлтээр дахин гэрээг шинэчилсэн 163 хүн байна.

Мөн тус улсад ажиллаж амьдарч байгаа иргэдээс шинээр 215 даатгуулагчийг сайн дурын даатгалд хамруулав.

МУ-ын 34 иргэн БНУУ-аас сар бүр тэтгэвэр авч байна. Тус улсад ажилласан жилээ баталгаажуулж, өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 2 иргэний тэтгэврийг шинээр тогтоож, 26 иргэний холбогдох материалыг илгээгээд байна.

МУ, ОХУ-ын хооронд НД-ын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг шинэчлэхтэй холбоотой зохион байгуулсан 2 талын ажлын хэсгийн цахим уулзалтад оролцож хэлэлцээрийн төсөлд оруулахаар тохирсон нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгаж, талууд өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу хэлэлцээрийн төслийг дотооддоо үргэлжлүүлэн хэлэлцэхээр тохиролцов.

МУ, БНТУ-ын ЗГ хоорондын "Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр"–ийг хэрэгжүүлэхэд ашиглах маягтын загваруудыг 2 талын ажлын хэсгийн гишүүд боловсруулж, 2022 оны 03 дугаар сарын 02-нд талууд албан ёсоор баталснаар хэрэгжилтийг зохион байгуулж эхлэв.

МУ, БНКазУ хооронд тэтгэврийн салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг хэлэлцэх шинжээчдийн ажлын хэсгийн 12 дахь удаагийн уулзалтаар хэлэлцээрийн төслийн эцсийн хувилбарыг тохиролцов.

### 3.3.13 Хүний нөөц

НД-ын салбарын хэмжээнд 1416 (100%) ажилтан, албан хаагч ажиллаж байгаагаас санхүү, эдийн засгийн мэргэжилтэй 1062 (75.0%), эрх зүйч 44 (3.1%), бусад мэргэжлийн албан хаагч 310 (21.9%) байна.

График 11. НДБ-ын албан хаагчдын албан тушаалын ангилал, тоо




НД-ын салбарт ажиллагсдын 70.9 хувь нь эмэгтэйчүүд, 55.6 хувь нь 40 хүртэлх насны хүмүүс байна.

Хүснэгт 12. НДБ-ын албан хаагчдын нас, хүйсийн мэдээлэл

| № | Нас | Тоо | Хүйс | Тоо |
|---|---|---|---|---|
| 1 | 30 хүртэлх | 273 | Эрэгтэй | 412 |
| 2 | 31-40 | 504 | Эмэгтэй | 1004 |
| 3 | 41-50 | 411 | - | - |
| 4 | 51-60 | 228 | - | - |

### 3.3.14 Үйл ажиллагааны зардал

НДБ-ын 2022 оны үйл ажиллагааны зардалд 32.2 тэрбум төгрөг батлагдсанаас 31.2 тэрбум төгрөгийг зарцуулж, 1.0 тэрбум төгрөгийг хэмнэсэн байна. Нийт зардлын 74.0 хувь буюу 23.1 тэрбум төгрөгийг ажилтан, албан хаагчдын цалин хөлс, НД-ын шимтгэлд зарцуулжээ.

График 12. НДБ-ын үйл ажиллагааны зардал /тэрбум.төг/



### 3.3.15 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

НДБ-ын хэмжээнд Шилэн дансны тухай хууль, ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-д заасны дагуу шилэн дансны цахим хуудсанд НД-ын 33 байгууллага, НДС-ийн 31 салбар эрх, нийт 238 хэрэглэгчээр хандан НДС-ийн болон байгууллагын шилэн дансны мэдээллийг төсөв, гүйцэтгэлийн 9, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5, бусад 7, нийт 21 төрлийн мэдээллийг байршуулсан.

НД-ын төв, орон нутгийн байгууллагууд 2022 онд нийт 10069 мэдээллийг байршуулахаас 10040 мэдээллийг мэдээлж, мэдээлэл байршуулалт 99.7 хувьтай байна. Үүнээс:

- Хугацаанд нь байршуулсан мэдээлэл 9565, биелэлт 95.0%
- Хугацаа хоцроосон мэдээлэл 475, нийт байршуулбал зохих мэдээллийн 4.7%
- Мэдээлээгүй 29, нийт байршуулбал зохих мэдээллийн 0.3%-ийг тус тус эзэлж байна.

## ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

НДҮЗ нь системчилсэн үнэлгээнд хамрагдах хугацаанд УИХ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", 2015 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого", ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө. Нийгмийн даатгалын үйлчилгээний маркетингийн дунд хугацааны хөтөлбөр (2019-2022 он)-ийг хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулсан.

2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг бодлогын баримт бичиг, салбарын үндэсний хөтөлбөр, байгууллагын стратеги төлөвлөгөөний зорилтыг чиглэл болгон 67 ажил үйлчилгээ, арга хэмжээг чиг үүргийн дагуу хийж гүйцэтгэхээр боловсруулсан. Төлөвлөгөөт ажил, үйлчилгээ, арга хэмжээний биелэлт тус бүрд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэхэд нийт хэрэгжилт 94.8 хувьтай гарсан бөгөөд төлөвлөлт, түүний биелэлт, хэрэгжилтийн байдал байгууллагын төсөв, санхүү, дотоод үйл ажиллагаа "бүрэн хангалттай" үр дүнд хүрсэн байна гэж дүгнэлээ.

Хэрэгжүүлсэн нийт арга хэмжээний зорилт, арга хэмжээ нь зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн 100 хувийн хэрэгжилттэй 48, зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан 90.0-99.4 хувийн хэрэгжилттэй 10, тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, гүйцэтгэл нь 70.0-74.0 хувийн хэрэгжилттэй 8 арга хэмжээ байна гэж үнэлэгдсэн.

Системчилсэн үнэлгээ хийгдсэн хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, ажил үүргийг зохих түвшинд биелүүлжээ.

НД-ын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, НДС-ийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зохицуулалтыг хийж, холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангах, даатгуулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний үр дүнг улам сайжруулах шаардлагатай байна.

**ТАВ. ЦААШДЫН БОДЛОГО, ЧИГЛЭЛ**

Цаашид Нийгмийн даатгалын багц хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод байдлыг хангах замаар байгууллагын хөгжил, тогтвортой үйл ажиллагааг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, НД-ын үйлчилгээг иргэд даатгуулагч, тэтгэвэр авагчдад чирэгдэлгүй шуурхай хүргэх боломжийг судлах, орчин үеийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, НД-ын талаар төрөөс хэрэгжүүлэх бодлогын хэрэгжилтийг хангуулах, МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл болон ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 2023 онд НД-ын салбарын хэмжээнд дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

- Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлтэй холбогдуулан хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүдийн дагуу дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн батлах, хэрэгжилтийг хангуулах, НД-ын салбарын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг шилэн тунгалаг, авлигаас ангид байлгахад чиглүүлэх;
- “Шинэ сэргэлтийн бодлого”, “Алсын хараа-2050” МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого, ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, МУ-ын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- “Нийгмийн даатгалын мэдээллийн системийг хөгжүүлэх” төслийн хүрээнд НДБ-ын болон сангийн санхүүгийн системийг бүрэн цахимжуулах, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;
- Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд НДС-д 3.1 их наяд төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, 1.2 сая орчим даатгуулагчдад 3.7 их наяд төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардалд зарцуулахаар тусгасан бол зөвхөн тэтгэвэрт 3.3 их наяд төгрөгийг олгохоор байна. Иймд энэ их хэмжээний зарлагад тухай бүр хяналт тавих боломжийг хангах;
- НД-ын шимтгэлээр төвлөрүүлэх орлогын хэмжээ 2022 онтой харьцуулахад 700 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдсэн учраас орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэхэд онцгой анхаарч ажиллах;
- НДС-ийн хөрөнгийг найдвартай оновчтой удирдах, мөнгөн хөрөнгийн хөрвөх чадвар, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангаж эрсдэлийг бууруулах зорилгоор сангийн хөрөнгийг арвижуулахад удирдлагаар хангаж, үр ашгийг өсгөн нэмэгдүүлэх, хууль эрх зүйн боломжийг бүрдүүлэн ажиллах,

Төрийн санд хуримтлуулсан хөрөнгийг өгөөжтэй болгох, эрсдэлийн удирдлагын чадавх, бүтцийг хөгжүүлэх;

- НД-ын үйлчилгээг даатгуулагч, ажил олгогчид илүү хүртээмжтэй, ээлтэй болгох, даатгуулагчдын санхүүгийн хуримтлалыг дэмжсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулан бүрэн цахимжуулах;
- Ажил олгогчоос авах 383.6 тэрбум төгрөгийн НД-ын шимтгэлийн авлагыг барагдуулах, хуримтлагдсан авлагыг бууруулах ажлыг эрчимжүүлэх, ялангуяа төсвийн байгууллагын хувьд шимтгэлийн өр авлага үүсгэхгүй ажиллах, үр дүнг олон нийтэд ил тод мэдээлж байх;
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, төсвийн сахилгыг мөрдөж ажиллах;

Эдгээр зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлснээр Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдаж, иргэд, даатгуулагчид, ажил олгогчид үзүүлэх НД-ын үйлчилгээ улам сайжирна.

## ЗУРГАА. НДБ-ЫН ЭРХ ЗҮЙН АКТЫН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

Хүснэгт 13. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт
/2022 оны жилийн эцсийн байдлаар/

| № | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Хэрэгжилтийн явц |
|---|---|---|
| | | ***НЭГ. ЗГ-ЫН ТОГТООЛ*** |
| 1. | 2021.12.14 №374 Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай | ЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 374 дүгээр тогтоолоор 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Энэхүү тогтоолоор хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд болон байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаанд өөрчлөлт орсон бөгөөд уг өөрчлөлтийн дагуу ЗГ-ын үйл ажиллагааны /2020-2024/ хөтөлбөрийн хэрэгжилтийг, Төсвийн ерөнхийлөн захирагч /Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд/-аас Төсвийн шууд захирагчтай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, хуулийн хугацаанд нь ХНХЯ-д хүргүүлэв. |
| 2. | 2021.12.22 №388 МУ-ын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай | 5.1 НДБ-ын цахим сургалтын 2022 оны төлөвлөгөөг батлуулан, байцаагч ажилтнуудыг чадавхжуулах, ААНБ-ын албан хаагчдад НД-ын хууль тогтоомж, НД-ын үйлчилгээний талаар мэдээлэл олгох сургалтуудыг цахимаар зохион байгуулж ажиллалаа. 2022 онд НДБ-ын цахим хурал, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулж, албан хаагчдыг нэгэн зэрэг олноор нь сургалт, мэдээллээр шуурхай хангах зорилгоор "Динамик сургалтын платформ"-ыг түрээсээр 5 сар ашиглах, зүүм интеграцийн 500 хүний эрхийг 11 сараар ашиглах зэрэг саналыг төсвийн хамт боловсруулан шийдвэрлүүлснээр сургалт, хурал, уулзалтын үйл ажиллагааг цахимаар явуулах нөхцөлийг бүрдүүлсэн.<br>ХНХЯ-ны дэргэдэх "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл"-өөс зарласан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын цахим |

| | | |
|---|---|---|
| | | сургалтын платформыг нэвтрүүлэх тендерийн ажлын даалгаврын санал боловсруулах, програмын хөгжүүлэлтийн явцын сургалт, санал солилцох уулзалтуудад оролцож, “Динамик сургалтын платформ”-ыг хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан.<br>Тайлант хугацаанд дараах сургалтыг цахимаар зохион байгууллаа. Үүнд: “Байгууллагын нууцын тухай” болон “Хувь хүний нууц” “ХАСХОМ”, “Тэтгэвэр, тэтгэмж хариуцсан байцаагчдын”, “Хяналт шалгалтын байцаагчдын”, “Шинэ ажилтны цуврал сургалт”, аймаг, дүүргийн НДХ-ийн албан хаагчдад зориулсан Монгол үндэсний бичгийн сургалт, “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн”-тэй хамтарсан сургалт, Улсын байцаагчийн шалгалтад бэлтгэх сургалтуудыг зохион байгуулж 1289 албан хаагчийг (давхардсан тоогоор) хамруулсан.<br>5.2. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар ЗГ-ын агентлаг тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2022 оны А/109, Б/03 дугаар тушаалуудаар НДЕГ-ын дэд дарга Г.Саран, Т.Батмөнх нарыг албан үүргээс нь тус тус чөлөөлсөн болно.<br>5.3. Хэнтий аймгийн НДХ-ийн дарга Ц.Баярмаа нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул НДЕГ-ын даргын 2022 оны Б/28 дугаар тушаалаар төрийн албанаас чөлөөлж, Б.Нямхатанг албан тушаалын онцлогоос шалтгаалан тус хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон.<br>5.4. 2022 онд гадаад албан томилолтын төсөв батлагдаагүй. НДБ нь сурталчилгааны бүтээгдэхүүн хэвлүүлээгүй бөгөөд НД-ын үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх, даатгуулагч иргэд, тэтгэвэр, тэтгэмж авагчид, ажил олгогчдод НД-ын үйлчилгээний мэдээллийг цахим хэлбэрээр буюу байгууллагын веб сайт, сошиал хуудсаар болон хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран түгээж ажилласан. Мөн УИХ-ын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор НДБ-дын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг 164.0 сая төгрөгөөр бууруулан баталсан байна. НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 06/1234 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн НДХ-ийн дарга нарт төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахад авах зарим арга хэмжээний талаар чиглэлийг хүргүүлэв. |
| 3. | 2022.01.05<br>№01<br>Журам шинэчлэн батлах тухай | “Коронавируст халдварын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг баримтлан улбар шар түвшинд шилжсэн тул хязгаарлалтгүйгээр үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлж ажилласан. |
| 4. | 2022.01.05<br>№07<br>Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | 5.4. НДБ-ын 2022 оны сургалтын төлөвлөгөөнд “Үндэсний монгол бичгийн ур чадварыг дээшлүүлэх, монгол бичгээр албан бичиг боловсруулах ур чадвар олгох сургалтыг тусгаж хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. НДЕГ-аас салбарын байцаагч ажилтнуудын монгол бичгийн ур чадварыг дээшлүүлэх Монгол бичгийн цахим сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд долоо хоног бүрийн Даваа, Пүрэв гаригт |

| | | |
|---|---|---|
| | | зохион байгуулж, салбарын нийт 220 гаруй албан хаагчийг хамруулсан.<br>5.5. Монгол хэлний тухай хууль, МУ-ын ЗГ-ын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-т заасны дагуу 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих ажлын хүрээнд НД-ын салбарын хэмжээнд ажилтнуудын монгол бичгийн чадварыг дээшлүүлэх, улмаар албан хэргээ монгол бичгээр хөтлөх бэлтгэлийг хангах, ажлын байрны хаяг, сургалт сурталчилгааны материалыг монгол бичгээр хослуулан бичиж хэвших зэрэг тодорхой арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллах тухай чиглэлийг аймаг, дүүргийн НДХ-дэд хүргүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд НД-ын төв, орон нутгийн байгууллагаас хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хагас болон бүтэн жилийн байдлаар нэгтгэн ХНХЯ-нд хүргүүллээ. |
| 5. | 2022.02.01<br>№63<br>Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай | ЗГ-ын 2022 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “НДС-аас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд баримтлах заавар”-ыг боловсруулан аймаг, дүүргийн НДХ-дэд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд НДС-аас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, НДС-аас олгох ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу олгож байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлэн, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500000 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400000 төгрөгт хүргэж 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тэтгэвэр авагчдад тэтгэврийг нэмэгдсэн дүнгээр олгосон болно. Энэ арга хэмжээний дүнд 2022 оны 01 дүгээр сарын байдлаар тэтгэвэр авч байсан 469.2 мянган хүний тэтгэвэр дунджаар 130.8 мянган төгрөгөөр, үүнээс бүрэн тэтгэвэр авч байсан 385.1 мянган хүний тэтгэвэр дунджаар 150.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэвэр авч байсан 84.1 мянган хүний тэтгэвэр дунджаар 100.0 мянган төгрөгөөр, дундаж тэтгэвэр 424.8 мянган төгрөгөөс 555.6 мянган төгрөгт хүрч, дунджаар 130.8 мянган төгрөгөөр буюу 30.8 хувиар тус тус нэмэгдсэн. Нийт тэтгэвэр авагчдын 58.1 хувь нь доод хэмжээ (350000 төг)-ний тэтгэвэр авч байсан бол тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний дараа тэтгэвэр авагчдын 76.1 хувь нь доод хэмжээ (500000 төг) авдаг боллоо. Тэтгэвэр нэмэгдүүлэхийн өмнө бүрэн тэтгэврийн доод хэмжээнээс дээш (350001-435000 төгрөг) тэтгэвэр авч байсан 75.4 мянган хүн, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээнээс дээш (300001-348000 төгрөг) тэтгэвэр авч байсан 4.4 мянган хүн, нийт 79.8 мянган хүний тэтгэврийн хэмжээ нь тэтгэврийн доод хэмжээ (500000 төг)-ээр өөрчлөн тогтоогдсон. |
| 6. | 2022.03.09<br>№107<br>Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод | НДЕГ-ын 2022 оны цалингийн санд уг нэмэгдлийг олгох хөрөнгө тусгагдаагүй тул, 2023 оны цалингийн санд өөрчлөлт оруулан олгохоор тусгасан. |

| | | |
|---|---|---|
| | хэмжээг тогтоох тухай | |
| 7. | 2022.05.11 №187 Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагаа ны талаар авах зарим арга хэмжээний тухай | 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ЗГ-ын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-д НДБ-тай холбоотой 557 санал хүсэлт, өргөдөл гомдлыг иргэдээс ирүүлсэн бөгөөд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг ажлын 5-10 өдөрт багтаан хариуг өгч ажиллав. Ирсэн санал хүсэлтийн дийлэнхийг тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой асуудлууд эзэлж байна.<br>Мөн ЗГ-ын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-д нэр бүхий 8 иргэнээс ирүүлсэн 1.0 сая төгрөгөөс доош цалинтай даатгуулагчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 50.0 хувийн буцаан олголттой холбоотой саналыг ЗГ-аас УИХ-д өргөн барьсан “Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөлд тусгуулахаар ХНХЯ-нд уламжилсан. |
| 8. | 2022.05.11 №192 Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай | НДЕГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн “Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоох тухай” Б/155 дугаар тушаалын хавсралтаар төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг нэр бүхий 12 албан хаагчийн албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоож, 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн тооцон олгож байна. |
| 9. | 2022.05.11 №197 Журам, жагсаалт батлах тухай | НДБ нь 2015 онд төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон бөгөөд "Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах, ашиглах журам"-ын дагуу уг сүлжээгээр дамжуулан төрийн 18 байгууллагатай НД-ын 69 төрлийн мэдээлэл (сервис)-ийг солилцож байна. Үйл ажиллагаандаа нууцлал хамгаалал, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. |
| 10. | 2022.05.18 №201 Журам батлах тухай | “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хууль, “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуульд заасны дагуу НДБ-аас нээлттэй болгох 16 нэр төрлийн өгөгдлийн жагсаалтыг гарган ЦХХХЯ-нд хүргүүлсэн. ЦХХХЯ-наас өгсөн чиглэлийн дагуу нээлттэй өгөгдлийн цахим портал ”opendata.gov.mn”-д НДБ-аас нээлттэй болгох 16 нэр төрлийн 20 мэдээллийг тус бүр 4 хувилбараар, улирал, хагас жилээр байршуулсан. |
| 11. | 2022.05.25 №203 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | 1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар ЗГ-ын агентлаг тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын тушаалаар НДЕГ-ын дэд дарга Г.Саран, Т.Батмөнх нарыг албан үүргээс нь тус тус чөлөөлсөн.<br>1.3. НДБ-ын цахим сургалтын 2022 оны төлөвлөгөөг батлуулан, байцаагч ажилтнуудыг чадавхжуулах, ААНБ-ын албан хаагчдад НД-ын хууль тогтоомж, НД-ын үйлчилгээний талаар мэдээлэл олгох сургалтуудыг цахимаар зохион байгуулж ажиллалаа.<br>2022 онд НДБ-ын цахим хурал, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулж, албан хаагчдыг нэгэн зэрэг олноор сургалт, мэдээллээр шуурхай хангах зорилгоор “Динамик сургалтын платформ”-ыг түрээсээр 5 сар ашиглах, зүүм интеграцийн 500 хүний эрхийг 11 сараар ашиглах зэрэг саналыг төсвийн хамт боловсруулан шийдвэрлүүлснээр сургалт, хурал, уулзалтын үйл ажиллагааг цахимаар явуулах нөхцөлийг бүрдүүлсэн.<br>1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсэгт заасан хэрэгжүүлэхийг хориглосон төсөл, хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлээгүй болно. |

| | | |
|---|---|---|
| 12. | 2022.05.25<br>№204<br>Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | ТӨБЗГ-ын 2022 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/1/981 дүгээр “Мэдэгдэл хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор НДЕГ-ын эзэмшилд байсан Хьюндай Соната-8 0370-УНҮ, Хьюндай Соната-8 0625-УБҮ, Форд Эверест 0468-УБЯ улсын дугаар бүхий 3 ширхэг тээврийн хэрэгслийг ЗГ-ын Авто баазад хүлээлгэн өгч, ТӨБЗГ-ын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” тогтоолын дагуу ЗГ-ын авто бааз, ЭЗХЯ-нд балансаас балансад шилжүүлсэн болно. |
| 13. | 2022.07.05<br>№266<br>Дүрэм шинэчлэн батлах тухай | ЗГ-ын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 266 дугаар тогтоолоор баталсан “Гомдлын шаардлагын зөвлөлийн дүрэм”-ийн 2.2, 2.4 дэх хэсэгт тус тус заасны дагуу НДЕГ-ын 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/129 дүгээр тушаалаар НДЕГ-ын дэргэдэх Гомдлын шаардлагын төв зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан. Тус зөвлөл нь 2022 онд шинэчлэн байгуулагдсанаасаа хойш 4 удаа хуралдаж, нийт 31 иргэний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.<br>Мөн НДЕГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/132 дугаар тушаалаар аймаг, дүүргийн НДХ-ийн дэргэдэх Гомдлын шаардлагын салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Аймаг, дүүргийн НДХ-ийн дэргэдэх Гомдлын шаардлагын салбар зөвлөл нь шинэчлэн байгуулагдсанаасаа хойш 4 удаа хуралдаж, нийт 362 иргэний өргөдөл гомдлыг хэлэлцэн, 265 иргэний хүсэлтийг ханган шийдвэрлэж, 90 иргэний хүсэлтийг хууль тогтоомжийн заалтыг хангахгүй гэж үзэн татгалзсан, мөн 7 иргэнээс нэмэлт баримт бүрдүүлж дахин хэлэлцэхээр шийдвэрлэсэн байна. |
| 14. | 2022.08.24<br>№314<br>Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээг батлах тухай | Уг заалт тус газарт хамааралгүй тул хасуулах саналтай. |
| 15. | 2022.09.22<br>№350<br>Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай | Уг заалт тус газарт хамааралгүй тул хасуулах саналтай. |
| 16. | 2022.12.07<br>№448<br>Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай | Уг тогтоолын хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнана. |

| | | |
|---|---|---|
| 17. | 2022.12.28 №481 Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний талаар | Уг тогтоолыг хяналтад бүртгэж авсан бөгөөд хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнана. |
| 18. | 2022.12.28 №487 Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай | Уг тогтоолыг хяналтад бүртгэж авсан бөгөөд хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнана. |
| 19. | 2022.12.28 №488 Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай | Уг тогтоолыг хяналтад бүртгэж авсан бөгөөд хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнана. |
| 20. | 2022.12.28 №490 Журамд өөрчлөлт оруулах тухай | Уг тогтоолыг хяналтад бүртгэж авсан бөгөөд хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнана. |
| 21. | 2022.12.28 №491 Журамд өөрчлөлт оруулах тухай | Уг тогтоолыг хяналтад бүртгэж авсан бөгөөд хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнана. |
| ***ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ*** | | |
| 1. | 2022.10.10 №163 Ажлын хэсэг байгуулах тухай | Үндсэн ажлын хэсгийн гишүүнээр Тамгын газрын дарга Б.Батсүх томилогдон ажилласан бөгөөд Дэд ажлын хэсэгт Мэдээллийн технологийн төвийн Орлогч захирал Д.Энхбат ажилласан. НД-ын нэгдсэн мэдээллийн сангаас 4 удаа даатгуулагчдын ХХТАО-ын судалгаа (нууцлалтай)-г гарган ажлын хэсгийг мэдээллээр хангасан. |
| 2. | 2022.12.09 №214 Ажлын хэсэг байгуулах тухай | Өргөдөл, гомдол шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах зорилгоор иргэд, даатгуулагч, байгууллага, ажил олгогчоос НДБ, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судлан үзэж, шуурхай шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, шийдвэрлэлтийн дүн, мэдээ авах, дуудлагын төвд ажиллах албан хаагчдын нэрс, хуваарь, баримтлан ажиллах удирдамжийг онцгой анхаарч, биечлэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийслэлийн нийгмийн даатгалын газар, аймгийн НДХ-ийн дарга |

| | | |
|---|---|---|
| | | нарт тус тус үүрэгжүүлэн ажиллалаа. 2022 онд нийт 236 өргөдөл, гомдол ирснийг шийдвэрлэсэн байна. |
| | ***ГУРАВ. ЗГ-ЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ*** | |
| 1. | 2021.12.14 №64 Төрийн хяналт шалгалтын нөхцөл байдал, түүнийг хөнгөвчлөх арга хэмжээний талаар | Улс орны эдийн засаг болон цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан салбарын хэмжээнд гадагшаа чиглэсэн хяналт, шалгалтын ажлыг түр хугацаагаар хойшлуулан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, дотоодын хяналт шалгалтыг эрчимжүүлж ажиллах талаар 21 аймаг, 9 дүүргүүдэд 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 07/419 дүгээр албан бичгээр зөвлөмж хүргүүллээ.<br>Тайлант хугацаанд Төв, Сүхбаатар, Өвөрхангай аймаг, Баянзүрх дүүргийн НДХ-т НД-ын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд шалгалт хийсэн. |
| 2. | 2022.01.12 №03 Агентлагийн дарга нарт | НДЕГ-ын нэгжийн болон, хэлтсийн дарга нарт өгсөн үүргийн дагуу 0-5 насны хүүхэдтэй 18 албан хаагчид гэрээсээ буюу цахимаар ажиллах боломжийг бүрдүүлэн, “ABLE” програмаар ажлын цагт хяналт тавин ажилласан. |
| 3. | 2022.02.16 №11 Агентлагийн дарга нарт | Төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулж цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх ажлыг өргөжүүлэн дараах ажил үйлчилгээнүүдийг цахимаар үзүүлэх боломжийг бүрдүүллээ. Тухайлбал:<br>1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын дагуу ХЧТА, жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг цахимаар олгохтой уялдуулан ажил олгогч болон даатгуулагч эрүүл мэндийн байгууллагаас олгож буй эмнэлгийн хуудсыг цахимаар хүлээн авах нөхцөлийг бүрдүүллээ. Ингэснээр эрүүл мэндийн байгууллагаас илгээсэн албан журмын даатгуулагчийн ХЧТА-ны эмнэлгийн хуудсыг ажил олгогч “Шимтгэлийн цахим систем”-ээр хүлээн авч, тэтгэмжийн тооцооллыг нягтлан шалгаж шаардлагатай тохиолдолд засварлан НДБ-д цахимаар илгээх, тэтгэмж олгосон тайланг хэвлэн авч баталгаажуулах боломжтой болсон.<br>2. Сайн дураар даатгуулагч, сайн дураар даатгуулагч эх “Даатгуулагчид зориулсан веб” систем, E-Mongolia порталыг ашиглан хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлтээ цахимаар гаргах нөхцөлийг бүрдүүллээ.<br>3. Албан журмын даатгуулагч эх жирэмсэн болон амаржсаны тэтгэмж авах хүсэлтээ дээрх хоёр системээр цахимаар гаргах боломжийг бүрдүүлсэн.<br>Дээрх боломжуудыг бүрдүүлснээр 2022 онд 850 гаруй эрүүл мэндийн байгууллагаас нийтдээ 163.0 мянган эмнэлгийн хуудсыг цахимаар хүлээн авсан байна.<br>4. Хөдөлмөрийн харилцаа нь дуусгавар болсон даатгуулагч “Даатгуулагчид зориулсан веб” систем, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia-гаар дамжуулан ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ цахимаар гаргах боломжийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд 2022 онд нийтдээ 1.6 мянган хүсэлт цахимаар илгээгдсэн байна. |
| 4. | 2022.03.16 №16 Төсвийн захирагч нарт | Өөрийн хөрөнгөөр зохион байгуулагдах нийт 3,924.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 худалдан авалт, улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар 300 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 худалдан авалтын төлөвлөгөөг батлан, шалгаруулалтыг “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ээр зохион байгууллаа. Үүнд: |

| | | |
|---|---|---|
| | | 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан 2 худалдан авалт:<br>- XI.2.3.1 НДЕГ-ын тоног төхөөрөмж худалдан авах 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын ажлыг 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс 03 дугаар сарын 02-ны өдрийн хооронд зохион байгуулж хөрөнгүүдийг хүлээн авч гэрээний дагуу 44.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгон барааг бүртгэлд тусгалаа.<br>- XI.2.2.1 НДЕГ-ын байрны их засварын 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн ажлыг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс 03 дугаар сарын 28-ны өдрийн хооронд зохион байгуулсан боловч "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хуулиар төсөв хасагдсан байна.<br>2. НДС-аас санхүүжүүлэхээр батлагдсан 9 худалдан авалт:<br>- НДБ-ын үйл ажиллагаанд ашиглагдах сервер лицензийн худалдан авалтыг 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 04 дүгээр сарын 18-ны хооронд зохион байгуулж шалгарсан "Ай Ти Зон" XXK-тай худалдан авалтын гэрээг байгуулж гэрээний дүн болох 1,014.2 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгалаа.<br>- Ажлын компьютер болон түүний дагалдах тоног төхөөрөмжийн худалдан авалтыг 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 05 дугаар сарын 09-ний өдрийн хооронд зохион байгуулж, шалгарсан "Ай Ти Зон" XXK-тай худалдан авалтын гэрээг байгуулан гэрээний дүн болох 1,185.1 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгав.<br>- НДЕГ-ын харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэгчийг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 22-ны өдрийн хооронд сонгон шалгаруулж 39.5 сая төгрөгийн хамгийн бага үнийн санал ирүүлсэн "Шүтээн-Уул" XXK-тай ажлын гэрээ байгууллаа.<br>- НДБ-дын албан хэрэгцээнд шаардлагатай тэтгэврийн хувийн хэрэг хэвлэн нийлүүлэгчийг 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрөөс 07 дугаар сарын 01-ний өдрийн хооронд сонгон шалгаруулж 20.5 сая төгрөгийн хамгийн бага үнийн санал ирүүлсэн "Соёмбопринтинг" XXK-тай гэрээ байгуулж тэтгэврийн хувийн хэргийг хэвлүүлсэн байна.<br>- НДБ-дын албан хэрэгцээнд шаардлагатай зөөврийн компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмж худалдан авалтыг (зөөврийн компьютер 1, хэвлэх, хувилах төхөөрөмж 2, програм хангамж 3) 3 багц болгон тендер зарлаж, шалгарсан компаниудтай худалдан авалтын гэрээг байгуулан, 933.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгав.<br>- НДБ-дын албан хэрэгцээнд шаардлагатай ажлын компьютер, принтерийг "Ай Ти Зон" XXK-тай худалдан авах гэрээг байгуулан 157.8 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгалаа.<br>- НДБ-ын албан хэрэгцээнд шаардлагатай 47.15 сая төгрөгийн анхан шатны маягтыг шууд гэрээ байгуулан худалдан авав.<br>Дээрх худалдан авалтуудын сонгон шалгаруулалтыг зохион байгуулснаар нийт 3,974.18 сая төгрөгийн гэрээг байгуулжээ. |
| 5. | 2022.03.30<br>№18<br>ЗГ-ын агентлагийн дарга нарт | 4. НДБ-ын хэмжээнд удирдлагаас өгсөн үүрэг даалгавар бүрэн хэрэгжсэн.<br>5. НДБ-ын хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2022 оны хагас жилийн байдлаар 97.3 хувьтай үнэлэгдсэн. МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны үйл |

| | | |
|---|---|---|
| | | ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу СЯ-аас Шилэн дансны нэгдсэн цахим хуудас (https://gap.mof.gov.mn/)-ыг шинээр хөгжүүлэх, шинэчилсэн хувилбарыг 2023 онд нэвтрүүлэх ажил үе шаттайгаар хийгдэж байна.<br>Энэ ажлын хүрээнд шинэчилсэн системд бүртгүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах, мөн системийн шинэчлэлтэй холбоотой зохион байгуулах цахим сургалтуудад оролцож байна. |
| 6. | 2022.04.13<br>№22<br>ЗГ-ын агентлагийн дарга нарт | НДЕГ-ын нэгжийн дарга нар болон аймаг(нийслэл), дүүргийн НДХ (газар)-ийн удирдлага болох нийт 40 албан тушаалтнаас биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай эсэх, спортын холбоодын тэргүүний үүрэг хашдаг эсэх, сонгуульт албан тушаалтны ажлыг хавсран гүйцэтгэдэг эсэх талаарх судалгааг авч үзэхэд төрийн бус байгууллагатай 1, спортын холбоодын тэргүүний үүрэг гүйцэтгэдэг 2 албан тушаалтан байна гэсэн судалгаа гарсан байна. Дээрх албан тушаалтнуудад ЗГ-ын хуралдааны 22 дугаар тэмдэглэлийг ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 03/1063 дугаар албан бичгийн хамт хүргүүлж, спортын чиглэлийн төрийн бус байгууллага эрхлэх, спортын холбооны тэргүүний үүргийг хавсран гүйцэтгэхээс татгалзан, чөлөөлөгдөх арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгов. |
| 7. | 2022.05.11<br>№28<br>ЗГ-ын агентлагийн дарга нарт | Цахим гарын үсгийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор НД-ын үйлчилгээ үзүүлэх, түүнчлэн салбарын хэмжээнд ашиглагдаж буй мэдээллийн системүүдэд нэвтрэх, албан хэрэг хөтлөлт зэрэг ажилд тоон гарын үсэг ашиглах ажлыг шат дараатайгаар нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Энэ ажлын хүрээнд НДБ-дад тоон гарын үсэг ашиглах заавры баталсан. Мөн “Үндэсний дата төв”-тэй хамтран НД-ын байцаагч ажилтнуудад тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулж, нийт 950 ажилтанд тоон гарын үсэг олгоод байна. |
| 8. | 2022.05.31<br>№31<br>ЗГ-ын агентлагийн дарга нарт | УИХ-ын 2020 оны 45 дугаар тогтоол болон 2021 оны 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, салбарын дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д заасны дагуу хөгжлийн зорилтот хөтөлбөрт тусган боловсруулах ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд НДБ-ын хэмжээнд тусгах арга хэмжээний саналыг ХНХЯ-нд хүргүүлсэн. |
| 9. | 2022.08.17<br>№41<br>Агентлагийн дарга нарт | НДБ-ын албаны цахим хаяг болох undeg@ndaatgal.mn цахим шуудангийн системээр дамжуулан иргэдэд шаардлагатай мэдээлэл, мэдэгдэл хүргэж, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэн ажиллаж байгаа бөгөөд нийт 77 иргэний хүсэлтэд хариу өгсөн. |
| 10. | 2022.08.17<br>№41<br>Агентлагийн дарга нарт | ЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 374 дүгээр “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолын дагуу урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ХНХЯ-нд хүргүүлнэ. |
| 11. | 2022.08.17<br>№41<br>Агентлагийн дарга нарт | 2. НДБ-ын хэмжээнд удирдлагаас өгсөн үүрэг даалгавар бүрэн хэрэгжсэн.<br>3. МУ-ын ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 2022 оны гүйцэтгэлийн |

| | | |
|---|---|---|
| | | төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийг 94.8 хувиар дүгнэж “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэж, үнэлгээний тайланг ХНХЯ-нд хүргүүлсэн.<br>Зохион байгуулалтын нэгжүүдийн 2022 оны эхний хагас жилийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний дунджийг 93.4 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэж, удирдлагад хүргүүлсэн.<br>4. Дотоод аудит, мониторингийн газрын нэмэлт ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу НД-ын төв, орон нутгийн байгууллагуудад хүргүүлсэн хариутай бичиг, хугацаатай үүрэг даалгаврын биелэлтэд дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай ажлын саналыг тайлан мэдээний хамт удирдлагад танилцуулсан. |
| 12. | 2022.09.22<br>№46<br>Агентлагийн дарга нарт | Батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийг хяналтад бүртгэж, дотоод сүлжээгээр салбарын удирдлага болон албан хаагчдад танилцуулан ажиллаж байна. Мөн НДЕГ-ын холбогдох газраас, хууль тогтоомжтой холбоотой холбогдох чиглэл, зөвлөмжийг аймаг (нийслэл) дүүргийн НДХ-дэд тухай бүр хүргэн ажиллаж байна. |
| 13. | 2022.10.05<br>№48<br>ЗГ-ын агентлагийн дарга нарт | Тус газар нь ямар нэг тусгай зөвшөөрөл олгодоггүй тул хасуулах саналтай. |
| 14. | 2022.10.10<br>№49<br>ЗГ-ын агентлагийн дарга нарт | Төв болон орон нутгийн НДХ client/server програмууд ашигладаг тул “Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршуулах боломжгүй болно. |
| 15. | 2022.11.16<br>№55<br>ЗГ-ын агентлагийн дарга нарт | Уг тогтоолыг хяналтад бүртгэж авсан бөгөөд хэрэгжилтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ХЗДХЯ-нд хүргүүлсэн байна. |
| 16. | 2022.11.30<br>№57<br>ЗГ-ын агентлагийн дарга нарт | Төсвийн хэмнэлтийн тухай хууль болон төсвийн хөрөнгөөр төрийн байгууллагууд шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулахгүй байх талаарх чиглэлийг 2022 оны 12 дугаар 12-ны өдрийн 03/2316 дугаар албан бичгээр аймаг (нийслэл) дүүргийн НДХ-дэд хүргүүлэв. |
| 17. | 2022.12.07<br>№58<br>ЗГ-ын агентлагийн дарга нарт | НД-ын төв болон орон нутгийн байгууллагууд нь гадаад томилолтын зардал гаргаагүй, төсвийн хөрөнгөөр шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулаагүй бөгөөд урсгал зардлыг 987.3 сая төгрөгөөр хэмнэж ажилласан. |
| 18. | 2022.12.07<br>№58<br>ЗГ-ын агентлагийн дарга нарт | Үндэсний дата төвтэй холбогдон Төрийн мэдээлэл солилцооны “Docx” системийг Эйбл програмтай холбуулахаар тусгай эрх (Токен)-ийг авч, хүсэлтийг 2022 оны 12 дугаар сард “Эйбл Соост” ХХК руу цахимаар илгээсэн.<br>Энэхүү ажлын хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнана. |
| ***ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР*** | | |
| 1. | 2022.07.04<br>№03<br>Цахим шилжилтийг | НД-ын үндсэн үзүүлэлтүүдийн мэдээ, ЭМД-ын хамралтын мэдээллийг сар бүр, аймаг, дүүргээр гарган мэдээллээр ханган ажиллав. |

| | | |
|---|---|---|
| | эрчимжүүлэх тухай | ҮСХ-ны даргын баталсан маягтын дагуу НДБ-ын 2021 оны жилийн эцэс, 2022 оны эхний хагас жилийн статистик мэдээллийг тус тус хугацаанд нь гаргаж ХНХЯ, ҮСХ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтэд хүргүүлэв.<br>"НДС-ийн сарын мэдээний тойм" мэдээг ndaatgal.mn вебсайтад байршуулав.<br>ХНХЯ болон бусад газруудад нийт 36 удаа мэдээ, мэдээлэл хүргүүлэн ажиллав. |
| | ***ТАВ. НДҮЗ-ИЙН ТОГТООЛ*** | |
| 1. | 2021.12.27<br>№20<br>Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тогтоох тухай | НДҮЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 20 дугаар тогтоолоор өндөр насны тэтгэвэр тогтоолгоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл ("К")-ийг 2022-2024 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жилээр тус тус тогтоосон.<br>Энэхүү тогтоолыг 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05/141 дүгээр албан бичгээр аймаг, дүүргийн НДХ-дэд хүргүүлэн, чиглэл зөвлөмж өгч мэргэжил арга зүйгээр ханган хэрэгжилтийг зохион байгуулав.<br>Уг зөвлөмжөөр тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан даатгуулагчид нэрийн дансны аргаар эсхүл 7 жилийн цалин хөлсний дунджаас тооцон тэтгэвэр тогтоолгох нөхцөлүүдийн аль өөрт ашигтайг сонгох боломжийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллах талаар чиглэл өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. |
| 2. | 2021.12.27<br>№21<br>Нэрийн дансны 2021 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай | НДҮЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2021 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 11.6 хувиар баталсан.<br>Энэхүү тогтоолыг 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05/141 дүгээр албан бичгээр аймаг, дүүргийн НДХ-дэд хүргүүлэн, чиглэл зөвлөмж өгч мэргэжил арга зүйгээр ханган хэрэгжилтийг зохион байгуулав.<br>Уг албан бичгээр даатгуулагчийн нэрийн дансны холбогдох мэдээллийг "Нийгмийн даатгал" аппликейшн, нийгмийн даатгалын байгууллагын www.ndaatgal.mn цахим хуудас дахь "Даатгуулагчид зориулсан веб" зэргээс харах, татах, хэвлэж авах боломжийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллах чиглэл, зөвлөмжийг аймаг, дүүргийн НДХ-дэд өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.<br>НДҮЗ-ийн 2021 оны 21 дүгээр тогтоолын дагуу нэрийн дансны програмд даатгуулагчдын нэрийн дансны 2020 оны эцсийн үлдэгдэл, 2021 оны шимтгэлийн орлогод хүү тооцох ажлыг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулах, нэрийн дансны 2021 оны мэдээлэх хуудсыг даатгуулагчийн НД-ын цахим дэвтэр, www.ndaatgal.mn веб сайтын даатгуулагчид зориулсан веб, "Нийгмийн даатгал" аппликейшн, ХУР систем, E-Mongolia зэрэгт цахимаар мэдээлэх боломжийг бүрдүүлэх талаар 2022 оны 01 дүгээр 06-ны өдрийн 05/29 дүгээр албан бичгээр Мэдээллийн технологийн төвд хүргүүлэн, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.<br>Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд 2021 оны жилийн эцсийн байдлаар 1.5 сая даатгуулагчийн 24.2 их наяд төгрөгийн шимтгэл болон шимтгэлд тооцсон хүү хийсвэрээр |

| | | |
|---|---|---|
| | | бүртгэв. Мөн нэрийн дансны тооцоолол, үлдэгдэл шалгах, тэтгэвэр тооцох програмд 95.5 мянган даатгуулагч тэтгэврийн нэрийн дансны үлдэгдлээ, 49.4 мянган даатгуулагч ирээдүйд авах тэтгэврийн тооцоллоо өөрөө тооцоолж үзэх боломжийг бүрдүүлэв. |
| 3. | 2021.12.27<br>№23<br>2022 оны төсвийн хуваарь батлах тухай | НДС-ийн 2022 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27.3.6 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн нарийвчилсан хуваарь", "Аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын сангийн орлого зарлагын 2022 оны төсвийн хуваарь, "Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2022 оны төсвийн хуваарь"-ийг тус тус боловсруулан НДҮЗ-ийн "2022 оны төсвийн хуваарь батлах тухай" 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлуулан аймаг, дүүргийн НДХ-дэд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. |
| 4. | 2021.12.28<br>№24<br>Тогтоолд өөрчлөлт оруулах тухай | Уг тогтоолын дагуу КЭХА-аас 22.15 тэрбум төгрөгийн өртөгтэй 46 хөрөнгө хүлээн авч данс бүртгэлд тусгасан болно. |
| 5. | 2022.02.23<br>№01<br>Өр төлбөрт хөрөнгө хүлээн авах тухай | Уг тогтоолоор КЭХА-аас нэхэмжилсэн сангийн төлбөрт хөрөнгө тооцон авах зөвшөөрөл олгогдож холбогдох ажлуудыг зохион байгуулахыг НДЕГ-т даалгасан. Үүнд:<br>Тогтоолоор КЭХА-аас 25.9 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 86 ширхэг үл хөдлөх хөрөнгийг НДС-ийн нэхэмжилсэн өр төлбөрт суутган авахыг зөвшөөрсөн боловч 2.9 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 32 ширхэг хөрөнгүүдийг хүлээн авч нягтлан бодох бүртгэлд бүртгэх ажлууд хийгдлээ.<br>НДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан хөрөнгийн мөнгөн дүн, тоо ширхэг өөрчлөгдсөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:<br>1. Дээрх хөрөнгүүдийг ЭМДЕГ авахаар санал гаргасан тул харилцан тохиролцож 8.4 тэрбум төгрөгийн 22 ширхэг хөрөнгийг сонгосон.<br>2. НДЕГ-аас 8.8 тэрбум төгрөгийн 8 ширхэг хөрөнгийг дахин үнэлгээ хийлгэхээр хүсэлт гаргасан.<br>3. НДЕГ, ЭМДЕГ-аас үнэлгээ өндөр хэмээн 5.7 тэрбум төгрөгийн 25 ширхэг хөрөнгийг хүлээн авахаас татгалзсан.<br>НДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор баталсан КЭХА-аас нэхэмжилсэн сангийн төлбөрт тооцон авах мөнгөн дүн дээрх шалтгаанаар өөрчлөгдсөн тул тус тогтоолын 1 дэх хэсгийн хөрөнгийн нийт мөнгөн дүн, тоо ширхэгт өөрчлөлт оруулан хавсралтыг хүчингүй болгон дахин шинэчлэн батлуулах санал хүсэлтийг НДҮЗ-д гаргасан болно.<br>Мөн КЭХА-аас нэхэмжилсэн сангийн төлбөрт шилжүүлэн хүлээн авсан хөрөнгийг худалдан борлуулахаар "Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам"-ын хэрэгжилтийг ханган дуудлага худалдааг 2022 оны 06 дугаар сарын 28, мөн оны 08 дугаар сарын 17, 09 дүгээр сарын 27, 11 дүгээр сарын 08-ны өдрүүдэд тус тус зарлан 1.8 тэрбум төгрөгийн 6 ширхэг хөрөнгийг 1.9 тэрбум төгрөгөөр худалдан борлуулсан. |
| 6. | 2022.02.23<br>№02 | Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27.3.6 дахь заалтыг |

| | | |
|---|---|---|
| | 2022 оны тодотгосон төсвийн хуваарь батлах тухай | хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2022 оны тодотгосон төсвийн нарийвчилсан хуваарь, “Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2022 оны тодотгосон төсвийн хуваарь”-ийг тус тус боловсруулан НДҮЗ-ийн “2022 оны тодотгосон төсвийн хуваарь батлах тухай” 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлуулан аймаг, дүүргийн НДХ-дэд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. |
| 7. | 2022.08.01 №04 Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай | НДҮЗ-ийн 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн “Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 04 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нөхцөлийг хангасан даатгуулагчийн оршуулгын тэтгэмжийн болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмжийн хэмжээг хоёр сая төгрөгөөр шинэчлэн, оршуулгын тэтгэмж олгох нөхцөлийг хангасан, амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг гурван сая таван зуун мянган төгрөгөөр тус тус тогтоож, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр шийдвэрлэсэн.<br>Иймд НДС-аас оршуулгын тэтгэмж олгоход НДЕГ-ын даргын 2022 оны А/72 дугаар тушаалаар баталсан “Тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”-ыг баримтална. Харин амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт оршуулгын тэтгэмж олгохдоо энэхүү журмын 3.12-т заасан баримт бичгээс гадна Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албанаас Эрүүл мэндийн сайдын баталсан маягтын дагуу олгосон “Даатгуулагчийг донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлэхээр болсон талаарх тодорхойлолт”-ыг үндэслэнэ.<br>Амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт оршуулгын тэтгэмж олгосон тохиолдолд хоёр сая төгрөгийн оршуулгын тэтгэмжийг давхардуулан олгохгүй. Энэ тохиолдолд 2022 онд нас барсан даатгуулагчийн ар гэрээс оршуулгын тэтгэмж авах хүсэлтээ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 24.4.2-т заасан хугацаанд багтааж гаргасан нь 2023 он дамжсан бол энэ зөвлөмжид заасан хэмжээгээр оршуулгын тэтгэмжийг олгоно. Харин шинээр тогтоосон амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш уг тэтгэмжийг авах эрх үүссэн тохиолдолд олгоно. |
| | ***ЗУРГАА. БУСАД /хамтарсан тушаал/*** | |
| 1. | 2021.12.30 №704 Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай | ТӨБЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 704 дүгээр тогтоол, НДЕГ-ын даргын 2022 оны А/179 дүгээр тушаалын дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулж, төв, орон нутгийн НДБ-дын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 312 нэрийн 1039 ширхэг нийт 2,575.989.345.10 төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан үнэ бүхий хөрөнгийг данснаас хасаж нийт 779,457.656.63 төгрөгөөр үнэлгээг шинэчлэн тогтоож, ашиглах |

| | | |
|---|---|---|
| | | хугацаа, шинэчлэн тогтоосон үнээр нягтлан бодох бүртгэлд тусгасан.<br>Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгаж "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д тухай бүр бүртгэсэн болно.<br>Уг ажлын биелэлтийг НДЕГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/611 дүгээр албан бичгээр ТӨБЗГ-т хүргүүлсэн. |
| 2. | 2021.12.30<br>№721<br>Хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай | ТӨБЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 721 дүгээр тогтоол, НДЕГ-ын даргын А/180 дугаар тушаалын дагуу төв, орон нутгийн НДБ-дын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, эвдэрч гэмтсэн, сэргээн засварлаж цаашид ашиглах боломжгүй болсон нийт 134 нэр төрлийн 1020 ширхэг 271,262.962.80 төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор актлах ажлыг зохион байгуулж, данс бүртгэлээс хассан.<br>Хөрөнгийн хөдлөлийг зохих журмын дагуу нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгаж, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д тухай бүр бүртгэсэн болно.<br>Уг ажлын биелэлтийг НДЕГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/611 дүгээр албан бичгээр ТӨБЗГ-т хүргүүлсэн. |
| 3. | 2022.11.11<br>03/2951<br>Чиглэл хүргүүлэх тухай | ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаас ирүүлсэн "Чиглэл хүргүүлэх тухай" 03/2951 дугаар албан бичгийг НДЕГ-ын нэгжийн дарга нарт танилцуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг үүрэг болгосон. |

## ДОЛОО. УИХ-ЫН БАЙНГЫН ХОРООНООС ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

1. Жил бүрийн эхэнд Үндэсний зөвлөлүүдийн хуралдаанаар банкинд байршуулах хадгаламжийн дээд хэмжээ, хүүгийн түвшинг банк тус бүрээр батлах, тухайн банкинд байршуулах хадгаламжийн хэмжээ, хүүгийн хувийг тогтоохдоо банкны зохистой харьцааг хангаж байгаа эсэх, активын хэмжээгээр эрсдэл даах чадвар, ашиг, алдагдлын хэмжээг нь тооцдог байх;

- Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, НДҮЗ-ийн 2018 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг арилжааны банкинд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам"-ын 3 дугаар хэсгийн 3.4.1, 3.5 дугаар заалтын дагуу 2022 онд хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн талаар санал, танилцуулга, тооцоолол, хамтарсан шийдвэрийн төслийг бэлтгэж, НДҮЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж СЯ, Монголбанкинд санал авахаар хүргүүлсэн боловч СЯ-аас дэмжээгүй тул арилжааны банкинд хугацаатай хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн хэмжээ батлагдаагүй учраас сангийн мөнгөн хөрөнгийг арилжааны банкинд хугацаатай хадгаламж хэлбэрээр байршуулаагүй болно.

2. Хадгаламжийн хүүг тогтоохдоо үзүүлэлт болон авсан хүүгийн дунджаас гадна банкнуудын санал болгосон өндөр хүүг харгалзан тогтоох;

- Арилжааны банкинд сангийн мөнгөн хөрөнгийг хугацаатай хадгаламж хэлбэрээр байршуулах шийдвэр гараагүй тул хадгаламжийн хүү тогтоогдоогүй болно.

3. НДС-аас Капитал банкинд байршуулсан хадгаламжийн хөрөнгийг холбогдох яам, агентлагийн төсвийн эрх захирагч нарт арга хэмжээ авч ажиллахыг чиглэл болгох.

***Капитал банк***

- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/96 дугаар тушаалаар Капитал банкийг албадан татан буулгах шийдвэр гарч, Банкны эрх хүлээн авагч томилогдсоноос хойших хугацаанд КЭХА-аас төлбөр нэхэмжлэх, нэхэмжилсэн төлбөрийг төлүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар НДҮЗ-ийн хуралдаанаар 11 удаа хэлэлцэж, 6 тогтоол батлан гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- КЭХА-аас авах НДС-ийн өр төлбөрийг барагдуулах ажлыг хэрэгжүүлэх зорилгоор Авлигатай тэмцэх газар, Эрүүгийн цагдаагийн газар, Монголбанк, Нийслэлийн прокурорын газартай мэдээлэл солилцон, хамтран ажиллаж байна.
- КЭХА-аас 104.2 тэрбум төгрөг нэхэмжилсэн ба мөнгөн хэлбэрээр 9.9 тэрбум төгрөг, хөрөнгөөр 25.1 тэрбум төгрөгийн төлбөр барагдуулснаар 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар 69.2 тэрбум төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.
- Эрх бүхий дараах байгууллагуудын шийдвэр зөвшөөрлийн дагуу КЭХА-тай “Өр төлбөр барагдуулж, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх гэрээ”-г байгуулан, 25.0 тэрбум төгрөгийн 78 ширхэг хөрөнгийг авч, санхүүгийн тайлан мэдээнд тусгасан.
- НДҮЗ-ийн 2018 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам”-ыг баримтлан КЭХА-аас хүлээн авсан хөрөнгүүдийг борлуулан 8 удаагийн дуудлага худалдаагаар 6.2 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 20 хөрөнгө, мөн гэрээгээр 2.1 тэрбум төгрөгийн 10 хөрөнгийг борлуулж нийт 30 ширхэг хөрөнгийг 8.3 тэрбум төгрөгөөр тус тус борлуулсан байна.
- Мөн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах боломжтой хөрөнгүүдийг түрээслэн, нийт 237.2 сая төгрөгийн түрээсийн орлогыг НДС-д төвлөрүүлсэн.

***Чингис хаан банк***

Чингис хаан банк ХХК нь 2019 оны 10 дугаар сараас Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-т заасан “....хадгаламж эзэмшигч, харилцагчийн мөнгөн хөрөнгийг бүрэн байлгаж, тэдгээрийн анхны шаардлагаар гаргаж өгөх, шилжүүлэх” шаардлагын дагуу нийгмийн даатгалын төлбөр тооцоог хугацаанд нь гүйцэтгэж чадахгүй болсон.

Тус банкинд НДС-ийн мөнгөн хөрөнгө 2022 оны эхний байдлаар 100.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

Тайлант хугацаанд Чингис хаан банкинд байршиж буй мөнгөн хөрөнгийг буцаан татахаар банкны гүйцэтгэх болон төлөөлөн удирдах зөвлөлийн удирдлагуудтай удаа дараа уулзалт зохион байгуулж, холбогдох ажлуудыг гүйцэтгэснээр нэхэмжилсэн дүнгээс тухайн жилд 4.4 тэрбум төгрөгийн өр төлбөрийг барагдуулж, жилийн эцсийн байдлаар 96.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

***Үндэсний хөрөнгө оруулалтын банк***

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Үндэсний хөрөнгө оруулалтын банктай 2008 онд “Хамтран ажиллах гэрээ” байгуулж хамтран ажилласан байдаг.

Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-т заасан хадгаламж эзэмшигч, харилцагчийн мөнгөн хөрөнгийг бүрэн байлгаж, тэдгээрийн анхны шаардлагаар гаргаж өгөх, шилжүүүлэх” шаардлагыг 2019 оны 10 дугаар сараас эхлэн хангахгүй болсон.

2021 оны 04 дүгээр сард Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө болох 5.3 тэрбум төгрөгийг гаргуулах тухай нэхэмжлэл гаргасан.

Тус банкинд нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 12.4 сая, хүүгийн авлага 34.3 сая төгрөг, нийт 46.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

2022 оны 06 дугаар сарын 09-нд 17 сая, 2022 оны 06 дугаар сарын 13-нд 29.7 сая төгрөгийг харилцах данснаас шилжүүлж тус банкны дансыг хаасан.

**НДС-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл**

Хүснэгт 14. НДС-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, тэрбум.төг
/2022 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар/

| № | Банкны нэр | Харилцахын үлдэгдэл | Нийт дүн |
|---|---|---|---|
| 1 | Голомт банк | 49.6 | 49.6 |
| 2 | Капитрон банк | 9.15 | 9.15 |
| 3 | Төрийн банк | 265.7 | 265.7 |
| 4 | Төрийн сан | 244.6 | 244.6 |
| 5 | Хаан банк | 303.7 | 303.7 |
| 6 | Хас банк | 1.9 | 1.9 |
| 7 | Худалдаа хөгжлийн банк | 20.7 | 20.7 |
| 8 | БНСУ-ын Үрий банк | 0.09 | 0.09 |
| 9 | Чингис хаан банк | 96.1 | 96.1 |
| **Нийт дүн** | | **991.6** | **991.6** |
| | Капитал банкнаас авах авлага | 69.3 | 69.3 |

2022 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар арилжааны 9 банкинд 991.6 тэрбум төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй, төрийн санд 244.6 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.

Хавсралт 1

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

/2022 оны жилийн эцсийн байдлаар/

| Дугаар | Зүйл заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Биелэлт | Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) |
|---|---|---|---|---|
| | | ***МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ*** | | |
| 1. | Бүх заалт. | **2022.10.10 №163 Ажлын хэсэг байгуулах тухай** | Үндсэн ажлын хэсгийн гишүүнээр Тамгын газрын дарга Б.Батсүх томилогдон ажилласан бөгөөд Дэд ажлын хэсэгт Мэдээллийн технологийн төвийн Орлогч захирал Д.Энхбат ажилласан.<br>Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сангаас 4 удаа даатгуулагчдын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын судалгаа /нууцлалтай/-г гарган ажлын хэсгийг мэдээллээр хангасан. | 100 |
| 2. | Бүх заалт. | **2022.12.09 №214 Ажлын хэсэг байгуулах тухай** | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/181 дүгээр тушаалаар иргэд, даатгуулагч, байгууллага, ажил олгогчоос нийгмийн даатгалын байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судлан үзэж, шуурхай шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, шийдвэрлэлтийн дүн, мэдээ авах, дуудлагын төвд ажиллах албан хаагчдын нэрс, хуваарь, баримтлан ажиллах удирдамжийг онцгой анхаарч, биечлэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийслэлийн нийгмийн даатгалын газар, аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт тус тус үүрэгжүүлэн өргөдөл, гомдол шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газарт нийт 236 өргөдөл, гомдол ирснийг шийдвэрлэсэн байна | 100 |
| | | ***ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ*** | | |
| 1. | | **2021.12.14 №374 Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай** | Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 374 дүгээр тогтоолоор 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 206 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Энэхүү тогтоолоор хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд болон байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаанд өөрчлөлт орсон бөгөөд уг өөрчлөлтийн дагуу Засгийн газрын үйл ажиллагааны /2020-2024/ хөтөлбөрийн хэрэгжилтийг, Төсвийн ерөнхийлөн захирагч /Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд/-аас Төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-тай | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж хуулийн хугацаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэн ажиллалаа. | |
| 2. | 5. | **2021.12.22<br>№388<br>Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай** | 5.1 Нийгмийн даатгалын байгууллагын цахим сургалтын 2022 оны төлөвлөгөө батлуулан, байцаагч ажилтнуудыг чадавхжуулах, аж ахуйн нэгж байгууллагын албан хаагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын үйлчилгээний талаар мэдээлэл олгох сургалтуудыг цахимаар зохион байгуулж ажиллалаа.<br>2022 онд Нийгмийн даатгалын байгууллагын цахим хурал, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулж, олон албан хаагчдыг нэгэн зэрэг сургалт, мэдээллээр шуурхай хангах зорилгоор “Динамик сургалтын платформ”-ыг түрээсээр 5 сар ашиглах, зоом интеграцийн 500 хүний эрхийг 11 сараар ашиглах зэрэг саналыг төсвийн хамт боловсруулан шийдвэрлүүлснээр сургалт, хурал, уулзалтын үйл ажиллагааг цахимаар явуулах нөхцөлийг бүрдүүлсэн. ХНХЯ-ны дэргэдэх “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-өөс зарласан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын цахим сургалтын платформыг нэвтрүүлэх тендерийн ажлын даалгаврын санал боловсруулах, програмын хөгжүүлэлтийн явцын сургалт, санал солилцох уулзалтуудад оролцож, “Динамик сургалтын платформ”-ыг хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан. Тайлант хугацаанд дараах сургалтыг цахимаар зохион байгууллаа. Үүнд: “Байгууллагын нууцын тухай” болон “Хувь хүний нууц” “ХАСХОМ”, “Тэтгэвэр, тэтгэмж хариуцсан байцаагчдын”, “Хяналт шалгалтын байцаагчдын”, “Шинэ ажилтны цуврал сургалт”, аймаг, дүүргийн НДХ-ийн албан хаагчдад зориулсан Монгол үндэсний бичгийн сургалт, “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн”-тэй хамтарсан сургалт, Улсын байцаагчийн шалгалтад бэлтгэх сургалтуудыг зохион байгуулж 1289 албан хаагчийг (давхардсан тоогоор) хамруулсан.<br>5.2. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар Засгийн газрын агентлаг тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/109 тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэд дарга Г.Саранг, мөн оны 06 дугаар сарын 29-ний өдрийн Б/03 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дэд дарга Т.Батмөнх нарыг албан үүргээс нь тус тус чөлөөлсөн болно.<br>5.3. Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Ц.Баярмаа нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны Б/28 дугаар тушаалаар төрийн албанаас чөлөөлөгдсөн. Албан тушаалын онцлогоос шалтгаалан тус хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Б.Нямхатанг томилсон.<br>5.4. 2022 онд гадаад албан томилолтын төсөв батлагдаагүй.<br>Нийгмийн даатгалын байгууллага нь сурталчилгааны бүтээгдэхүүн хэвлүүлээгүй бөгөөд нийгмийн даатгалын үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх, | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | даатгуулагч иргэд, тэтгэвэр, тэтгэмж авагчид, ажил олгогчдод нийгмийн даатгалын үйлчилгээний мэдээллийг цахим хэлбэрээр буюу байгууллагын веб сайт, сошиал хуудсаар болон хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран түгээж ажилласан. Мөн Улсын Их Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн “Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг 164.0 сая төгрөгөөр бууруулан баталсан байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн газрын даргын 2022 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 06/1234 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахад авах зарим арга хэмжээний талаар чиглэлийг хүргүүлэв. | |
| 3. | 1, 2, 3 | **2022.01.05<br>№01<br>Журам шинэчлэн батлах тухай** | “Коронавируст халдварын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг баримтлан улбар шар түвшинд шилжсэн тул хязгаарлалтгүйгээр үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлж ажилласан. | 100 |
| 4. | 5. | **2022.01.05<br>№07<br>Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай** | 5.4. Нийгмийн даатгалын байгууллагын 2022 оны сургалтын төлөвлөгөөнд “Үндэсний монгол бичгийн ур чадварыг дээшлүүлэх, монгол бичгээр албан бичиг боловсруулах ур чадвар олгох сургалтыг тусгаж хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газраас салбарын байцаагч ажилтнуудын монгол бичгийн ур чадварыг дээшлүүлэх Монгол бичгийн цахим сургалтыг 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд долоо хоног бүрийн Даваа, Пүрэв гаригт зохион байгуулж, салбарын нийт 220 гаруй албан хаагчийг хамруулсан байна.<br>5.5. Монгол хэлний тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-т заасны дагуу 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих ажлын хүрээнд нийгмийн даатгалын салбарын хэмжээнд ажилтнуудын монгол бичгийн чадварыг дээшлүүлэх, улмаар албан хэргээ монгол бичгээр хөтлөх бэлтгэлийг хангах, ажлын байрны хаяг, сургалт сурталчилгааны материалыг монгол бичгээр хослуулан бичиж хэвших зэрэг тодорхой арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллах тухай чиглэлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 01/491 дүгээр албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагаас хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хагас болон бүтэн жилийн байдлаар нэгтгэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэн ажиллалаа. | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5. | Бүх заалт | **2022.02.01 №63 Тэтгэврийн хэмжээг нэмэгдүү лэх тухай** | Засгийн газрын 2022 оны "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/17 дугаар тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд баримтлах заавар"-ыг боловсруулан 2022 оны 05/221 дүгээр албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.<br>Тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу олгож байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлэн, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500 000 төг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400 000 төгрөгт хүргэж 2022 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тэтгэвэр авагчдад тэтгэврийг нэмэгдсэн дүнгээр олгосон болно.<br>Тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний дүнд 2022 оны 01 дүгээр сарын байдлаар тэтгэвэр авч байсан 469.2 мянган хүний тэтгэвэр дунджаар 123.8 мянган төгрөгөөр, үүнээс бүрэн тэтгэвэр авч байсан 385.1 мянган хүний тэтгэвэр дунджаар 129.2 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэвэр авч байсан 84.1 мянган хүний тэтгэвэр дунджаар 98.7 мянган төгрөгөөр, дундаж тэтгэвэр 425.5 мян.төгрөгөөс 549.3 мянган төгрөгт хүрч дунджаар 123.8 мянган төгрөгөөр буюу 28.5 хувиар нэмэгдсэн.<br>Нийт тэтгэвэр авагчдын 58.1 хувь нь доод хэмжээ (350 000 төг)-ний тэтгэвэр авч байсан бол тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний дараа доод хэмжээ (500 000 төг)-ээр тэтгэвэр авагчдын тоо 76.1 хувьд хүрлээ. Тэтгэвэр нэмэгдүүлэхийн өмнө бүрэн тэтгэврийн доод хэмжээнээс дээш (350 001-435 000 төгрөг) тэтгэвэр авч байсан 75.4 мянган хүн, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээнээс дээш (300 001-348 000 төгрөг) тэтгэвэр авч байсан 4.4 мянган хүн, нийт 79.8 мянган хүний тэтгэврийн хэмжээ нь тэтгэврийн доод хэмжээ (500 000 төг)-гээр өөрчлөн тогтоогдсон. | 100 |
| 6. | | **2022.03.09 №107 Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай** | Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны цалингийн санд уг нэмэгдлийг олгох хөрөнгө тусгагдаагүй тул, 2023 оны цалингийн санд өөрчлөлт оруулан олгохоор тусгасан. | 90 |
| 7. | | **2022.05.11 №187 Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны** | 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв"-д нийгмийн даатгалын байгууллагатай холбоотой 540 санал хүсэлт, өргөдөл гомдлыг иргэдээс ирүүлсэн бөгөөд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг ажлын 5-10 өдөрт багтаан хариуг өгч ажиллав. Ирсэн санал | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | **талаар авах зарим арга хэмжээний тухай** | хүсэлтийн дийлэнхийг тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой асуудлууд эзэлж байна.<br>Мөн Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-д нэр бүхий 8 иргэнээс ирүүлсэн 1.0 сая төгрөгөөс доош цалинтай даатгуулагчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 50.0 хувийн буцаан олголттой холбоотой саналыг Засгийн газраас УИХ-д өргөн барьсан “Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөлд тусгуулахаар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/782 дугаар албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд уламжилсан. | |
| 8. | | **2022.05.11<br>№192<br>Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай** | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн “Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоох тухай” Б/155 дугаар тушаалын хавсралтаар төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг нэр бүхий 12 албан хаагчийн албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон болно. Шинэчлэн тогтоосон цалинг 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн тооцон олгохыг үүрэг болгосон байна. | 100 |
| 9. | | **2022.05.11<br>№197<br>Журам, жагсаалт батлах тухай** | Нийгмийн даатгалын байгууллага нь 2015 онд төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон бөгөөд "Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах, ашиглах журам"-ын дагуу уг сүлжээгээр дамжуулан төрийн 18 байгууллагатай нийгмийн даатгалын 69 төрлийн мэдээлэл /сервис/-ийг солилцож байна. Үйл ажиллагаандаа нууцлал хамгаалал, аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. | 100 |
| 10. | | **2022.05.18<br>№201<br>Журам батлах тухай** | “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хууль, “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуульд заасны дагуу нийгмийн даатгалын байгууллагаас нээлттэй болгох 16 нэр төрлийн өгөгдлийн жагсаалтыг гарган Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. ЦХХХЯ-наас өгсөн чиглэлийн дагуу нээлттэй өгөгдлийн цахим портал ”opendata.gov.mn”-д нийгмийн даатгалын байгууллагаас нээлттэй болгох 16 нэр төрлийн 20 мэдээллийг тус бүр 4 хувилбараар, улирал, хагас жилээр байршуулсан.<br>Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудаст дээрх 16 нэр төрлийн нээлттэй 20 мэдээллийг 4 хувилбараар, улирал, хагас жилийн байдлаар тус тус байршуулсан. | 100 |
| 11. | 1.1, 1.3, 1.4 | **2022.05.25<br>№203<br>Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай** | 1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар Засгийн газрын агентлаг тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/109 тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэд дарга Г.Саранг, мөн оны 06 дугаар сарын 29-ний өдрийн Б/03 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дэд дарга Т.Батмөнх нарыг албан үүргээс нь тус тус чөлөөлсөн болно.<br>1.3. Нийгмийн даатгалын байгууллагын цахим сургалтын 2022 оны төлөвлөгөөг батлуулан, байцаагч ажилтнуудыг чадавхжуулах, аж ахуйн нэгж байгууллагын албан хаагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | үйлчилгээний талаар мэдээлэл олгох сургалтуудыг цахимаар зохион байгуулж ажиллалаа.<br>2022 онд Нийгмийн даатгалын байгууллагын цахим хурал, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулж, олон албан хаагчдыг нэгэн зэрэг сургалт, мэдээллээр шуурхай хангах зорилгоор “Динамик сургалтын платформ”-ыг түрээсээр 5 сар ашиглах, зоом интеграцийн 500 хүний эрхийг 11 сараар ашиглах зэрэг саналыг төсвийн хамт боловсруулан шийдвэрлүүлснээр сургалт, хурал, уулзалтын үйл ажиллагааг цахимаар явуулах нөхцөлийг бүрдүүлсэн.<br>1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсэгт заасан хэрэгжүүлэхийг хориглосон төсөл, хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлээгүй болно. | |
| 12. | 1,9 | **2022.05.25**<br>**№204**<br>**Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай** | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/1/981 дүгээр “Мэдэгдэл хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын эзэмшилд байсан Хьюндай Соната-8 0370-УНҮ, Хьюндай Соната-8 0625-УБҮ, Форд Эверест 0468-УБЯ улсын дугаар бүхий 3 ширхэг тээврийн хэрэгслийг тээврийн хэрэгслийн гэрчилгээ, татвар төлөгчийн гэрчилгээ, автомашины түлхүүрийн хамт 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 09:00 цагт Засгийн газрын Авто баазад хүлээлгэн өгөв.<br>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” тогтоолын дагуу Засгийн газрын авто бааз, Эдийн засаг, хөгжлийн яаманд балансаас балансад шилжүүлсэн болно. | 100 |
| 13. | Бүх заалт. | **2022.07.05**<br>**№266**<br>**Дүрэм шинэчлэн батлах тухай** | Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 266 дугаар тогтоолоор баталсан “Гомдлын шаардлагын зөвлөлийн дүрэм”-ийн 2.2, 2.4 дэх хэсэгт тус тус заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн А/129 дүгээр тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Гомдлын шаардлагын төв зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан.<br>Тус зөвлөл нь 2022 онд шинэчлэн байгуулагдсанаасаа хойш 4 удаа хуралдаж, нийт 31 иргэний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.<br>Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн А/132 дугаар тушаалаар аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Гомдлын шаардлагын салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.<br>Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Гомдлын шаардлагын салбар зөвлөл нь шинэчлэн байгуулагдсанаасаа хойш 4 удаа хуралдаж, нийт 362 иргэний өргөдөл гомдлыг хэлэлцэн, 265 иргэний хүсэлтийг хангаж шийдвэрлэж, 90 иргэний хүсэлтийг хууль тогтоомжийн заалтыг хангахгүй гэж үзэн татгалзсан, мөн 7 иргэнээс нэмэлт баримт бүрдүүлж дахин хэлэлцэхээр шийдвэрлэсэн байна. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 14. | | **2022.08.24 №314 Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээг батлах тухай** | Нийгмийн даатгалын ерөнхий газрын газар, хэлтсийн дарга нарт танилцуулж санал авсан боловч тусгайлан санал өгсөн газар хэлтэс байхгүй болно. | Одоогийн байдлаар Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх боломжгүй тул хасуулах саналтай байна. |
| 15. | | **2022.09.22 №350 Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай** | | Үүрэг даалгавар өгөгдөөгүй тул хасуулах саналтай байна. |
| 16. | | **2022.12.07 №448 Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай** | Уг тогтоолыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад байгаа тогтоол шийдвэрт бүртгэж авсан бөгөөд хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнана. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 17. | | **2022.12.28 №481 Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний талаар** | Уг тогтоолыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад байгаа тогтоол шийдвэрт бүртгэж авсан бөгөөд хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнана. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 18. | | **2022.12.28 №487 Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын** | Уг тогтоолыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад байгаа тогтоол шийдвэрт бүртгэж авсан бөгөөд хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнана. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | **жагсаалтыг шинэчлэн батлах тухай** | | |
| 19. | | **2022.12.28 №488 Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай** | Уг тогтоолыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад байгаа тогтоол шийдвэрт бүртгэж авсан бөгөөд хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнана. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 20. | | **2022.12.28 №490 Журамд өөрчлөлт оруулах тухай** | Уг тогтоолыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад байгаа тогтоол шийдвэрт бүртгэж авсан бөгөөд хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнана. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 21. | | **2022.12.28 №491 Журамд өөрчлөлт оруулах тухай** | Уг тогтоолыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад байгаа тогтоол шийдвэрт бүртгэж авсан бөгөөд хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнана. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| ***ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ*** | | | | |
| 1. | Бүх заалт. | **2021.12.14 №64 Төрийн хяналт шалгалтын нөхцөл байдал, түүнийг хөнгөвчлөх арга хэмжээний талаар** | Улс орны эдийн засаг болон цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан салбарын хэмжээнд гадагшаа чиглэсэн хяналт, шалгалтын ажлыг түр хугацаагаар хойшлуулан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, дотоодын хяналт шалгалтыг эрчимжүүлж ажиллах талаар 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 07/419 дүгээр албан бичгээр зөвлөмж хүргүүллээ.<br>Харин тайлант хугацаанд Төв, Сүхбаатар, Өвөрхангай аймаг, Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд шалгалт хийсэн. | 100 |
| 2. | 2. | **2022.01.12 №03 Агентлагийндарга нарт** | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргаас Нийгмийн даатгалын ерөнхий газрын нэгжийн болон, хэлтсийн дарга нарт өгсөн үүргийн дагуу 0-5 насны хүүхэдтэй 18 албан хаагчид гэрээсээ буюу цахимаар ажиллах боломжийг бүрдүүлэн, “ABLE” програмаар ажлын цагт хяналт тавин ажилласан. | 100 |
| 3. | Бүх заалт | **2022.02.16 №11 Агентлагийн дарга нарт** | Төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулж цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх ажлыг өргөжүүлэн дараах ажил үйлчилгээнүүдийг цахимаар үзүүлэх боломжийг бүрдүүллээ. Тухайлбал:<br>1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын дагуу хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг цахимаар олгохтой уялдуулан ажил олгогч болон даатгуулагч эрүүл мэндийн байгууллагаас олгож буй эмнэлгийн хуудсыг цахимаар хүлээн авах нөхцөлийг бүрдүүллээ. Ингэснээр эрүүл мэндийн байгууллагаас илгээсэн албан | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | журмын даатгуулагчийн ХЧТА-ы эмнэлгийн хуудсыг ажил олгогч “Шимтгэлийн цахим систем”-ээр хүлээн авч, тэтгэмжийн тооцооллыг нягтлан шалгаж шаардлагатай тохиолдолд засварлан нийгмийн даатгалын байгууллагад цахимаар илгээх, тэтгэмж олгосон тайланг хэвлэн авч баталгаажуулах боломжтой болсон.<br>2. Сайн дураар даатгуулагч, сайн дураар даатгуулагч эх “Даатгуулагчид зориулсан вэб” систем, E-Mongolia порталыг ашиглан хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлтээ цахимаар гаргах нөхцөлийг бүрдүүллээ.<br>3. Албан журмын даатгуулагч эх жирэмсэн болон амаржсаны тэтгэмж авах хүсэлтээ дээрх хоёр системээр цахимаар гаргах боломжийг бүрдүүлсэн.<br>Дээрх боломжуудыг бүрдүүлснээр 2022 онд 850 гаруй эрүүл мэндийн байгууллагаас нийтдээ 163.0 мянган эмнэлгийн хуудсыг цахимаар хүлээн авсан байна.<br>4. Хөдөлмөрийн харилцаа нь дуусгавар болсон даатгуулагч “Даатгуулагчид зориулсан вэб” систем, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia-аар дамжуулан ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ цахимаар гаргах боломжийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд 2022 онд нийтдээ 1.6 мянган хүсэлт цахимаар илгээгдсэн байна. | |
| 4. | | **2022.03.16<br>№16<br>Төсвийн захирагч нарт** | Өөрийн хөрөнгөөр зохион байгуулагдах нийт 3,924.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 худалдан авалт, улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар 300 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 худалдан авалтын төлөвлөгөөг батлан, шалгаруулалтыг “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ээр зохион байгууллаа. Үүнд:<br>1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан 2 худалдан авалт:<br>- XI.2.3.1 Нийгмийн даатгалын ерөнхий газрын тоног төхөөрөмж худалдан авах 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын ажлыг 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс 03 дугаар сарын 02-ны өдрийн хооронд зохион байгуулж хөрөнгүүдийг хүлээн авч гэрээний дагуу 44.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгон барааг бүртгэлд тусгалаа.<br>- XI.2.2.1 Нийгмийн даатгалын ерөнхий газрын байрны их засварын 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн ажлыг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс 03 дугаар сарын 28-ны өдрийн хооронд зохион байгуулсан боловч “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар төсөв хасагдсан байна.<br>2. Нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр батлагдсан 9 худалдан авалт:<br>- Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах сервер лицензийн худалдан авалтыг 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 04 дүгээр сарын 18-ны хооронд зохион байгуулж шалгарсан “Ай Ти Зон” ХХК-тай худалдан авалтын гэрээг байгуулж гэрээний дүн болох 1,014.2 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгалаа. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | - Ажлын компьютер болон түүний дагалдах тоног төхөөрөмжийн худалдан авалтыг 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 05 дугаар сарын 09-ний өдрийн хооронд зохион байгуулж, шалгарсан "Ай Ти Зон " ХХК-тай худалдан авалтын гэрээг байгуулан гэрээний дүн болох 1,185.1 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгав.<br>- Нийгмийн даатгалын ерөнхий газрын харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэгчийг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 22-ны өдрийн хооронд сонгон шалгаруулж 39.5 сая төгрөгийн хамгийн бага үнийн санал ирүүлсэн "Шүтээн-Уул" ХХК-тай ажлын гэрээ байгууллаа.<br>- Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай тэтгэврийн хувийн хэрэг хэвлэн нийлүүлэгчийг 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрөөс 07 дугаар сарын 01-ний өдрийн хооронд сонгон шалгаруулж 20.5 сая төгрөгийн хамгийн бага үнийн санал ирүүлсэн "Соёмбопринтинг" ХХК-тай гэрээ байгуулж тэтгэврийн хувийн хэргийг хэвлүүлсэн байна.<br>- Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай зөөврийн компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмж худалдан авалтыг (зөөврийн компьютер 1, хэвлэх, хувилах төхөөрөмж 2, програм хангамж 3) 3 багц болгон 2022 оны 08 дугаар сарын 23-ны өдрөөс 09 дүгээр сарын 23-ны өдрийн хооронд зохион байгуулж, шалгарсан "Саммит компьютер технологи" ХХК, "Бодь-Электроникс" ХХК, "Ай Ти Зон" ХХК-тай худалдан авалтын гэрээг байгуулан гэрээний дүн болох 933.9 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгав.<br>- Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай ажлын компьютер, принтер худалдан авалтыг 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 21-ний өдрийн хооронд зохион байгуулж, шалгарсан "Ай Ти Зон" ХХК-тай худалдан авах гэрээг байгуулан гэрээний дүн болох 157.8 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгалаа.<br>- Нийгмийн даатгалын байгууллагын албан хэрэгцээнд шаардлагатай 47.15 сая төгрөгийн анхан шатны маягтыг шууд гэрээ байгуулан худалдан авав.<br>Дээрх худалдан авалтуудын сонгон шалгаруулалтыг зохион байгуулснаар нийт 3,974.18 сая төгрөгийн гэрээг байгуулжээ. | |
| 5. | 4, 5. | **2022.03.30<br>№18<br>Засгийн газрын агентлагийн дарга нарт** | 4. Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд удирдлагаас өгсөн үүрэг даалгавар бүрэн хэрэгжсэн.<br>5. Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2022 оны хагас жилийн байдлаар 97.3 хувьтай үнэлэгдсэн. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Сангийн яамнаас Шилэн дансны нэгдсэн цахим хуудас (https://gap.mof.gov.mn/)-ыг шинээр хөгжүүлэх, шинэчилсэн хувилбарыг 2023 онд нэвтрүүлэх ажил үе шаттайгаар хийгдэж байна. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Энэ ажлын хүрээнд шинэчилсэн системд бүртгүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах, мөн системийн шинэчлэлтэй холбоотой зохион байгуулах цахим сургалтад тухай бүр оролцох талаар 2022 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 04/1586 дугаар албан бичгийг Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудад хүргүүлж, холбогдох зөвлөгөө мэдээллийг өгч ажиллаж байна. | |
| 6. | 1, 2 | **2022.04.13<br>№22<br>Засгийн газрын агентлагийн дарга нарт** | Нийгмийн даатгалын ерөнхий газрын нэгжийн дарга нар болон аймаг /нийслэл/, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс /газар/-ийн удирдлага болох нийт 40 албан тушаалтнаас биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай эсэх, спортын холбоодын тэргүүний үүрэг хашдаг эсэх, сонгуульт албан тушаалтны ажлыг хавсран гүйцэтгэдэг эсэх талаарх судалгааг авч үзэхэд төрийн бус байгууллагатай 1, спортын холбоодын тэргүүний үүрэг гүйцэтгэдэг 2 албан тушаалтан байна гэсэн судалгаа гарсан байна. Дээрх албан тушаалтнуудад Засгийн газрын хуралдааны 22 дугаар тэмдэглэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 03/1063 дугаар албан бичгийн хамт хүргүүлж, спортын чиглэлийн төрийн бус байгууллага эрхлэх, спортын холбооны тэргүүний үүргийг хавсран гүйцэтгэхээс татгалзан, чөлөөлөгдөх арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгов. | 100 |
| 7. | | **2022.05.11<br>№28<br>Засгийн газрын агентлагийн дарга нарт** | 4. Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд удирдлагаас өгсөн үүрэг даалгавар бүрэн хэрэгжсэн.<br>5. Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2022 оны хагас жилийн байдлаар 97.3 хувьтай үнэлэгдсэн. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Сангийн яамнаас Шилэн дансны нэгдсэн цахим хуудас (https://gap.mof.gov.mn/)-ыг шинээр хөгжүүлэх, шинэчилсэн хувилбарыг 2023 онд нэвтрүүлэх ажил үе шаттайгаар хийгдэж байна.<br>Энэ ажлын хүрээнд шинэчилсэн системд бүртгүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах, мөн системийн шинэчлэлтэй холбоотой зохион байгуулах цахим сургалтад тухай бүр оролцох талаар 2022 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 04/1586 дугаар албан бичгийг Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудад хүргүүлж, холбогдох зөвлөгөө мэдээллийг өгч ажиллаж байна. | 100 |
| 8. | | **2022.05.31<br>№31<br>Засгийн газрын агентлагийн дарга нарт** | Нийгмийн даатгалын ерөнхий газрын нэгжийн дарга нар болон аймаг /нийслэл/, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс /газар/-ийн удирдлага болох нийт 40 албан тушаалтнаас биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай эсэх, спортын холбоодын тэргүүний үүрэг хашдаг эсэх, сонгуульт албан тушаалтны ажлыг хавсран гүйцэтгэдэг эсэх талаарх судалгааг авч үзэхэд төрийн бус байгууллагатай 1, спортын холбоодын тэргүүний үүрэг гүйцэтгэдэг 2 албан тушаалтан байна гэсэн судалгаа гарсан байна. Дээрх албан тушаалтнуудад Засгийн газрын хуралдааны 22 дугаар тэмдэглэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 03/1063 дугаар албан | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | бичгийн хамт хүргүүлж, спортын чиглэлийн төрийн бус байгууллага эрхлэх, спортын холбооны тэргүүний үүргийг хавсран гүйцэтгэхээс татгалзан, чөлөөлөгдөх арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгов. | |
| 9. | | **2022.08.17<br>№41<br>Агентлагийн дарга нарт** | Нийгмийн даатгалын ерөнхий газрын албаны цахим хаяг болох undeg@ndaatgal.mn цахим шуудангийн системээр дамжуулан иргэдэд шаардлагатай мэдээлэл, мэдэгдэл хүргэж, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэн ажиллаж байгаа бөгөөд нийт 77 иргэний хүсэлтэд 100% хариу мэдээлэл хүргүүлсэн байна. | 100 |
| 10. | | **2022.08.17<br>№41<br>Агентлагийн дарга нарт** | Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 374 дүгээр "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тогтоолын дагуу урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлнэ. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 11. | 2, 3, 4. | **2022.08.17<br>№41<br>Агентлагийн дарга нарт** | 2. Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд удирдлагаас өгсөн үүрэг даалгавар бүрэн хэрэгжсэн.<br>3.Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийг **94.8** хувиар дүгнэж **"Тодорхой үр дүнд хүрсэн" гэж** дүгнэж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 01/2344 дүгээр албан бичгээр болон цахимаар Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.<br>Зохион байгуулалтын нэгжүүдийн 2022 оны эхний хагас жилийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний дунджийг 93.4 хувь буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэж, удирдлагад хүргүүлсэн.<br>4. Дотоод аудит, мониторингийн газрын нэмэлт ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудад хүргүүлсэн хариутай бичиг, хугацаатай үүрэг даалгаврын биелэлтэд дүн шинжилгээ хийж цаашид ажилдаа хийж хэвшүүлэх шаардлагатай ажлын саналыг тайлан мэдээний хамт удирдлагад танилцуулсан. | 100 |
| 12. | | **2022.09.22<br>№46<br>Агентлагийн дарга нарт** | Батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргэгдэж ирмэгц хяналтад байгаа тогтоол шийдвэрт бүртгэлжүүлэн, дотоод сүлжээгээр салбарын удирдлага болон албан хаагчдад танилцуулан ажиллаж байгаа болно. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын холбогдох газраас, хууль тогтоомжтой холбоотой холбогдох чиглэл, зөвлөмжийг аймаг /нийслэл/ дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд тухай бүр хүргэн ажиллаж байна. | 100 |
| 13. | | **2022.10.05<br>№48** | 2.4 Зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх арга | Одоогийн байдлаар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | **Засгийн газрын агентлагийн дарга нарт** | хэмжээ авч, 2022 оны 10 дугаар сард багтаан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, төрийн болон нутгийн захиргааны байгууллагад.” гэжээ. | Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх боломжгүй тул хасуулах саналтай байна. |
| 14. | Бүх заалт | **2022.10.10 №49 Засгийн газрын агентлагийн дарга нарт** | Төв болон орон нутгийн нийгмийн даатгалын хэлтсүүд client/server програмууд ашигладаг тул “Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршуулах боломжгүй болно. | Одоогийн байдлаар Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх боломжгүй тул хасуулах саналтай байна. |
| 15. | | **2022.11.16 №55 Засгийн газрын агентлагийн дарга нарт** | Уг тогтоолыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад байгаа тогтоол шийдвэрт бүртгэж авсан бөгөөд хэрэгжилтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн байна. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 16. | | **2022.11.30 №57 Засгийн газрын агентлагийн дарга нарт** | Төсвийн хэмнэлтийн тухай хууль болон төсвийн хөрөнгөөр төрийн байгууллагууд шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулахгүй байх талаарх чиглэлийг 2022 оны 12 дугаар 12-ны өдрийн 03/2316 дугаар албан бичгээр аймаг /нийслэл/ дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэв. | 100 |
| 17. | | **2022.12.07 №58 Засгийн газрын агентлагийн дарга нарт** | Нийгмийн даатгалын төв болон орон нутгийн байгууллагууд нь гадаад томилолтын зардал гаргаагүй, төсвийн хөрөнгөөр шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулаагүй бөгөөд урсгал зардлыг 987.3 сая төгрөгөөр хэмнэж ажилласан. | 100 |
| 18. | | **2022.12.07 №58 Засгийн газрын агентлагийн дарга нарт** | Үндэсний дата төвтэй холбогдон Төрийн мэдээлэл солилцооны “Docx” системийг Эйбл програмтай холбуулахаар тусгай эрх (Токен)-ийг авч, хүсэлтийг 2022 оны 12 дугаар сард “Эйбл Соост” ХХК руу цахимаар илгээсэн.<br>Энэхүү ажлын хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнана. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **_МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР_** | | | | |
| 1. | 4. | **2022.07.04<br>№03<br>Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай** | Нийгмийн даатгалын үндсэн үзүүлэлтүүдийн мэдээ, Эрүүл мэндийн даатгалын хамралтын мэдээллийг сар бүр, аймаг, дүүргээр гарган мэдээллээр хангаж ажиллав.<br>Үндэсний статистикийн хорооны даргын баталсан маягтын дагуу нийгмийн даатгалын салбарын 2021 оны жилийн эцсийн статистик мэдээллийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 01/937, 2022 оны эхний хагас жилийн статистик мэдээллийг 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 01/1494 дүгээр албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтэд тус тус хүргүүлэв.<br>"Нийгмийн даатгалын сангийн сарын мэдээний тойм" мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газрын ndaatgal.mn вэбсайтад байршуулав.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон бусад газруудад нийт 36 удаа мэдээ, мэдээлэл хүргүүлэн ажиллав. | 100 |
| **_НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ_** | | | | |
| 1. | 1,2 | **2021.12.27<br>№20<br>Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тогтоох тухай** | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 20 дугаар тогтоолоор өндөр насны тэтгэвэр тогтоолгоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл ("К")-ийг 2022-2024 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жилээр тус тус тогтоосон байна.<br>Энэхүү тогтоолыг 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05/141 дүгээр албан бичгээр аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн, чиглэл зөвлөмж өгч мэргэжил арга зүйгээр хангаж хэрэгжилтийг зохион байгуулав.<br>Уг зөвлөмжөөр тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан даатгуулагчид нэрийн дансны аргаар эсхүл 7 жилийн цалин хөлсний дунджаас тооцон тэтгэвэр тогтоолгох нөхцөлүүдийн аль өөрт ашигтайг сонгох боломжийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллах талаар чиглэл өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | 100 |
| 2. | 1,2. | **2021.12.27<br>№21<br>Нэрийн дансны 2021 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай** | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2021 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 11.6 хувиар баталсан.<br>Энэхүү тогтоолыг 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05/141 дүгээр албан бичгээр аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн, чиглэл зөвлөмж өгч мэргэжил арга зүйгээр хангаж хэрэгжилтийг зохион байгуулав.<br>Уг албан бичгээр даатгуулагчийн нэрийн дансны холбогдох мэдээллийг "Нийгмийн даатгал" аппликейшн, нийгмийн даатгалын байгууллагын www.ndaatgal.mn цахим хуудас дахь "Даатгуулагчид зориулсан вэб" зэргээс харах, татах, хэвлэж авах боломжийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллах чиглэл, зөвлөмжийг аймаг, | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.<br>Мөн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 21 дүгээр тогтоолын дагуу нэрийн дансны програмд даатгуулагчдын нэрийн дансны 2020 оны эцсийн үлдэгдэл, 2021 оны шимтгэлийн орлогод хүү тооцох ажлыг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулах, нэрийн дансны 2021 оны мэдээлэх хуудсыг даатгуулагчийн нийгмийн даатгалын цахим дэвтэр, www.ndaatgal.mn вэб сайтын даатгуулагчид зориулсан вэб, "Нийгмийн даатгал" аппликейшн, ХУР систем, E-Mongolia зэрэгт цахимаар мэдээлэх боломжийг бүрдүүлэх талаар 2022 оны 01 дүгээр 06-ны өдрийн 05/29 дүгээр албан бичгээр Мэдээллийн технологийн төвд хүргүүлэн, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд 2021 оны жилийн эцсийн байдлаар 1.5 сая даатгуулагчийн 24.2 их наяд төгрөгийн шимтгэл болон шимтгэлд тооцсон хүүг хийсвэрээр бүртгэв. Мөн нэрийн дансны тооцоолол, үлдэгдэл шалгах, тэтгэвэр тооцох програмд 95.5 мянган даатгуулагч тэтгэврийн нэрийн дансны үлдэгдлээ, 49.4 мянган даатгуулагч ирээдүйд авах тэтгэврийн тооцооллоо өөрөө тооцоолж үзсэнээр нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар шуурхай үзүүлэв. | |
| 3. | 1,2,3 | **2021.12.27<br>№23<br>2022 оны төсвийн хуваарь батлах тухай** | Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 6 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн нарийвчилсан хуваарь", "Аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын сангийн орлого зарлагын 2022 оны төсвийн хуваарь, "Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2022 оны төсвийн хуваарь"-ийг тус тус боловсруулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн "2022 оны төсвийн хуваарь батлах тухай" 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/84 дүгээр албан бичгээр аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | 100 |
| 4. | 1,2,4 | **2021.12.28<br>№24<br>Тогтоолд өөрчлөлт оруулах тухай** | Уг тогтоолын дагуу "Капитал банк" ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас 22.15 тэрбум төгрөгийн өртөгтэй 46 хөрөнгө хүлээн авч данс бүртгэлд тусгасан болно. | 100 |
| 5. | 1,2 | **2022.02.23<br>№01<br>Өр төлбөрт хөрөнгө хүлээн авах тухай** | Уг тогтоолоор "Капитал банк" ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн сангийн төлбөрт хөрөнгө тооцон авах зөвшөөрөл олгогдож холбогдох ажлуудыг зохион байгуулахыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт даалгасан. Үүнд:<br>Тогтоолоор "Капитал банк" ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас 25.9 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 86 ширхэг үл хөдлөх хөрөнгийг нийгмийн даатгалын сангийн нэхэмжилсэн өр төлбөрт суутган авахыг зөвшөөрсөн боловч 2.9 тэрбум төгрөгийн | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | үнэлгээтэй 32 ширхэг хөрөнгүүдийг хүлээн авч нягтлан бодох бүртгэлд бүртгэх ажлууд хийгдлээ.<br>Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан хөрөнгийн мөнгөн дүн, тоо ширхэг өөрчлөгдсөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:<br>1. Дээрх хөрөнгүүдийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар авахаар санал гаргасан тул харилцан тохиролцож 8.4 тэрбум төгрөгийн 22 ширхэг хөрөнгийг сонгосон.<br>2. Нийгмийн даатгалын ерөнхий газраас 8.8 тэрбум төгрөгийн 8 ширхэг хөрөнгийг дахин үнэлгээ хийлгэхээр хүсэлт гаргасан.<br>3. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас үнэлгээ өндөр хэмээн 5.7 тэрбум төгрөгийн 25 ширхэг хөрөнгийг хүлээн авахаас татгалзсан.<br>Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор баталсан "Капитал банк" ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн сангийн төлбөрт тооцон авах мөнгөн дүн дээрх шалтгаанаар өөрчлөгдсөн тул тус тогтоолын Нэг дэх хэсгийн хөрөнгийн нийт мөнгөн дүн, тоо ширхэгт өөрчлөлт оруулан хавсралтыг хүчингүй болгон дахин шинэчлэн батлуулах санал хүсэлтийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд гаргасан болно.<br>Мөн "Капитал банк" ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн сангийн төлбөрт шилжүүлэн хүлээн авсан хөрөнгийг худалдан борлуулахаар "Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам"-ын хэрэгжилтийг ханган дуудлага худалдааг 2022 оны 06 дугаар сарын 28, мөн оны 08 дугаар сарын 17, 09 дүгээр сарын 27, 11 дүгээр сарын 08-ны өдрүүдэд тус тус зарлан 1.8 тэрбум төгрөгийн 6 ширхэг хөрөнгийг 1.9 тэрбум төгрөгөөр худалдан борлуулсан. | |
| 6. | 1,2,3,4 | **2022.02.23**<br>**№02**<br>**2022 оны тодотгосон төсвийн хуваарь батлах тухай** | Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 6 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2022 оны тодотгосон төсвийн нарийвчилсан хуваарь, "Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2022 оны тодотгосон төсвийн хуваарь"-ийг тус тус боловсруулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн "2022 оны тодотгосон төсвийн хуваарь батлах тухай" 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 01/494 дүгээр албан бичгээр аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | 100 |
| 7. | | **2022.08.01**<br>**№04** | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн "Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 04 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | **Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай** | зүйлд заасан нөхцөлийг хангасан даатгуулагчийн оршуулгын тэтгэмжийн болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмжийн хэмжээг хоёр сая төгрөг (2 000 000)-өөр шинэчлэн, оршуулгын тэтгэмж олгох нөхцөлийг хангасан, амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг гурван сая таван зуун мянган төгрөг (3 500 000)-өөр тус тус тогтоож, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр шийдвэрлэсэн.<br>Иймд нийгмийн даатгалын сангаас оршуулгын тэтгэмж олгоход Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/72 дугаар тушаалаар баталсан "Тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам"-ыг баримтална. Харин амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт оршуулгын тэтгэмж олгохдоо энэхүү журмын 3.12-т заасан баримт бичгээс гадна Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албанаас Эрүүл мэндийн сайдын баталсан маягтын дагуу олгосон "Даатгуулагчийг донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлэхээр болсон талаарх тодорхойлолт"-ыг үндэслэнэ.<br>Амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт оршуулгын тэтгэмж (3 500 000 төгрөг) олгосон тохиолдолд 2 000 000 төгрөгийн оршуулгын тэтгэмжийг давхардуулан олгохгүй. Энэ тохиолдолд 2022 онд нас барсан даатгуулагчийн ар гэрээс оршуулгын тэтгэмж авах хүсэлтээ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2-т заасан хугацаанд багтааж гаргасан нь 2023 он дамжсан бол энэ зөвлөмжид заасан хэмжээ (2 000 000 төгрөг)-ээр оршуулгын тэтгэмжийг олгоно. Харин шинээр тогтоосон амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш уг тэтгэмжийг авах эрх үүссэн тохиолдолд олгоно. | |
| | | | ***БУСАД /хамтарсан тушаал/*** | |
| 1. | | **2021.12.30 №704 Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай** | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 704 дүгээр тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/179 дүгээр тушаалын дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулж, төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 312 нэрийн 1,039 ширхэг нийт 2,575,989,345.10 төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан үнэ бүхий хөрөнгийг данснаас хасаж нийт 779,457,656.63 төгрөгөөр үнэлгээг шинэчлэн тогтоож, ашиглах хугацаа, шинэчлэн тогтоосон үнээр нягтлан бодох бүртгэлд тусгасан. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгаж "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д тухай бүр бүртгэсэн болно.<br>Уг ажлын биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/611 дүгээр албан бичгээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн. | |
| 2. | | **2021.12.30<br>№721<br>Хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай** | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 721 дүгээр тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/180 дугаар тушаалын дагуу төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, эвдэрч гэмтсэн, сэргээн засварлаж цаашид ашиглах боломжгүй болсон нийт 134 нэр төрлийн 1,020 ширхэг 271,262,962.80 төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор актлах ажлыг зохион байгуулж, данс бүртгэлээс хассан.<br>Хөрөнгийн хөдлөлийг зохих журмын дагуу нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгаж, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д тухай бүр бүртгэсэн болно.<br>Уг ажлын биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/611 дүгээр албан бичгээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн. | 100 |
| 3. | | **2022.11.11<br>03/2951<br>Чиглэл хүргүүлэх тухай** | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргаас ирүүлсэн "Чиглэл хүргүүлэх тухай" 03/2951 дугаар албан бичгийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын нэгжийн дарга нарт танилцуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг үүрэг болгосон. | 100 |
| **Хэсгийн дундаж: 100 хувь** | | | | |
| **Нийт дундаж: 97.3 хувь** | | | | |

---oOo---

Хавсралт 2

# ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

/2022 оны жилийн эцсийн байдлаар/

| № | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Хүрсэн түвшин | Гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар) |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Он | Түвшин | | |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| ***2.5.1. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.*** | | | | | | | |
| 2.5.1.1. | Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | - | Нийгмийн даатгалын багц хууль батлагдсан байна. | 2021 | Нийгмийн даатгалын эрх зүйн шинэчлэл хийгдээгүй, олон давхаргат тэтгэврийн тогтолцоо бүрдээгүй байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ажлын хэсэгт Нийгмийн даатгалын байгууллагын төлөөлөл ажиллаж, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлснээр 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн барьсан. Үүнд:<br>- Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд нэр томьёоны тодорхойлолт, хуулийн үйлчлэх хүрээ, нийгмийн даатгалын тогтолцоо, зарчим, төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, шимтгэл төлөх, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, хуваарилах, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зарцуулах, тайлагнах, хяналт тавих, сангийн хөрөнгө оруулалтын удирдлага, мэдээллийн нэгдсэн сан, шимтгэл ногдуулах орлогын бүрэлдэхүүн, шимтгэл төлснөөр тооцох хугацаа, итгэлцүүр, шимтгэлээс чөлөөлөх, нөхөн төлүүлэх, буцаан олгох, тэтгэврийн даатгалын нэрийн дансыг бүртгэх, тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, өвлүүлэх, шимтгэлийн өр, хөөн хэлэлцэх хугацааг тогтоох, нийгмийн даатгалын сангийн хэтийн тооцоолол хийх, сангийн эрсдэлийг үнэлэх, санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий мэргэжлийн хороодыг ажиллуулах, ажил олгогч, даатгуулагчийн эрх үүрэг, Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо, нийгмийн даатгалын хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага зэрэг зохицуулалтыг тусгав.<br>- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлд олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, даатгуулагч сайн дурын үндсэн дээр хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд даатгуулж, нэмэгдэл тэтгэвэр авах, тэтгэврийг индексжүүлэн нэмэгдүүлэх, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэвэр бодоход баримтлах ХХТАО-ын дунджийг тооцох, олон жил шимтгэл төлсөн даатгуулагчийг урамшуулах, тэтгэврийн нас, тэтгэвэр бодох аргачлал, хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттайгаар шилжих зэрэг асуудлыг тусгасан болно. | |
| 2.5.1.2. | Иргэн бүрд суурь тэтгэвэр олгох эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | - | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль (шинэчлэгдсэн найруулга) | 2021 | Иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байна. | Тэтгэврийн тогтолцоог шинэчилж олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх бодлогын хүрээнд эхний давхарга нь нийгмийн халамжийн тэтгэвэр байхаар нийгмийн халамжийн тэтгэврийн хуулиар зохицуулж улсын төсвөөс олгохоор нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн төсөлд тусгасан болно. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | батлагдсан байна. | | | | |
| 2.5.1.3. | Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | - | Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тухай хууль батлагдсан байна. | 2021 | Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байна. | Тэтгэврийн тогтолцоог шинэчилж олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх бодлогын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар Нийгмийн даатгалын багц хуулийн үзэл баримтлал, төсөл, танилцуулга бэлтгэх Ажлын хэсгийг холбогдох төрийн болон олон нийтийн байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан байгуулж, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлснээр Улсын Их Хуралд өргөн барьсан болно. | 70 |
| **2.5.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.** | | | | | | | |
| 2.5.2.1. | Олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих эрх зүйн орчны хүрээнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | - | Тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх талаарх хуулийн заалт батлагдсан байна.. | 2021 | Хууль эрх, зүйн орчин бүрдээгүй байна: | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад оруулах, санхүүгийн хэрэгслийг тодорхойлох, тэтгэврийн даатгалын нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг мөнгөжүүлэн хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлэх асуудлыг тусгасан. | 70 |
| ***2.5.4. Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.*** | | | | | | | |
| 2.5.4.1. | Хөдөлмөрийн зах зээл, ажилгүйдлийн даатгалын эрх | - | Хуулийн шинэчлэлтэй уялдуулан бусад хууль, | 2021 | Ажилгүйдлийн даатгалын сан, Хөдөлмөр эрхлэлтийг | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөлд тэтгэмжийн даатгалын сангаас | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зүйн орчныг шинэчилж, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлнэ. | | тогтоомж, дүрэм журамд өөрчлөлт оруулж батлуулсан байна. | | дэмжих сангийн уялдаа холбоо хангалттай биш. | хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгох, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж, ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх зэрэг асуудлыг тусгасан.<br>Хуулийн төсөлд бөөрний дутагдал, эрхтэн шилжүүлэх, эрхтний донор болсон даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, ихэр хүүхэд төрүүлсэн эхийн амаржсаны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг ОУХБ-ын минимум стандартад нийцүүлэх, даатгуулагчийг ажилгүй болохоос урьдчилан сэргийлэх, ажлын байранд нь тогтвор, суурьшилтай, урт хугацаанд ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ажил олгогчид 5 жилд 1 удаа 10 хувиар шимтгэлийн хөнгөлөлт үзүүлж байсныг сангийн чадавхад үндэслэн 3 жилд нэг удаа 15 хувиар хөнгөлөлт үзүүлэхээр тусгав.<br>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөлд эдгээр асуудлыг тусгасан болно. | |
| **2.5.5 Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 2.5.5.1 | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 310.1 тэрбум /Улсын төсөв/, 327.2 тэрбум /Тэтгэврийн даатгалын сан/ 2022 оны зарлагын төсвөөс | Инфляцын түвшинтэй уялдуулан тэтгэврийн хэмжээг нэмэгдсэн байна. | 2021 | Бүрэн тэтгэврийн доод хэмжээ 500.0 мян төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 400.0 мян.төгрөг | Засгийн газрын 2022 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 63 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээг 500,000 (таван зуун мянган) төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400,000 (дөрвөн зуун мянган) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 15.0 хувиар нэмэгдүүлэн 2022 оны 2 дугаар сарын 1-ээс эхлэн олгосон.<br>Тэтгэврийн нэмэгдэлд 2022 онд нийтдээ 637.4 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын сангаас болон Улсын төсвөөс олгов. | |
| 2.5.5.2 | Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтооно. | 156.2 тэрбум Улсын төсөв | Тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтоож, тэтгэвэр авагчийн тэтгэвэр нэмэгдэн, тэтгэврийн зөрүү ойртсон байна. | 2015 | Засгийн газрын тогтоолоор тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг тогтоосон. | Нийгмийн даатгалын сангийн 2023-2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023 оны жилийн хязгаарын саналд тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчилснээр тэтгэврийг өөрчлөн тогтооход 156.2 тэрбум төгрөг шаардлагатай тооцооллыг хийж Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв. | 70 |
| ***2.5.6 “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй болгоно*** | | | | | | | |
| 2.5.6.1. | Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй цахим хэлбэрээр хүргэнэ. | 400,0 сая.төг Гадаадын зээл тусламж | Нийгмийн даатгалын үйлчилгээг бүрэн цахимжуулсан байна. | 2021 | Нийгмийн даатгалын үйлчилгээний 25 хувь цахимжсан. | Монгол улсын Засгийн Газрын 2020 оны 203 дугаар тогтоол болон “Цахим Монгол” арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээр дамжуулан иргэд даатгуулагч, ажил олгогч, төрийн болон бусад байгууллагуудад нийгмийн даатгалын үйлчилгээг цаг хугацаа, орон зайн хамааралгүйгээр, цахим хэлбэрээр түргэн шуурхай хүргэх ажлыг өргөжүүлэн ажиллалаа. Тухайлбал:<br>*Эмнэлгийн хуудсыг цахимаар солилцох, тэтгэмж олгох үйлчилгээг цахимаар хүргэх боломжийг бүрдүүллээ:*<br>- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын дагуу хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг цахимаар олгохтой уялдуулан ажил олгогч болон даатгуулагч эрүүл мэндийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагаас олгож буй эмнэлгийн хуудсыг цахимаар хүлээн авах нөхцөлийг бүрдүүллээ.<br>Ингэснээр эрүүл мэндийн байгууллагаас илгээсэн албан журмын даатгуулагчийн ХЧТА-ын эмнэлгийн хуудсыг ажил олгогч “Шимтгэлийн цахим систем”-ээр хүлээн авч, тэтгэмжийн тооцооллыг нягтлан шалгаж, шаардлагатай тохиолдолд засварлан нийгмийн даатгалын байгууллагад цахимаар илгээх, тэтгэмж олгосон тайлангаа хэвлэн авч баталгаажуулах боломжтой болсон.<br>- Сайн дураар даатгуулагч, сайн дураар даатгуулагч эх “Даатгуулагчид зориулсан вэб” систем, “E-Mongolia” порталыг ашиглан хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлтээ цахимаар гаргах нөхцөлийг бүрдүүллээ.<br>- Албан журмын даатгуулагч эх жирэмсэн болон амаржсаны тэтгэмж авах хүсэлтээ мөн дээрх хоёр системээр цахимаар гаргах боломжийг бүрдүүллээ.<br>Эдгээр боломжууд бүрдсэнээр энэ онд 850 гаруй эрүүл мэндийн байгууллагаас нийтдээ 163.0 мянган эмнэлгийн хуудас цахимаар хүлээн авсан байна.<br>- Эрүүл мэндийн байгууллагаас олгосон жирэмсэн болон амаржсаны эмнэлгийн хуудсыг нийгмийн даатгалын байгууллагад илгээх хугацаа дуусахаас 8 хоногийн өмнө тэтгэмж авах хүсэлтээ илгээх талаар сануулах мэдэгдлийг тухайн даатгуулагчийн гар утасны дугаар руу мессежээр илгээх үйлчилгээг нэвтрүүллээ.<br>Уг мэдэгдлийн дагуу даатгуулагч эмнэлгийн хуудсаа “Даатгуулагчид зориулсан вэб” систем, “E-Mongolia” порталыг ашиглан цахимаар илгээх боломжтой. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сануулах мэдэгдлийг хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас авсан сайн дурын даатгуулагчид илгээх юм.<br>Энэхүү үйлчилгээг энэ оны 12 дугаар сараас эхлэн нэвтрүүлсэн бөгөөд одоогийн байдлаар нийт 253 даатгуулагчид сануулах мэдэгдлийг мессежээр илгээсэн байна.<br>- Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болсон даатгуулагч "Даатгуулагчид зориулсан вэб" систем, "E-Mongolia" порталаар дамжуулан ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ цахимаар гаргах боломжийг бүрдүүллээ. Энэхүү боломжийг бүрдүүлснээр ажилгүйдлийн тэтгэмж олголтын үйлчилгээг зайнаас үзүүлэх нөхцөл хангагдаж энэ онд 1.6 мянган хүсэлт цахимаар илгээсэн байна.<br>*Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах ажлыг өргөжүүлснээр энэ онд дараах үр дүнгүүд гарсан байна. Үүнд:*<br>- Төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системд хүргүүлж буй 46 сервисийг ашиглан төрийн 18 байгууллага нийтдээ 4.5 сая орчим удаагийн хандалт хийж ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл төлөлтийн мэдээллийг цахимаар авсан байна.<br>- Ажил олгогчийн "Шимтгэлийн цахим систем"-ийг ашиглан идэвхтэй шимтгэл төлөгч нийт 52.7 мянган ажил олгогч 579.7 мянган удаагийн хандалт хийж нийгмийн даатгалын тайлангаа цахимаар илгээсэн байна.<br>- "Нийгмийн даатгал" аппликейшнийг нийтдээ 250.0 мянга орчим даатгуулагч өөрийн шимтгэл төлөлт, тэтгэвэр, тэтгэмжийн мэдээллээ харах, сайн дурын даатгалын үйлчилгээнд хамрагдах зэргээр идэвхтэй ашиглаж байна.<br>- "Даатгуулагчид зориулсан вэб" системийг ашиглан нийтдээ 69.9 мянган даатгуулагч сайн дурын даатгалын гэрээ байгуулах, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сунгах, шимтгэлийн төлбөрөө төлөх үйлчилгээнд хамрагдсан байна.<br>- "Даатгуулагчид зориулсан вэб" систем, "Нийгмийн даатгал" аппликейшн, "Нэгдсэн лавлагааны програм"-аас нийтдээ 2.4 сая орчим QR кодтой шимтгэл төлөлтийн лавлагаа тодорхойлолт авсан байна.<br>- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа тодорхойлолтыг үнэн зөв, бодит байдлыг шалгах вэб системээр нийт 4.2 мянган ажил олгогч, 18.1 мянган даатгуулагчийн QR кодтой лавлагаа тодорхойлолтыг шалгасан байна.<br>- Төрийн үйлчилгээний 109 ТҮЦ машинаар үзүүлж буй үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэн даатгуулагч 2000-2005 оны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолтоо авах боломжийг бүрдүүлсэн. Энэ онд 156.9 мянган иргэн ТҮЦ машинаас 4 төрлийн лавлагаа тодорхойлолтоо хэвлэн авсан байна.<br>- Иргэд, даатгуулагч нийгмийн даатгалын байгууллагуудад өгсөн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцаа цахимаар харах, хянах боломжийг бүрдүүлснээр энэ оны эхний 11 сарын байдлаар нийт 6.7 мянган иргэний өргөдөл бүртгэгдэж, холбогдох мэдээллийг иргэнд мессежээр илгээсэн байна.<br>- Төрийн үйлчилгээний нэгдсэн портал "E-mongolia"-гаар хүргэж буй үйлчилгээг өргөжүүлэн дараах боломжуудыг бүрдүүллээ. Үүнд:<br>- Хөдөлмөрийн чадвар түр алдалтын, жирэмсэн болон амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмжийн хүсэлтээ цахимаар гаргах;<br>- Тэтгэвэр тогтоолтын хуудсаа цахимаар авах;<br>- Нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийн буцаан олголт авах дансны дугаараа бүртгүүлэх, засах; | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ингэснээр иргэд даатгуулагч, ажил олгогч уг порталаас нийгмийн даатгалын 11 төрлийн үйлчилгээг цахимаар авч байгаа бөгөөд үүнээс 4 төрлийн лавлагаа тодорхойлолтыг англи хэл дээр авч байна. | |
| **НИЙТ ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ** | | | | | | | **77,5** |

Хавсралт 3

# МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТУСГАГДСАН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

/2022 оны жилийн эцсийн байдлаар/

| № | Монгол улсын 2022 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, үйл ажиллагаа | Төсөв /сая.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Хүрсэн түвшин | Гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар) |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Он | Түвшин | | |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **2.5. Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ** | | | | | | | |
| 2.5.1. | Нийгмийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх /ЗГҮАХ-2.5.1/ | - | Нийгмийн даатгалын багц хууль батлагдсан байна. | 2021 | Нийгмийн даатгалын эрх зүйн шинэчлэл хийгдээгүй, олон давхаргат тэтгэврийн тогтолцоо бүрдээгүй байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгаалын яамны ажлын хэсэгт Нийгмийн даатгалын байгууллагын төлөөлөл ажиллаж Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлснээр 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн барьсан. Үүнд:<br>- Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд нэр томьёоны тодорхойлолт, хуулийн үйлчлэх хүрээ, нийгмийн даатгалын тогтолцоо, зарчим, төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, шимтгэл төлөх, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавих, сангийн хөрөнгө оруулалтын удирдлага, мэдээллийн нэгдсэн сан, шимтгэл ногдуулах орлогын бүрэлдэхүүн, шимтгэл төлснөөр тооцох хугацаа, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | итгэлцүүр, шимтгэлээс чөлөөлөх, нөхөн төлүүлэх, буцаан олгох, тэтгэврийн даатгалын нэрийн дансыг бүртгэх, тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, өвлүүлэх, шимтгэлийн өр, хөөн хэлэлцэх хугацааг тогтоох, нийгмийн даатгалын сангийн хэтийн тооцоолол хийх, сангийн эрсдэлийг үнэлэх, санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий мэргэжлийн хороодыг ажиллуулах, ажил олгогч, даатгуулагчийн эрх үүрэг, Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо, нийгмийн даатгалын хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага зэрэг зохицуулалтыг тусгав.<br>- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлд олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, даатгуулагч сайн дурын үндсэн дээр хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд даатгуулж, нэмэгдэл тэтгэвэр авах, тэтгэврийг индексжүүлэн нэмэгдүүлэх, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэвэр бодоход баримтлах ХХТАО-ын дунджийг тооцох, олон жил шимтгэл төлсөн даатгуулагчийг урамшуулах, тэтгэврийн нас, тэтгэвэр бодох аргачлал, хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттайгаар шилжих зэрэг асуудлыг тусгасан болно. | |
| **НИЙТ ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ** | | | | | | | **70** |

Хавсралт 4

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

/2022 оны жилийн эцсийн байдлаар/

| № | Үзүүлэлт | 2021 оны суурь түвшин | 2022 оны зорилтот түвшин | 2022 оны гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ын нийгмийн даатгалд хамрагдсан хувь | 82.8 | 85.0 | 87.5 | 100.0 |
| 2 | Дундаж тэтгэврийн хэмжээ, төгрөгөөр | 424,800 | 488,520 | 555,600 | 100.0 |
| 3 | Ажил олгогч | 52,754 | 55,391 | 55,454 | 100.0 |
| 4 | Нийт даатгуулагчийн тоо, үүнээс | 1,177,846 | 1,207,291 | 1,269,375 | 100.0 |
| 5 | Албан журмын даатгуулагчийн тоо | 1,014,437 | 1,039,797 | 1,104,870 | 100.0 |
| 6 | Сайн дурын даатгуулагчийн тоо | 163,409 | 167,494 | 164,505 | 98.2 |
| 7 | Нийгийн даатгалын үйлчилгээ авсан хүний тоо /давхардсан тоогоор мянган хүн/ | 748.3 | 730.6 | 746.7 | 100.0 |
| **Хэсгийн дундаж: 100 хувь** | | | | | |
| **Нийт дундаж: 99.7** | | | | | |

Хавсралт 6

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ**

/2022 оны жилийн эцсийн байдлаар/

| № | Үйл ажиллагаа | № | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| **Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх** | | | | | | |
| 1. | Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт | 1.1. | Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо: | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх цахим болон танхимын сургалтуудыг зохион байгуулсан байна. | Албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх цахим болон танхимын 50 удаагийн сургалтаар 6261 (давхардсан тоогоор) албан хаагчийг хамруулсан | |
| | | Үүнээс: | Ажлын байран дахь сургалт | 2 | 250 | |
| | | | Мэргэшүүлэх сургалт | 2 | 978 | |
| | | | Туршлага солилцох арга хэмжээ | 1 | 145 | |
| | | | Бусад | - | - | |
| | | 1.2. | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх цахим болон танхимын сургалтуудыг зохион байгуулсан байна. | Албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх цахим болон танхимын 50 удаагийн сургалтаар 6261 (давхардсан тоогоор) албан хаагчийг хамруулсан | |
| | | Үүнээс: | Эмэгтэй албан хаагч | Сургалтад хамруулсан эмэгтэй албан хаагчийн тоо | 4383 (давхардсан тоогоор) | |
| | | | Эрэгтэй албан хаагч | Сургалтад хамруулсан эрэгтэй албан хаагчийн тоо | 1878 (давхардсан тоогоор) | |
| | | | Удирдах албан тушаалтан | Сургатад хамруулсан удирдах албан тушаалтны тоо | 150 (давхардсан тоогоор) | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | | 6111 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1.3. | Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь | 100% | 100% | |
| 2. | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт | 2.1. | Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо | 2 | 2 | |
| | | 2.2. | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | 20 | 20 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй албан хаагч | 15 | 15 | |
| | | | Эрэгтэй албан хаагч | 5 | 5 | |
| | | | Удирдах албан тушаалтан | 8 | 8 | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 12 | 12 | |
| | | 2.3. | Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь | 28% | 28% | |
| 3. | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн | 3.1. | Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | 90545400 | 90450071 | |
| | | 3.2. | Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь | 12% | 12.3% | |
| **Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах** | | | | | | |
| 4. | Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх | 4.1. | Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь | 52.31% | 54.05% | |
| | | 4.2. | Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг) | 1865600 | 1865600 | |
| 5. | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх | 5.1. | Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж) | 100% | 100% | |
| 6. | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | 6.1. | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд) | 1 удаа | 1 удаа | |
| | | 6.2. | Албан хаагчдын хамрагдалт | 79 албан хаагч | 79 албан хаагч | |
| 7. | Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал | 7.1. | Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | 142405900 | 140525512 | 1 удаагийн буцалтгүй тусламж |

Хавсралт 7

## ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

/2022 оны жилийн эцсийн байдлаар/

| № | Эрх зүйн актын нэр, агуулга, огноо, дугаар, заалт | Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө |
|---|---|---|
| 1. | Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны дотор, сар улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны дотор | “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 2-р хавсралтын дагуу өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг 2022 оны 01 дүгээр сард, сар улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны дотор нийт 12 удаа байршуулж иргэдэд нээлттэй ил тод танилцуулж ажиллав. |
| 2. | Дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 –р сарын 15-ны өдрийн дотор | 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөллийг боловсруулан хуулийн хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэн, цахим хаягт байршуулсан. |
| 3. | Жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийг 04 дүгээр сарын 25- дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны дотор | Мэдээллийн ангилал, бүтэц, мэдээлэл боловсруулахад тавигдах шаардлагын дагуу 2021 оны жилийн эцэс, 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланг ил тод байдлын самбарт болон www.shilendans.gov.mn сайтад байршуулсан. |
| 4. | Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04- сарын 25-ны дотор, | - |
| | Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 сарын 01 –ний өдрийн дотор | - |
| 5. | Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр | - |
| 6. | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэр | 2022 оны салбарын батлагдсан төсөв, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой мэдээллийг 12 удаа шилэн дансны цахим хаягт байршуулсан. |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/13/НА-СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

**Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Энхжавхлан**
Утас: 261945 Цахим хаяг: enkhjavkhlants@audit.gov.mn
**Аудитын менежер: Ч.Болд**
Утас: 260512 Цахим хаяг: Boldch@audit.gov.mn
**Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ**
Утас: 261628 Цахим хаяг: Bat-erdenes@audit.gov.mn
**Аудитор: А.Баясгалан**
Утас: 261628 Цахим хаяг: Bayasgalana@audit.gov.mn

Улаанбаатар хот
2023 он

## АГУУЛГА


1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ....2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ....4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан ....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан ....4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан ....5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан ....5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ....8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ....9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ....9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ....9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ....10
3.4.1 Мөнгөн хөрөнгө ....10
3.4.2 Авлага ....11
3.4.3 Бараа материал ....11
3.4.4 Бусад эргэлтийн хөрөнгө ....12
3.4.5 Үндсэн хөрөнгө ....12
3.4.6 Өр төлбөр ....12
3.4.7 Засгийн газрын хувь оролцоо ....13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....13
3.5.1 Төсвийн төлөвлөлт ....13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл ....14
3.5.3 Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл ....15
3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт ....15
3.5.5 Нэмэлт төсөв ....16
4. АУДИТЫН ТАЙЛАН ....17
4.1 Ерөнхий зүйл ....17
4.2 Материаллаг байдал ....17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ....17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ....17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ....18
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ....18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ....20
5.1 Албан шаардлага ....20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ....22


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| ААНБ | Аж ахуйн нэгж, байгууллага |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| НДҮЗ | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл |
| НДС | Нийгмийн даатгалын сан |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| НДХ | Нийгмийн даатгалын хэлтэс |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин |

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.04.25 № 916
танай ____________ -ны № ____________ -т

ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД БӨГӨӨД НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Х.БУЛГАНТУЯА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Нийгмийн даатгалын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Капитал банкны эрх хүлээн авагчаас авах авлага барагдуулаагүй, Чингис хаан банкин дахь харилцах дансны үлдэгдэл санд төвлөрөөгүй, олон жилийн насжилттай авлага барагдаагүй зэрэг 172,179.9 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн байна.

Эдгээр нь УСНББОУС болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль холбогдох журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх", "тохиолдсон байх", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50.0 хувийг буцаан олгох тухай хууль хэрэгжин, тайлант оны гүйцэтгэлээр давхардсан тоогоор нийт 2,087,746 иргэнд 72,652.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Z:\Yawsan_Bichig\2023\0425 SNAG-30.Docx

0001031124

**Аудитын гол асуудал**

Капитал банкны эрх хүлээн авагчаас 2021 онд 22,156.6 сая төгрөгийн, 2022 онд 2,905.2 сая төгрөгийн, нийт 25,061.8 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг НДС-ийн өр төлбөрт хүлээн авч өнгөрсөн онд 484.5 сая төгрөгийн, тайлант онд 7,272.8 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулж 17,304.5 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлд Green finance програмыг нэвтрүүлсэн бөгөөд тус программ нь Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ын дагуу санхүүгийн мэдээллийг иж бүрэн, тодорхой илэрхийлэхгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Д.ЗАНДАНБАТ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Тайлангийн үзүүлэлт | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,963,569,348.4** | **1,809,894,883.4** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 905,542,034.3 | 994,024,826.4 |
| 33 | АВЛАГА | 1,035,324,484.8 | 797,556,050.7 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 22,681,229.3 | 18,292,406.3 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 21,600.0 | 21,600.0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **36,538,903.1** | **37,436,415.6** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 36,538,903.1 | 37,436,415.6 |
| 39200 | Биет хөрөнгө | 32,743,625.3 | 34,373,497.4 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 3,795,277.8 | 3,062,918.2 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,000,108,251.6** | **1,847,331,299.0** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **24,604,991.2** | **20,093,130.3** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 24,604,991.2 | 20,093,130.3 |
| 41300 | Өглөг | 12,467,818.3 | 3,897,373.6 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 12,137,172.9 | 16,195,756.7 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,975,503,260.4** | **1,827,238,168.7** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,975,503,260.4 | 1,827,238,168.7 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 12,216,142.7 | 12,216,142.7 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | - | 12,216,142.7 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 1,958,867,795.1 | 1,810,602,703.4 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 4,419,322.6 | 4,419,322.6 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,000,108,251.6** | **1,847,331,299.0** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Тайлангийн үзүүлэлт | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,194,884,278.9** | **3,778,232,377.9** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 2,783,340,990.6 | 3,218,634,817.9 |
| 112 | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого | 2,783,340,990.6 | 3,218,634,817.9 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 7,992,824.0 | 9,574,537.9 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 7,992,824.0 | 9,574,537.9 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 403,550,464.4 | 550,023,022.1 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,968,253,679.8** | **3,924,770,818.1** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,968,253,679.8 | 3,924,770,818.1 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 29,207,525.7 | 30,149,034.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 18,868,745.1 | 20,618,516.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 2,441,116.3 | 2,534,816.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,063,910.0 | 1,068,981.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 923,271.3 | 800,733.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 223,652.3 | 391,850.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 65,649.2 | 165,507.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,238,614.1 | 1,255,210.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,382,567.5 | 3,313,418.3 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,939,046,154.1 | 3,894,621,783.7 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **226,630,599.1** | **(146,538,440.2)** |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **-** | **7,590.0** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **48,568.1** | **62,187.2** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **226,582,031.0** | **(146,593,037.3)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| 1 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,746,643,067.7** | - | **1,746,643,067.7** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 2,278,161.6 | - | 2,278,161.6 |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,748,921,229.4** | - | **1,748,921,229.4** |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 226,582,031.0 | - | 226,582,031.0 |
| 10 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,975,503,260.4** | - | **1,975,503,260.4** |
| 11 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,975,503,260.4** | - | **1,975,503,260.4** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (1,672,054.3) | - | (1,672,054.3) |
| 13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,973,831,206.0** | - | **1,973,831,206.0** |
| 19 | Тайлант үеийн үр дүн | (146,593,037.3) | - | (146,593,037.3) |
| 20 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,827,238,168.7** | - | **1,827,238,168.7** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Тайлангийн үзүүлэлт | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,411,577,828.8** | **4,033,447,524.0** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 2,528,537,849.9 | 3,167,252,726.5 |
| 112 | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого | 2,528,537,849.9 | 3,167,252,726.5 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 249,754,837.1 | 21,288,636.4 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 249,754,837.1 | 21,288,636.4 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 633,285,141.8 | 844,906,161.2 |
| II | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,238,408,989.4** | **3,944,898,531.9** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,238,408,989.4 | 3,944,898,531.9 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 26,586,386.5 | 30,430,588.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 18,875,873.7 | 20,610,765.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 2,414,081.1 | 2,554,788.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,123,292.9 | 1,055,939.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 877,155.4 | 741,788.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 308,531.6 | 3,792,179.9 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 65,649.2 | 165,507.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,756,764.5 | 1,301,176.1 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 165,038.2 | 208,443.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,211,822,602.9 | 3,914,467,943.4 |
| III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **173,168,839.4** | **88,548,992.1** |
| V | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | - | **66,200.0** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 66,200.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 66,200.0 |
| VI | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | - | **(66,200.0)** |
| VIII | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **173,168,839.4** | **88,482,792.1** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 732,373,194.9 | 905,542,034.3 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 905,542,034.3 | 994,024,826.4 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,337,526,311,700.0** | **3,413,968,934,350.4** | **(76,442,622,650.4)** | **102.3** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,435,626,308,400.0** | **3,415,713,758,200.5** | **19,912,550,199.5** | **99.4** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **31,153,924,700.0** | **30,120,624,246.6** | **1,033,300,453.5** | **96.7** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **21,015,832,900.0** | **20,558,533,369.8** | **457,299,530.2** | **97.8** |
| 210101 | Үндсэн цалин | 14,227,965,600.0 | 14,078,186,079.3 | **149,779,520.7** | **98.9** |
| 210102 | Нэмэгдэл | 3,901,326,600.0 | 3,587,157,898.2 | **314,168,701.8** | **91.9** |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,797,314,500.0 | 1,510,529,227.0 | **286,785,273.0** | **84.0** |
| 210104 | Урамшуулал | 1,089,226,200.0 | 1,382,660,165.4 | **(293,433,965.4)** | **126.9** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **2,630,434,100.0** | **2,547,500,783.6** | **82,933,316.4** | **96.8** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,800,777,600.0 | 1,743,234,210.8 | **57,543,389.2** | **96.8** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 208,529,500.0 | 206,950,428.1 | **1,579,071.9** | **99.2** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 166,529,800.0 | 163,737,190.5 | **2,792,609.5** | **98.3** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 41,595,900.0 | 39,340,149.9 | **2,255,750.1** | **94.6** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 413,001,300.0 | 394,238,804.2 | **18,762,495.8** | **95.5** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,104,863,600.0** | **1,055,939,338.5** | **48,924,261.5** | **95.6** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 200,622,400.0 | 184,088,918.3 | **16,533,481.7** | **91.8** |
| 210302 | Түлш, халаалт | 681,210,600.0 | 656,619,985.3 | **24,590,614.7** | **96.4** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 100,092,100.0 | 92,300,548.6 | **7,791,551.4** | **92.2** |
| 210304 | Байрны түрээс | 122,938,500.0 | 122,929,886.3 | **8,613.7** | **100.0** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **766,168,000.0** | **736,679,414.6** | **29,488,585.5** | **96.2** |
| 210401 | Бичиг хэрэг | 225,945,300.0 | 224,861,545.0 | **1,083,755.0** | **99.5** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 231,424,400.0 | 215,591,529.0 | **15,832,871.0** | **93.2** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 147,578,300.0 | 139,711,662.6 | **7,866,637.4** | **94.7** |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 18,454,000.0 | 14,453,496.0 | **4,000,504.0** | **78.3** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 142,766,000.0 | 142,061,182.0 | **704,818.0** | **99.5** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,821,867,400.0** | **3,672,879,869.0** | **148,987,531.0** | **96.1** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,504,619,300.0 | 3,365,556,372.0 | **139,062,928.0** | **96.0** |
| 210604 | Урсгал засвар | 317,248,100.0 | 307,323,497.0 | **9,924,603.0** | **96.9** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **123,320,800.0** | **110,794,674.0** | **12,526,126.0** | **89.8** |
| 210702 | Дотоод албан томилолт | 123,320,800.0 | 110,794,674.0 | **12,526,126.0** | **89.8** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,424,739,000.0** | **1,278,589,520.7** | **146,149,479.4** | **89.7** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 396,172,100.0 | 353,874,167.0 | **42,297,933.0** | **89.3** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 87,877,600.0 | 85,036,520.0 | **2,841,080.0** | **96.8** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 49,348,900.0 | 42,018,004.0 | **7,330,896.0** | **85.1** |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 5,536,200.0 | 3,720,452.0 | **1,815,748.0** | **67.2** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 511,914,200.0 | 511,912,495.7 | **1,704.4** | **100.0** |
| 210807 | Газрын төлбөр | 10,050,100.0 | 6,415,207.0 | **3,634,893.0** | **63.8** |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 295,673,800.0 | 215,372,675.0 | **80,301,125.0** | **72.8** |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 68,166,100.0 | 60,240,000.0 | **7,926,100.0** | **88.4** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **266,698,900.0** | **159,707,276.5** | **106,991,623.5** | **59.9** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 108,120,500.0 | 12,120,500.0 | **96,000,000.0** | **11.2** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 158,578,400.0 | 147,586,776.5 | **10,991,623.5** | **93.1** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,404,472,383,700.0** | **3,385,593,133,953.9** | **18,879,249,746.1** | **99.4** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,404,472,383,700.0** | **3,385,593,133,953.9** | **18,879,249,746.1** | **99.4** |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 3,403,052,245,400.0 | 3,384,300,980,328.0 | **18,751,265,072.0** | **99.4** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 350,942,500.0 | 328,130,304.9 | **22,812,195.1** | **93.5** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 1,053,595,800.0 | 948,532,704.0 | **105,063,096.0** | **90.0** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,600,000.0 | 15,490,617.0 | **109,383.0** | **99.3** |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **(98,099,996,700.0)** | **(1,744,823,850.1)** | **(96,355,172,850.0)** | **1.8** |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | (98,099,996,700.0) | (1,744,823,850.1) | **(96,355,172,850.0)** | **1.8** |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **3,337,526,311,700.0** | **3,510,780,396,772.2** | **(173,254,085,072.2)** | **105.2** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **844,678,161,200.0** | **842,775,708,475.0** | **1,902,452,725.0** | **99.8** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 844,678,161,200.0 | 842,775,708,475.0 | **1,902,452,725.0** | **99.8** |
| **33** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,590,778,147,200.0** | **2,656,449,055,825.7** | **(65,670,908,625.7)** | **102.5** |
| 330001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 2,589,678,147,200.0 | 2,655,349,055,825.7 | **(65,670,908,625.7)** | **102.5** |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,100,000,000.0 | 1,100,000,000.0 | **-** | **100.0** |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **170,000,000.0** | **13,300,456,321.5** | **(13,130,456,321.5)** | **7823.8** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 13,223,609,231.8 | **(13,223,609,231.8)** | |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 170,000,000.0 | 76,847,089.8 | **93,152,910.3** | **45.2** |
| **37** | **БУСАД ЭХ ҮҮСВЭР** | **(98,099,996,700.0)** | **(1,744,823,850.1)** | **(96,355,172,850.0)** | **1.8** |
| 370001 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | (98,099,996,700.0) | (1,744,823,850.1) | **(96,355,172,850.0)** | **1.8** |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 905,519,973,920.2 | **(905,519,973,920.2)** | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 994,023,846,770.7 | **(994,023,846,770.7)** | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **2,931** | **2,781** | **150** | **94.9** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **35** | **35** | **-** | **100.0** |
| 610001 | Төсвийн байгууллага | 35 | 35 | **-** | **100.0** |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **1,448** | **1,373** | **75** | **94.8** |
| 620001 | Удирдах ажилтан | 43 | 42 | **1** | **97.7** |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 1,220 | 1,173 | **47** | **96.1** |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 185 | 158 | **27** | **85.4** |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **1,448** | **1,373** | **75** | **94.8** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 1,244 | 1,101 | **143** | **88.5** |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | 12 | 8 | **4** | **66.7** |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 183 | 264 | **(81)** | **144.3** |
| 650010 | Гэрээт ажилтан | 9 | - | **9** | |



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **421,329,585.6** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **355,129,585.6** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **314,004,324.6** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **52,232,434.0** |
| 210104 | Урамшуулал | | 52,232,434.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **7,287,601.0** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 7,287,601.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **5,109,440.0** |
| 210401 | Бичиг хэрэг | | 1,300,000.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 1,809,440.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 2,000,000.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **119,300,000.0** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 111,900,000.0 |
| 210604 | Урсгал засвар | | 7,400,000.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **54,712,500.0** |
| 210702 | Дотоод албан томилолт | | 54,712,500.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **22,586,000.0** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 22,586,000.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **52,776,349.6** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 25,445,764.6 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 27,330,585.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **41,125,261.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **41,125,261.0** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 4,981,511.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 36,143,750.0 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **66,200,000.0** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | | **66,200,000.0** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 66,200,000.0 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **400,248,821.0** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **400,248,821.0** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 89,180,172.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 137,683,785.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 170,453,440.0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 2,931,424.0 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | **(21,080,764.6)** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 22,060,377.7 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 979,613.1 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь эрхэм зорилгоо "Нийгмийн даатгалын үйл ажиллагаанд оролцогч талуудын тэгш оролцоотойгоор нийгмийн даатгалын эрх зүйн орчин, тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгож, төрөөс баримталж буй бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, хүн амын насжилт, хөдөлмөр эрхлэлтийн хэв шинж, тэтгэвэр, тэтгэмж авагчдын тооны байдал зэрэг нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн хүчин зүйлтэй уялдуулан тэтгэврийн даатгалын тогтолцоог шинэчилж, олон давхаргат тогтолцоог бий болгох, хүн амыг нийгмийн даатгалд бүрэн хамруулах, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөн арвижуулах, нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, иргэдийнхээ нийгмийн баталгааг хангана" гэж тодорхойлжээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль, тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд НДС-ийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 63 дугаар "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Журам батлах тухай" 230 дугаар тогтоол;
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/64 дугаар тушаалаар "Нийгмийн даатгалын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг шинэчлэн баталсан байна.

ТЕЗ-ийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/64 дүгээр тушаалаар нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг шинэчлэн баталсан байна.

Тус сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, стандартад нийцсэн, сангийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 152,777.0 сая төгрөгөөр буюу 7.6 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 905,542.0 | 994,024.8 | 88,482.8 |
| Авлага | 1,035,324.5 | 797,556.1 | (237,768.4) |
| Бараа материал | 22,681.2 | 18,292.4 | (4,388.8) |
| Үндсэн хөрөнгө | 36,538.9 | 37,436.4 | 897.5 |
| **Нийт хөрөнгө** | **2,000,108.3** | **1,847,331.3** | **(152,777.0)** |
| Өр төлбөр | 24,605.0 | 20,093.1 | (4,511.9) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,975,503.3 | 1,827,238.2 | (148,265.1) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,000,108.3** | **1,847,331.3** | **(152,777.0)** |

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 994,024.8 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 88,482.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Банканд байгаа бэлэн мөнгө** | **905,507.3** | **993,324.8** | **87,817.0** |
| Төрийн сангийн харилцах | 299,904.7 | 244,746.8 | (55,157.9) |
| Арилжааны банк дахь харилцах | 605,580.5 | 748,565.7 | 142,985.2 |
| Бусад төсөл, нөөцийн харилцах | - | 11.4 | 11.4 |
| Нэмэлт санхүүжилтийн харилцах | 22.1 | 0.9 | (21.2) |
| Замд яваа мөнгөн хөрөнгө | 34.7 | 700.0 | 665.3 |
| **Дүн** | **905,542.0** | **994,024.8** | **88,482.8** |

*Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 748,565.7 сая төгрөг арилжааны банкны харилцахад, 244,746.8 сая төгрөг төрийн сангийн харилцахад, 0.9 сая төгрөг нэмэлт санхүүжилтийн харилцахад, 11.4 сая төгрөг бусад төсөл, нөөцийн харилцахад, 700.0 сая төгрөг замд яваа мөнгөн хөрөнгийн дансанд байна.

Мөнгөн хөрөнгө дансны 2022 оны эцсийн үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 88,482.8 сая төгрөгөөр өссөн нь ҮОМШӨ-ийн даатгалын сангийн харилцах 160,254.0 сая, тэтгэмжийн даатгалын сангийн харилцах 58,096.4 сая төгрөгөөр тус тус өссөн, тэтгэврийн даатгалын сангийн харилцахын үлдэгдэл өмнөх оноос 106,356.0 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

*Хүснэгт 3. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл харилцах дансны төрлөөр*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Тэтгэврийн даатгалын сангийн харилцах | 573,432.6 | 467,076.6 | (106,356.0) |
| Тэтгэмжийн даатгалын сангийн харилцах | 59,442.6 | 117,539.0 | 58,096.4 |
| ҮОМШӨ-ний даатгалын сангийн харилцах | 201,803.6 | 362,057.6 | 160,254.0 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн харилцах | 59,015.2 | 38,287.2 | (20,728.0) |

| | | | |
|---|---|---|---|
| Эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах | 7,307.2 | 1,541.0 | (5,766.2) |
| Төвлөрсөн харилцах | 4,457.0 | 6,652.5 | 2,195.5 |
| Үйл ажиллагааны харилцах | 49.1 | 170.9 | 121.8 |
| Замд яваа мөнгө | 34.7 | 700.0 | 665.3 |
| **Дүн** | **905,542.0** | **994,024.8** | **88,482.8** |

*Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд ҮОМШӨ-ний даатгалын сангийн харилцахын үлдэгдэл 160,254.0 сая төгрөгөөр өсөж 362,057.6 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангийн харилцахын үлдэгдэл 58,096.4 сая төгрөгөөр өсөж 117,539.0 сая төгрөг, тэтгэврийн даатгалын сангийн харилцахын үлдэгдэл 106,356.0 сая төгрөгөөр буурч 467,076.6 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангийн харилцахын үлдэгдэл 20,728.0 сая төгрөгөөр буурч 38,287.2 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн харилцахын үлдэгдэл 5,766.2 сая төгрөгөөр буурч 1,541.0 сая төгрөг, бусад харилцахын үлдэгдэл 7,523.4 сая төгрөг байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 797,556.1 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 237,768.4 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 4. Авлагын үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 297,410.4 | 354,357.7 | 56,947.3 |
| Татаас, санхүүжилтийн авлага | 651,458.4 | 359,832.6 | (291,625.8) |
| Байгууллагаас авах авлага | 86,389.9 | 83,294.4 | (3,095.5) |
| Хувь хүмүүсээс авах авлага | 65.8 | 71.3 | 5.5 |
| **Дүн** | **1,035,324.5** | **797,556.1** | **(237,768.4)** |

*Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлага дансны эцсийн үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 23.0 хувиар буурсан нь татаас санхүүжилтийн авлага 291,625.8 сая төгрөгөөр буурснаас голлон нөлөөлсөн байна.

Нийт авлагын дансны 45.1 хувийг татаас, санхүүжилтийн авлага, 44.4 хувийг төлбөртэй үйлчилгээний авлага, 10.5 хувийг байгууллагаас авах авлага бүрдүүлж байна.

Төлбөртэй үйлчилгээний авлага 56,947.3 сая төгрөгөөр өсөж 354,357.7 сая төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 5.5 сая төгрөгөөр өсөж 71.3 сая төгрөг, татаас, санхүүжилтийн авлага өмнөх оны үлдэгдлээс 291,625.8 сая төгрөгөөр буурч 359,832.6 сая төгрөг, байгууллагаас авах авлага 3,095.5 сая төгрөгөөр буурч 83,294.4 сая төгрөг болжээ. Байгууллагаас авах авлагын 83.3 хувь буюу 69,350.0 төгрөг нь Капитал банкны эрх хүлээн авагчаас авах нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн авлага байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 18,292.4 сая төгрөг болж, өмнөх оноос 4,388.8 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Бэлэн бүтээгдэхүүн** | **21,672.1** | **17,304.5** | **(-4,367.6)** |
| **Хангамжийн материал** | **1,009.1** | **987.9** | **(21.2)** |
| Бичиг хэргийн материал | 63.1 | 63.4 | 0.3 |
| Аж ахуйн материал | 374.1 | 386.2 | 12.1 |
| Сэлбэг хэрэгсэл | 96.2 | 87.6 | (8.6) |
| Түлш, шатах тослох материал | 8.0 | 3.4 | (4.6) |
| Барилгын засварын материал | 1.0 | 0.2 | (0.8) |
| Бусад хангамжийн материал | 466.7 | 447.1 | (19.6) |
| **Дүн** | **22,681.2** | **18,292.4** | **(4,388.8)** |

...ЙН АУДИТ... ...УЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын дансны 94.6 хувийг бэлэн бүтээгдэхүүн, 5.4 хувийг хангамжийн материал эзэлж байна. Тайлант онд бэлэн бүтээгдэхүүн өмнөх оны үлдэгдлээс 4,367.6 сая төгрөгөөр буурсан нь бараа материалын дансны үлдэгдэл буурах гол шалтгаан болсон. Капитал банкны эрх хүлээн авагчаас нийгмийн даатгалын сангийн өрөнд хүлээн авсан үл хөдлөх хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулсантай холбоотой бэлэн бүтээгдэхүүн дансны үлдэгдэл өмнөх оноос буурсан байна.

### 3.4.4 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 21,600.0 сая төгрөг байна.

*Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Бусад эргэлтийн хөрөнгө | 21,600.0 | 21,600.0 | - |
| Дүн | 21,600.0 | 21,600.0 | - |

*Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бусад эргэлтийн хөрөнгийн дансанд Нийслэлийн Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн конторын барилгын зургийн 21,600.0 сая төгрөгийн дуусаагүй ажил бүртгэлтэй байна.

### 3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 37,436.4 сая төгрөг болж, өмнөх оноос 897.5 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Биет хөрөнгө** | **32,743.6** | **34,373.5** | **1,629.9** |
| Барилга, байгууламж, орон сууц | 28,555.6 | 27,905.5 | (650.1) |
| Авто-тээврийн хэрэгсэл | 457.8 | 367.3 | (90.5) |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 2,598.8 | 5,235.7 | 2,636.9 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 1,129.6 | 863.5 | (266.1) |
| Бусад үндсэн хөрөнгө | 1.8 | 1.6 | (0.2) |
| **Биет бус хөрөнгө** | **3,795.3** | **3,062.9** | **(732.4)** |
| Программ хангамж | 2,605.8 | 1,835.3 | (770.5) |
| Бусад биет бус хөрөнгө | 1,189.5 | 1,227.7 | 38.2 |
| **Дүн** | **36,538.9** | **37,436.4** | **897.5** |

*Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө худалдан авсан 66.2 сая төгрөг, шилжүүлэн авсан 3,610.6 сая төгрөг, хандиваар ирсэн 11.5 сая төгрөг, бусад 282.9 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 695 дугаартай тогтоолоор акталсан 1,100.1 сая төгрөг, балансаас балансд шилжүүлсэн 60.2 сая төгрөг, бусад 1,236.4 сая төгрөгийн хөрөнгөөр буурсан байна.

### 3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 20,093.1 сая төгрөг болж, өмнөх оноос 4,511.9 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажилчидтай холбогдсон өглөг | 30.2 | 33.6 | 3.4 |

| | | | |
|---|---|---|---|
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 5,104.8 | 2,148.4 | (2,956.4) |
| Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | 0.1 | 0.1 | - |
| Хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг | 0.6 | 0.6 | - |
| Байгууллагад төлөх өглөг | 7,332.2 | 1,714.8 | (5,617.4) |
| Урьдчилж орсон орлого | 12,137.2 | 16,195.8 | 4,058.6 |
| Дүн | 24,605.0 | 20,093.1 | (4,511.9) |

*Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд урьдчилж орсон орлого 80.6 хувийг, бараа үйлчилгээний зардлын өглөг 10.7 хувийг, байгууллагад төлөх өглөг 8.5 хувийг бусад өглөг 0.2 хувийг тус тус эзэлж байна.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 4,511.9 сая төгрөгөөр буурсан нь бараа үйлчилгээний зардлын өглөг 2,956.4 сая төгрөгөөр, байгууллагад төлөх өглөг 5,617.4 сая төгрөгөөр буурч, урьдчилж олсон орлого 4,058.6 сая төгрөгөөр өссөнөөс голлон нөлөөлсөн байна.

### 3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,827,238.2 сая төгрөг болж, өмнөх оноос 148,265.1 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал | 12,216.1 | 12,216.1 | - |
| **Хуримтлагдсан үр дүн** | **1,958,867.8** | **1,810,602.7** | **(148,265.1)** |
| Өмнөх үеийн үр дүн | 1,732,285.8 | 1,957,195.7 | 224,910.0 |
| Тайлант үеийн үр дүн | 226,582.0 | (146,593.0) | (373,175.1) |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 4,419.3 | 4,419.3 | - |
| **Дүн** | **1,975,503.3** | **1,827,238.2** | **(148,265.1)** |

*Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс буурсан нь тайлант онд хуримтлагдсан үр дүн 148,265.1 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг ирүүлэхээр заасан. Тус ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хамаарах тухайн жилийн төсвийн орлого, зарлагын болон нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулгыг хавсаргаж ирүүлсэн байна.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2022 оны төсвийн төслийг боловсруулахдаа нийт орлогыг 3,685,277.5 сая төгрөг, нийт зарлагыг 3,331,960.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг 2,379,466.3 сая төгрөг, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 459,852.6 сая төгрөг, сангийн зарлагыг 2,750,964.7 сая төгрөгөөр тус тус баталсан бөгөөд дараах нөхцөл байдлын улмаас нийгмийн даатгалын сангийн төсөвт 2 удаа тодотгол хийсэн. Үүнд:

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2,379,466.3 сая төгрөг, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 310,100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 769,952.6 сая төгрөг болгож нийт 3,149,418.9 сая төгрөг, сангийн зарлагыг 610,100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 3,361,064.7 сая төгрөгөөр тус тус өөрчлөн баталсан. Энэхүү нэмэгдүүлсэн төсвийг Засгийн газрын 2022 оны "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 63 дугаар тогтоолоор тэтгэврийн хэмжээг 15.0 хувиар нэмэгдүүлэхэд зарцуулсан бөгөөд энэ арга хэмжээний дүнд бүрэн тэтгэврийн доод хэмжээ 500.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 400.0 мянган төгрөг, дундаж тэтгэвэр 555.6 мянган төгрөг болсон.

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50.0 хувийг буцаан олгох тухай хууль батлагдсантай холбоотойгоор Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг 2,379,971.8 сая төгрөг, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 920,698.1 сая төгрөг, сангийн зарлагыг 3,511,746.3 сая төгрөгөөр тус тус өөрчлөн баталсан.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

#### Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт

Нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх нийт орлогыг 3,225,750.0 сая төгрөгөөр баталснаас 3,512,525.2 сая төгрөг төвлөрч 108.9 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 10. Нийгмийн даатгалын сангийн нийт орлого*

/сая төгрөгөөр/

| Орлогын төрөл | 2021 оны гүйцэтгэл | 2022 оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
| Тэтгэвэр | 1,842,185.0 | 1,958,597.6 | 2,183,003.7 | 111.5 | 224,406.1 |
| Тэтгэмж | 140,479.6 | 199,962.5 | 230,885.1 | 115.5 | 30,922.7 |
| ҮОМШӨ | 125,623.5 | 179,143.1 | 202,199.6 | 112.9 | 23,056.4 |
| Ажилгүйдэл | 28,799.9 | 42,268.6 | 52,561.2 | 124.4 | 10,292.6 |
| УТ-ийн дэмжлэг | 593,852.6 | 844,678.2 | 842,775.7 | 99.8 | (1,902.5) |
| ЭМДС-аас олгох шилжүүлэг | 1,100.0 | 1,100.0 | 1,100.0 | 100.0 | - |
| **Нийт дүн** | **2,732,040.5** | **3,225,750.0** | **3,512,525.2** | **108.9** | **286,775.3** |

Тайлант онд тэтгэврийн даатгалын сангийн орлого төлөвлөгөөнөөс 224,406.1 сая төгрөгөөр давж 111.5 хувийн, тэтгэмжийн даатгалын сан 30,922.7 сая төгрөгөөр давж 115.5 хувийн, ҮОМШӨ-ний даатгалын сан 23,056.4 сая төгрөгөөр давж 112.9 хувийн, ажилгүйдлийн даатгалын сан 10,292.6 сая төгрөгөөр давж 124.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого 228,775.3 сая төгрөгөөр давж биелсэн нь тайлант онд нийгмийн даатгалд 55.5 мянган ААНБ бүртгэгдэж, өмнөх оноос 2.7 мянган ААНБ-аар нэмэгдсэн, албан журмын болон сайн дурын даатгалд 1,269.4 мянган даатгуулагч хамрагдаж өмнөх оноос 7.8 хувиар өссөн нь нөлөөлжээ.

#### Нийгмийн даатгалын сангийн зарлага

Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага 3,435,626.3 сая төгрөгөөр батлагдсанаас 3,415,713.8 сая төгрөгийг зарцуулж, 99.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

*Хүснэгт 10. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага*

/сая төгрөгөөр/

| Даатгалын сангийн төрөл | 2021 оны гүйцэтгэл | 2022 оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
| Тэтгэвэр | 2,281,770.2 | 3,055,181.6 | 3,031,288.5 | 99.2 | (23,893.1) |
| Тэтгэмж | 169,427.5 | 171,464.2 | 165,942.6 | 96.8 | (5,521.6) |
| ҮОМШӨ | 30,737.4 | 38,328.7 | 35,933.9 | 93.8 | (2,394.8) |
| Ажилгүйдэл | 57,011.4 | 63,727.6 | 78,685.3 | 123.5 | 14,957.7 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны зардал | 26,616.5 | 32,198.7 | 31,211.2 | 96.9 | (987.5) |
| ДТШ-н 50 хувийн буцаалт | - | 74,725.6 | 72,652.3 | 97.2 | (2,073.3) |
| **Урсгал зардлын дүн** | **2,565,563.0** | **3,435,626.3** | **3,415,713.8** | **99.4** | **(19,912.6)** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тайлант онд ажилгүйдлийн даатгалын сангийн зардал 14,957.7 сая төгрөгийн илүү гүйцэтгэлтэй гарсан нь ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо 30.5 мянга болж өмнөх оноос 4.4 мянган хүнээр нэмэгдэж зарцуулсан хөрөнгө өмнөх оны гүйцэтгэлээс 21,673.9 сая төгрөгөөр өссөн байна.

Тэтгэврийн даатгалын сангийн зардал 99.2 хувь, тэтгэмжийн даатгалын сан 96.8 хувь, ҮОМШӨ-ний даатгалын сан 93.8 хувийн гүйцэтгэлтэй, даатгуулагчийн төлсөн шимтгэлийн 50.0 хувийн буцаалт 97.2 хувь, үйл ажиллагааны зардал 96.9 хувийн зарцуулалттай байна.

Нэг сая ба түүнээс доош төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах сарын хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос албан журмаар болон сайн дураар даатгуулсан даатгуулагчид өөрийнх нь 2022 оны 5 дугаар сараас 12 дугаар сард хариуцан төлсөн тэтгэврийн, тэтгэмжийн, ажилгүйдлийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн 50.0 хувийг сар бүр буцаан олгож, тайлант оны гүйцэтгэлээр давхардсан тоогоор нийт 2,087.746 иргэнд 72,652.3 сая төгрөгийн буцаан олголтыг шилжүүлсэн байна.

### 3.5.3 Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны бараа, ажил, үйлчилгээний худалдан авах төлөвлөгөөнд 10 арга хэмжээнд 3,916.8 сая төгрөгийн худалдан авалтыг урсгал санхүүжилтээс баталсан. Худалдан авалтын төлөвлөгөөнд 3,814.4 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг нээлттэй сонгон шалгаруулалт, 62.6 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар, 39.8 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 3,291.2 сая төгрөгийн гэрээг нээлттэй сонгон шалгаруулалт, 56.5 сая төгрөгийн 2 гэрээг харьцуулалтын аргаар, 39.8 сая төгрөгийн 4 гэрээг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны бараа, ажил, үйлчилгээний худалдан авах тайлангаар 10 арга хэмжээнд 3,387.5 сая төгрөгийн худалдан авалтыг урсгал санхүүжилтээс гаргажээ.

### 3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан тус төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгажээ.

2022 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогчийн тооны өсөлт өмнөх жилээс 5.1 хувиар өсөж 55.5 мянгад хүрсэн байна. Нийгмийн даатгалд албан журмын болон сайн дурын дутгуулагчдын тоо өмнөх оноос 7.8 хувиар өсөж 1,269.4 мянгад хүрсэн байна. Нийгмийн даатгалын сангаас давхардсан тоогоор 746.7 мянган хүн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авсан байна.

*Хүснэгт 11. Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт*

| 27.2 | Нийгмийн даатгал | | Зорилтод | Үр дүн |
|---|---|---|---|---|
| | 27.2.1 | Нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогчийн тооны өсөлт /өмнөх жилд харьцуулсан хувь/ | 5 | 5.1 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 27.2.2 | Нийгмийн даатгалд даатгуулсан даатгуулагчийн тооны өсөлт /өмнөх жилд харьцуулсан хувь/ | 2.5 | 7.8 |
| | 27.2.3 | Нийгмийн даатгалын үйлчилгээ авсан хүний тоо /давхардсан тоогоор мянган хүн/ | 730.6 | 746.7 |

*Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар, Бодлого хэрэгжилт, судалгааны газар*

### 3.5.5 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 89.2 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгө болон дээд шатны төсвийн захирагчаас 308.1 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2.9 сая төгрөг, нийт 400.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 314.0 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 41.1 сая төгрөг, хөрөнгийн зардалд 66.2 сая төгрөг, нийт 421.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Санхүү-Нийцлийн аудитын газрын ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, аудитор А.Баясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ч.Болд, Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Энхжавхлан, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2023 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 02/658 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 2,968,302.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 29,683.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний 29 байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, 7 байгууллагад дээрх хуулийн зарим заалтыг хэрэгжүүлээгүй зөрчилд 0.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 11.7 сая төгрөгийн 4 албан шаардлага, 10.6 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн байна. Дэлгэрэнгүйг хавсралтаар оруулав.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний 16 байгууллага 2022 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн 4 болон 6 дугаар зүйлд заасны дагуу байршуулаагүйгээс 3,802.4 сая төгрөгийн 8 албан шаардлага, 183.6 сая төгрөгийн 8 зөвлөмжийг хүргүүлсэн байна.



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

НДҮЗ-ийн даргын эрхлэх асуудлын хүрээний 13 байгууллагын захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 27 ажилтанд ажилгүй байсан хугацааны цалин, НДШ-ийн 186.3 сая төгрөгийг нөхөн төлүүлэх шийдвэр гарснаас, төсвөөс 185.7 сая төгрөгийг төлж хохирлыг барагдуулсан байна. Төсвөөс төлсөн нийт төлбөрөөс 0.6 сая төгрөгийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлж, 185.0 сая төгрөгийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтан төлөөгүй, төсөвт хохирол учруулсан хэвээр байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ, 103.2 "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна", 104 дүгээр зүйлийн 104.1 "Захиргааны байгууллагын хууль ёсны үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөний улмаас хохирол учирсан бол төрөөс нөхөх олговор олгож хохирлыг барагдуулна", Төрийн албаны тухай хуулийн 50.1 "Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх талаар дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 71.4 хувьтай байна.

*Хүснэгт 12. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/сая төгрөгөөр/*

| Д.д | Үзүүлэлт | Өмнөх аудитаар | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| 1 | Албан шаардлага | 4 | 112,837.4 | 3 | 85,739.9 | 75.0 |
| 2 | Зөвлөмж | 3 | 3.5 | 2 | 3.5 | 66.7 |
| | **Нийт дүн** | **7** | **112,840.9** | **5** | **85,743.4** | **71.4** |

Чингис хаан банк ХХК-тай 2021 онд байгуулсан "Төлбөр тооцооны үүрэг хэсэгчлэн гүйцэтгэх тухай" гэрээний үүргийг хангуулах, харилцахын үлдэгдлийг барагдуулж ажиллах талаар өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Дээрх мөнгөн хөрөнгөөс тайлант онд 4,443.6 сая төгрөгийг татан төвлөрүүлж, жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 96,105.9 сая төгрөгийн төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй 6,451.2 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй, хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлээгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Капитал банкны эрх хүлээн авагчаас нийгмийн даатгалын өр төлбөрт үл хөдлөх хөрөнгө хүлээн авах тогтоолын хэрэгжилт, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлд нэвтрүүлж буй санхүүгийн

программ хүлээн авахтай холбоотой асуудлыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 172,179.9 сая төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 172,179.9 сая төгрөгийн 6 албан шаардлага өгсөн.

Зөрчлийн дүн болох 172,179.9 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 29,689.0 сая төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

**Харьяа байгууллагууд:**

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 36 төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 4 байгууллагыг түүвэрт хамруулж, 31 байгууллага “Өөрчлөлтгүй”, 1 байгууллага “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 285.0 сая төгрөгийн 22 санхүүгийн алдааг аудитын явцад залруулж, 6.6 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт, 174,033.0 сая төгрөгийн зөрчилд 33 албан шаардлага, 595.8 сая төгрөгийн зөрчилд 39 зөвлөмж хүргүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар үзсэн нийцлийн асуудлаар 3,998.3 сая төгрөгийн 14 албан шаардлага, 3,076.5 сая төгрөгийн 16 зөвлөмж хүргүүлсэн байна.

### 5.1 Албан шаардлага

1. Нийгмийн даатгалын төв сан нь Капитал банкнаас авах 73,999.9 сая төгрөгийн авлагаас тайлант онд 1,744.8 сая төгрөгийг мөнгөн хэлбэрээр, 2,905.2 сая төгрөгийн 32 нэр төрлийн үл хөдлөх хөрөнгийг хүлээн авч, данс бүртгэлд тусгаж, жилийн эцсийн санхүүгийн тайланд 69,350.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ..." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Капитал банкнаас авах авлагыг үе шаттай барагдуулах, холбогдох төрийн байгууллагуудтай хамтарч ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

2. Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй Чингис хаан банканд байршиж буй НДС-ийн 96,105.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг НДС-ийн төв санд буцаан төвлөрүүлээгүй, тус банктай 2021 онд байгуулсан "Төлбөр тооцооны үүрэг хэсэгчлэн гүйцэтгэх тухай" гэрээний үүргийг бүрэн хангуулаагүй, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд эрсдэл үүссэн хэвээр байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.3 "нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлт болон нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Чингис хаан банканд байршиж буй НДС-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг НДС-ийн төв санд төвлөрүүлэх талаар албан шаардлага хүргүүлэв.

3. НДС-ийн төв сангийн санхүүгийн тайланд олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй иргэн, аж ахуй нэгж байгууллага, татан буугдсан банк, даатгалын компани болон Нийслэлийн өмчийн харилцааны газраас авах 6,451.2 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, авлага барагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ..." Нийгмийн даатгалын тухай хуулийн

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

24 дүгээр зүйлийн 2-т “нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй иргэн, аж ахуй нэгж байгууллагаас авах авлагыг хуулийн байгууллагад хандан үе шаттай барагдуулах талаар албан шаардлага хүргүүлэв.

4. Капитал банкны эрх хүлээн авагчаас шилжүүлэн авсан Чингэлтэй дүүргийн 3-р хорооны Энхтайвны өргөн чөлөөний гудамжинд байрлах "Энхтайван найрамдлын ордон"-г 2021 онд "М" ХХК-тай гэрээ байгуулж түрээсэлсэн боловч, гэрээний үүргийг хангуулаагүйгээс жилийн эцсийн санхүүгийн тайланд 87.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ..." Түрээсийн гэрээний 4 дүгээр зүйл "Төлбөр тооцоо, барьцаа" 4.2-т заасан гэрээний үүргийг биелэлтийг хангуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулах талаар албан шаардлага хүргүүлэв.

5. НДҮЗ-ийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 285.0 сая төгрөгийн 22 алдааг залруулж, 6.6 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт тогтоож, 2,038.1 сая төгрөгийн зөрчилд 29 албан шаардлага хүргүүлж, 595.8 сая төгрөгийн зөрчилд 39 зөвлөмж өгсөн байна. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар 3,813.3 сая төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага, 3,076.5 сая төгрөгийн зөрчилд 16 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд илэрсэн алдаа, зөрчилд дүн шинжилгээ хийж, дотоод хяналтын үйл ажиллагаа, хариуцлагыг сайжруулах, аудитын зөвлөмжийн дагуу төлөвлөгөө, удирдамж гаргаж, үе шаттай хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, талаар албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагуудын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Д.д | Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Нийгмийн даатгалын төв сан | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 2 | НДҮЗ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 3 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн технологийн төв | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 4 | Нийгмийн даатгалын ерөнхий газар | 4 | 136.9 | - | - | 4 | 136.9 | 4 | 136.9 | - | - | - | - |
| 5 | БНСУ дахь НДА | 1 | 1.0 | - | - | 1 | 1.0 | - | - | 1 | 1.0 | 1 | 1.0 |
| 6 | Нийслэлийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 7 | Багануур дүүргийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 8 | Багахангай дүүргийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 9 | Баянгол дүүргийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 10 | Баянзүрх дүүргийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 11 | Налайх дүүргийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 12 | Сонгинохайрхан дүүргийн НДХ | 1 | 6.5 | - | - | 1 | 6.5 | 1 | 6.5 | - | - | - | - |
| 13 | Сүхбаатар дүүргийн НДХ | 5 | 16.3 | - | - | 5 | 16.3 | 5 | 16.3 | - | - | - | - |
| 14 | Хан-Уул дүүргийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 15 | Чингэлтэй дүүргийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 16 | Архангай аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 17 | Баян-Өлгий аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 18 | Баянхонгор аймгийн НДХ | 1 | 0.3 | - | - | 1 | 0.3 | 1 | 0.3 | - | - | - | - |
| 19 | Булган аймгийн НДХ | 1 | 99.5 | - | - | 1 | 99.5 | 1 | 99.5 | - | - | - | - |
| 20 | Говь-Алтай аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 21 | Говьсүмбэр аймгийн НДХ | 3 | 5.8 | - | - | 3 | 5.8 | 3 | 5.8 | - | - | - | - |
| 22 | Дархан-Уул аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 23 | Дорноговь аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 24 | Дорнод аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 25 | Дундговь аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 26 | Завхан аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 27 | Сүхбаатар аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 28 | Орхон аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 29 | Өвөрхангай аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 30 | Өмнөговь аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 31 | Сэлэнгэ аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 32 | Төв аймгийн НДХ | 1 | 6.7 | - | - | 1 | 6.7 | 1 | 6.7 | - | - | - | - |
| 33 | Увс аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 34 | Ховд аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 35 | Хэнтий аймгийн НДХ | 3 | 5.1 | - | - | 3 | 5.1 | 3 | 5.1 | - | - | - | - |
| 36 | Хөвсгөл аймгийн НДХ | 3 | 8.0 | - | - | 3 | 8.0 | 3 | 8.0 | - | - | - | - |
| | **Дүн** | **23** | **286.0** | **-** | **-** | **23** | **286.0** | **22** | **285.0** | **1** | **1.0** | **1** | **1.0** |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Д.д | Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Нийгмийн даатгалын төв сан | 4 | 171,994.9 | - | - | 4 | 171,994.9 | - | - | - | - | - | - |
| 2 | НДҮЗ | 1 | 1.9 | - | - | - | - | 1 | 1.9 | - | - | - | - |
| 3 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн технологийн төв | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 4 | Нийгмийн даатгалын ерөнхий газар | 4 | 184.3 | - | - | 2 | 105.5 | 2 | 78.8 | - | - | - | - |
| 5 | БНСУ дахь НДА | 3 | 51.1 | - | - | 1 | 45.0 | 2 | 6.1 | - | - | - | - |
| 6 | Нийслэлийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 7 | Багануур дүүргийн НДХ | 2 | - | - | - | - | - | 2 | - | - | - | - | - |
| 8 | Багахангай дүүргийн НДХ | 1 | 0.5 | - | - | 1 | 0.5 | - | - | - | - | - | - |
| 9 | Баянгол дүүргийн НДХ | 6 | 84.2 | - | - | - | - | 6 | 84.2 | - | - | - | - |
| 10 | Баянзүрх дүүргийн НДХ | 9 | 930.7 | - | - | 4 | 925.6 | 5 | 5.1 | - | - | - | - |
| 11 | Налайх дүүргийн НДХ | 2 | 5.0 | - | - | - | - | 2 | 5.0 | - | - | - | - |
| 12 | Сонгинохайрхан дүүргийн НДХ | 1 | 1.0 | - | - | 1 | 1.0 | - | - | - | - | - | - |
| 13 | Сүхбаатар дүүргийн НДХ | 3 | 882.4 | - | - | 2 | 882.4 | 1 | - | - | - | - | - |
| 14 | Хан-Уул дүүргийн НДХ | 1 | 0.8 | - | - | - | - | 1 | 0.8 | - | - | - | - |
| 15 | Чингэлтэй дүүргийн НДХ | 2 | - | - | - | - | - | 2 | - | - | - | - | - |
| 16 | Архангай аймгийн НДХ | 2 | 6.2 | 1 | 1.1 | 1 | 5.1 | - | - | - | - | - | - |
| 17 | Баян-Өлгий аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 18 | Баянхонгор аймгийн НДХ | 2 | 1.9 | 1 | 0.9 | 1 | 1.0 | - | - | - | - | - | - |
| 19 | Булган аймгийн НДХ | 1 | 16.6 | - | - | - | - | 1 | 16.6 | - | - | - | - |
| 20 | Говь-Алтай аймгийн НДХ | 8 | 9.6 | 3 | 1.2 | 5 | 8.4 | - | - | - | - | - | - |
| 21 | Говьсүмбэр аймгийн НДХ | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| 22 | Дархан-Уул аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 23 | Дорноговь аймгийн НДХ | 3 | - | - | - | - | - | 3 | - | - | - | - | - |
| 24 | Дорнод аймгийн НДХ | 1 | 0.1 | 1 | 0.1 | - | - | - | - | - | - | - | - |
| 25 | Дундговь аймгийн НДХ | 3 | 0.3 | - | - | 3 | 0.3 | - | - | - | - | - | - |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 26 | Завхан аймгийн НДХ | 1 | 47.1 | - | - | 1 | 47.1 | - | - | - | - | - | - |
| 27 | Сүхбаатар аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 28 | Орхон аймгийн НДХ | 8 | 2.0 | 1 | 0.9 | 3 | 0.8 | 4 | 0.4 | - | - | - | - |
| 29 | Өвөрхангай аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 30 | Өмнөговь аймгийн НДХ | 2 | 1.0 | 2 | 1.0 | - | - | - | - | - | - | - | - |
| 31 | Сэлэнгэ аймгийн НДХ | 7 | 406.2 | 2 | 1.1 | 3 | 15.5 | 2 | 389.6 | - | - | - | - |
| 32 | Төв аймгийн НДХ | 3 | 1.4 | 1 | 0.4 | 1 | - | 1 | 1.0 | - | - | - | - |
| 33 | Увс аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 34 | Ховд аймгийн НДХ | 1 | 4.8 | - | - | - | - | 1 | 4.8 | - | - | - | - |
| 35 | Хэнтий аймгийн НДХ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 36 | Хөвсгөл аймгийн НДХ | 1 | 0.5 | - | - | - | - | 1 | 0.5 | - | - | - | - |
| | **Нийт дүн** | **83** | **174,634.4** | **12** | **6.6** | **33** | **174,033.0** | **38** | **594.8** | **-** | **-** | **-** | **-** |

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

| Д.д | Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 1 | НДҮЗӨВЛӨЛ | 1 | 405.6 | - | - | 1 | 405.6 | - | - |
| 2 | Нийгмийн даатгалын ерөнхий газар | 1 | 226.5 | - | - | 1 | 226.5 | - | - |
| 3 | БНСУ дахь НДА | 1 | 826.3 | - | - | 1 | 826.3 | - | - |
| 4 | Багануур дүүргийн НДХ | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| 5 | Багахангай дүүргийн НДХ | 1 | 2,027.6 | - | - | 1 | 2,027.6 | - | - |
| 6 | Налайх дүүргийн НДХ | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| 7 | Сонгинохайрхан дүүргийн НДХ | 1 | 75.7 | - | - | - | - | 1 | - |
| 8 | Сүхбаатар дүүргийн НДХ | 1 | - | - | - | 1 | - | - | 75.7 |
| 9 | Чингэлтэй дүүргийн НДХ | 1 | 104.3 | - | - | - | - | 1 | 104.3 |
| 10 | Булган аймгийн НДХ | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| 11 | Говьсүмбэр аймгийн НДХ | 1 | 9.3 | - | - | 1 | 9.3 | - | - |
| 12 | Дорнод аймгийн НДХ | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| 13 | Завхан аймгийн НДХ | 1 | 88.8 | - | - | 1 | 88.8 | - | - |
| 14 | Орхон аймгийн НДХ | 1 | 3.6 | | | - | - | 1 | 3.6 |
| 15 | Өмнөговь аймгийн НДХ | 1 | 218.3 | - | - | 1 | 218.3 | - | - |
| 16 | Төв аймгийн НДХ | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| | **Дүн** | **16** | **3,985.9** | **-** | **-** | **8** | **3,802.4** | **8** | **183.6** |
| | Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| 1 | Нийгмийн даатгалын төв сан | 2 | 185.0 | - | - | 2 | 185.0 | - | - |
| 2 | НДҮЗӨВЛӨЛ | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| 3 | Нийгмийн даатгалын ерөнхий газар | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| 4 | Нийслэлийн НДХ | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| 5 | Сүхбаатар дүүргийн НДХ | 3 | 2,883.1 | - | - | - | - | 3 | 2,883.1 |
| 6 | Булган аймгийн НДХ | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| 7 | Говь-Алтай аймгийн НДХ | 2 | 2.4 | - | - | 1 | 2.4 | 1 | - |
| 8 | Говьсүмбэр аймгийн НДХ | 1 | 2.4 | - | - | 1 | 2.4 | - | - |
| 9 | Завхан аймгийн НДХ | 1 | 6.1 | - | - | 1 | 6.1 | - | - |
| 10 | Төв аймгийн НДХ | 1 | 9.9 | - | - | - | - | 1 | 9.9 |
| | **Дүн** | **14** | **3,088.9** | **-** | **-** | **6** | **195.9** | **8** | **2,893.0** |
| | **Нийт дүн** | **30** | **7,074.9** | **-** | **-** | **14** | **3,998.3** | **16** | **3,076.5** |

**Хавсралт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн аудитын горим сорилын үр дүнд илрүүлсэн зөрчил

/сая төгрөгөөр/

| № | Байгууллагын нэр | Зөрчлийн утга | Мөнгөн дүн | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 6 дугаар зүйл | | 15 дугаар зүйл | | |
| | | | | 6.1 | 6.3 | 15.1.1 | 15.1.3 | 15.2.3 |
| 1 | Баянгол дүүргийн НДХ | Байгууллага нь Элентра маркийн УНҮ 13-32 дугаартай суудлын автомашиныг ашиглаж, нийт 7,403.7 мянган төгрөгийн зардал гаргасан байна. | 7.4 | | 7.4 | | | |
| 2 | Баянзүрх дүүргийн НДХ | Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Киа серато маркийн УБҮ07-33 улсын дугаар бүхий суудлын автомашин албан хэрэгцээнд ашигласан байна. | 3.2 | | 3.2 | | | |
| 3 | Сонгинохайрхан дүүргийн НДХ | Тайлант онд 1,000.0 мянган төгрөгийн сургалтын зардал гаргасан. | 1.0 | | | | | 1.0 |
| 4 | Булган аймгийн НДХ | Төрийн өмчид бүртгэлтэй 69-89БУЛ улсын дугаартай авто машины улсын номойр тод өнгийн тэмдэглэгээгүй. | - | | | | | |
| 5 | Говь-Алтай аймгийн НДХ | Хуульд зааснаас бусад байдлаар шагнал урамшуулал өгсөн | 4.4 | | | 0.6 | 3.8 | |
| 6 | Завхан аймгийн НДХ | Байгууллагын автомашин эвдэрч үйлчилгээнд ашиглагдаагүй байхад жолоочийн орон тоог цомхотгох, өөр албан тушаалд сэлгүүлэн ажиллуулах шийдвэрийн аль нэгийг гаргаагүй. | 6.1 | | 6.1 | | | |
| 7 | Орхон аймгийн НДХ | Байгууллагын тээврийн хэрэгслийг хот дотор хэрэглэж нийт 0.8 сая төгрөгийн шатахуун зарцуулсан байна. | 0.8 | 0.8 | | | | |
| | **Нийт дүн** | | **22.9** | **0.8** | **16.7** | **0.6** | **3.8** | **1.0** |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ХЯЗГААРЛАГДМАЛ
САНАЛ ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 04 дугаар сарын 25 № 926/00110001 Улаанбаатар хот

СНДТ-2023/13/НА-СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Капитал банкны эрх хүлээн авагчаас шилжүүлэн авсан Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороонд байрлах "Энхтайван найрамдлын ордон"-ыг 2021 онд "М" ХХК-тай гэрээ байгуулж түрээсэлсэн боловч, гэрээний үүргийг хангуулаагүйгээс жилийн эцсийн санхүүгийн тайланд 87,858,900.00 /наян долоон сая, найман зуун тавин найман мянга есөн зуун/ төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ...*" гэж заасантай нийцээгүй, Түрээсийн гэрээний 4 дүгээр зүйлийн "*Төлбөр тооцоо, барьцаа*" 4.2-т заасан гэрээний үүргийг биелэлтийг хангуулж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Түрээсийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Х.Булгантуяа/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганцэцэг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ЗАНДАНБАТ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26[illegible]30*

Z:\Alban Shaardlaga\2023-0425 SNAG-27.Docx

0001081997

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 04 дугаар сарын 05 № 927/АО110001 Улаанбаатар хот
СНДТ-2023/13/НБ-ОТЯ-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 35 байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн 6,603,180.00 төгрөг, нийцлийн 6,889,824,980.00 төгрөгийн зөрчлүүд илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 *"санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"*, 14 дүгээр зүйлийн 14.2 *"Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ"*, 14.2.10 *"өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"* гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"*-ын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрч буй алдаа, зөрчлийг арилгаагүй, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Х.Булгантуяа/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганцэцэг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ЗАНДАНБАТ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264130*

Z:\Albon Shaardlaga\2023\0425 SNAG-27.Docx

0001081939

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 04 дугаар сарын 25 № 928/А0110001 Улаанбаатар хот
СНДС-2023/13/НА-СТЭ-763

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний 13 байгууллагын захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 27 ажилтанд ажилгүй байсан хугацааны цалин, НДШ-ийн 186,330,622.00 төгрөгийг нөхөн төлүүлэх шийдвэр гарснаас, төсвөөс 185,682,363.00 төгрөгийг төлж хохирлыг барагдуулсан байна. Төсвөөс төлсөн нийт төлбөрөөс 648,259.00 төгрөгийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлж, 185,034,104.00 /нэг зуун наян таван сая гучин дөрвөн мянга нэг зуун дөрвөн/ төгрөгийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтан төлөөгүй, төсөвт хохирол учруулсан хэвээр байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн **103.1-т** *"Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ"*, 103.2-д *"Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна"*, Төрийн албаны тухай хуулийн 50.1-т *"Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ"* гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"*-ын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй зөрчлийг байгууллагын дотоод аудитын нэгж зохион байгуулалтын арга хэмжээ авч зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Х.Булгантуяа/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганцэцэг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ЗАНДАНБАТ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264130*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 04 дугаар сарын 25 № 929/АО110001 Улаанбаатар хот
СНДТ-2023/13/НА-СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын төв сан нь Капитал банкнаас авах 73,999,999,100.00 төгрөгийн авлагаас тайлант онд 1,744,823,850.00 төгрөгийг мөнгөн хэлбэрээр, 2,905,176,150.00 төгрөгийн 32 нэр төрлийн үл хөдлөх хөрөнгийг хүлээн авч, жилийн эцсийн санхүүгийн тайланд 69,349,999,100.00 /жаран есөн тэрбум гурван зуун дөчин есөн сая есөн зуун ерэн есөн мянга нэг зуун/ төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ...*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/05 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Капитал банкнаас авах авлагыг бүрэн барагдуулаагүй, холбогдох төрийн байгууллагуудтай хамтарч ажиллаасан ч үр дүн гараагүй, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Х.Булгантуяа/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганцэцэг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ЗАНДАНБАТ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261430*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 04 дугаар сарын 25 № 930/А011/0001 Улаанбаатар хот
СНДГ-2023/13/НЛ-СТЛ-Т63

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын сангийн төв сангийн санхүүгийн тайланд олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй иргэн, аж ахуй нэгж байгууллага, татан буугдсан банк, даатгалын компани болон Нийслэлийн өмчийн харилцааны газраас авах 6,451,154,267.00 /зургаан тэрбум дөрвөн зуун тавин нэгэн сая нэг зуун тавин дөрвөн мянга хоёр зуун жаран долоон/ төгрөгийн авлагыг барагдуулах талаар өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ...*" Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 "*нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй иргэн, аж ахуй нэгж байгууллагаас авах авлагыг хууль хяналтын байгууллагад хандан барагдуулаагүй, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Х.Булгантуяа/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганцэцэг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ЗАНДАНБАТ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264430*

Z:\Alban Shaardlaga\2023\0425 SHAG-27.Docx

0001081995

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 04 дугаар сарын 25 № 931/2010001 Улаанбаатар хот
СНДГ-2023/13)НА-СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй Чингис хаан банканд байршиж буй НДС-ийн 96,105,875,246.00 /ерэн зургаан тэрбум нэг зуун таван сая найман зуун далан таван мянга хоёр зуун дөчин зургаан/ төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Нийгмийн даатгалын төв санд буцаан төвлөрүүлээгүй, тус банктай 2021 онд байгуулсан "Төлбөр тооцооны үүрэг хэсэгчлэн гүйцэтгэх тухай" гэрээний үүргийг бүрэн хангуулаагүй, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд эрсдэл үүссэн хэвээр байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 "*өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах*", Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.3 "*нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлт болон нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Чингис хаан банканд байршиж буй НДС-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Нийгмийн даатгалын төв санд төвлөрүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Х.Булгантуяа/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганцэцэг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ЗАНДАНБАТ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2023\0425 SNAG-27.Docx

0001081993

Хавсралт 5

# БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар оруулах | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*** | | | | | | | |
| *"Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 1.1. | Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлтэй холбоотой нийгмийн даатгалын дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн батлуулах талаар холбогдох саналыг боловсруулан шаардлагатай судалгаа, тооцооны хамт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэх; | Шаард-лагагүй | Боловсруулсан санал | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/73 дугаар тушаалаар баталсан Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсэгт ажиллан Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлснээр Улсын Их хуралд өргөн барив. | Шаардлагатай судалгаа тооцооны хамт санал боловсруулан хүргүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/73 дугаар тушаалаар баталсан Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсэгт ажиллан Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлснээр Улсын Их хуралд өргөн барив.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөл дээр дахин ажиллаж байна. | 90 |
| 1.2. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид орсон өөрчлөлтийн хэрэгжилтийг зохион байгуулах, холбогдох журам, заавар, | Шаард-лагагүй | Журам, заавар, зөвлөмж, чиглэлийн тоо | Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой 22 удаагийн чиглэл, зөвлөмж, 6 журмыг хүргүүлэн, | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэх | **Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль,** Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудад орсон 2022 оноос мөрдөх зохицуулалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 1 журам, 4 заавар, 11 зөвлөмж чиглэлийг аймаг, дүүргийн Нийгмийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвлөмж, чиглэлийг боловсруулан батлуулж төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагыг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллах; | | | хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. | чиглэлээр орсон өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэн журам, заавар, чиглэл боловсруулан төв, орон нутгийн албадад хүргүүлсэн байна. Жилийн эцэст, хүргүүлсэн журам, заавар, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. | даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллав. | |
| 1.3. | Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулсан үр дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэх; | Шаард-лагагүй | Хуулийн дагуу шимтгэлээ төлсөн иргэдийн баталгаажилтын хуудсыг хэвлэсэн тоо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн тайлан | 2021 онд урьдчилсан байдлаар нийт дүнгээр 24.9 мянган иргэнийг тэтгэврийн нөхөн даатгалд хамруулснаар 52.3 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын санд төвлөрүүлэв. | Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулсан үр дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна. | Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль, Засгийн газрын 2019 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам"-ын хэрэгжилтийг 2020-2021 онд зохион байгуулан 31.8 мянган малчин, 2.6 мянган хувиараа хөдөлмөр эрхлэгч, нийтдээ 34.4 мянган иргэнийг нөхөн даатгалд хамруулж, 76.4 тэрбум төгрөгийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, баталгаажилтын хуудсыг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн, даатгуулагчид олгох ажлыг зохион байгуулав.<br>Эдгээр иргэдээс 19.6 мянган иргэн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоолгон, тэтгэвэрт нь 155.9 тэрбум төгрөг зарцуулаад байна.<br>Уг хуулийн хэрэгжилт, үр дүнгийн тайланг 2022 оны 01/377 дугаар албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. | 100 |
| 1.4. | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оноос эхлэн дагаж мөрдөхтэй | Шаард-лагагүй | Нийгмийн даатгалын харилцаатай холбогдолтой | Шинээр хэрэгжинэ. | Зөвлөмж хүргүүлсэн байна. Жилийн эцэст зөвлөмжийн | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан УИХ-ын 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын тухай хуульд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбоотойгоор уг хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах; | | зүйл, заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр хүргүүлсэн зөвлөмж | | хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. | өөрчлөлт оруулах тухай хуулиар шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг өөрчлөн баталсан.<br>Дээрх хууль болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ыг хэрэгжүүлэх зөвлөмжийг аймаг, дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.<br>Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх талаарх зөвлөмжийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд 2022 оны 01/34 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. | |
| 1.5. | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 71 дүгээр зүйлд заасан туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээ бүхий иргэдэд хууль тогтоомжийг сурталчлах, нийгмийн даатгалд хамруулах ажлыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газартай хамтран зохион байгуулах; | Шаард-лагагүй | Хамтран ажиллах гэрээ | Шинээр хэрэгжинэ. | Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хооронд гэрээ байгуулах талаар хамтран ажиллах санал авсан байна. Жилийн эцэст хоёр байгууллагын хооронд хамтран ажиллах гэрээ байгуулан, хэрэгжилтийг зохион байгуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны "Туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээний загвар батлах тухай" А/55 дугаар тушаалыг хэрэгжүүлэх чиглэлийн хамт аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэв.<br>Энэхүү ажлын хүрээнд ажил олгогчоос туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтантай хөдөлмөрийн гэрээг байгуулан аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст, суманд Засаг даргын тамгын газарт бүртгүүлсэн туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтанг сайн дурын даатгалд хамруулах ажлыг Хөдөлмөр, халамж, үйлчилгээний ерөнхий газар, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамж, үйлчилгээний албадтай хамтран зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. | 100 |
| 1.6. | Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2022 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тооцож, | Шаард-лагагүй | Батлагдсан хүүгийн хэмжээ | Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2021 оны | Нэрийн дансны хүүгийн хэмжээг тооцон, Үндэсний статистикийн хорооны саналыг | Даатгуулагчийн 2022 оны тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр батлуулах бэлтгэл ажлын хүрээнд 2021 онд нийгмийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Үндэсний статистикийн хорооноос санал авч, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх; | | | орлогод тооцох хүүгийн хэмжээг тооцож Үндэсний статистикийн хорооноос санал авч Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 21 дүгээр тогтоолоор 2021 оны хүүгийн хэмжээг 11.6 хувиар батлуулав. | авч, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр батлуулсан байна. | даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчдын цалин хөлсний дунджийг нийгмийн даатгалын тайланд үндэслэн гаргав.<br>Нэрийн дансны 2022 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тооцож санал авах хүсэлтийг Үндэсний статистикийн хороонд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 01/2289 дүгээр албан бичгээр хүргүүллээ.<br>2021 оны нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг тооцон Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 12 дугаар сарын хуралд оруулж батлуулахаар тооцоолол судалгааг гарган ажиллаж байна. | |
| 1.7. | Нэрийн дансны 2021 оны эцсийн үлдэгдлийг тооцон даатгуулагчдад мэдээлэл хүргэх; | Шаард-лагагүй | Нэрийн дансны үлдэгдлийн хэмжээ | 2020 оны жилийн эцсийн байдлаар 1.5 сая даатгуулагчийн 18.8 их наяд төгрөгийн шимтгэлийг хүүгийн хамт бүртгэсэн. | Нэрийн дансны 2021 оны жилийн эцсийн үлдэгдлийг тооцон даатгуулагчид мэдээлсэн байна. | Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд 2021 оны жилийн эцсийн байдлаар 1.5 сая даатгуулагчийн 24.2 их наяд төгрөгийн шимтгэлийг хүүгийн хамт бүртгэв.<br>Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээлэх хуудсыг цахимаар олгох ажлыг зохион байгуулан, нийгмийн даатгалын цахим дэвтэр, www.ndaatgal.mn вэб сайтын даатгуулагчид зориулсан вэб, "Нийгмийн даатгал" аппликейшн, ХУР систем E-Mongolia зэрэгт цахим байдлаар байршуулав.<br>Мөн нэрийн дансны тооцоолол, үлдэгдэл шалгах, тэтгэвэр тооцох програмыг шинээр нэвтрүүлэн 95.5 мянган даатгуулагч тэтгэврийн нэрийн дансны үлдэгдлээ, 49.4 мянган даатгуулагч ирээдүйд авах тэтгэврийн тооцооллоо өөрөө тооцоолж үзсэнээр нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар шуурхай үзүүлэв. | 100 |
| 1.8. | "Нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоох нь" сэдэвт сургалтыг салбарын нийт ажилтнуудын дунд үе шаттайгаар зохион байгуулах; | Шаард-лагагүй | Зохион байгуулсан сургалтын тоо | Шинээр хэрэгжинэ. | "Нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоох нь" сэдэвт сургалтыг зохион байгуулсан байна. | Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн тэтгэвэр хариуцсан болон сумын байцаагчдад зориулсан "Цалин хөлсөнд суурилсан аргаар болон нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоох, олгоход анхаарах асуудал", Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/31 дүгээр тушаалаар баталсан "Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журмыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал" | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сэдвүүдээр сургалт зохион байгуулж, уг сургалтад 500 байцаагч ажилтан оролцов. Нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудын мэдлэгийг бататгах, арга зүйн зөвлөгөө өгөхөд чиглэсэн сургалтыг 2022 оны 11 дүгээр сард "Динамик сургалтын платформ"-ыг ашиглан цахимаар зохион байгуулж, уг сургалтад 200 гаруй албан хаагчид оролцов. | |
| 1.9. | Малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах ажлыг зохион байгуулах, үр дүнг тооцож ажиллах; | Шаард-лагагүй | Шинээр нийгмийн даатгалд хамруулсан сайн дурын даатгуулагч, малчдын тоо | 2021 онд 40.6 мянган иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулав. Үүнээс 2.4 мянган малчныг нийгмийн даатгалд шинээр хамруулав. | Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, жилийн эцэст гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна. | Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нартай байгуулсан 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шинээр даатгалд хамруулах даатгуулагчийн тоог тусгаж, 2022 онд 49.3 мянган иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулав. Үүнээс: 12.3 мянган малчинтай сайн дурын даатгалын гэрээг цахимаар байгуулах ажлыг зохион байгуулав. | 100 |
| 1.10. | Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, сангийн орлогын бааз суурийг өргөжүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчдыг шинээр хамруулах ажлыг зохион байгуулах; | Шаард-лагагүй | Шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо | 2021 онд 4.7 мянган аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр бүртгэж, 130.4 мянган иргэнийг албан журмын даатгалд хамруулсан. | Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, жилийн эцэст гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна. | Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нартай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шинээр даатгалд хамруулах ажил олгогч, даатгуулагчийн тоог тусгаж, 2022 онд 4.4 мянган аж ахуйн нэгж, байгууллагыг нийгмийн даатгалд шинээр хамруулж, 134.1 мянган иргэнийг албан журмын даатгалд хамруулав. | 100 |
| 1.11. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо, Хөдөлмөрийн аюулгүй | 1.57 тэрбум төгрөг | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, хийж гүйцэтгэсэн ажлын тоо | Төлөвлөгөөнд тусгагдсан 34 ажлыг хийж гүйцэтгэн, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 785.9 тэрбум төгрөгийг зарцуулав. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил зохион байгуулсан байна. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан 32 ажлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 947.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгов. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байдал, эрүүл мэндийн төв, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, үр дүнг сурталчлан ажиллах; | | | | | | |
| 1.12. | Өндөр насны тэтгэвэр тогтоохтой холбоотой 2022 онд мөрдөх хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, иргэдэд хуулийг сурталчлан таниулах, төв, орон нутгийн албадыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах; | Шаард-лагагүй | Хүргүүлсэн чиглэл, зөвлөмжийн тоо | 2021 онд 353.8 мянган тэтгэвэр авагчийн өндөр насны тэтгэвэр 1,790.4 тэрбум төгрөгийг зарцуулсан.<br>Төв, орон нутгийн албадад 3 удаагийн чиглэл, зөвлөмжийг хүргүүлсэн. | Хуулийг хэрэгжүүлэх талаар чиглэл, зөвлөмж өгч, мэргэжил, арга зүйгээр хангаж ажилласан байна. | 1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөлөөр 2022 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох нөхцөлийн талаар аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.<br>Уг зөвлөмжид 2022 онд өндөр насны тэтгэвэр тогтоох насыг эрэгтэй 61 нас 3 сар, эмэгтэй 56 нас 3 сараар баримтлах, мөн өөрийн хүсэлтээр эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 настайдаа тогтоолгох даатгуулагчийн шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа 21 жил 3 сар байх зэрэг чиглэлийг тусгав.<br>2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/31 дүгээр тушаалаар "Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам"-ыг шинэчлэн баталж Хууль зүй, дотоод хэргийн яам Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.<br>3. Засгийн газрын 2022 оны "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 63 дугаар тогтоолыг шуурхай хэрэгжүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/17 дугаар тушаалаар "Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд баримтлах заавар"-ыг батлан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд нийгмийн даатгалын сангаас болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу олгож байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлэн, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400.0 мянган төгрөгт хүргэж 2022 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тэтгэвэр авагчдад тэтгэврийг нэмэгдсэн дүнгээр олгож байна.<br>4. Гадаад харилцааны сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны "Цаг уурын хүнд нөхцөлтэй гэж үзэх гадаад улсын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" А/32, А/246, А/81 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд даатгуулагчийн малчнаар ажилласан хугацааг тодорхойлж байгаа орон тооны бус зөвлөл нь даатгуулагчийн малчнаар ажилласан хугацааг тогтоохдоо зөвлөлийн дүрмийг баримталж, ямар нэгэн нотлох баримтгүй, үндэслэлгүй баримт бичгээр тогтоохгүй байх талаар тус тус зөвлөмж, чиглэл хүргүүлэв. | |
| 1.13. | Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоох, олгох ажлыг зохион байгуулан, хууль тогтоомжид орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэх чиглэлээр төв, орон нутгийн албадыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах; | Шаардлагагүй | Хүргүүлсэн чиглэл, зөвлөмжийн тоо | 2021 онд 19.7 мянган цэргийн тэтгэвэр, тэтгэмжид 162.1 тэрбум төгрөгийг зарцуулсан.<br>Төв, орон нутгийн албадад 2 удаагийн чиглэл, зөвлөмжийг хүргүүлсэн. | Хуулийг хэрэгжүүлэх талаар чиглэл, зөвлөмж өгч, мэргэжил, арга зүйгээр хангаж ажилласан байна. | Засгийн газрын 2022 оны "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/17 дугаар тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд баримтлах заавар"-ыг боловсруулан аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.<br>Энэхүү арга хэмжээнд нийт 19.7 мянган цэргийн алба хаасны тэтгэвэр авагч хамрагдав. | 100 |
| ***Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| *"Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион* | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| *байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах" **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 2.1. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх ажил зохион байгуулах; | - | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны "2022 оны төсвийн хуваарь батлах тухай" 23 дугаар тогтоолын дагуу орлогын гүйцэтгэлийг хангуулсан байна. | Нийгмийн даатгалын санд 2 397.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн. | Нийгмийн даатгалын санд 3,300.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлнэ. | Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар 2022 онд 3,300.8 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулахаас 3,445.9 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулж, төлөвлөгөөг 104.4 хувиар биелүүлэв. Үүнд: - Тэтгэврийн даатгалын санд 2,857.6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2,969.4 тэрбум төгрөг,<br>- Тэтгэмжийн даатгалын санд 212.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 232.2 тэрбум төгрөг,<br>- ҮОМШӨ-ний даатгалын санд 185.6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 198.4 тэрбум төгрөг,<br>- Ажилгүйдлийн даатгалын санд 45.1 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 45.9 тэрбум төгрөгийн орлого хуримтлууллаа.<br>Нийгмийн даатгалын санд батлагдсан төсвийн дагуу улсын төсвөөс 2022 онд нийт 876.6 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг авав.<br>- Тэтгэврийн даатгалын санд 859.7 тэрбум төгрөг,<br>- Тэтгэмжийн даатгалын санд 8.8 тэрбум төгрөг,<br>- ҮОМШӨ-ийн даатгалын санд 6.1 тэрбум төгрөг,<br>- Ажилгүйдлийн даатгалын санд 2.0 тэрбум төгрөг. | 100 |
| 2.2. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хүрээнд даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хуульд заасан хугацаанд олгох; | - | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны "2022 оны төсвийн хуваарь батлах тухай" 23 дугаар тогтоолын дагуу зарлагын гүйцэтгэлийг | Нийгмийн даатгалын сангаас 2 594.3 тэрбум төгрөг олгосон. | Нийгмийн даатгалын сангаас 3,511.7 тэрбум төгрөг олгоно. | Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар 3,511.7 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохоос 3,376.4 тэрбум төгрөг олгож, 96.1 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. Үүнд:<br>- Тэтгэврийн даатгалын сангаас 3,214.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 3,101.9 тэрбум төгрөг,<br>- Тэтгэмжийн даатгалын сангаас 187.3 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 163.9 тэрбум төгрөг,<br>- ҮОМШӨ-ний даатгалын сангаас 43.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 35.1 тэрбум төгрөг, | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хангуулсан байна. | | | - Ажилгүйдлийн даатгалын сангаас 67.2 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 75.5 тэрбум төгрөг тус тус зарцууллаа.<br>Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын сангийн төвлөрүүлэлтэд сар бүр хяналт тавьж, даатгуулагчдад олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн санхүүжилтийг хугацаанд нь шилжүүлэх арга хэмжээ авсан. | |
| 2.3. | Нийгмийн даатгалын байгууллагуудад сангийн болон үйл ажиллагааны урсгал санхүүжилтийг шилжүүлэх; | - | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны "2022 оны төсвийн хуваарь батлах тухай" 23 дугаар тогтоолын дагуу санхүүжилт олгосон байна. | Нийгмийн даатгалын байгууллагуудад 1058.1 тэрбум төгрөгийн сан болон урсгал зардлын санхүүжилт олгосон. | Нийгмийн даатгалын байгууллагуудад 1,131.8 тэрбум төгрөгийн сан болон үйл ажиллагааны урсгал зардлын санхүүжилт олгоно. | 1. Төв болон орон нутгийн Нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд даатгуулагчдад олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн санхүүжилтэд 1,107.7 тэрбум төгрөг шилжүүлэв. Үүнд:<br>- Тэтгэврийн даатгалын санд 1,025.4 тэрбум төгрөг;<br>- Тэтгэмжийн даатгалын санд 12.7 тэрбум төгрөг;<br>- ҮОМШӨ-ний даатгалын санд 4.1 тэрбум төгрөг;<br>- Ажилгүйдлийн даатгалын санд 34.5 тэрбум төгрөгийг тус тус шилжүүлэв.<br>2. Төв болон орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудад 32.0 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны урсгал санхүүжилтийг хугацаанд нь олгосон. Үүнээс: 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас төлөвлөгөөний дагуу нэхэмжлэн авсан. | 100 |
| 2.4. | Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн дагуу шимтгэлийн орлогыг цуглуулах, төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах; | - | Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар хооронд байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний заалт хэрэгжсэн байна. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 398.2 тэрбум төгрөг шилжүүлсэн. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар руу Даваа гариг бүр төвлөрсөн орлогыг шилжүүлнэ. | Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудаас төвлөрүүлсэн ажил олгогч, даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний дагуу Даваа гариг бүр эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах дансанд шилжүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 473.8 тэрбум төгрөг шилжүүллээ. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогод эзлэх авлагын хэмжээг 15.0 хувиас хэтрүүлэхгүй байх; | - | Ажил олгогчоос авах нийгмийн даатгалын шимтгэлийн орлогод эзлэх авлагын хувийг нэмэгдүүлээгүй байна. | Ажил олгогчоос авах нийгмийн даатгалын шимтгэлийн авлага орлогын 14.9 хувийг эзэлсэн. | Ажил олгогчоос авах нийгмийн даатгалын шимтгэлийн авлага орлогын 15.0 хувийг эзэлнэ. | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах, ажил олгогч, даатгуулагчийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах, нийгмийн баталгааг хангах зорилгоор аймаг /нийслэл/ дүүргийн Нийгмийн даатгалын /газар/ хэлтсүүдэд үүрэг, чиглэл өгч, үр дүнг тооцон ажиллалаа.<br>1. Дэлхий нийтийг хамарсан цар тахалтай холбоотой аж ахуйн нэгж байгууллагууд санхүүгийн хүндрэлд орсон, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор ирүүлсэн чиглэлийн дагуу шимтгэлийн хуримтлагдсан авлага үүсгэсэн ажил олгогчийн арилжааны банк дахь харилцах дансны зарлагын гүйлгээг хаах, шүүхэд шилжүүлэх арга хэмжээг хойшлуулсан байсан бөгөөд 2022 оны 10 дугаар сараас эхлэн ЭМНДЕГ-ын даргын 2017 оны А/108 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг үүссэн хугацаагаар нь ангилах, хянан шийдвэрлэх журам"-ыг хэрэгжүүлж, шимтгэлийн авлагыг бууруулах шат дараалсан арга хэмжээг авч ажиллахыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд даалган, хэрэгжилтийг хангаж ажилласнаар дараах үр дүнд хүрсэн байна.<br>- Нийгмийн даатгалын шимтгэлийн 210.9 тэрбум төгрөгийн авлага барагдуулахаар цахимаар болон биечлэн байдлаар 14,028 ажил олгогчтой уулзалт зохион байгуулж хамтран ажилласны үр дүнд 13,428 ажил олгогчийн 19.5 тэрбум төгрөгийн хуримтлагдсан авлагыг барагдуулсан;<br>- Нийгмийн даатгалын шимтгэлийн 36.0 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн 990 ажил олгогчид албан шаардлага хүргүүлж, 9.8 тэрбум төгрөгийн хуримтлагдсан авлагыг барагдуулсан;<br>- Нийгмийн даатгалын шимтгэлийн 47.0 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн 1302 ажил олгогчийн банк дах харилцах дансны | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зарлагын гүйлгээг хааж, 1.2 тэрбум төгрөгийн хуримтлагдсан авлагыг барагдуулсан;<br>- Нийгмийн даатгалын шимтгэлийн 161.5 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн 1,370 ажил олгогчтой шимтгэлийн авлага барагдуулах гэрээ байгуулж, 30.5 тэрбум төгрөгийн хуримтлагдсан авлагыг барагдуулсан;<br>- Нийгмийн даатгалын шимтгэлийн 3.0 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн 118 ажил олгогчийг шүүхэд шилжүүлж, 1.1 тэрбум төгрөгийн хуримтлагдсан авлагыг барагдуулсан;<br>- Нийгмийн даатгалын шимтгэлийн 23.5 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн 569 ажил олгогчийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлж, 1.5 тэрбум төгрөгийн хуримтлагдсан авлагыг барагдуулсан байна.<br>*/Авлагын мөнгөн дүн, ажил олгогчийн тоо нь давхардсан дүнгээр илэрхийлэгдсэн болно./*<br>2. Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын газар, хэлтсүүдийн ажил олгогч, даатгуулагчаас авах шимтгэлийн авлагыг бууруулахад дэмжлэг үзүүлж, дараах ажлуудыг зохион байгуулан, хэрэгжилтийг тооцон ажиллалаа. Үүнд:<br>- Засгийн газраас авч хэрэгжүүлсэн бараа, бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах бодлогын хүрээнд нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүсгэсэн аж ахуй нэгж, байгууллагуудтай "Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг тогтоосон хугацаанд барагдуулахаар тохиролцож байгуулсан гэрээ" байгуулан, төлөлтийн хуваарь баталж, гэрээний үүргийн хэрэгжилтийг үндэслэн даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж олгох ажлыг зохион байгуулсан.<br>- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-нд заасны дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүсгэсэн эрүүл мэндийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагын жагсаалтыг сар бүр хүргүүлснээр тус газартай гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагын шимтгэлийн авлага оны эхнээс 18.3 хувиар буурсан.<br>- Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 01/2185 дугаар албан бичгээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 31.6 тэрбум төгрөгийн шимтгэлийн өртэй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 48 хуулийн этгээдийн жагсаалтыг хүргүүлж, төлбөрийг бүрэн барагдуулах, цаашид шимтгэлийн өр нэмж үүсгэхгүй байх талаар холбогдох арга хэмжээ авах тухай хүсэлт хүргүүлсэн бөгөөд тус газраас дээрх 48 хуулийн этгээдэд 2022 онд багтаан шимтгэлийн авлагыг бүрэн барагдуулах чиглэл, даалгавар өгсөн байна.<br>- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны А/91 дүгээр тушаалаар баталсан "Монголбанкны зээлийн мэдээллийн санд ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх мэдээллийг хүргүүлэхэд баримтлах журам"-ын хүрээнд 17,658 ажил олгогчийн шимтгэлийн авлагын талаарх мэдээллийг хүргүүлэв.<br>Дээрх авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнд оны эхний нийгмийн даатгалын шимтгэлийн 297.1 тэрбум төгрөгийн авлагаас 63.7 тэрбум төгрөгийн шимтгэлийн авлага барагдуулсан боловч урсгал авлага нэмэгдэж, 2022 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар авлага 383.6 тэрбум төгрөг болсон.<br>Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын орлогод эзлэх хувь нь 14.95 хувь байна. | |
| 2.6. | Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээг зохион байгуулах; | - | Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээг хугацаанд нь зохион | Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг бүрэн зохион байгуулсан. | Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | Нийгмийн даатгалын сангийн санхүүжилтээр зохион байгуулагдах нийт 3,924.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 худалдан авалт, улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар 300 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 худалдан авалтын төлөвлөгөөг батлан, ажлыг "Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем"-ээр зохион байгуулж, шалгаруулсан. Үүнд: | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулсан байна. | | | 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан 2 худалдан авалт:<br>- XI.2.3.1 Нийгмийн даатгалын ерөнхий газрын тоног төхөөрөмж худалдан авах 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын ажлыг 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс 03 дугаар сарын 02-ны өдрийн хооронд зохион байгуулж, хөрөнгүүдийг хүлээн авч, гэрээний дагуу 44.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгон, барааг бүртгэлд тусгасан.<br>- XI.2.2.1 Нийгмийн даатгалын ерөнхий газрын байрны их засварын 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн ажлыг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс 03 дугаар сарын 28-ны өдрийн хооронд амжилттай зохион байгуулсан боловч "Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хуулиар төсөв хасагдсан.<br>2. Нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр батлагдсан 9 худалдан авалт:<br>- Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах сервер лицензийн худалдан авалтыг 2022 оны 03 дугаар сарын 17-ноос 04 дүгээр сарын 18-ны хооронд зохион байгуулж, шалгарсан Ай Ти Зон ХХК-тай "Худалдан авалтын гэрээ"-г байгуулан гэрээний дүн болох 1,014.2 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгасан.<br>- Ажлын компьютер, түүний дагалдах тоног төхөөрөмжийн худалдан авалтыг 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 05 дугаар сарын 09-ний хооронд зохион байгуулж, шалгарсан Ай Ти Зон ХХК-тай "Худалдан авалтын гэрээ"-г байгуулан гэрээний дүн болох 1,185.1 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгасан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Нийгмийн даатгалын ерөнхий газрын харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэгчийг 2022 оны 06 дугаар сарын 15-наас 22-ны өдрийн хооронд сонгон шалгаруулж, 39.5 сая төгрөгийн хамгийн бага үнийн санал ирүүлсэн Шүтээн-Уул ХХК-тай ажлын гэрээ байгуулсан.<br>- Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай тэтгэврийн хувийн хэрэг хэвлэн нийлүүлэгчийг 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс 07 дугаар сарын 01-ний өдрийн хооронд сонгон шалгаруулж 20.5 сая төгрөгийн хамгийн бага үнийн санал ирүүлсэн Соёмбопринтинг ХХК-тай гэрээ байгуулж тэтгэврийн хувийн хэргийг хэвлүүлсэн.<br>- Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай зөөврийн компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмж худалдан авалтыг /Зөөврийн компьютер-1, Хэвлэх, хувилах төхөөрөмж-2, Програм хангамж-3/ 3 багц болгон 2022 оны 08 дугаар сарын 23-ны өдрөөс 09 дүгээр сарын 23-ны өдрийн хооронд зохион байгуулж, шалгарсан Саммит компьютер технологи ХХК, Бодь-Электроникс ХХК, Ай Ти Зон ХХК-тай "Худалдан авалтын гэрээ"-г байгуулан гэрээний дүн болох 933.9 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгасан.<br>- Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай ажлын компьютер, принтер худалдан авалтыг 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 21-ны хооронд зохион байгуулж, шалгарсан Ай Ти Зон ХХК-тай "Худалдан авалтын гэрээ"-г байгуулан гэрээний дүн болох 157.8 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгасан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай 47.1 сая төгрөгийн анхан шатны маягтыг шууд гэрээ байгуулан худалдан авлаа.<br>Дээрх худалдан авалтуудын сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулснаар нийт 3,974.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. | |
| 2.7 | Нийгмийн даатгалын сангийн болон урсгал зардлын гүйцэтгэлийн дүнг мэдээлэх ажлыг зохион байгуулах; | - | Төсвийн гүйцэтгэлийн 12 удаагийн мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | Төсвийн гүйцэтгэлийн 12 удаагийн мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлсэн. | Төсвийн гүйцэтгэлийн 12 удаагийн мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлнэ. | Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр нэгтгэн баталгаажуулж, Сангийн яамны Төрийн сангийн газар, Зарлагын хэлтэс, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам, Үндэсний Статистикийн Хороо, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Монголбанк, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд тус тус хуулийн хугацаанд цахимаар болон албан бичгээр хүргүүлсэн.<br>Нийгмийн даатгалын сангийн зарлагыг эдийн засгийн ангиллаар Сангийн Яамны "Fiscal" програмд сар бүр оруулж мэдээлсэн.<br>Нийгмийн даатгалын төсвийн гүйцэтгэлийн зарлагын сарын мэдээг сар бүр хуульд заасан хугацаанд Шилэн дансанд байршуулсан. | 100 |
| 2.8. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах ажлыг зохион байгуулах; | - | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг 2 удаа нэгтгэн хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг 2 удаа нэгтгэн хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлсэн. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг 2 удаа нэгтгэн хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлнэ. | Төв орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудад 2021 оны жилийн эцэс, 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах хуваарийг хүргүүлэн хуваарийн дагуу тайлангуудыг шалган нэгтгэж, 2022 оны 01/634, 01/976, 01/1461 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газар, Сангийн яам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд хуулийн хугацаанд нь хүргүүлсэн.<br>Нийгмийн даатгалын сангийн 2021 оны жилийн эцэс, 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн танилцуулгыг бэлтгэн 2022 оны 01/976, 01/1461 дугаар албан бичгээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албанд хуулийн хугацаанд хүргүүлж, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн, нийтэд мэдээллээ.<br>Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, Аудитын зөвлөмжийн биелэлтийг www.shilendans.gov.mn сайтад хугацаанд нь байршуулсан. | |
| 2.9. | Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад байршуулж, нэмэгдүүлэх ажил зохион байгуулах; | - | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолыг хэрэгжүүлсэн байна. | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг байршуулах санал тооцоолол, хамтарсан шийдвэрийн саналын төслийг Сангийн яам, Монгол банкинд хүргүүлсэн боловч 2020 онд Сангийн яам, Монгол банк, 2021 онд Сангийн яамнаас зөвшөөрөөгүй тул тухайн онуудад хөрөнгийн дээд хэмжээ батлагдаагүй болно. | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолыг хэрэгжүүлэн нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкуудад хугацаатай байршуулна. | Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг арилжааны банкинд хадгаламж хэлбэрээр байршуулах журмын "3.4.1 Хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн тухайн жилийн дээд хэмжээг тооцоолон, эхний улиралд багтаан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлнэ." гэж заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албанд шийдвэрийн төсөл, тооцооллыг 2022 оны 3 дугаар сарын 2-ны өдөр болон 11 дүгээр сарын 08-ны өдөр хүргүүлсэн.<br>Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь энэхүү саналыг Сангийн яам болон Монголбанк руу хүргүүлсэн боловч Сангийн яамнаас татгалзсан хариу ирүүлсэн тул энэ онд арилжааны банкинд хугацаатай хадгаламж хэлбэрээр байрлуулах хөрөнгийн хэмжээ батлагдаагүй.<br>Иймд арилжааны банкинд сангийн мөнгөн хөрөнгийг хугацаатай хадгаламж хэлбэрээр байршуулаагүй болно. | 70 |
| 2.10. | Нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, удирдлагаар хангах; | - | Өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод | "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн шийдвэр гарсан. | Өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах ажлыг 2 удаа зохион байгуулна. | Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн хөрөнгө, аж ахуйн материал, маягтын ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллалаа. Үүнд:<br>- Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолын дагуу төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудад төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалахтай холбоотой бүртгэл, тооллого явуулах, төрийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тайлагнах ажлыг 2 удаа зохион байгуулж, “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн шийдвэр гарсан байна. | | | өмчийн бүрэн бүтэн байдал, төрийн өмчийн эзэмшил, ашиглалтад хяналт тавих замаар төрийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн улсын үзлэг, тооллогыг 6 дугаар сард заасан хугацаанд нь зохион байгууллаа.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны “Эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай” А/87 дугаар тушаалаар төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын эд хөрөнгийн улсын үзлэг тооллого явуулах үүрэг өгөгдөж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гаргасан төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулах аргачлал, гарын авлагаар ханган, удирдлагаар ханган ажиллалаа.<br>- Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын 2022 оны хөрөнгийн дэлгэрэнгүй судалгааг гарган, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хугацаанд нь хүргүүлсэн.<br>Төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагуудын 2022 оны “Эд хөрөнгийн тооллогын бүртгэл”-ийг хүлээн авч нэгтгэн, нийгмийн даатгалын байгууллагуудад мэргэжил, арга зүйн зааварчилгаа өгч ажилласан.<br>- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн суудлын автомашин ашиглалтын талаарх дэлгэрэнгүй судалгааг Төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагуудаас гаргуулан авч нэгтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн.<br>- Нийгмийн даатгалын ерөнхий газрын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар дараах асуудлуудыг авч хэлэлцэв. Үүнд:<br>1. Нийгмийн даатгалын ерөнхий газар болон харьяа хэлтсүүдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 1.2 тэрбум төгрөгийн 2,857 ширхэг хөрөнгийг акталж данснаас хасах тухай; | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2. Нийгмийн даатгалын ерөнхий газар болон хэлтсүүдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэгдэл өртөггүй 959.5 сая төгрөгийн 690 ширхэг тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, 354.5 сая төгрөгийн 5 ширхэг тээврийн хэрэгслийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоох;<br>3. Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй болсон 207.1 мянган төгрөгийн хүйтэн грашийг акталж данснаас хасах;<br>4. Нийгмийн даатгалын ерөнхий газар болон аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, газар хооронд 27.2 сая төгрөгийн 6 ширхэг хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай;<br>5. Цахимжилттай холбогдон хүчингүй болсон, цаашид ашиглахгүй анхан шатны маягтыг актлах зэрэг болно.<br>Дээрх асуудлуудыг хэлэлцэн холбогдох зөвшөөрлийг авахаар баримт, материалуудыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн шийдвэрлүүлсэн.<br>Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны А1/981 дугээр албан бичгээр ирүүлсэн мэдэгдлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3 ширхэг авто машиныг Засгийн газрын авто баазад хүлээлгэж өгсөн.<br>Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, өдөр тутмын албан хэрэгцээнд ашиглах зайлшгүй шаардлагатай 38 ширхэг авто машиныг үргэлжлүүлэн ашиглах тухай санал хүсэлтээ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн. | |
| 2.11. | Үндсэн хөрөнгө шилжүүлэх, устгах | - | Нийгмийн даатгалын | Нийгмийн даатгалын | Нийгмийн даатгалын | Нийгмийн даатгалын төв болон орон нутгийн байгууллагуудад тоног төхөөрөмж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | саналыг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах, нийгмийн даатгалын байгууллагуудад хөрөнгө хүлээн авах, хөдөлгөөн хийх, хуваарилах, хэрэгжилтэд хяналт тавих; | | байгууллагуудын үндсэн хөрөнгийг хуваарилах, бүртгэх, бусдад хуваарилах, бүртгэх, бусдад худалдах, шилжүүлэх, данс бүртгэлээс хасах тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангасан байна. | байгууллагуудын үндсэн хөрөнгөтэй холбоотой шийдвэр хэрэгжсэн. | байгууллагуудын үндсэн хөрөнгөтэй холбоотой шийдвэрийг хэрэгжүүлнэ. | нийлүүлэх ХНХЯ/202210026 дугаартай гэрээний дагуу улсын төсвийн санхүүжилтээр худалдан авсан 44.5 сая төгрөгийн 23 ширхэг иж бүрэн компьютер түүний дагалдах хэрэгслийг хүлээн авч бүртгэсэн.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны "Тоног төхөөрөмж хуваарилах тухай" А/69 дүгээр тушаалаар компьютер түүний дагалдах хэрэгсэл зайлшгүй шаардлагатай байгууллагуудад хуваарилан хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллав.<br>- Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл"-ийн хүрээнд зарласан тендер шалгаруулалтын үр дүнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гөү Смарт ТМ ХХК-ийн хооронд 2022 оны 08 дугаар сарын 29-нд байгуулсан Ү3-С1-GO-05/ХЭДТ/202203001 дугаартай "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх цахим сургалтын программ хангамж нийлүүлэх, суурилуулах" гэрээний дагуу нийлүүлсэн 59.1 сая төгрөгийн өртөг бүхий онлайн сургалтын программ хангамжийг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны "Программ хангамж хүлээн авч, бүртгэх тухай" А/164 дүгээр тушаалаар томилогдсон хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүн тендерийн баримт бичигт заасан техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авч, нягтлан бодох бүртгэлд тусган үндсэн хөрөнгөд бүртгэж, сургалтын үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байна.<br>- Нээлттэй тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээний дагуу дараах хөрөнгийг хүлээн авч бүртгэн, төв орон нутгийн байгууллагуудад хуваарилан хүлээлгэж өгсөн. Үүнд:<br>1. "Ай Ти Зоне" ХХК-тай байгуулсан "Нийгмийн даатгалын ерөнхий газрын тоног төхөөрөмж нийлүүлэх" ХНХЯ/202210026 гэрээний дагуу | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | худалдан авсан 44.4 сая төгрөгийн өртөг бүхий 23 ширхэг ажлын компьютер, дагалдах тоног төхөөрөмж,<br>2. "Ай Ти Зоне" ХХК-тай байгуулсан "Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай ажлын компьютер, дагалдах тоног төхөөрөмж худалдан авах" НДЕГ/202201002 дугаар гэрээний дагуу худалдан авсан нийт 1 185.0 сая төгрөгийн өртөг бүхий 530 ширхэг ажлын компьютер, дагалдах тоног төхөөрөмж,<br>3. "Ай Ти Зоне" ХХК-тай байгуулсан "Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай сервер, лиценз нийлүүлэх" НДЕГ/202201001 дугаар гэрээний дагуу нийлүүлсэн 1014.2 сая төгрөгийн өртөг бүхий сүлжээний төхөөрөмж,<br>4. "Ай Ти Зоне" ХХК-тай байгуулсан "Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай програм хангамж /Багц-3/ нийлүүлэх" НДЕГ/202206003 дугаар гэрээний дагуу нийлүүлсэн 74.3 сая төгрөгийн өртөг бүхий "Статистик хүснэгтэн тайлан мэдээний програм хангамж,<br>5. "Саммит компьютер технологи" ХХК-тай байгуулсан "Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай Зөөврийн компьютер /багц-1/ нийлүүлэх" НДЕГ/202206003 дугаар гэрээний дагуу нийлүүлсэн 479.5 сая төгрөгийн өртөг бүхий зөөврийн болон таблет компьютер,<br>6. Бодь электроникс ХХК-тай байгуулсан "Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай хэвлэх, хувилах төхөөрөмж /багц-2/ нийлүүлэх" НДЕГ/202206003 гэрээний дагуу нийлүүлсэн 380.1 сая төгрөгийн өртөг бүхий зөөврийн болон таблет компьютер зэрэг болно. | |
| 2.12. | Нийгмийн даатгалын байгууллагуудтай Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн орлогыг санд | - | Нийгмийн даатгалын байгууллагуудын түрээсийн | Түрээсийн 80.0 сая төгрөгийн орлого орсон. | Түрээсийн гэрээг хугацаанд нь байгуулан түрээсийн орлогыг нийгмийн | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны "Төрийн өөрийн өмчийн түрээсийн талаарх зарим арга хэмжээний тухай" 50 дугаар тогтоолоор баталсан Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төвлөрүүлэхэд хяналт тавих; | | гэрээний үүргийн хэрэгжилтийг бүрэн хангасан байна. | | даатгалын санд бүрэн төвлөрүүлнэ. | гэрээний үлгэрчилсэн загварын дагуу төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагуудын байр, талбайг ашиглаж байгаа улсын төсөвт үйлдвэрийн 4 газар, 2 аж ахуйн нэгж, байгууллага, арилжааны 7 банк нийт 13 хуулийн этгээдтэй түрээсийн гэрээг сунгаж, хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулсан нийт 12 иргэн, хуулийн этгээдээс 93.0 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлэв.<br>Түрээсийн орлогын тооцоонд сар бүр хяналт тавьж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 40 хувь болох 37.0 сая төгрөгийг төвлөрүүлж ажилласан. | |
| 2.13. | Нийгмийн даатгалын байгууллагуудын "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулах, дүгнүүлэхэд хяналт тавьж ажиллах; | - | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын журмын дагуу "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулах, дүгнүүлэхэд шаардагдах баримт материалыг бүрдүүлэн хугацаанд нь хүргүүлсэн байна. | **Нийгмийн даатгалын** нийт 32 **байгууллага "Төрийн** өмчийг **эзэмшүүлэх** гэрээ"-г **шинэчлэн** байгуулж, **дүгнүүлсэн.** | "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулж, дүгнүүлнэ. | Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудад "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулах, биелэлтийг дүгнүүлэх талаар заавар зөвлөгөө өгч, удирдлагаар хангаж ажилласан.<br>Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудаас Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 715 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу 2021 оны "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулах, дүгнүүлэхэд шаардагдах баримт материалыг бүрдүүлж Төрийн өмчийн бодлого зохицуулах газарт хүргүүлснээр тус газар нь 2021 оны "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г шалгуур үзүүлэлт тус бүрээр дүгнэж, баталгаажуулах хуудсаар гэрээний биелэлтийн үнэлгээ болон 2022 оны "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г шинээр байгуулж баталгаажуулсан.<br>Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагууд "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-д заасан, үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг хангалттай биелүүлж салбарын хэмжээнд 94-95 хувь буюу "Сайн" гэсэн үнэлгээтэй дүгнэгдсэн байна. | 90 |
| 2.14. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын эзэмшилд байгаа үл | - | Монгол банкны эрх хүлээн | Шинээр хэрэгжинэ. | Нээлттэй дуудлагын | Капитал банкны Эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн нийгмийн даатгалын сангийн өр, төлбөрөөс тооцон авсан хөрөнгийг худалдан | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөдлөх хөрөнгийн нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулах; | | авагчаас Нийгмийн даатгалын сангийн өр авлагад Капитал банкны шилжүүлсэн хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 18 дугаар "Журам батлах тухай" тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 268 дугаар "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоол, 269 дүгээр "Мэдээ, | | худалдааг зохион байгуулна. | борлуулах нээлттэй дуудлага худалдааг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны "Журам батлах тухай" 18 дугаар тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 268 дугаар "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг тус тус үндэслэн зохион байгууллаа.<br>1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/159, А/160 дугаар тушаалаар орон нутагт байрлалтай нийт 5.2 тэрбум төгрөгийн 12 ширхэг хөрөнгийн дуудлага худалдаа зохион байгуулах тухай Ажлын хэсэг болон хөрөнгийн жагсаалт, нээлттэй дуудлага худалдааны зар батлан, хэлтсийн ажилтнуудын оролцоо болон цахим байдлаар орон нутагт зар түгээн, нээлттэй дуудлага худалдааг холбогдох хууль, журмын хүрээнд хөрөнгийн дуудлага худалдааг зохион байгуулж, дараах 4 хөрөнгийг худалдан борлуулсан. Үүнд:<br>- Баян-Өлгий объект /Баян-Өлгий аймгийн Өлгий сум, 2 дугаар баг, "Цагаан эрэг" хаягт байршилтай 2 давхар 1,169.6 м.кв үйлчилгээ, конторын зориулалттай барилга, 2,399 м.кв эзэмших эрхтэй газрын хамт/ 1.3 тэрбум төгрөгөөр;<br>- Баянхонгор объект /Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 3 дугаар баг, Дуурсах Капитал банк ХХК-ийн байр, 22 тоот 2 давхар 381 м.кв үйлчилгээний талбайтай объект, 2,290 м.кв эзэмших эрхтэй газрын хамт/ 542.8 сая төгрөгөөр;<br>- Говьсүмбэр объект /Говьсүмбэр аймаг Сүмбэр сум 1 дүгээр баг 51 дүгээр байрны 01 тоот 98 м.кв талбайтай 3 өрөө орон сууц , 51 дүгээр байрны 02 тоот 43 м.кв талбайтай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тайлангийн маягт батлах тухай" тогтоол, Иргэний хуулийн 197 дугаар зүйл болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, худалдах, түрээслүүлэх | | | 3 өрөө орон сууц, 461 м.кв эзэмших эрхтэй газрын хамт/ 137.1 сая төгрөгөөр;<br>- Булган объект /Булган аймаг Д.Лхагвадоржийн өргөн чөлөө ХХААЖДҮГ-ын хойд талд байрлалтай дуусаагүй барилга-карказ боссон /3036/ м.кв үйлчилгээний талбайтай объект 667 м.кв эзэмших эрхтэй газрын хамт/ 1.2 тэрбум төгрөгөөр;<br>2. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай хамтран нийт 11.9 тэрбум төгрөгийн 10 ширхэг хөрөнгийн дуудлага худалдаа зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хөрөнгийн жагсаалтыг Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/24 А/19, А25 А/20, А/76 А/67 дугаар хамтарсан тушаалаар баталж, нээлттэй дуудлага худалдааны зарыг өдөр тутмын сонин, цахим мэдээллийн хэрэгслүүдэд байршуулан, дуудлага худалдааг 3 удаа зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй болно.<br>3. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/89 дугаар тушаалаар 2021, 2022 онд хүлээн авсан 4.9 тэрбум төгрөгийн 32 ширхэг хөрөнгийн нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулж, дараах 2 хөрөнгийг худалдан борлуулсан.<br>- Дорнод объект /Үйлчилгээ, оффис зориулалттай барилга: 269.92 м.кв, 38,9 м.кв, худалдаа үйлчилгээний зориулалттай эзэмших эрхтэй 2565 м.кв газрын хамт/ 769.0 сая төгрөгөөр;<br>- Өмнөговь объект /Конторын болон гражийн зориулалттай 240 м.кв барилга, 1164 м.кв эзэмших эрхтэй газрын хамт/ 385.5 сая төгрөгөөр;<br>4. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/111 тушаал, "Нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах тухай" А/112 дугаар тушаалын дагуу хөрөнгийн дуудлага | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | худалдааг зохион байгуулж, дараах 5 хөрөнгийг худалдан борлуулсан.<br>- Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, 14 дүгээр хороолол /13335/, Намъянжугийн гудамж 11 дүгээр байр 1005 тоот 74.19 м.кв талбай бүхий орон сууцыг 199.0 сая төгрөгөөр;<br>- Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, 14 дүгээр хороолол /13335/, Намъянжугийн гудамж 11 дүгээр байр 1006 тоот 76.01 м.кв талбай бүхий орон сууцыг 209.0 сая төгрөгөөр;<br>- Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, 14 дүгээр хороолол /13335/, Намъянжугийн гудамж 11 дүгээр байр 1104 тоот 72.37 м.кв талбай бүхий орон сууцыг 194.4 сая төгрөгөөр;<br>- Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, 14 дүгээр хороолол /13335/, Намъянжугийн гудамж 11 дүгээр байр 1105 тоот 68.41 м.кв талбай бүхий орон сууцыг 183.6 сая төгрөгөөр;<br>- Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, 14 дүгээр хороолол /13335/, Намъянжугийн гудамж 11 дүгээр байр 1106 тоот 92.37 кв талбай бүхий орон сууцыг 247.7 сая төгрөгөөр;<br>5. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/126 дугаар тушаал, "Нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах тухай" А/127 дугаар тушаалын дагуу хөрөнгийн дуудлага худалдааг зохион байгуулж, Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, 14 дүгээр хороолол /13335/, Намъянжугийн гудамж 11 дүгээр байр, 1305 тоот 68.41м.кв орон сууцыг 210.6 сая төгрөгөөр;<br>6. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/143 дугаар тушаал, "Нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах тухай" А/144 дүгээр тушаалын дагуу хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулж, Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо, 361-ийн гарам хаягт байрлах 480 м.кв талбай бүхий агуулахын зориулалттай үл хөдлөх хөрөнгө 19,484 м.кв эзэмших эрхтэй газрын хамт 754.7 сая төгрөгөөр тус тус худалдан борлуулсан.<br>2022 онд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг нийт 8 удаа зохион байгуулж, 5.9 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 19 хөрөнгийг 6.0 тэрбум төгрөгөөр худалдан орлогыг нийгмийн даатгалын санд төвлөрүүлэн ажиллалаа. | |
| 2.15. | "Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд Нийгмийн даатгалын салбарын нягтлан бодох бүртгэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх; | - | Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлсэн байна. | Нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн "GreenFinance" програмын туршилт, нэвтрүүлэлтийг салбарын хэмжээнд эхлүүлсэн. Сангийн нягтлан бодох бүртгэлийн "Core" системийн хөгжүүлэлтийг төсөл хэрэгжүүлэгч "Ай Ти Зон" ХХК-тай хамтран гүйцэтгэсэн. | Нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн "GreenFinance" програмын нэвтрүүлэлтийг салбарын хэмжээнд хэрэгжүүлнэ. Сангийн нягтлан бодох бүртгэлийн "Core" системийн туршин нэвтрүүлэлтийг төсөл хэрэгжүүлэгч "Ай Ти Зон" ХХК-тай хамтран хэрэгжүүлнэ. | Нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийг "Green finance" системээр хөтөлж, 2021 оны санхүүгийн тайлан, 2022 оны улирлын тайлан, сарын мэдээг 35 байгууллагаар гаргах ажлыг зохион байгуулсан.<br>Нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийг "Green finance" системээр хөтлөх, мэдээ, тайлан гаргах, хүсэлт хүлээлгэн өгөх чиглэлээр "Ай Ти Зон" ХХК-ийн төслийн багтай тухай бүр явцын уулзалтыг хийж, хамтран ажилласан.<br>Ажлын үр дүнд төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагууд төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайланг Засгийн газрын нэгтгэл Э-тайланд системээс автоматаар илгээдэг болсон.<br>Нийгмийн даатгалын тусгай сангийн санхүүгийн системийн тухай "Ай Ти Зон" ХХК болон арилжааны банкуудтай цахимаар болон биечилсэн уулзалтыг тухай бүр зохион байгуулж, хамтран ажиллав.<br>Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст "Core" системийн туршин нэвтрүүлэлтийг эхлүүлэн, явцын үр дүнг тухай бүр тооцон ажиллаж байна.<br>Тусгай сангийн санхүүгийн системтэй холбогдуулан нягтлан бодох бүртгэлийн журнал, дэлгэрэнгүй болон хураангуй бүртгэл, ерөнхий дэвтэр, аккруэл, мөнгөн шалгах баланс, 5 төрлийн сарын мэдээ зэрэг бүртгэл, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээ, тайлантай холбоотой загвар, тохиргоонуудыг Ай Ти Зон ХХК-д хүргүүлэн заавар зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна.<br>Мөн "Ай Ти Зон" ХХК-д "Байгууллагын санхүү дэд систем", "Бараа материалын дэд систем", "Тусгай сангийн санхүү дэд систем", "Тайлан дэд систем"-ийг хүлээн авах хуудас бэлтгэн хүргүүлж, холбогдох ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. | |
| 2.16. | Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн аймаг, нийслэл, дүүргийн нарийвчилсан хуваарь, Газрын даргын баталсан сар, улирлын хуваарийг төв, орон нутгийн нийгмийн даатгалын албадад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах; | Нийгмийн даатгалын сангийн орлого 2,840.4 тэрбум төгрөг (Улсын төсвийн татаас орсон дүн), зарлага 2,751.0 тэрбум төгрөг, үйл ажилла гааны урсгал зардал 32.4 тэрбум төгрөг | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр батлуулан, хуваарийн дагуу төсвийг олгосон байна. | Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн аймаг, нийслэл, дүүргийн нарийвчилсан хуваарь, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан сар, улирлын хуваарийг төв, орон нутгийн албадад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. | Төсвийн аймаг, нийслэл, дүүргийн нарийвчилсан хуваарь, Газрын даргын баталсан сар, улирлын хуваарийг нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэн уг хуваарийн дагуу тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, нийгмийн даатгалын байгууллагын урсгал зардлын төсвийг олгосон байна. | Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль батлагдсанаас хойш нэмэлт 2 удаагийн өөрчлөлтийн хэрэгжилтийг зохион байгуулав. Үүнд:<br>1. "Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх 637.0 тэрбум төгрөгийн төсвийг тусган баталсан бөгөөд Засгийн газрын 2022 оны "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 63 дугаар тогтоолоор бүх төрлийн тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлэн, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.<br>Дээрх шийдвэрийг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/42 дугаар тушаалаар аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын болон сар, улирлын хуваарийг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулав.<br>2. Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгохоор шийдвэрлэсэнтэй холбогдуулан буцаан олгох 150.8 тэрбум төгрөг батлагдсан.<br>3. Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор нийгмийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг 164.0 сая төгрөгөөр бууруулан баталсан.<br>Дээрх шийдвэрүүдийг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 03 дугаар тогтоолоор аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын хуваарийг батлан нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлсэн. | |
| 2.17. | Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсөөллийн саналыг төв, орон нутгийн нийгмийн даатгалын албадаас хүлээн авч хянан боловсруулж, саналыг Газрын даргын зөвлөл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хуулиар тогтоосон хугацаанд хүргүүлэх; | Шаардлагагүй | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна. | 2022 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсөөллийн Газрын даргын зөвлөл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. | Нийгмийн даатгалын байгууллагуудаас 2023-2025 оны төсвийн төсөл, төсөөллийг хүлээн авсан байна.<br>Жилийн эцэст, төсвийн төслийг хянан Газрын даргын зөвлөлийн болон НДҮЗ-ийн гишүүдийн саналыг тусган Нийгмийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна. | Нийгмийн даатгалын сангийн 2023-2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийн санал, 2023 оны төсвийн жилийн хязгаарын санал, төсвийн төсөл, төсөөллийн саналыг боловсруулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2022 оны 01/1383 дугаар албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.<br>Саналд тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчлэх, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, төсвийн байгууллагын цалингийн хэмжээг 10-20 хувиар нэмэгдүүлэх, 2023 оноос хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 550.0 мянган төгрөг болгох зэрэг өөрчлөлтүүдийг тооцож, холбогдох тооцооллыг хийсэн болно. | 100 |
| 2.18. | Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын | Шаардлагагүй | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр батлуулан, хуваарийг Нийгмийн | 2022 оны төсвийн аймаг, нийслэлийн нарийвчилсан хуваарийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн | 2023 оны төсвийн аймаг, нийслэлийн нарийвчилсан хуваарийг Нийгмийн даатгалын үндэсний | Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулиар батлансы дагуу нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2023 оны төсвийн аймаг, | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2023 оны төсвийн аймаг, нийслэлийн нарийвчилсан хуваарийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах, сар, улирлын хуваарийг батлах, төв, орон нутгийн албадад хүргүүлэх; | | даатгалын хэлтсүүдэд хүргүүлсэн байна. | батлуулж, сар, улирлын хуваарийг батлан, төв, орон нутгийн албадад хүргүүлсэн. | зөвлөлөөр, сар, улирлын хуваарийг баталж төв, орон нутгийн албадад хүргүүлсэн байна. | нийслэлийн нарийвчилсан хуваарийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар боловсруулж байна. | |
| 2.19. | НД-7, НД-8 тайланг ажил олгогчоос тоон гарын үсгээр хүлээн авах ажлыг эрчимжүүлэх; | - | Тоон гарын үсгээр тайлан илгээх ажил олгогчийн тоо нэмэгдсэн байх | 2021 онд 4.2 мянган ажил олгогчийн тоон гарын үсгээр илгээсэн тайланг хүлээн авсан. | Ажил олгогчоос тоон гарын үсгээр илгээсэн тайланг хүлээн авах ажлыг өргөжүүлсэн байна. | Ажил олгогчоос тоон гарын үсгээр баталгаажуулан илгээсэн тайланг хүлээн авах системийн хэвийн ажиллагааг ханган ажилласан бөгөөд энэ онд нийт идэвхтэй ажил олгогчийн 23.3 хувь буюу 12.5 мянган ажил олгогчоос тоон гарын үсгээр баталгаажуулан илгээсэн шимтгэлийн тайланг хүлээн авсан байна.<br>Цаашид ажил олгогч тоон гарын үсгээр баталгаажуулан эмнэлгийн хуудасны нэхэмжлэлээ "Шимтгэлийн цахим систем"-ээр илгээх боломжийг бүрдүүлэх ажлыг нэвтрүүлэхээр туршилтын ажил хийгдэж байна. | 70 |
| 2.20. | Нийгмийн даатгалын төв орон нутгийн албадыг нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны зардлын төсөв, төлөвлөгөө боловсруулах нэгдсэн удирдлага, мэргэжил, | Шаард лагагүй | Боловсруулсан төсөв, төсвийн төлөвлөгөө | Аймаг, дүүргээс ирүүлсэн нийгмийн даатгалын сангийн 2023-2025 оны төсвийн төслийг хянан нэгтгэж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийн саналыг | Эхний хагас жилд аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдийг мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан байна. Жилийн эцэст нийгмийн | Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд 2 удаа өөрчлөлт орсонтой холбоотойгоор аймаг /нийслэл/, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /газар/-т 4 удаагийн чиглэл, зөвлөмжийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 1/85, 1/86, 1/87, 5/837 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | арга зүйгээр хангаж ажиллах; | | | тусган 2021 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. | даатгалын төсөв, төлөвлөгөө хийгдсэн байна. | | |
| 2.21. | Нийгмийн даатгалын салбарын статистик үзүүлэлтийн нэгтгэлийг шинэчлэн нарийвчилсан үзүүлэлтээр баяжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх; | Шаард-лагагүй | Хагас, бүтэн жилийн статистикаар шинэчилсэн байна. | 2020 оны жилийн эцэс, 2021 оны эхний хагас жилийн байдлаар статистик үзүүлэлтийг шинэчилсэн. | 2022 оны эхний хагас жилд 2021 оны жилийн эцсийн үзүүлэлтээр шинэчилсэн байна.<br>2022 оны жилийн эцэст 2022 оны эхний хагас жилийн үзүүлэлтээр шинэчилсэн байна. | Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, ажил олгогч, албан журмын болон сайн дурын даатгуулагчийн тоо, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ зэрэг тоон мэдээллийг аймаг, дүүргээр 2021 оны байдлаар шинэчлэн нийгмийн даатгалын статистик үзүүлэлтийн нэгтгэлийг гаргасан.<br>Мөн Үндэсний статистикийн хорооноос баталсан маягтын дагуу 2021 оны байдлаар гаргасан мэдээллээр үзүүлэлтийн нэгтгэлийг баяжуулан ажиллав.<br>Нийгмийн даатгалын сангийн сарын мэдээний тоймыг бэлтгэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын www.ndaatgal.mn вэб сайтад сар бүр байршуулан ажиллав.<br>Монгол Улсын нийгмийн даатгалын салбарын хөгжлийн 80 жилийн түүхийг тоон үзүүлэлтээр илэрхийлсэн 6 дахь удаагийн "Нийгмийн даатгалын статистикийн эмхэтгэл" номыг<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэмжлэгтэйгээр хэвлүүлсэн.<br>Уг эмхэтгэлд нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны дэлгэрэнгүй үзүүлэлтүүдийг 1943-1945, 1950, 1955, 1960, 1970, 1980, 1990-1994, 1995-2021 оны байдлаар үечлэн багтаасан бөгөөд зарим үзүүлэлтүүдийг 2022 оны байдлаар гаргасан бөгөөд зарим үзүүлэлтийг илүү ойлгомжтой болгох зорилгоор дүрслэл, зургаар илэрхийлэн гаргасан байна. | 100 |
| 2.22. | Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 12 дугаар сарын | Шаард-лагагүй | Батлагдсан маягт | Уг ажлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн | Маягтыг шинэчлэн боловсруулах саналыг | Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны А/137 дугаар тушаалаар баталсан Нийгмийн даатгалын салбарын статистик | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 06-ны өдрийн тушаалаар баталсан нийгмийн даатгалын салбарын статистикийн мэдээллийн маягтыг Үндэсний статистикийн хороотой хамтран шинэчлэн боловсруулах; | | | хамгааллын яам, Үндэсний статистикийн хороотой хамтарсан уулзалтуудыг зохион байгуулж, гарсан саналыг тусган тодорхой бэлтгэл ажлыг хانган ажиллав. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна. | мэдээллийн маягт дах сарын мэдээний маягтыг шинэчлэх талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Сангийн яам, Үндэсний статистикийн хорооны хамтарсан уулзалт 2022 оны 6 сард зохион байгуулагдаж, талууд саналаа солилцож, цаашид хийх ажлын талаар хэлэлцсэн.<br>Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Үндэсний статистикийн хорооны хамтарсан 3 удаагийн уулзалтыг зохион байгуулсан.<br>Уг уулзалтын дүнд нийгмийн даатгалын салбарын жилийн эцэс, хагас жил болон сар бүр гаргадаг 25 статистик мэдээллийн маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн боловсруулах, батлуулах ажлыг Үндэсний статистикийн хороотой хамтран зохион байгуулж байна. | |
| ***Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| *"Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 3.1. | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэх; | Шаард-лагагүй | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үнэлгээ | Үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 1/14 тоот албан бичгээр болон цахимаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн явцад үнэлгээ хийгдэж хэрэгжилт биелсэн байна. | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад 2021 оны жилийн эцэс, 2022 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. Үүнд:<br>1. 2021 оны жилийн эцсийн байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын нийт 36 шийдвэрийн 50 заалт байна.<br>Хяналтад байгаа нийт 36 шийдвэрийн 1 шийдвэр нь 2019 онд гарсан, 5 шийдвэр нь 2020 онд, 30 шийдвэр нь 2021 онд шинээр хяналтад авсан заалтууд байна.<br>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн дэлгэрэнгүйг харуулбал: | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хийж, тайланг хуулийн хугацаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна. | | | • *Монгол Улсын Засгийн газрын 13 тогтоолын 16 заалтын 14 нь бүрэн хэрэгжиж 98.0%;*<br>• *Монгол Улсын Ерөнхий сайдын 1 захирамжийн 1 заалтын хэрэгжилт 100%;*<br>• *Засгийн газрын хуралдааны 12 тэмдэглэлийн 15 заалтын 13 нь бүрэн хэрэгжиж 98,0%;*<br>• *Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 6 тогтоолын 12 заалтын 11 нь бүрэн хэрэгжиж 98,0%;*<br>• *Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны сайдын 3 тушаалын 2 нь бүрэн хэрэгжиж 96,0%;*<br>• *Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 1 тушаал бүрэн хэрэгжиж 100,0 хувийн биелэлттэй байна.*<br>Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2021 оны жилийн эцсийн байдлаар 98.0 хувь буюу "Бүрэн хангалттай" гэж үнэлсэн ба үнэлгээний тайланг Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.<br>2. 2022 оны эхний хагас жилийн байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын нийт 21 шийдвэрийн 41 заалт байна.<br>Хяналтад байгаа нийт 21 шийдвэрийн 10 шийдвэр нь 2021 онд гарсан, 11 шийдвэр нь 2022 онд шинээр хяналтад авсан заалтууд байна.<br>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн дэлгэрэнгүйг харуулбал:<br>• *Монгол Улсын Засгийн газрын 6 тогтоолын 13 заалтын 5 нь бүрэн хэрэгжиж 99,0 хувийн хэрэгжилттэй;* | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • *Засгийн газрын хуралдааны 6 тэмдэглэлийн 7 заалтын 4 нь бүрэн хэрэгжиж 93,3 хувийн хэрэгжилттэй;*<br>• *Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 7 тогтоолын 19 заалтын 6 нь бүрэн хэрэгжиж 98,5 хувийн хэрэгжилттэй;*<br>• *Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2 тогтоолын 2 заалтын 2 нь бүрэн хэрэгжиж 100 хувийн хэрэгжилттэй байна.*<br>Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2022 оны хагас жилийн байдлаар 97,3 хувьтай үнэлсэн ба үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 01/1054 дүгээр албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. | |
| 3.2. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | Шаард-лагагүй | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж улирлын нэгдсэн тайланг дараа сарын 15-ны өдрийн дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна. | Үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 1/54, 1/604, 1/1154, 1/1645 дугаар албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдаж мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна. | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Нийгмийн даатгалын ерөнхий газар, түүний харьяа 33 байгууллага, Нийгмийн даатгалын сангийн 31 салбар эрх, нийт 238 хэрэглэгчээр хандан нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын шилэн дансны мэдээллийг төсөв, гүйцэтгэлийн 9, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5, бусад 7, нийт 21 төрлийн мэдээллийг байршуулж мэдээлэн хэрэглэгч, ажил олгогч, иргэд, олон нийтэд нээлттэй танилцах боломжийг ханган Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагууд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар шилэн дансны мэдээлэл байршуулалт нийт 7623 мэдээлэл мэдээлэхээс 7450 мэдээллийг мэдээлж, мэдээлэл байршуулалт 97.7 хувь байна.<br>Шилэн дансны нэгдсэн тайланг Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 1/83, 1/672, 1/1320, 1/1817 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.<br>Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан Шилэн дансны тухай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуулийн хэрэгжилтэд аудит хийх удирдамжийн дагуу аудитыг дараах чиглэлийн дагуу гүйцэтгэсэн. Үүнд:<br>• Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасан байгууллага буюу Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагууд нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж мэдээлсэн эсэх;<br>• Хуулийн 6 дугаар зүйлийн 6.7-д заасан Нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж мэдээлсэн эсэх;<br>• Хуулийн 8 дугаар зүйлд заасан холбогдох албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага зөвлөмжийг биелүүлсэн эсэх;<br>• Хуулийн 8 дугаар зүйлийг үндэслэн Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгосон эсэх;<br>Тус аудитаар шилэн дансны цахим хуудсанд 2021 онд байршуулсан мэдээлэл дараах байдалтай байна.Үүнд:<br>***1. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудын хувьд:***<br>Нийгмийн даатгалын байгууллагын мэдээлэл байршуулалт нийт 34 хэрэглэгчээс 5066 мэдээлэл мэдээлэхээс 4419 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, мэдээлэл байршуулалт 94.18 хувь. Үүнээс:<br>- Хугацаанд нь мэдээлээгүй, хугацаа хоцроосон 363 мэдээлэл ба нийт мэдээллийн 7.17 хувь;<br>- Мэдээлээгүй буюу дутуу мэдээлсэн 565 шийдвэрийн 10.4 тэрбум төгрөгийн 284 мэдээлэл байгаа нь нийт мэдээллийн 5.61 хувийг эзэлж байна.<br>***2. Нийгмийн даатгалын сангийн хувьд:*** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт нийт 32 хэрэглэгчээс 5003 мэдээлэл мэдээлэхээс 4273 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, мэдээлэл байршуулалт 93.50 хувь. Үүнээс<br>- Хугацаанд нь мэдээлээгүй, хугацаа хоцроосон 422 мэдээлэл ба нийт мэдээллийн 8.43 хувь;<br>- Мэдээлээгүй буюу дутуу мэдээлсэн 26910 шийдвэрийн 5.155,83 сая төгрөгийн 308 мэдээлэл байгаа нь нийт мэдээллийн 6.16 хувийг эзэлж байна.<br>Аудитаар аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдээс ирүүлсэн тайлан мэдээг дахин хянан нягтлахад мэдээллийг хугацаа хоцроож байршуулах, мэдээлээгүй зэрэг зөрчлөөс гадна мэдээлэх ёсгүй мэдээллийг оруулах, хугацаанд нь байршуулсан харагдах боловч доторх мэдээлэл хоосон байх, мэдээллээ байршуулсан хэдий ч Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т " Шилэн дансны мэдээлэл татаж авах, хэвлэх боломжтой байх" гэж заасан стандартыг хангаж ажиллаагүй, урьд сарын мэдээллийг дараа сард давтан оруулах, урьд оны мэдээллийг оруулах зэрэг нийтлэг зөрчлүүд илэрсэн.<br>Аудитын дүн мэдээг гарын үсгээр баталгаажуулж, нэгтгэн холбогдох газрын дарга нарт танилцуулан, цаашид авах арга хэмжээний саналыг Тамгын газарт хүргүүлсэн. | |
| 3.3. | Төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | Шаард-лагагүй | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 1/125 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. | Төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт үе шаттай хангагдсан байна. | "Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.<br>Монгол Улсын Их Хурлын 2015 оны 53 дугаар тогтоолоор баталсан Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого /2015-2030 он/-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр 6 зорилтын 45 арга хэмжээ тусгагдсан байна. Үүнд: | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг 02 дугаар сарын 01-ний өдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна. | | | • Тэтгэврийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх ажлын хүрээнд 3 үйл ажиллагаа;<br>• Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд 21 үйл ажиллагаа;<br>• Малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын хүрээнд 5 үйл ажиллагаа;<br>• Тэтгэврийн нас, тэтгэвэр тогтоох хөнгөлөлттэй нөхцөлийн тухайд 4 үйл ажиллагаа;<br>• Тэтгэврийн даатгалын шимтгэлийн талаар 4 арга хэмжээ;<br>• Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоог бэхжүүлэх ажлын хүрээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.<br>Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг авч үзэхэд:<br>1. "үр дүнтэй" зорилт арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан буюу 100 хувийн биелэлттэй 6 зорилт 39 арга хэмжээ байна.<br>2. "тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70.0 хувийн биелэлттэй 6 зорилт арга хэмжээ байна.<br>Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны жилийн эцсийн байдлаар 97.9 хувиар дүгнэж үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 1/188 дугаар албан бичгээр Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн | |
| 3.4. | Засгийн газрын үйл ажиллагааны | Шаард-лагагүй | Засгийн газрын 2020 | Нийгмийн даатгалын ерөнхий | Засгийн газрын үйл ажиллагааны | Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | | оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг 01 дүгээр сарын 20, 06 дугаар 20-ны өдрийн дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна. | газрын даргын 2021 оны 1/67, 1/1020 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. | хөтөлбөрийн хэрэгжилт үе шаттай биелсэн байна. | хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2021 оны жилийн эцэс, 2022 оны эхний хагас жилийн байдлаар тайлан, холбогдох мэдээ, мэдээллийг үндэслэн хяналт-шинжилгээ үнэлгээг хийж, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.<br>1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр 2 бодлого, 6 зорилт, 8 арга хэмжээ тусгагдсан байна.<br>Энэхүү зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2021 оны жилийн эцсийн байдлаар Үр дүнтэй" буюу зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрсэн, удирдлага зохион байгуулалтын ажил бүрэн хийгдсэн, тодорхой үр дүн гарсан "100 хувийн хэрэгжилттэй" гэж үнэлж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 1/123 дугаар албан бичгээр Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.<br>2. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2022 онд нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр 6 зорилт бүхий 9 арга хэмжээ тусгагдсан байна.<br>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 6 зорилт, 9 арга хэмжээ тус бүрийн биелэлтийг харуулбал:<br>-100 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ;<br>-90 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ;<br>-70 хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ;<br>Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжилтийн явцыг 2022 оны эхний хагас жилийн байдлаар 86.6 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 1/1189 дугаар албан бичгээр Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. | |
| 3.5. | Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Монгол Улсыг (2021-2025) хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | Шаард-лагагүй | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 1/31 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна. | Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт үе шаттай биелэгдсэн байна. | Монгол Улсыг (2021-2025) хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор үнэлгээний дүнг тайлангийн хамт Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэхээр бэлтгэж байна. | Хугацаа болоогүй |
| *“Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах” **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.6 | Нийгмийн даатгалын тухай хуулиуд, Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, батлагдсан удирдамжийн дагуу аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, ажил үйлчилгээний үр дүнг тооцож ажиллах; | 30.0 сая | Нийслэлийн Нийгмийн даатгалын газар, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс болон Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд Нийгмийн даатгалын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг шалгаж, өмнөх шалгалтын мөрөөр хийсэн ажлын гүйцэтгэлд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг Сонгинохайрхан дүүрэг болон Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Увс аймгуудын Нийгмийн даатгалын хэлтэст шалгалт хийж илэрсэн зөрчилд Улсын байцаагчийн акт тогтоож 54.5 хувийг барагдуулж ажилласан. | Нийгмийн даатгалын тухай хуулиуд, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг батлагдсан удирдамжийн дагуу дурдсан аймаг, дүүргүүдийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн ажил үйлчилгээний үр дүнг тооцох, Улсын байцаагчийн актаар тогтоосон төлбөрийн 70-аас дээш хувийг барагдуулж ажиллах | Тайлант хугацаанд Төв, Сүхбаатар, Өвөрхангай аймаг, Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж тус хэлтсүүдийн 2017-2021 онуудын сангийн болон үйл ажиллагааны санхүүгийн баримтууд, тэтгэвэр, тэтгэмжийн хувийн хэрэг, бусад анхан шатны баримтуудад үндэслэн шалгасан. Үүнд:<br>Дээрх шалгалтаар дараах төлбөр зөрчил илэрсэн. Үүнд:<br>- Үндэслэлгүй баримтаар шүүхийн шийдвэр гаргуулсан, мөн хуурамч архивын лавлагаа гаргуулан хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авсан 86 хүнтэй холбоотой 1834.0 сая төгрөгийн;<br>- Байцаагчийн алдаанаас 103 хүнд илүү тооцож олгосон 61.9 сая төгрөгийн, 50 хүнд дутуу олгосон 44.8 сая төгрөгийн;<br>- Ажилгүйдлийн даатгалын сангаас 44 хүнд үндэслэлгүйгээр олгосон 29.6 сая төгрөгийн, 1 хүнд дутуу олгосон 1.1 сая төгрөгийн;<br>Нийтдээ 698.5 сая төгрөгийн төлбөрийг нөхөн төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоож, актаар тогтоосон төлбөрийн 81.9 хувийг барагдуулаад байна.<br>Шалгалтын явцад хөдөлмөрийн хэвийн болон хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авсан 22.6 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийн тогтоолтыг, давхардсан тоогоор 388.9 мянган тэтгэврийн олголтыг шалгаж, идэвхтэй 93.0 тэтгэвэр авагчийн 6,1 мянган зогсоогдсон нас барсан тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэргийг тоолж, Дархан-Уул, Сэлэнгэ, Увс, Архангай аймгуудын архивын газраас 136 тэтгэвэр авагчийн ажилласан жилийн тушаалын үндэслэлийг шалгаж, тэтгэвэр анх тогтоолгосон баримтын бүрдэл дутуу 65 тэтгэвэр авагчийн баримтыг дахин | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | арилгах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулж ажиллах | | | бүрдүүлсний дараа тэтгэврийг үргэлжлүүлэн олгохоор түр хугацаагаар зогсоосон.<br>Мөн Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст хийгдсэн шалгалтаар үндэслэлгүй баримтаар зардал гаргасан, түрээсийн орлогыг хуулийн дагуу төвлөрүүлээгүй, нярав, нягтлан бодогч нарын хувийн дансаар дамжуулан гүйлгээ хийсэн зэрэг 27.5 сая төгрөгийн зөрчил илрүүлэн шийдвэрлэлээ.<br>Шалгалтын хугацаанд шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авч, баталгаажуулах, өр авлагыг барагдуулах, санхүү бүртгэл болон хүний нөөцийн асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. | |
| 3.7. | Малчны тэтгэврийн тогтоолт, олголтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтоож, олгосон байдалд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах; | 10.0 сая | 1-2 аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Малчны тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгаж, шалгалтын дүнг үндэслэн цаашид авах арга хэмжээний тухай санал боловсруулах | Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн малчны тэтгэвэр тогтоолт олголтыг шалгаж 60.9 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлэн 37.8 хувийг барагдуулж ажилласан. | Батлагдсан удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын хэлтсүүдэд холбогдох хуулийн хэрэгжилтийг шалгаж, ажил үйлчилгээний үр дүнг тооцож, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх | 2018-2021 онуудад малчны нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авсан иргэдийн тэтгэврийн тогтоолт, олголтыг хянах тухай нэгдсэн удирдамж боловсруулан улсын хэмжээнд 26.3 мянган тэтгэврийн хувийн хэрэг шалгаж "Малчин даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтооход баримтлах заавар"-ын 6 дугаар зүйлийн 6.6.2 заалтын дагуу нийгмийн даатгалын байцаагчид тус аймгуудын ЗДТГ-ын архиваас гарсан А дансны лавлагааг үндсэн баримттай нь тулган шалгаагүй, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 1/1424 дугаар албан бичгээр хүргүүлсэн чиглэлд "Малчнаар ажилласан хугацааг нотлох баримтад тулгуурлан тогтоох" тухай заалтын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зэрэг зөрчлүүдийг илрүүлэн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.<br>Мөн гүйцэтгэлийн хяналтаар 4573 иргэний тэтгэврийн материалыг хамруулан шалгаж, нийт 32 тэтгэвэр авагчтай холбоотой 18.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, улсын байцаагчийн акт тогтоон төлбөрийг 100 хувь барагдуулсан байна. | 100 |
| 3.8. | Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод үйл ажиллагаа болон бусад чиглэлээр аймаг, | Шаард лагагүй | Нэгдсэн удирдамжийн дагуу аймаг, дүүргийн | Шинээр хэрэгжинэ | Батлагдсан удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын | Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан салбарын хэмжээнд гадагшаа чиглэсэн хяналт шалгалтын ажлыг түр хугацаагаар хойшлуулан зөвлөн туслах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдийн хийж гүйцэтгэх хяналт шалгалтын ажлын нэгдсэн удирдамж боловсруулж хүргүүлэн, шалгуулах ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулж мэргэжил арга зүйгээр ханган ажиллах; | | Нийгмийн даатгалын хэлтсийн дотоодын хяналт шалгалтаар шалгуулах ажлыг зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, үр дүнг тооцож ажиллах | | хэлтсүүдэд холбогдох хуулийн хэрэгжилтийг шалгаж, ажил үйлчилгээний үр дүнг тооцож, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх | үйлчилгээ үзүүлж, 21 аймаг, 9 дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд дотоодын хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх талаарх зөвлөмжийг 2022 оны 07/419 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн бүтээгдэхүүн олборлогч, тээвэрлэгч, байгууллагад тулгамдаж буй асуудлаар Авто тээврийн үндэсний төвтэй хамтарсан уулзалт зохион байгуулж, уулзалтаар байгууллага хооронд харилцан мэдээлэл солилцох ажлыг шуурхай болгох, хуулийн этгээд, даатгуулагчдын нийгмийн асуудлыг нэг мөр зохицуулах, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг ил тод болгох, жолооч нарын бүртгэлийг цахимжуулах талаар гэрээнд өөрчлөлт оруулах тухай хэлэлцлээ.<br>Түүнчлэн уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэгч 280 гаруй байгууллагын жагсаалтыг Авто тээврийн үндэсний төвтэй хамтран гаргаж, Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийг сурталчлах зорилгоор нийт 46 байгууллагын үйл ажиллагаанд нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн талаарх мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. | |
| ***Төрийн захиргаа, хүний нөөц.*** | | | | | | | |
| 3.9. | Нийгмийн даатгалын байгууллагын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөг боловсруулж батлах, хэрэгжилтэд хяналт тавих; | Үйл ажиллагааны зард лаар | Ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг батлуулсан байна. | Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу давхардсан тоогоор нийт 326 албан хаагчид 35 873 973 төгрөгийн буцалтгүй тусламж олгож 100 хувь биелсэн байна. | Нийгмийн даатгалын байгууллагын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, бодит тусламжийг үзүүлсэн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөнд 5 зүйл 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, 2022 оны байдлаар давхардсан тоогоор нийт 357 албан хаагчид 48.2 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, 2 албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламжид 37,6 сая төгрөг, төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу ажлаас чөлөөлөгдсөн 4 албан хаагчид 8.5 сая төгрөгийг олгож, хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь биелэлттэй байна. | 100 |
| 3.10. | Ахмад настны нийгмийн баталгааг | Ахма дын сангаас | Ахмад настны тухай хуулийн | Нийгмийн даатгалын ерөнхий | Ахмад настнуудын нийгмийн | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх ахмадын хорооны 2022 оны ажлын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангах, тусламж дэмжлэг олгох журмыг хэрэгжүүлж ажиллах; | | хүрээнд Ахмадын сангийн хөрөнгийг зарцуулах журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | газрын даргын 2019 оны А/09 дүгээр "Журам дүрэм шинэчлэн батлах тухай" тушаалын хавсралтаар баталсан "Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Ахмадын хорооны дүрэм" болон "Ахмадын сангийн хөрөнгө зарцуулах журам"-д заасны дагуу 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 7,000,000 төгрөгийн буцалтгүй тусламжийг ахмад настнуудын ирүүлсэн өргөдөл хүсэлтийг үндэслэн олгосон байна. | баталгааг хангаж, холбогдох хууль журмын дагуу дэмжлэг тусламжийг олгосон байх, Ахмадын хорооны 2022 оны хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтэд анхаарч ажиллах | төлөвлөгөөнд нийт 12 ажлыг хэрэгжүүлэхээр батлав. Үүнд:<br>- Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2 ажил үйлчилгээ;<br>- Ахмад настны хөгжил оролцоог дэмжих ажлын хүрээнд 3 ажил үйлчилгээ;<br>- Ахмад настанд хүндэтгэл, нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, дэмжлэг тусламж үзүүлэх ажлын хүрээнд 7 ажил үйлчилгээ;<br>- Бусад асуудлын хүрээнд 4 ажил үйлчилгээ буюу нийт 12 ажил;<br>Тайлант хугацаанд дээрх төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд 100 хувийн биелэлттэй хэрэгжсэн бөгөөд дараах ажлуудыг зохион байгуулав. Үүнд:<br>- Нийт 53 ахмад настнуудаас 35 ахмад настан хамрагдаж эмчилгээ үйлчилгээ авснаас гадна ахмад настнууд эмнэлгийн үйлчилгээг авах шаардлагатай үедээ үнэмлэхээ үзүүлэн үйлчилгээ авч байна.<br>- Сар шинийн баярыг тохиолдуулан НДЕГ-ын 53 ахмад настанд 3.1 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон.<br>- Олон улсын Ахмадын өдөр, мөн Нийгмийн даатгалын байгууллага үүсэж хөгжсөний түүхт 80 жилийн ойг тохиолдуулан "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-оор 3, "Ардын хувьсгалын 100 жилийн ойн хүндэт медаль"-иар 3, Монголын Ахмадын Холбооны "Хүндэт тэмдэг"-ээр 4 ахмад настныг тус тус шагнаж урамшуулсан байна.<br>Тайлант хугацаанд ахмад настан иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг үндэслэн Ахмадын хорооны хурлаар шийдвэрлэн эрүүл мэндийн шалтгааны улмаас эмчилгээ хийлгэх шаардлагатай 6 ахмад настанд 5.5 сая төгрөгийн, 80 насны ойг тохиолдуулан нэг ахмад настанд 200,0 мянган төгрөгийг олгосон байна. | |
| 3.11. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан тушаалтнуудын хувийн | Шаардлагагүй | Хуулийн хугацаанд гаргасан байх | Салбарын хэмжээнд ХАСХОМ мэдүүлэх 788 албан хаагч | ХАСХОМ-ыг салбарын хэмжээнд хуулийн | Салбарын хэмжээнд ХАСХОМ мэдүүлэх 720 албан хаагч байснаас 100 хувь буюу 720 албан хаагчийн 2021 оны ХАСХОМ гаргах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах, хянах, хадгалах, ХАСУМ, мэдэгдэл тайлбарыг гаргуулах, салбарын албан хаагчдын мэдүүлэг бүрдүүлэлтийн ажлын тайлан мэдээг Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд хүргүүлэх; | | | байснаас 100 хувь буюу 788 албан хаагчийн 2020 оны ХАСХОМ гаргах ажлыг нийслэл, аймаг, дүүргийн 31 ЭБАТ-тай хамтран зохион байгуулсан. Үүнээс Нийгмийн даатгалын ерөнхий газрын 114 албан хаагчийн ХАСХОМ-ыг хугацаанд нь гаргуулж, баталгааны маягтыг бүртгэсэн. Хуулийн хугацаанд буюу 2 дугаар сарын 28-нд ХАСХОМ-1, ХАСХОМ-2, ХАСХОМ-3, ХАСХОМ-4 тайлангуудыг салбарын хэмжээнд нэгтгэн гаргаж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. | хугацаанд 100% гаргасан байна. | ажлыг Нийслэлийн нийгмийн даатгалын газар, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн 31 Эрх бүхий албан тушаалтантай хамтран зохион байгуулсан.<br>Салбарын хэмжээнд ХАСХОМ-1, ХАСХОМ-2, ХАСХОМ-3, ХАСХОМ-4 тайлангуудыг нэгтгэн хуулийн хугацаанд буюу 2 дугаар сарын 28-нд гаргаж, 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 1/387 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. | |
| 3.12. | Байгууллагын хэмжээнд авлигаас сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах, салбарын албан хаагч, иргэн, төрийн бус байгууллагуудад хууль зүйн мэдээлэл, зөвлөгөө өгөх; | Шаардлагагүй | Зөвлөгөө өгсөн тоо | -Аймаг, нийслэл, дүүргийн ЭБАТ-уудад 1 дүгээр сард цахимаар сургалт зохион байгуулж, ХАСХОМ-ыг гаргах талаар чиглэл өгсөн.<br>Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран аймаг, дүүргийн ЭХМКомиссын нийт | Аймаг, нийслэл, дүүргийн ЭБАТ-уудад сургалт зохион байгуулж, ойлголт мэдээллийг нэмэгдүүлсэн байна. | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс зүй, ХАСХОМ мэдүүлгийг гаргуулах талаар холбогдох газруудтай хамтран 5 удаагийн сургалтад ажилтнуудыг хамруулсан байна. Үүнд:<br>- Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хэрхэн гаргах талаар аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн албан хаагчдад 3 удаагийн сургалтыг 2022 оны 1 дүгээр сард зохион байгуулсан сургалтанд 300 гаруй албан хаагчид хамрагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | гишүүдэд Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр, сумдын байцаагч нарт "Ёс зүй, харилцаа хандлага", Төрийн албаны тухай хуулийн талаарх сургалтуудыг бусад газруудтай хамтран зохион байгуулж давтагдсан тоогоор 800 албан хаагчдыг хамруулсан.<br>- Салбарын албан хаагч, иргэн, төрийн бус байгууллагуудад хууль, эрх зүйн мэдээлэл зөвлөгөөг 250 гаруй удаа өгч ажилласан. | | - Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд сүүлийн 2 жилийн хугацаанд шинээр томилогдсон албан хаагчдад "Төрийн албаны тухай хууль, төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, хориглох зүйл, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр цахим сургалтыг 3 дугаар сард зохион байгуулсан.<br>- Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн талаар цахим сургалтыг 2022 оны 10 дугаар сард зохион байгуулж, Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн 400 гаруй албан хаагчдыг хамруулсан.<br>Мөн салбарын албан хаагч, иргэн, төрийн бус байгууллагуудад хууль, эрх зүйн мэдээлэл зөвлөгөөг 250 гаруй удаа өгч ажиллалаа. | |
| 3.13. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас баталсан нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжүүлэхээр гарч буй тушаал, шийдвэр, дүрэм, журмуудын талаар нэгдсэн бүртгэлтэй болж, холбогдох ажилтан, албан хаагчдыг нэгдсэн мэдээллээр хангаж ажиллах; | Шаардлагагүй | Захиргааны эрх зүйн актууд болон Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй тушаал, шийдвэр, эрх зүйн актуудыг нэгдсэн журмаар бүртгэлжүүлнэ. | Шинээр хэрэгжинэ. | Жилийн хугацаанд гарсан тушаал шийдвэр, эрх зүйн актуудыг нэгдсэн журмаар бүртгэлжүүлнэ. | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй нийгмийн даатгалтай холбоотой дүрэм, журам, аргачлал, заавар, зөвлөмжийн эмхэтгэлийг 2022 оны байдлаар 2 удаа шинэчлэн гаргаж, нийгмийн даатгалын байгууллагын нийт албан хаагчдад албан хэрэгцээнд ашиглахаар нийгмийн даатгалын байгууллагын дотоод сүлжээ /http://10.9.0.5/zarmedee-нд байршууллаа.<br>Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм журам, заавруудыг нэгтгэн Нийгмийн даатгалын ndaatgal.mn вэбсайтад байрлуулсан.<br>Мөн Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлд заасны дагуу хэм хэмжээний актад бүртгүүлэх шаардлагатай захиргааны актын судалгаа болон хүчингүй болсон 2010 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн "Журам батлах тухай" 163 дугаар тушаалыг Нийгмийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/30 дугаар тушаалаар шинэчлэн бүртгүүлэхээр 2022 оны 01/170 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ. | |
| ***Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын хөгжил, тогтвортой үйл ажиллагааг хангах.*** | | | | | | | |
| 3.14. | Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах; | Шаард-лагагүй | Хэлэлцээрийн хүрээнд хийгдсэн ажлын тоо | Хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллав. | Хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган ажилласан байна. | -Монгол Улс болон Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын "Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр"-ийг хэрэгжүүлэхэд ашиглах маягтын загваруудыг 2 талын ажлын хэсгийн гишүүд боловсруулж, 2022 оны 3 дугаар сард 2 тал албан ёсоор баталснаар хэрэгжилтийг зохион байгуулж байна.<br>- Монгол Улс, Бүгд Найрамдах Унгар Улсын хоорондын нийгмийн хамгааллын хэлэлцээрийн дагуу өргөдөл хүсэлт ирүүлсэн Монгол Улсын 28 иргэний тэтгэврийг тогтоох болон ажилласан жилтэй холбоотой мэдээлэлд хариу ирүүлэхгүй байгаа 26 иргэний сануулах маягтыг тус тус батлагдсан маягтын дагуу Бүгд Найрамдах Унгар Улсын тэтгэврийн албанд цахимаар илгээв. Шинээр Монгол Улсын 2 иргэний тэтгэвэр Бүгд Найрамдах Унгар Улсаас тогтоогдов.<br>- Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд ашиглах маягтын загваруудад санал бэлтгэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гадаад хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах хэлтэст цахимаар хүргүүлэв.<br>- Хилийн чанадад оршин суугаа Монгол Улсын иргэдэд Нийгмийн даатгалын хууль тогтоомж болон сайн дурын даатгалыг сурталчлах, сайн дурын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор 2022 оны 3, 4 дүгээр сард цахим сургалт зохион байгуулж "Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр" сэдвээр танилцуулга мэдээлэл өгөв. | 100 |
| 3.15. | Казахстан болон Оросын холбооны | Шаард-лагагүй | Хэлэлцээрийн хүрээнд | Холбогдох ажлын хэсэгт ажиллаж, | Хэлэлцээрийг хэрэгжүүлэх | 1. Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд нийгмийн даатгалын салбарт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | улсын Засгийн газар хоорондын Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг шинэчлэхтэй холбоотой тооцоо, судалгаа хийх, санал боловсруулах, сурталчлах; | | хийгдсэн ажлын тоо | шаардлагатай тооцоо, судалгаа, саналыг хүргүүлэв. | чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран ажилласан байна. | хамтран ажиллах хэлэлцээрийг шинэчлэхтэй холбоотой 2022 оны 04 дүгээр сарын 04-өөс 06-ны өдрүүдэд зохион байгуулсан 2 талын ажлын хэсгийн цахим уулзалтад оролцож хэлэлцээрийн төсөлд оруулахаар тохирсон нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгаж, талууд үндэсний хууль тогтоомжийн дагуу хэлэлцээрийн төслийг дотооддоо үргэлжлүүлэн хэлэлцэхээр тохиролцов.<br>Мөн хэлэлцээртэй холбоотой тоон мэдээ, мэдээллийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2022 оны 01 дүгээр сарын 27, 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрүүдэд цахимаар хүргүүлэн ажилласан.<br>2. Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хооронд тэтгэврийн салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг хэлэлцэх ажлын хэсгийн 11 дэх удаагийн уулзалт 2022 оны 08 дугаар сарын 23, 24-ний өдрүүд Улаанбаатар хотод зохион байгуулагдаж талууд санал солилцож, хэлэлцээрийн төсөлд орох нэмэлт, өөрчлөлтүүдийг тохиролцов. | |
| 3.16. | БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай Засгийн Газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд иргэдийн ажилласан хугацааг баталгаажуулах; | Үйл ажил-лагаа ны зард лаар | Ажилласан хугацааг баталгаажуулсан иргэдийн тоо Боловсруулсан баримт бичгийн тоо, төрөл | 2021 онд нийт 86 иргэний хүсэлтийг холбогдох улсын тэтгэврийн санд албан бичгээр хүргүүлэв. Аж ахуйн нэгж байгууллагад 121 иргэний материалыг албан бичгээр хүргүүлсэн. 125 иргэнийг хүлээн авч мэдээлэл зөвлөгөө өгсөн байна. | Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн лавлагааг баталгаажуулах ажлыг зохион байгуулсан байна. | БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд Монгол Улсаас ОХУ-д ажилласан хугацааг баталгаажуулах хүсэлт гаргасан иргэдийн хүсэлтийг ОХУ-ын Тэтгэврийн Фондод, ОХУ-ын Тэтгэврийн Фондоос ирүүлсэн ажилласан хугацааг баталгаажуулахаар ирүүлсэн иргэдийн хүсэлтийг Монгол улс дахь холбогдох байгууллагад хүргүүлэн шийдвэрлэж байна.<br>2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар ажилласан хугацааг баталгаажуулахаар ирүүлсэн нийт 69 иргэний хүсэлтийг холбогдох улсын тэтгэврийн санд хүргүүлэн шийдвэрлэсэн ба эдгээр иргэдийн ажилласан жилийн лавлагааг гаргуулахаар холбогдох аж ахуйн нэгж, ажил олгогчдод албан бичгийг тухай бүрт нь хүргүүлж ажилласан. Үүнд: | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1. Монгол Улсад ажил хөдөлмөр эрхэлж байгаа болон эрхэлж байсан ОХУ-ын 50 иргэний материалтай танилцан шийдвэрлэж, ОХУ-ын тэтгэврийн фонд руу;<br>2. Монгол Улсад албан ёсоор оршин суудаг ОХУ-ын 4 иргэний материалыг ОХУ-ын тэтгэврийн фонд руу;<br>3. ОХУ-д албан ёсоор оршин суудаг болон ОХУ-д ажиллаж байсан Монгол Улсын 13 иргэний материалыг хүлээн авч холбогдох байгууллага болон ОХУ-ын тэтгэврийн фонд руу;<br>4. Монгол Улсад ажиллаж байсан Украин улсын 2 иргэний материалыг Украйн улсын тэтгэврийн фонд руу тус тус илгээсэн байна.<br>Иргэний ажилласан жилийг баталгаажуулах зорилгоор Үндэсний Төв архив, Нийслэлийн архивын газар, Булган, Сэлэнгэ Орхон, Дорнод, Дархан-Уул аймгийн архивын тасгууд, харьяа нийгмийн даатгалын хэлтсүүд, Монгол Оросын хамтарсан 3 дугаар сургууль, "Эрэл" сургууль, Улаанбаатар төмөр зам, Соёл урлагийн их сургууль, Монгол дахь Аэрофлотын төлөөлөгчийн газар, Цемент-шохой ХК, Алтайн Хөндий ХХК, "Алтан дорнод" ХХК, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Монголросцветмет" ТӨҮГ зэрэг байгууллага руу ажилласан жилийн тодорхойлолтыг хүссэн 101 /давхардсан тоогоор/ иргэний хүсэлтийг албан бичгээр хүргүүлсэн.<br>Тайлант хугацаанд 98 иргэнд нийгмийн хамгааллын хэлэлцээрийн талаарх мэдээлэл зөвлөгөөг өгч ажиллалаа. | |
| 3.17. | Олон улсын байгууллагатай хамтран ажиллах болон гэрээ, хэлэлцээр байгуулах, хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдаж буй ажлын бэлтгэл хангах; | Үйл ажил-лагаа ны зард лаар | Боловсруулсан баримт бичгийн тоо, төрөл<br>-Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, төрөл | Швейцарийн хөгжлийн агентлаг, Туркийн хамтын ажиллагаа зохицуулах агентлаг, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Солонгосын олон | Олон улсын байгууллага, донор байгууллагуудтай хамтран ажиллаж, өөрсдийн үйл ажиллагааг танилцуулж сурталчилсан байна. | 1. Тайлант хугацаанд хамтран ажиллах тухай саналыг холбогдох газруудад хүргүүлсэн байна. Үүнд:<br>- БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албатай хамтран ажиллах үйл ажиллагааны чиглэлүүдийг англи, монгол хэл дээр боловсруулж, хамтран ажиллах саналыг БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албаны Олон улсын харилцааны төвийн ерөнхий захирал | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | улсын хамтын ажиллагааны байгууллага (KOICA)-тай хамтран ажиллах үйл ажиллагааны чиглэлүүдийг боловсруулан баталж, хамтран ажиллах саналыг албан бичгээр хүргүүлсэн. Туркийн хамтын ажиллагаа зохицуулах агентлаг, Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага (KOICA) -тай уулзалт зохион байгуулсан. | Хамтын ажиллагааны гарцын талаар санал солилцсон байна. | Шин Жаэ Хуюкт 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01/254 дугаар албан бичгээр;<br>- Монгол Улсад БНХАУ-аас суугаа Элчин Сайдын Яамтай хамтран ажиллах саналыг Элчин Сайдын Яамны Худалдаа эдийн засгийн газарт 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/360 дугаар албан бичгээр;<br>- Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлагтай хамтран ажиллах саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхарт 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/380 дугаар албан бичгээр;<br>- Фредрих Эбертийн сантай хамтран ажиллах саналыг суурин төлөөлөгч Бенедикт Ивановст 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 01/450 дугаар албан бичгээр;<br>2. Тайлант хугацаанд гадаад хамтын ажиллагааны хүрээнд дараах уулзалтуудыг зохион байгуулж оролцлоо. Үүнд:<br>- 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан Европын Холбооны Socieux Plus байгууллагын төлөөлөгчтэй санал солилцох уулзалтад оролцлоо.<br>Уулзалтаар Европын Холбооноос Монгол Улсад суугаа төлөөлөгчийн газраас Socieux Plus байгууллагатай нийгмийн хамгааллын чиглэлээр зөвлөгөө мэдээлэл, туршлага солилцох, чадавхыг дээшлүүлэх богино хэмжээний сургалт, төсөл хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл солилцлоо.<br>- НДЕГ, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба хоорондын хамтын ажиллагааны хүрээнд 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр цахим уулзалт зохион байгууллаа. Уулзалтын үеэр мэдээлэл технологийн чиглэлээр хамтран ажиллах, сургалтад мэргэжилтнүүдийг хамруулах, цаашид урт хугацаагаар хамтран ажиллах чиглэлээр харилцан ярилцаж санал солилцов.<br>- Мөн НДЕГ, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Үндэсний тэтгэврийн албаны Нийгэмд хувь нэмэр оруулах сангийн төлөөлөлтэй 2022 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оны 07 дугаар сарын 06-ны өдөр уулзалт зохион байгуулж, нийгмийн хариуцлагын чиглэлээр төр, хувийн хэвшил, их сургуулиудын хамтын ажиллагааны хүрээнд орон нутагт нийтийн эрх ашигт нийцсэн төслүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар харилцан ярилцаж санал солилцов.<br>- Монгол Улсын онцлогт нийцсэн хуримтлалын нэгдсэн сангийн тогтолцоог бий болгоход зөвлөх үйлчилгээ үзүүлэх Бүгд Найрамдах Сингапур Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагын Зүүн өмнөд Азийн газрын захирал Тан По Текээр ахлуулсан Сингапурын Хуримтлалын нэгдсэн сан (CPF), Сингапурын хамтын ажиллагааны байгууллага (SCE)-ын төлөөлөгчид Монгол Улс дахь айлчлалын үеэр 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдөр НДЕГ, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст ажиллалаа.<br>Уг уулзалтаар төлөөлөгчид Монгол улсын нийгмийн даатгалын мэдээллийн сангийн бүрдүүлэлт, нийгмийн даатгалын хөгжлийн явц, ялангуяа тэтгэврийн даатгалын санд тулгарч байгаа сорилтын талаар тодруулж, Сингапурын Хуримтлалын нэгдсэн сангийн хөгжлийн туршлагаас хуваалцав.<br>3. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан уулзалтуудаас гадна Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 21 олон улсын байгууллагыг сонгон авч холбогдон тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран ажиллах боломжийн талаар судалгаа гаргалаа.<br>2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан “Нийгмийн даатгалын байгууллагын 80 жил- Хөгжил, шинэчлэлийн алсын хараа” зөвлөгөөнд Дэлхийн банкны Монгол Улс хариуцсан менежер бөгөөд суурин төлөөлөгч Андрей Михнев, Азийн хөгжлийн банкны суурин төлөөлөгч Павит Рамачандран, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын БНХАУ, Монгол Улс хариуцсан товчооны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | захирал Чанхи Ли, Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг /ЖАЙКА/ байгууллагуудын Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Танака Шиничи нар урилгаар оролцсон. | |
| **Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.** | | | | | | | |
| *"Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах"* **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:** | | | | | | | |
| 4.1. | ISO 9001:2015 олон улсын стандартад нийцсэн чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах; | Дэлхийн банкны төслийн санхүү жилтээр | Чанарын удирдлагын тогтолцоонд шилжих, нэвтрүүлэх ажлын явцыг хянаж, удирдлага, арга зүйгээр хангах | 2018 онд Төв, Орхон, 2019 онд Архангай, Дархан-Уул, Өвөрхангай, Хөвсгөл, 2020 онд Сонгинохайрхан дүүрэг болон Баян-Өлгий, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, 2021 онд Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс болон Булган, Дорноговь, Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсүүд үйл ажиллагаандаа Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэн батламжаа гардан авсан. | Жилийн эцэст Нийгмийн даатгалын ерөнхий газар, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Увс аймаг, Багануур, Баянгол, Налайх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн үйл ажиллагаанд ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлсэн байна. | Тайлант хугацаанд ISO 9001:2015 олон улсын стандартад нийцсэн чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:<br>1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Увс аймаг, Багануур, Баянгол, Налайх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст ISO 9001:2015 стандартын талаар нийт 11 удаагийн сургалтыг "Удирдах урлаг хөгжил" ТББ-тай хамтран цахимаар болон танхимаар зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 760 гаруй албан хаагчдыг хамруулаад байна.<br>2. ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх 4 ажлын дэд багийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын газар, хэлтсийн албан хаагчдыг хамруулан байгуулж, байгууллагын гадаад, дотоод асуудал, сонирхогч талууд болон тэдгээрийн хэрэгцээ, хүлээлт, Нийгмийн даатгалын байгууллагын Чанарын менежментийн тогтолцооны зураглалыг тодорхойлох, нийгмийн даатгалын байгууллагаас иргэд, даатгуулагч, ажил олгогч нарт үзүүлж байгаа 34 үйлчилгээний жагсаалт, байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа гадны гаралтай болон дотоодын баримт бичгүүдийг ангилах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3. Чанарын удирдлагын стандартыг нэвтрүүлж буй Нийгмийн даатгалын ерөнхий газар, 8 аймаг, 6 дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн нийт 83 албан хаагчдыг хамруулан дотоод аудитын сургалтыг 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 27-ны өдрүүдэд зохион байгуулж сертификат олгов.<br>Уг сургалтын хүрээнд өөрсдийн ажиллаж байгаа газар, хэлтсийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, аудитын тайланг цахимаар хэлэлцэв.<br>Төслийн багаас цаашид дотоод аудит хийхэд анхаарах асуудлуудын талаар баг тус бүрт зөвлөгөө өгч ажиллав.<br>3. Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс стандартын хэрэгжилтэд хөндлөнгийн байгууллагаар 12 дугаар сарын 12-ны өдрөөс 16-ны хооронд явцын аудит хийлгэхээр хүсэлтээ өгөөд байна.<br>Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандартын шаардлагын дагуу хөндлөнгийн байгууллагаар аудит хийлгэх талаар тусгасан тул аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдийн хувьд стандартын хэрэгжилтэд урьдчилсан болон баталгаажилтын аудит хийлгэх зардал 2022 оны төсөвт тусгагдаагүй тул аудит хийлгэх хугацаа хойшлогдоод байна. | |
| 4.2. | Иргэд, даатгуулагч, ажил олгогчдод нийгмийн даатгалын талаарх мэдээлэл, зөвлөгөө өгөх; | - | -Байршуулсан мэдээ, мэдээлэл<br>-Цахимаар мэдээлэл зөвлөгөө авсан иргэд даатгуулагчийн тоо | -Нийгмийн даатгалын ерөнхий газраас иргэдэд мэдээлэл зөвлөгөө өгөх зорилготой Фэйсбүүк хуудсыг 26,760 иргэн дагаж байгаа бөгөөд давхардсан тоогоор нийгмийн даатгалын талаарх мэдээлэлтэй танилцсан 1,156,467, эргэж холбогдсон 150,787, | Иргэдэд цахим хэлбэрээр мэдээлэл зөвлөгөө хүргэх хүрээг өргөтгөн, дагагчдын тоог нэмэгдүүлсэн, тэднийг нийгмийн даатгалтай холбоотой шинэ мэдээ, мэдээллээр тогтмол хангаж ажилласан байна. | 1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Нийгмийн даатгалын мэдээлэл зөвлөгөө” фэйсбүүк хуудсыг 2022 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар 29765 иргэн дагаж нийгмийн даатгалын талаарх мэдээлэл зөвлөгөөг авч байгаа бөгөөд давхардсан тоогоор зөвлөгөө, мэдээлэлтэй танилцсан 1508369, эргэж холбогдсон 106369, сэтгэгдэл үлдээсэн 4734, бусдад түгээсэн 10404 иргэн байна.<br>Энэхүү фэйсбүүк хуудасны чатаар зурвас илгээсэн 15660 иргэнд хариу зөвлөгөө мэдээллийг өгч ажиллалаа.<br>Мөн фэйсбүүк хуудсаар нийгмийн даатгалтай холбоотой нийт 204 мэдээллийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сэтгэгдэл үлдээсэн 4,531, бусдад түгээсэн 9,532 иргэн байна. Чатаар зурвас илгээсэн 16,180 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгсөн.<br>-Уг Фэйсбүүк хуудсаар нийгмийн даатгалтай холбоотой нийт 88 мэдээллийг зурган болон линк шэйрлэх хэлбэрээр оруулсан байна.<br>-"Нийгмийн даатгал" гар утасны апплейкшнээр дамжуулж 4,914 иргэнд, ndaatgal.mn цахим хуудасны санал хүсэлт булангаар 727 иргэн, даатгуулагчид мэдээлэл зөвлөгөөг өгч ажилласан байна. | | зурган болон линк шэйрлэх хэлбэрээр оруулсан байна.<br>2. "Нийгмийн даатгал" гар утасны аппликейшнээр 4940 иргэнд, ndaatgal.mn цахим хуудасны "Санал хүсэлт" булангаар 178 иргэн, даатгуулагчдад мэдээлэл зөвлөгөөг өгч ажилласан. | |
| *"Нийгмийн даатгалын байгууллагын хүний **нөөцийн** чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.3. | Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх; | 65,0 сая (Хичээл үйлдвэр лэлийн дадлага) | Зохион байгуулсан сургалт, хамрагдсан хүний тоо | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 947 удаагийн сургалтад 16,310 албан хаагчийг хамруулсан. | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх цахим болон танхимын сургалтуудыг зохион байгуулсан байна. | Нийгмийн даатгалын салбарын албан хаагчдыг чадавхжуулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор салбарын хэмжээнд нийт 1046 (давхардсан тоогоор) удаагийн сургалтыг зохион байгуулж, сургалтад 21678 албан хаагч хамрагдсан байна. Үүнээс:<br>1. Нийгмийн даатгалын ерөнхий газар: 50 удаагийн сургалтад 6261 (давхардсан тоогоор) албан хаагч; | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2. Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүд: 996 (давхардсан тоогоор) удаагийн сургалаад 15417 албан хаагч; | |
| 4.4. | Ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх; | 20,0 сая (Хичээл үйлдвэр лэлийн дадлага) | Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо | Салбарын хэмжээнд зорилтот бүлэгт чиглэсэн 5,066 удаагийн сургалтад 6,513 аж ахуйн нэгжийн 193,948 иргэд, даатгуулагчийг хамруулсан. Мөн 596 удаагийн явуулын үйлчилгээ, нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, 288,543 иргэд, даатгуулагчийг хамруулсан. | Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх, зорилтот сургалт, арга хэмжээг зохион байгуулсан байна. | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд зохион байгуулсан ажил олгогч, иргэд даатгуулагчдад чиглэсэн 3299 удаагийн танхимын болон цахим сургалтад 13949 аж ахуйн нэгжийн 241533 иргэд, даатгуулагчид хамрагдсан ба 892 удаагийн явуулын үйлчилгээнд 94677, мөн 187 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөгт 51706, нийт 1122 удаагийн арга хэмжээнд 146383 иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын талаар зөвлөгөө мэдээллийг хүргэн ажиллалаа.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан сургалтуудаас дурдвал:<br>- Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнуудад зориулсан цахим сургалтыг 2022 оны 5 дугаар сарын 6-ны өдрөөс 27-ны өдрүүдэд салбарын хэмжээнд зохион байгуулахад удирдлагаар ханган оролцов:.<br>Мөн "Макс импекс" ХХК-ийн харьяа 20 байгууллагын 25 санхүүгийн ажилтан, нягтлан бодогч нарын сургалт;<br>- Онцгой байдлын ерөнхий газрын төв, орон нутгийн байгууллагын санхүү бүртгэлийн ажилтнуудын сургалт;<br>- Шинжлэх ухааны академийн удирдах ажилтны зөвлөгөөн;<br>- Цаг уурын орчны шинжилгээний газрын харьяа байгууллагуудын 21 аймгийн 44 шинжээч ажилтнуудын сургалт;<br>- Ажилчдын хөгжлийн нэгдсэн холбоо ТББ;<br>- Хил хамгаалах ерөнхий газраас зохион байгуулсан хилийн цэргийн ангиуд, тусгай салбаруудад зохион байгуулах нэгдсэн сургалт;<br>- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын албан хаагчдад зориулсан сургалт;<br>- "Даатгалтай ирээдүй сургалт өдөрлөг" | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - "Олон улсын ахмадын баярт зориулсан сургалт-өдөрлөг"-ийг тус тус амжилттай зохион байгууллаа.. | |
| 4.5 | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангах; | 50,0 сая (Мэдээлэл сурталчилгааны зардал) | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийсэн тоо | 148 хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан 641 удаагийн давтамжтайгаар нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд даатгуулагчдад хүргэж ажилласан. | Олон нийтэд хүргэх шаардлагатай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай дамжуулж, мэдээлэл авах хүсэлт гаргасан хэвлэл мэдээллийн байгууллагуудыг мэдээллээр хангасан байна. | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагаа болон цаг үеийн мэдээллийг ТВ9, ТВ6, ТВ8, С1, МН25, Ийгл, Парламент, Өлзий ТВ, МҮОНРТ-ийн ММ, Хурд, Соёмбо агентлаг, Малчин, Монгол HD, Стар, UBS, ETV, NTV, Тэнгэр телевиз, news.mn, itoim.mn, zarig.mn, zaag.mn, arslan.mn, ikon.mn, ulsturch.mn, ubn.mn, face.mn вебсайт, "Өглөөний сонин", "Өдрийн сонин", "Өнөөдөр" сонин, "Монголын үнэн" сонин зэрэг 81 хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан давхардсан тоогоор 578 удаагийн давтамжтайгаар иргэд, даатгуулагчдад хүргэж, хэвлэл мэдээллийн байгууллагыг эх сурвалж, мэдээллээр хангаж ажиллав. | 90 |
| 4.6. | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ач холбогдол, үйл ажиллагаа, үйлчилгээг иргэдэд ойлгомжтой, шинэлэг байдлаар тайлбарласан контент бэлтгэх;<br>/Видео,постер.../ | - | Шинэ контент бэлтгэсэн тоо | Нийгмийн даатгалын үйлчилгээний талаар 15 нэвтрүүлэг, 2 шторк, 14 видео хичээл нийт 31 видео контент, 198 постер, 7 төрлийн сурталчилгааны хуудас (брошур) шинээр бэлтгэн түгээсэн. | Шинэ контентийн агуулга, хэлбэрийг тодорхойлон бэлтгэж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон сошиал сүлжээгээр нэвтрүүлэн иргэд (даатгуулагч), ажил олгогчид хүргэсэн байна. | 1. Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээний мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын @sigomongolia сошиал хуудсаар 7 заавар, гарын авлага, 53 постер мэдээлэл, 4 шторк, 71 удаагийн цаг үеийн буюу нийт 133 удаагийн мэдээллийг бэлтгэн түгээж ажиллалаа. Тухайлбал:<br>- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн үйлчилгээг цахимаар үзүүлж эхэлсэнтэй холбогдуулан 1 видео, 5 гарын авлагыг шинээр боловсруулан иргэд, даатгуулагч, ажил олгогч, эрүүл мэндийн байгууллагад цахим хэлбэрээр түгээсэн нь давхардсан тоогоор 627764 иргэнд хүрсэн байна.<br>- Нийгмийн даатгалын хууль тогтоомжид орсон, 2022 оноос хэрэгжиж эхэлсэн өөрчлөлт, цахим үйлчилгээний талаарх 32 постер мэдээллийг түгээсэн нь давхардсан тоогоор 2.8 сая иргэнд хүрсэн байна.<br>2.Нийгмийн даатгалын байгууллагын 80 жилийн ойн арга хэмжээг угтсан ажлын хүрээнд Нийгмийн даатгалын салбарын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | танилцуулга номыг шинэчлэн цахим хэлбэрээр түгээсэн.<br>3. Иргэд, даатгуулагчдын санал хүсэлтэд шуурхай хариулах, эргэх холбоог хангах зорилгоор @sigomongolia сошиал хуудсанд чатбот мессенжерийг ажиллуулж байна.<br>Тайлант хугацаанд чатбот мессенжерт нийт 75519 иргэн мэдээлэл авахаар хандсанаас, 60738 иргэн автомат хариулагчаас мэдээлэл авсан бол 11125 иргэн тухайлсан зөвлөгөө мэдээлэл авахаар, 2619 иргэн бусад асуудлаар, 1037 иргэн санал, гомдол ирүүлснийг тухай бүр шийдвэрлэн ажиллав. | |
| *"Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.7. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, Эмнэлэг хөдөлмөрийн комиссын гишүүдэд сургалт зохион байгуулах; | 10 сая | Сургалтын тайлан, хамрагдсан хүний тоо | 2021 онд Өвөрхангай аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн болон Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт цахим сургалт зохион байгуулсан. | Сургалт зохион байгуулагдсан байна. | 1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс нь Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/758, А/197 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан "Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах ердийн өвчний жагсаалт"-ыг 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдөөс эхлэн мөрдөхтэй холбоотойгоор "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний хөдөлмөрийн чадвар алдалт тогтоож буй бодлого зохицуулалт" сэдэвт 4 удаагийн бүсчилсэн сургалт, "Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход оролцож байгаа эрүүл мэндийн байгууллагын эмч нарыг чадавхжуулах, сургагч багш бэлтгэх " 1 удаагийн сургалт, нийт **5** удаагийн сургалтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлүүдтэй хамтран зохион байгуулав. Үүнд:<br>- Баруун бүсийн сургалтад Баян-Өлгий аймагт 2022 оны 03 дугаар сарын 03-07-ны өдрүүдэд зохион байгуулж, Баян-Өлгий, Увс, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Ховд аймгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын төрөлжсөн мэргэжлийн болон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийгмийн даатгалын хэлтсийн магадлагч эмч нар зэрэг нийт 50 гаруй гишүүд оролцов.<br>- Говийн бүсийн сургалтыг Өмнөговь аймагт 2022 оны 03 дугаар сарын 07-10-ны өдрүүдэд зохион байгуулж, Өмнөговь, Дундговь аймаг, Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Хан-уул, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргүүдийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын орлогч дарга, магадлагч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмч нар нийт 60 орчим гишүүд оролцов.<br>- Зүүн бүсийн сургалтыг Хэнтий аймагт 2022 оны 03 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд зохион байгуулж, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Говьсүмбэр, Дорноговь аймгууд, Багануур, Налайх дүүргийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын орлогч дарга, магадлагч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмч нар, нийт 40 гаруй гишүүд, эмч, мэргэжилтнүүд оролцов.<br>- Төвийн бүсийн сургалтыг Дархан-Уул аймагт 2022 оны 03 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд зохион байгуулж, Дархан-Уул, Орхон, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв, Архангай, Өвөрхангай аймгууд, Сэтгэцийн болон Мэргэжлээс шалтгаалсан өвчний Эмнэлэг хөдөлмөрийн магадлах салбар комиссын орлогч дарга, магадлагч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмч нар, нийт 50 гаруй гишүүд, эмч, мэргэжилтнүүд оролцов.<br>Бүсчилсэн сургалтуудад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын эмч нар, Эрүүл мэндийн яамны дэргэдэх дотор, мэдрэл, сэтгэц, чих, хамар, хоолойн өвчний мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, гишүүд оролцож холбогдох чиглэлүүдээр мэдээлэл өгч ажилласан байна.<br>2. "Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход оролцож байгаа эрүүл мэндийн байгууллагын эмч нарыг чадавхжуулах, сургагч багш бэлтгэх | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалт"-ыг 2022 оны 04 дүгээр сарын 07, 08-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулав. Энэхүү сургалтад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн магадлагч эмч, салбар, орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, болон эрүүл мэндийн байгууллагын Эмнэлэг хяналтын комиссын гишүүд, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, өрх, сумын Эрүүл мэндийн төвийн, нийт 170 орчим эмч, мэргэжилтнүүдийг хамруулав. | |
| 4.8. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын хамтарсан болон дахин магадлалыг сонгогдсон аймаг, дүүрэгт зохион байгуулах; | 35 сая | Хяналт шалгалтын дүн, тайлан | 2021 онд Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Завхан, Орхон, Хөвсгөл, Увс аймагт дахин магадлал, Баян-Өлгий, Баянхонгор, Сэлэнгэ аймагт хамтарсан магадлалыг зохион байгуулсан. | Батлагдсан хуваарийн дагуу аймаг, дүүрэгт хяналт шалгалт зохион байгуулсан байна. | 1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дахин магадлалыг Сүхбаатар дүүрэг болон Сүхбаатар, Говь-Сүмбэр, Дорноговь, Баянхонгор, Баян-Өлгий аймгуудад зохион байгуулав.<br>Дээрх аймаг, дүүргүүдийн нийт 1406 иргэнийг дахин магадлаж үнээс. 1025 /79.2%/ иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг хэвээр магадлан, 332 /26.3%/ иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын заалт, хувь, хугацааг өөрчилж, 49 /4%/ иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцлахаар шийдвэрлэв.<br>2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын хамтарсан магадлалыг хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгосон даатгуулагч (иргэн)-ийн тоогоор улсын дундаж (3.2)-аас өндөр байгаа Ховд, Архангай, Дорнод аймгуудад Эрүүл мэндийн яамны мэргэжлийн салбар зөвлөлүүдтэй хамтран зохион байгуулав.<br>Хамтарсан магадлалаар дээрх аймгуудын хөдөлмөрийн чадвар алдсан **2493** иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон байдалд хяналт шалгалт хийж, 1430 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэвээр магадлан, 223 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 773 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, заалт, оношийг тус тус өөрчилж, 136 иргэнийг шинжилгээнд хамруулж магадлав. | |
| 4.9. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын шинжээч эмчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах; | 200.0 мян | Сонгон шалгаруулалтын тайлан, комиссын бүрэлдэхүүний тушаал | 2018 онд сонгон шалгаруулалт зохион байгуулсан. | Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тушаалын төсөл боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна. | Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, дүгнэлт гаргах, эрдэм шинжилгээ, судалгаа хийх зорилгоор Засгийн газрын 2021 оны "Дүрэм шинэчлэн батлах тухай" 67 дугаар тогтоолоор батлагдсан "Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм"-ийн 2 дахь хэсгийн 2.10-2.15, 2.17 дугаар заалт, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/166 дугаар тушаалаар батлагдсан "Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчийг сонгон шалгаруулах журам"-ыг үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтын зонхилох шалтгаан болж буй мэдрэл, сэтгэц, дотор, гэмтэл согогийн өвчний чиглэлээр Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын шинжээч эмч нарын сонгон шалгаруулалтыг 2015 оноос эхлэн 3 жил тутамд зохион байгуулж, томилон ажиллуулж байна.<br>Тус газрын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дотор, мэдрэл, сэтгэц, гэмтлийн мэргэжлийн шинжээч эмч нарын хугацаа дуусгавар болж 2022 оны 01 дүгээр сард дээрх төрөлжсөн мэргэжлийн эмч нарын сонгон шалгаруулалтыг зарлав.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/05 дугаар тушаалаар Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын шинжээч эмчийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын шинжээч эмчээр мэргэжлийн эмч нарыг сонгон шалгаруулж, Засгийн газрын 2021 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан "Эмнэлэг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм"-ийн 2 дах хэсгийн 2.2.2, 2.17 дахь заалтуудыг үндэслэн сонгон шалгаруулалтын дүнгийн танилцуулга болон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын шинжээч эмч нарын сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох саналыг Нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/02 дугаар тушаалаар Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулав. | |
| *"Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.10. | Салбарын хэмжээнд хууль тогтоомжийн өөрчлөлт болон шинээр батлагдсан хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг мэдээллийн технологиор дэмжин ажиллах; | - | Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн дэвшилтэт технологид суурилан үзүүлэх үйлчилгээний хэвийн ажиллагааг хангасан байх | - Шинээр 2 систем нэвтрүүлсэн.<br>- Ашиглагдаж буй 10 гаруй програм хангамжид нийт 110 орчим удаагийн өөрчлөлт, хөгжүүлэлт хийсэн. | 2022 онд хэрэгжих хууль тогтоомжийн өөрчлөлтийг мэдээллийн технологид суурилан хэрэгжүүлэх зорилгоор одоо ашиглагдаж буй програм хангамжид өөрчлөлт оруулна. Шаардлагатай тохиолдолд шинээр мэдээллийн систем боловсруулж нэвтрүүлнэ.<br>-"Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах; | Тайлант хугацаанд салбарын хэмжээнд гарсан хууль тогтоомжийн өөрчлөлт болон шинээр батлагдсан хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд шинээр 3 систем, 15 сервисийг боловсруулан нэвтрүүллээ. Үүнд:<br>1. УИХ-аас шинээр баталсан "Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай" хууль, Засгийн газрын 2022 оны "Журам батлах тухай" 230 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд "Refund50-Core" системийг шинээр боловсруулан нэвтрүүллээ. Энэхүү вэб систем нь нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олголт авах нөхцөл хангасан даатгуулагчдын дансны мэдээллийг Монгол банкны дансны нэгдсэн систем /ДНС/-ээс шалгах, тухайн сард эрх нь үүссэн даатгуулагчийн буцаан олголтын мэдээллийг Сангийн яам руу илгээх, хариуг хүлээн авах зориулалт бүхий цогц систем юм. Уг вэб системийг ашиглан сар бүр буцаан олголт олгох 621.0 мянган даатгуулагчийн дансны мэдээллийг шалган, 5-аас 10 дугаар сарын байдлаар давхардсан тоогоор нийт 1766.9 мянган гүйлгээ хийгдсэн байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн $19^2$ дүгээр зүйлийн 3 дахь заалтын хэрэгжилтийг хангах;<br>-Шинээр хууль тогтоомж батлагдсан, өөрчлөлт орсон тохиолдолд хэрэгжилтийг хангах; | 2. Төв орон нутгийн нийгмийн даатгалын байцаагч, ажилтнууд сар бүрийн нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олголттой холбоотой дараах мэдээллүүдийг харах, хянах, даатгуулагч, ажил олгогчийг мэдээллээр хангах зориулалтаар ашиглах “Refund50” вэб програм хангамж боловсруулан нэвтрүүлсэн. Үүнд:<br>- Буцаан олголт олгох нөхцөл хангасан, Сангийн яам руу илгээгдсэн, Сангийн яамнаас банкууд руу гүйлгээ хийгдсэн, мөн гүйлгээ нь буцаагдсан даатгуулагчдын тоон мэдээллийг харах;<br>- Дансгүй, овог нэр, данс нь зөрүүтэй, буцаан олголт нь буцаагдсан даатгуулагчдын дэлгэрэнгүй жагсаалтыг харах;<br>-Даатгуулагчдын буцаан олголт олгосон түүхийг харах;<br>- Буцаан олголт илүү хийгдсэн даатгуулагчдын жагсаалтыг харах.<br>3. Эмнэлгийн хуудас цахимжсантай холбогдуулан төв, орон нутгийн магадлагч эмч нар эрүүл мэндийн байгууллагаас илгээж буй эмнэлгийн хуудасны бичилт, олголт болон бусад дэлгэрэнгүй мэдээллийн үнэн зөв байдлыг шалгах “Medical Monitor” вэб програм хангамжийг боловсруулан нэвтрүүллээ. Уг програм хангамжаар нийтдээ 163.0 мянган эмнэлгийн хуудасны мэдээллийг нягтлан шалгасан байна.<br>4. Тэтгэмжийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсэн болон амаржсаны, ажилгүйдлийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн үйлчилгээг цахимжуулахтай холбогдуулан төрийн мэдээлэл солилцооны ХУР системд 10 төрлийн, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia-д 5 төрлийн сервисийг шинээр боловсруулан хүргүүлсэн.<br>Үүнээс гадна тайлант хугацаанд програм хангамжуудад 110 гаруй удаагийн өөрчлөлт, сайжруулалт хийлээ. Үүнээс хийсэн томоохон ажлуудаас дурдвал: | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны шалгуурыг эрэгтэй 61 нас 3 сар, эмэгтэй 56 нас 3 сараар тооцох, мөн шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдийн шимтгэл төлөх хугацааны шалгуурыг 21 жил 3 сараар тооцох.<br>2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн $19^2$ дүгээр зүйлийн 3 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авах эрх нь үүссэн, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш ихэр хүүхэд төрүүлсэн эхэд амаржсаны тэтгэмж олгох хугацааг 80 хоногоор тооцох.<br>3. Засгийн Газрын 2022 оны "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор "Тэтгэврийн тооцооны програм хангамж"-д дор дурдсан өөрчлөлтүүдийг оруулж, 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нийт тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэн олгох боломжийг бүрдүүлсэн. Үүнд:<br>- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгон авч буй нийт тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлэх;<br>- Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн, түүнчлэн цэргийн алба хаасны бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 500000, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400000 төгрөгөөр тус тус тооцох;<br>- Тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлэхэд бүрэн тэтгэврийн доод хэмжээ 500000 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 400000 төгрөгт хүрэхгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тохиолдолд шинэчлэн тогтоосон доод хэмжээнд тус тус хүргэж нэмэгдүүлэх.<br>Эдгээр боломжийг бүрдүүлснээр нийтдээ 469.2 мянган тэтгэвэр авагч тэтгэврээ нэмэгдүүлэн авсан байна.<br>4. Эрүүл мэндийн Сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2021 оны А/758, А/197 тоот хамтарсан тушаалаар шинэчлэн баталсан “Даатгуулагч /иргэн/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа”-ны жагсаалтыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхтэй холбогдуулан эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын бүртгэлийн програмд уг жагсаалтыг шинэчлэн оруулсан.<br>5. Нийгмийн даатгалын цахим үйлчилгээ өргөжиж байгаатай уялдан ажил олгогчийн хүний нөөцийн ажилтан ажилтнуудынхаа хөдөлмөр эрхлэлтийн хөдөлгөөнийг цахимаар бүртгэх, мөн эрүүл мэндийн байгууллагаас илгээсэн хөдөлмөрийн чадвар алдалтын эмнэлгийн хуудасны холбогдох мэдээллийг бүртгэх шаардлага үүссэн. Үүнтэй холбогдуулан “Шимтгэлийн цахим систем”-д ажил олгогчийн хүний нөөцийн ажилтан тусдаа эрхээр нэвтэрч зөвхөн тушаал, эмнэлгийн хуудас цэсэнд ажиллах боломжийг бүрдүүлсэн. Мөн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хүсэлтээр олон тооны ажилтантай байгууллагын хүний нөөцийн ажилтанг өөрийн хариуцсан нэгжийн ажилтны тушаал болон эмнэлгийн хуудаст хандах нөхцөлийг бүрдүүлсэн. Эдгээр боломжийг бүрдүүлснээр энэ онд нийт 443 ажил олгогчийн 497 хүний нөөцийн ажилтан 125.6 мянган тушаалын мэдээллийг бүртгэсэн байна.<br>6. “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай”, “Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай” хуулиуд 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн холбогдуулан цахим орчинд хувь хүний мэдээллийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ашиглахдаа тухайн иргэнээс зөвшөөрөл авах, хаанаас, ямар мэдээлэл дуудаж буй талаар иргэнд мэдэгдэхтэй холбогдуулан даатгуулагчийн улсын бүртгэлийн мэдээллийг УБЕГ-ын мэдээллийн сангаас шалгах зорилгоор ашиглаж буй "Regweb" програм хангамжид холбогдох өөрчлөлтийг оруулсан.<br>7. "Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай" хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд "Харилцахын тооцооны програм хангамж"-д нягтлан бодох бүртгэлийн 22 данс, 34 гүйлгээний төрөл шинээр нэмэх, тайлангийн 144 томьёонд өөрчлөлт оруулах, төрийн сангийн гүйлгээний хуулганаас буцаан тушаасан гүйлгээний мэдээллийг файлаас татуулах өөрчлөлтүүдийг хийлээ. Ингэснээр даатгуулагчдын нийгмийн даатгалын санд буцаан тушаасан гүйлгээ алдаагүй, үнэн зөв бүртгэгдэх боломж бүрдсэн.<br>8. Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, сэргээх шалгалт авахтай холбоотой "Зайн сургалт" вэб програм хангамжид байцаагч, ажилтнуудын мэдээлэл, шалгалтын 2190 асуулт, 8760 бодлогын текстийг хөрвүүлэн оруулж, дүнгийн хуудсыг хэвлэх боломжийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд шалгалтад хамрагдсан 443 байцаагч, ажилтнуудын ерөнхий мэдлэгийн шалгалтыг аван дүгнэж, бүх үйл ажиллагааг хувь хүний оролцоо, нөлөөлөлгүйгээр системээр амжилттай зохион байгуулсан. | |
| 4.11. | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд мэдээллийн шинэчилсэн системийг турших, нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлэх; | - | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд мэдээллийн шинэчилсэн системийг нэвтрүүлсэн байх | Шинээр хэрэгжинэ | -Нийгмийн даатгалын салбарын бүх байгууллагуудад мэдээллийн шинэчилсэн системийг нэвтрүүлсэн байна. | Нийгмийн даатгалын салбарын мэдээллийн шинэчилсэн системийг үе шаттайгаар туршин нэвтрүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>1. 2021 оноос эхлэн салбарын хэмжээнд үе шаттайгаар тестлэн туршиж байсан "Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн систем", "Хүний нөөцийн систем"-ийг энэ онд бүрэн нэвтрүүллээ. Ингэснээр салбарын 34 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг бодит цагийн горимоор үзүүлнэ. | нэгж байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, хүний нөөцтэй холбоотой мэдээллийг бүртгэх, тайлан, улмаар салбарын нэгдсэн тайлан гарах ажлууд амжилттай хийгдэж байна.<br>2. Нийгмийн даатгалын мэдээллийн шинэчилсэн системийг нэвтрүүлэхээр ажиллаж буй гүйцэтгэгч компанитай хамтран ажиллах ажлын хэсгийг байгуулан уг ажлын хэсгийн ажилтнууд болон нийгмийн даатгалын мэдээллийн технологийн мэргэжилтнүүд бүтээгдэхүүн, үйлчилгээг тестлэх, шийдэл гаргах, тулгамдаж буй асуудлуудын талаар нийтдээ 36 удаагийн уулзалт хийсэн. Хоёр тал хамтран тэтгэвэр, тэтгэмж, шимтгэлийн үйлчилгээний тохиолдлыг нэг бүрчлэн тестлэн ажилласан. Энэ явцад нийтдээ 600 гаруй санал гарсны 90 орчим хувийг гүйцэтгэгч байгууллага шийдвэрлэсэн байна.<br>3. Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан дээр хадгалагдаж буй даатгуулагч, ажил олгогчийн мэдээллийг шинээр нэвтрүүлэхээр туршиж буй систем рүү хөрвүүлэн оруулах ажил 90 хувийн гүйцэтгэлтэй хийгдсэн. Энэ ажлын хүрээнд нийт 8 хүснэгт /table/, 144.8 сая бичлэг хөрвүүлэх ажлыг гүйцэтгэлээ.<br>4. Шинэ системийн боловсруулалтын явц болон дээрх ажлуудын гүйцэтгэлийг ХУД-ийн НДХ-т туршин тестэлж байгаа бөгөөд одоогийн байдлаар тэтгэвэр, тэтгэмж, сайн дурын даатгалын үйлчилгээний 1.9 мянган тохиолдлыг тестлэн туршаад байна. Уг цогц системийг тестлэх ажлыг бүрэн дууссаны дараа 2023 оноос төв орон нутгийн салбарын байгууллагуудад нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | |
| 4.12. | Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, төрийн мэдээллийн нэгдсэн сангаас нийгмийн даатгалын үйлчилгээг тогтвортой үзүүлэх; | - | 1. Нэгдсэн мэдээллийн санг 2022 оны мэдээллээр баяжуулах<br>2. Нэгдсэн мэдээллийн сангаас | 1. 74GB нэгдсэн мэдээллийн сан үүссэн.<br>2. 210 удаагийн мэдээллийн боловсруулалт хийсэн. | 1. Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, нөөцлөх, төрийн нэгдсэн мэдээллийн санд байршуулах, нэгдсэн | Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, төрийн мэдээллийн нэгдсэн сангаас нийгмийн даатгалын үйлчилгээг тогтвортой үзүүлэх ажлын хүрээнд дараах ажил үйлчилгээг хийж гүйцэтгэлээ.<br>1. Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн санг баяжуулан хэвийн ажиллагааг хангаж ажиллалаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | судалгаа мэдээллийн боловсруулалт хийх<br>3. Цахимаар үзүүлж буй нийгмийн даатгалын үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах<br>4. Төрийн байгууллагуудтай цахимаар мэдээлэл солилцох ажлыг өргөжүүлэх | 3. Цахимаар үзүүлж буй нийгмийн даатгалын үйлчилгээ:<br>-"Нийгмийн даатгал" аппликейшнийг 207.2 мянган даатгуулагч идэвхитэй ашигласан.<br>-"Даатгуулагчдад зориулсан вэб" системд 1.7 сая удаагийн хандалт хийж, цахимаар үйлчилгээ авсан.<br>-ТҮЦ машинаас 130.5 мянган лавлагаа тодорхойлолт хэвлэн авсан.<br>-E-mongolia төрийн цахим үйлчилгээний нэгдсэн порталаар нийгмийн даатгалын 3 төрлийн лавлагаа тодорхойлолтыг цахимаар хүргэж, сайн дурын даатгалын үйлчилгээг нэмж оруулсан.<br>4. Цахимаар мэдээлэл солилцох төрийн байгууллагын тоог 3-аар нэмэгдүүлж, нийт 16 төрийн байгууллагад цахим мэдээлэл хүргүүлэх үйлчилгээ хэвийн явагдсан. | мэдээллийн сангаас үйлчилгээ үзүүлэх ажил тогтвортой хийгдсэн байна.<br>2. Нэгдсэн мэдээллийн сангаас судалгаа мэдээллийн боловсруулалт хийх ажлыг цаг тухай бүр гүйцэтгэсэн байна.<br>3. Иргэд даатгуулагч, ажил олгогч, харилцагч байгууллагуудад "Нийгмийн даатгал" аппликейшн, "Даатгуулагчид зориулсан вэб", ТҮЦ машин, төрийн цахим үйлчилгээний e-mongolia нэгдсэн порталаар дамжуулан цахимаар үзүүлэх мэдээллийн үйлчилгээг өргөжүүлж, тогтвортой ажиллагааг хангасан байна.<br>4. Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан төрийн байгууллагатай мэдээлэл солилцох | Салбарын 30 нэгжийн мэдээллийн санг өдөр бүр цахимаар цуглуулан нэгтгэж нэгдсэн мэдээллийн санг үүсгэх ажлыг тасралтгүй, тогтмол хийж гүйцэтгэсэн ба энэ онд ажил олгогч, даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж авагчийн дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан **82.3GB** нэгдсэн мэдээллийн сан үүссэн байна.<br>2. Нэгдсэн мэдээллийн сангаас 250 орчим удаагийн мэдээллийн боловсруулалт, судалгаа гаргаж хэрэглэгчийг мэдээллээр хангалаа.<br>Тухайлбал:<br>"Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай" хууль, Засгийн газрын 2022 оны "Журам батлах тухай" 230 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 5-10 дугаар саруудын байдлаар буцаан олголттой холбоотой 22 төрлийн томоохон судалгаа тооцооллыг нийт 6 удаа хийж, хууль тогтоомжийн хэрэгжилт цаг хугацаандаа явагдах нөхцөлөөр хангаж ажиллалаа. Үүнд:<br>- Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, төлсөн шимтгэлийн дүнг тооцоолж даатгуулагч нь хуулийн үйлчлэлд хамрагдах ажил олгогчийн мэдээллийг шинэчлэн гаргах<br>- Хуулийн нөхцөл хангасан албан журмын даатгуулагчдын буцаан олголтын мэдээллийг гаргах<br>- Сайн дурын даатгуулагч, сайн дурын даатгуулагч эхийн төлсөн шимтгэлийн дүнг тооцоолж хуулийн үйлчлэлд хамаарах даатгуулагчийн судалгааг шинэчлэн гаргах<br>- Дансгүй, овог, нэр зөрсөн даатгуулагчдын мэдээллийг аймаг, дүүргээр гарган нэгжүүдэд дансжуулахаар хүргүүлэх<br>- Сангийн яамнаас эцэслэн хийгдсэн гүйлгээ болон гүйлгээ нь буцаагдсан даатгуулагчдын мэдээллийг аймаг, дүүргээр болон 4 сангаар гаргах. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлчилгээг өргөжүүлж, тогтвортой ажиллагааг хангасан байна. | - Тэтгэврийн зөрүүг ойртуулах, тэтгэвэр нэмэгдүүлэх тооцоо, судалгаанд шаардлагатай мэдээллийг 8 загвараар<br>- ХНХЯ-ны хуулийн өөрчлөлт, тэтгэвэр нэмэгдүүлэх болон бусад зориулалтаар ашиглах мэдээллийг нийт 15 удаа;<br>- Засгийн газрын шийдвэр гаргахад ашиглах зориулалтаар ХНХЯ-тай хамтран тэтгэврийн итгэлцүүр өөрчлөх, тэтгэврийг нэмэгдүүлэх, цалингийн дээд хэмжээ өөрчлөх зэрэг 14 төрлийн мэдээлэл;<br>- Дэлхийн банкны зөвлөхөөр нийгмийн даатгалын хэтийн тооцоолол хийлгэх зориулалтаар нийгмийн даатгалын сангаас сүүлийн 6 жилийн тэтгэвэр авагчдын 18 үзүүлэлт мэдээлэл;<br>- Дэлхийн банкны зөвлөхөөс Монгол улсын тэтгэврийн даатгалын сангийн тогтвортой байдлын төлөвийг тооцоолоход ашиглах зориулалтаар 2006-гаас 2022 оны 06 дугаар сар хүртэл хугацаанд албан журмын болон сайн дураар шимтгэл төлсөн даатгуулагчдын шимтгэлийн дүн, шимтгэл төлсөн сарын тоо, ХХТАО-ын хэмжээ, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийг он тус бүр, нийт 9 үзүүлэлт мэдээлэл. /файл 45.3MB/<br>- Үндэсний статистикийн хороонд батлагдсан 34 маягтын дагуу ААНБ-ын ажилтны тоо, цалин хөлстэй холбоотой мэдээллийг 5 удаа;<br>- Үндэсний статистикийн хороонд батлагдсан 23 маягтын дагуу нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогч, даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо болон зарцуулсан хөрөнгийн мэдээллийг 2 удаа;<br>- Сангийн яамны хүсэлтээр нэр бүхий 105 ажил олгогчийн 2016-2022 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд төлсөн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээлэл;<br>- Төрийн албаны зөвлөлд төрийн албан хаагчийн цалин хөлс, ангилал, зэрэглэлийн талаар судалгаа хийхэд шаардлагатай мэдээллийг 2 удаа; | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Монгол банкны хүсэлтээр "Ковид-19 цар тахлын үед хэрэгжүүлж буй бодлогуудын хөдөлмөрийн зах зээлд үзүүлж буй нөлөөлөл"-ийг судлах зориулалтаар нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг сүүлийн 10 жилээр, ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, тэтгэмжийн дүн, мөн "Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай" хуулийн хүрээнд НДШ-ээс чөлөөлсөн дүнг ажил олгогчийн ЭЗҮАСА-аар, /2020, 2021 он/.<br>- Авлигатай тэмцэх газарт нэр бүхий ААНБ-уудын шимтгэл төлөлтийн мэдээллийг 10 удаа<br>- ЦЕГ-ын ЭЦА, МШХ, Экологийн цагдаагийн алба зэрэг байгууллагуудад нэр бүхий ААНБ-ын шимтгэл төлөлтийн мэдээллийг нийтдээ 54 удаа . . . гэх мэт.<br>3. Иргэд, даатгуулагч, ажил олгогчдод 4 сувгаар мэдээллийг цахимаар тогтмол хүргэлээ.<br>Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн "ХУР" системээр дамжуулан иргэд даатгуулагч, ажил олгогчдод нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар хүргэх ажил тогтмол, хэвийн явагдлаа. Тухайлбал:<br>- "Нийгмийн даатгал" аппликейшнийг нийтдээ 250.0 мянга орчим даатгуулагч өөрийн шимтгэл төлөлт, тэтгэвэр, тэтгэмжийн мэдээллээ харах, сайн дурын даатгалын үйлчилгээнд хамрагдах зэргээр идэвхтэй ашиглаж байна.<br>- "Даатгуулагчид зориулсан вэб" системийг ашиглан нийтдээ 69.9 мянга даатгуулагч сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, төлбөрөө төлөх үйлчилгээнд хамрагдсан байна.<br>Мөн "Даатгуулагчид зориулсан вэб" систем, "Нийгмийн даатгал" аппликейшн, "Нэгдсэн лавлагааны програм"-аас нийтдээ 2.4 сая орчим QR кодтой шимтгэл төлөлтийн лавлагаа тодорхойлолт авсан байна.<br>- Төрийн үйлчилгээний 109 ТҮЦ машинаар үзүүлж буй үйлчилгээний хүртээмжийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өргөжүүлэн даатгуулагч 2000-2005 оны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолтоо авах боломжийг нэмж бүрдүүлсэн. Энэ онд 156.9 мянган иргэн ТҮЦ машинаас 4 төрлийн лавлагаа тодорхойлолтоо хэвлэн авсан байна.<br>- Төрийн үйлчилгээний нэгдсэн портал E-mongolia-гаар хүргэж буй үйлчилгээг өргөжүүлэн даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдалтын, жирэмсэн болон амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмжийн хүсэлтээ цахимаар гаргах нөхцөлийг бүрдүүллээ. Мөн даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийн буцаан олголт авах дансны дугаараа бүртгүүлэх, засах боломжийг бүрдүүлсэн.<br>4. Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр мэдээлэл солилцох ажлыг өргөжүүллээ.<br>- Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Засгийн Газраас тавьсан нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэд даатгуулагчдад үзүүлэх цахим үйлчилгээг өргөжүүлэн Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв зэрэг байгууллагуудтай байгуулсан мэдээлэл солилцох гэрээний дагуу холбогдох сервисийг боловсруулан хүргүүлсэн.<br>- Төрийн үйлчилгээг иргэд даатгуулагчдад чирэгдэлгүй шуурхай хүргэх зорилгоор "ХУР" системд хүргүүлж буй 46 сервисийг ашиглан төрийн 18 байгууллага нийтдээ 4.5 сая орчим удаагийн хандалт хийж ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл төлөлтийн мэдээллийг цахимаар авсан байна. | |
| 4.13. | Эмнэлгийн хуудсыг цахимаар солилцох, иргэд даатгуулагчдад тэтгэмж олгох үйлчилгээг цахимаар хүргэх; | - | Эмнэлгийн хуудсаар тэтгэмж олгох үйлчилгээг цахимаар үзүүлэх нөхцлийг | Эрүүл мэндийн байгууллагаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн амаржсаны эмнэлгийн хуудсыг | - Эрүүл мэндийн байгууллагад бүртгэгдсэн хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн | Эмнэлгийн хуудсыг цахимаар солилцох, иргэд даатгуулагчдад тэтгэмж олгох үйлчилгээг цахимаар хүргэх ажлын хүрээнд дараах ажил үйлчилгээг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын дагуу хөдөлмөрийн чадвар түр алдсаны, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бүрдүүлсэн байх | цахимаар хүлээн авах бэлтгэл ажил хангагдсан. | амаржсаны эмнэлгийн хуудсыг ажил олгогч болон даатгуулагч цахимаар хүлээн авах боломжийг бүрдүүлсэн байна.<br>- Ажил олгогч тэтгэмжийн тайлангаа нийгмийн даатгалын байгууллагад цахимаар илгээх боломжийг бүрдүүлсэн байна.<br>- Даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн амаржсаны тэтгэмж авах хүсэлтээ цахимаар илгээх боломжийг бүрдүүлсэн байна.<br>- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн амаржсаны тэтгэмж олголтын үйлчилгээг зайнаас үзүүлэх нөхцөл хангагдсан байна. | жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг цахимаар олгохтой уялдуулан ажил олгогч болон даатгуулагч эрүүл мэндийн байгууллагаас олгож буй эмнэлгийн хуудсыг цахимаар хүлээн авах нөхцөлийг бүрдүүллээ. Ингэснээр эрүүл мэндийн байгууллагаас илгээсэн албан журмын даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсаны эмнэлгийн хуудсыг ажил олгогч "Шимтгэлийн цахим систем"-ээр хүлээн авч, тэтгэмжийн тооцооллыг нягтлан шалгаж, шаардлагатай тохиолдолд засварлан нийгмийн даатгалын байгууллагад цахимаар илгээх, тэтгэмж олгосон тайлан /Б-НД-2.1/-г хэвлэн авч баталгаажуулах боломжтой болсон.<br>2. Сайн дураар даатгуулагч, сайн дураар даатгуулагч эх "Даатгуулагчид зориулсан вэб" систем, E-Mongolia порталыг ашиглан хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлтээ цахимаар гаргах нөхцөлийг бүрдүүллээ.<br>3. Мөн албан журмын даатгуулагч эх жирэмсэн болон амаржсаны тэтгэмж авах хүсэлтээ дээрх хоёр системээр цахимаар гаргах боломжийг бүрдүүлсэн.<br>Эдгээр боломж бүрдсэнээр энэ онд 850 гаруй эрүүл мэндийн байгууллагаас нийтдээ 163.0 мянган эмнэлгийн хуудас цахимаар хүлээн авсан байна. | |
| 4.14. | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тогтоолгох өргөдөл, материалыг даатгуулагчаас цахимаар хүлээн авч, | - | Тэтгэвэр тогтоолгох хүсэлт, материалыг цахимаар хүлээн авах нөхцлийг | Шинээр хэрэгжинэ. | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд шинээр нэвтрүүлэх цогц системийг ашиглан | Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн өргөдөл болон шаардлагатай материалыг цахимаар хүлээн авч, шийдвэрлэх зорилгоор мэдээллийн санд байгаа даатгуулагчийн мэдээлэлд үндэслэн тэтгэвэр авагчийн тэтгэврийг урьдчилан тооцох, тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг хүлээн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрлэх ажлыг эхлүүлэх; | | бүрдүүлсэн байх | | даатгуулагч тэтгэвэр тогтоолгох хүсэлт, холбогдох баримт материалаа нийгмийн даатгалын байгууллагад цахимаар илгээх боломжийг бүрдүүлсэн байна. | авах боломжийг бүрдүүлж, "Даатгуулагчид зориулсан вэб" системтэй холбох ажил 60 хувьтай хийгдэж байна. | |
| 4.15. | Даатгуулагчдад ажилгүйдлийн тэтгэмж олгох үйлчилгээг цахимаар хүргэх; | - | Ажилгүйдлийн тэтгэмж олгох үйлчилгээг цахимаар үзүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байх | "Ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдөл"-ийг цахимаар хүлээн авах системийг хөгжүүлж нэвтрүүлсэн. | - Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ цахимаар илгээх боломжийг бүрдүүлсэн байна.<br>- Ажилгүйдлийн тэтгэмж олголтын үйлчилгээг зайнаас үзүүлэх нөхцөл хангагдсан байна. | Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болсон даатгуулагч "Даатгуулагчид зориулсан вэб" систем, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia-гаар дамжуулан ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ цахимаар гаргах боломжийг бүрдүүлэн ажиллалаа.<br>Энэхүү боломж бүрдсэнээр 2022 онд 1.6 мянган иргэний хүсэлт цахимаар илгээгдсэн байна. | 90 |
| **Нийт үнэлгээ** | | | | | | | **94,8** |